


101 аугаа либерал сэтгэгч

**СЭТГЭЛГЭЭНИЙ
СУРГУУЛЬ**

ИЙМОНН БАТЛЕР



**СЭТГЭЛГЭЭНИЙ
СУРГУУЛЬ:
101 АУГАА ЛИБЕРАЛ СЭТГЭГЧ**

Иймонн Батлер

2019 он

ННА 66
ДАА 320
Б-336

School of Thoughts: The Liberal 101 Thinkers
by Eamonn Butler

Copyright © The Institute of Economic Affairs 2019
First published by the Institute of Economics Affairs, London, in 2019

Сэтгэлгээний сургууль: 101 аугаа либерал сэтгэгч
Иймонн Батлер

Энэ монгол орчуулгын анхны хэвлэл: 2024 он
Англи хэлнээс орчуулсан: Намхайнямын Жаргал

Монгол орчуулгын эрхийг © 2024 Намхайнямын Жаргал эзэмшдэг.
Бүх эрхийг хуулиар хамгаалсан болно.

Энэхүү бүтээлийг Улстөрийн Нам, ТББ-аас бусад хувь хүн файл хэлбэрээр татаж авах, олшруулж, бусдад дамжуулах, хэсэгчилж эсвэл бүтнээрээ нь хэвлэх нь цөм чөлөөтэй бөгөөд гагцхүү орчуулагчийн нэрийг түүндээ дурдах ёстой. Улстөрийн Нам, ТББ хэрэглэх бол орчуулагчаас зөвшөөрөл авна.

“Эрх Чөлөөт Хүмүүст Зориулсан Номын-Сан” нэртэй вэбхуудасанд зориулж файлаар бас хэвлэв. www.libraryforfreerepeople.mn

Эдийн Засгийн Хэрэг Явдлын Хүрээлэнгийн зөвшөөрлөөр орчуулан хэвлэв.

ISBN: 978-9919-9058-6-6

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ОРШИЛ	1
Энэ юуны тухай ном вэ	1
Хэнд энэ номыг зориулсан вэ?	1
Энэ номыг хэрхэн зохиомжлов	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ:	
СОНГОДОГ ЛИБЕРАЛИЗМ, ЛИБЕРАЛ СЭТГЭГЧИД	3
Либерал гэж юу юм бол?	3
Либерал сэтгэгч гэж хэн бэ?	7
Зарим нэг голлох сонгодог либерал маргаан	8
ГУРАВДУГААР БҮЛЭГ: ЭРТНИЙ ЛИБЕРАЛ СЭТГЭГЧИД	11
Либерализмийн түрүү үеийн уг сурвалж	11
Эрх чөлөөний дундад зууны үзэл санаа	13
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:	
ОРЧИН ЦАГИЙН ЭХЭН ҮЕИЙН СЭТГЭГЧИД	16
ТАВДУГААР БҮЛЭГ: ОЮУН УХААНЫ ЭРИН	36
ЗУРГААДУГААР БҮЛЭГ: ХУВЬСГАЛЧИД, РАДИКАЛЧУУД	66
ДОЛООДУГААР БҮЛЭГ: ШИНЭТГЭЛИЙН ЭРИН	93
НАЙМДУГААР БҮЛЭГ: ОРЧИН ҮЕИЙН ЭРИН	130
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: ЧӨЛӨӨТ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ	145
АРАВДУГААР БҮЛЭГ:	
ӨНӨӨ ЦАГИЙН ЛИБЕРАЛ СЭТГЭГЧИД	184
АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ДҮГНЭЛТ	201
ЛИБЕРАЛ ЭШЛЭЛ	203

СЭТГЭГЧИД

Эртний либерал сэтгэгчид

- [1] **Лаоз** (ойр. 600 НТӨ)
Нийгэм өөрөө-бүрэлдэж зохион байгуулагддаг
- [2] **Перикл** (495–429 НТӨ)
Чөлөөт худалдаа болон чөлөөтэй нүүж шилжихийн ач тус
- [3] **Жуанг Жөү** (369–286 НТӨ)
"Хууль-тогтоогч"-ийн мэдлэг хязгаартай байдаг
- [4] **Аугаа Ашока** (304–232 НТӨ)
Шашны болон улстөрийн хүлцэхүй
- [5] **Тома Аквин**^[1] (1225–1274 он)
Жам ёсны хуулийн уламжлал
- [6] **Ибн Халдун** (1332–1406 он)
Өмч, эрх, санаачилгын ач холбогдол
- [7] **Франциско де Витория** (1486–1546 он) болон Схолостуудын
Сургаал, Жам ёсны эрх, өмчийн эрх
- [8] **Франциско Суарез** (1548–1617 он)
Төрийн хуульзүйн байдлын хязгаар; жам ёсны эрх
- [9] **I Акбар** (1542–1605 он)
Шашны хүлцэхүй

Орчны цагийн эхэн үеийн сэтгэгчид

- [10] **Эрхэм Эдвард Күүк** (1552–1634 он)
Хааны эрх мэдлийн хязгаар; буруутгагдсан хүмүүсийн эрх;

1 Thomas Aquinas -орос. бас Фома гэнэ. Уул нь Аквины Тома гэдэг.

бие даасан шүүгчдийн хэрэгцээ шаардлага

- [11] **Хюго Гроци** (1583–1645 он)
Өөрийн бие, өмчөө мэдэх эрх
- [12] **Томас Хоббес** (1588–1679 он)
Өөрийгөө хамгаалах эрх; нийгмийн гэрээний онол; харгис дарангуйлагчийг түлхэн унагаах эрх
- [13] **Жон Милтон** (1608–1674 он)
Чөлөөтэй үг хэлэх, ухамсарт байдал
- [14] **Жон Лилбөрн** (1614–1657 он) болон
- [15] **Ричард Овертон** (ойр. 1599–1664 он)
Амьдрах эрх, эрх чөлөө, өмчийн эрх; хуулийн өмнөх тэгш байдал
- [16] **Алжернон Сидний** (1622–1683 он)
Төр засаг шударга ёс, эрх чөлөөний төлөө л оршдог; харгис дарангуй хуулийг эсэргүүцэх эрх
- [17] **Жон Локк** (1632–1704 он)
Төрийн эрх мэдэл хувь хүмүүсээс үүсэж гардаг; өөрөө захиран зарцуулах өмч
- [18] **Самуэл фон Пүфендорф** (1632–1694 он)
Жам ёсны хуулийн нийгэмших явдлын үндэс^[2]; төвийн засаг захиргааг хэрэгцээгүй зүйл болгох эрх
- [19] **Виллиам Волластон** (1659–1724 он)
Өмчийн эрхийн зарчим; амьдрах эрх, аз жаргалаа хөөх эрх
- [20] **Жон Тренчард** (1662–1723 он) болон
- [21] **Томас Гордон** (ойр. 1691–1750 он)
Либерал зарчмуудыг дахин бататгаж Америк хувьсгалчдыг уриалан дуудав

Оюун Ухааны Эрин

[22] **Бернард Мандевилл** (1670–1733 он)

Өөрийн-тусыг бодох нь нийгмийн үндэс болох нь; алтруизм санаачилгыг устгадаг

[23] **Монтескю** [Шарл-Луй де Секонда] (1689–1755 он)

Эрх мэдлийг хуваах; шүүхийн зохих ёсны үйл ажиллагаа; чөлөөт худалдаа төр засгийн хязгаарлалт болох нь

[24] **Волтайр** [Франсуа-Марий Арое] (1694–1778 он)

Авилгыг шүүмжлэсэн; ёс суртахуун дахь саруул ухааны үүрэг нөлөө; хууль ёс; үг хэлэх эрх чөлөө

[25] **Франсуа Кюэснэй** (1694–1774 он)

Меркантилизмийн тухай шүүмжлэл; эрх чөлөөнөөс үүдэх нийгмийн сохирол; чөлөөт арилжаа

[26] **Бенжамин Франклин** (1706–1790 он)

Америкийн тусгаар тогтнол; жам ёсны эрх; баталгаажсан мөнгө^[3]; арилжаа худалдаа, эв найр

[27] **Дэвид Юм** (1711–1776 он)

Саруул ухаанд биш харин хэрэглээнд суурилсан нийгэм; хязгаарлагдмал-эрхтэй төр засаг

[28] **Адам Фергүсон** (1723–1816 он)

Өөрөө-тогтдог дэг журам; хөдөлмөрийн хуваарь; шинэ санаа, хөгжил дэвшил

[29] **Адам Смит** (1723–1790 он)

Меркантилизмийн эсрэг үзэл; арилжааны харилцан-хүртэх өгөөж; үл үзэгдэх гар; шударга ёс

[30] **Ричард Прайс** (1723–1791 он)

Эмэгтэйчүүдийн эрх; төр засгийн гэрээний үндэс суурь; сонгуулийн шинэчлэл

3 *sound money*

[31] Иммануэл Кант (1724–1804 он)

Эрх чөлөөнийн универсал буюу Бүх Хүний эрх⁴; хувь хүмүүс арга хэрэгсэл биш зорилго болох нь; хууль ёс

[32] Анне-Роберт-Жак Тюрго (1727–1781 он)

Тэнцвэртэй төсөв; хяналтыг устгах; үнийн субъектив онол

[33] Андерс Чайдени (1729–1803 он)

Чөлөөт худалдаа; өөрийн-тусыг бодох; үг хэлэх эрх чөлөө; зохицуулалт, дүрэм журам үгүй хийх

[34] Жосеф Прийстлий (1733–1804 он)

Үг хэлэх эрх чөлөө; шашны хүлцэхүй; иргэний болон улстөрийн эрх; боолчлолын эсрэг үзэл

Хувьсгалчид, Радикалууд

[35] Томас Пэйн (1737–1809 он)

Америкийн Хувьсгалыг дэмждэг гаргалгаа нотолгоо; хүлцэхүй; ёс суртахууны тэгш байдал; републиканизм

[36] Чезаре Беккариа (1738–1794 он)

Шийтгэлийн онол; шийтгэлийн шинэчлэл; хуульзүйн шинэчлэл

[37] Томас Жефферсон (1743–1826 он)

Салшгүй эрх; харгис дарангуйлагчийг түлхэн унагаах эрх; шашны хүлцэхүй; чөлөөт хэвлэл

[38] Никола де Кондорсе (1743 –1794 он)

Олон нийтийн сонголтын асуудал; эмэгтэйчүүдийн сонгуулийн эрх; арьсны өнгөний тэгш байдал

[39] Жереми Бентам (1748–1832 он)

Утилитарианизм; хүйсийн тэгш байдал; зохистой шийтгэл; эрхийн тухай шүүмжлэл

4 *Universal right to freedom*

- [40] **Жэймс Мадисон** (1751–1836 он)
Эрх мэдлийг зааглаж хуваах⁵; эрх өмч болох нь; цэрэгт татах явдлыг эсэргүүцсэн нь
- [41] **Каролины Жон Тэйлор** (1753–1824 он)
Жам ёсны эрх; хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засаг дор өөрийгөө захирах
- [42] **Антуан Дестү де Трэйси** (1754–1836 он)
Идеологиуд; өмчийн эрх; сүбъектив үнэ; инфляцийн-эсрэг үзэл; татаасын-эсрэг үзэл
- [43] **Виллиам Годвин** (1756–1836 он)
Анархизм; утилитарианизм; ёс суртахууны тэгш байдал
- [44] **Мэри Воллстөүнкрафт** (1759–1797 он)
Феминизм; тэгш эрх; републиканизм
- [45] **Жермайн де Стаёл** (1766–1817 он)
Ребапликч либерализм; өмч ба эрх; үндсэн хуульт хаант засаглал
- [46] **Вилхелм фон Хамболдт** (1767–1835 он)
Ёс суртахуун хөгжихөд эрх чөлөө амин чухал болох нь; харуулын-үүрэгтэй төр
- [47] **Бенжамин Констант** (1767–1830 он)
Үндсэн хуулийн харилцан хяналт, эрх мэдлийн тэнцвэр; хуульзүйн дагуу бус эрх баригчдыг эсэргүүцэх эрх
- [48] **Жан-Баптист Сэй** (1767–1832 он)
Сэйгийн хууль; эдийн засгийн ухааны нийлүүлэлтийн тал; хөгжил дэвшлийн либерал санаачилга
- [49] **Дэвид Рикардо** (1772–1823 он)
Эдийн засгийн онол; чөлөөт худалдаа; харьцангуй давуу тал
- [50] **Жэймс Милл** (1773–1836 он)
Хууль болон шоронгийн шинэчлэл; утилитарианизм;

5 *Separation of powers*

хүлцэхүй; парламентын шинэчлэл

Шинэчлэлийн Эрин

[51] **Виллиам Эллери Чаннинг** (1780–1842 он)

Жендерийн тэгш байдал; амьдрах эрх; боолчлолыг устгах

[52] **Сара Гримке** (1792–1873 он) болон

[53] **Анжелина Гримке** (1805–1879 он)

Аболиционизм [буюу боолчлолыг устгах хөдөлгөөн], эмэгтэйчүүдийн эрх

[54] **Фридрих Бастиа** (1801–1850 он)

Протекционизмын эсрэг үзэл; чөлөөт худалдаа болон хөрөнгө оруулалт; ондоо зардал^{6]}

[55] **Харрие Мартинэу** (1802–1876 он)

Либерал феминизм; либерал эдийн засагчдын санаанаасаа ургуулан бодсон төсөөлөл

[56] **Ричард Кобден** (1804–1865 он) болон

[57] **Жон Брайт** (1811–1889 он)

Чөлөөт худалдааны өгөөж; Манчестерийн Либерализм; Үр Тарианы Хуулийг хүчингүй болгуулах

[58] **Алекс де Токвилл** (1805–1859 он)

Үндсэн хуулийн шинэчлэл; хоёр-танхимт төр засаг; олонхийн засалалд тавих хязгаарлалт

[59] **Виллиам Ллойд Гаррисон** (1805–1879 он)

Аболиционизм; эмэгтэйчүүдийн эрх; идэвхигүй эсэргүүцэл

[60] **Жон Стюарт Милл** (1806–1873 он)

Сонголт хийх болон хариуцлага; олонхийн харгис дарангуйлал; үл хохироох зарчим

[61] **Харриет Тэйлор Милл** (1807–1858 он)

⁶ *opportunity cost*

*Эмэгтэйчүүдийн боловсрол болон сонгуулийн эрх;
ажилчдын хамтаараа-өмчлөх явдал*

[62] Лисандер Спүүнер (1808–1887 он)

*Зохицуулалтыг үгүй хийх, өрсөлдөөн; муу үйл гэмт хэрэг
биш; анархизм*

[63] Хенри Дэвид Төрэй (1817–1862 он)

*Иргэний үл захирагдах байдал; анархизм; аболиционизм;
олонхийн санал хураалтын шударга бус байдал*

[64] Фредерик Дүгласс (1818–1895 он)

Аболиционизм; хүмүүний сонголт, хариуцлага

[65] Густав де Молилари (1819–1912 он)

*Анархи-капитализм; төр, эрх мэдэл, давуу эрхийг шүүмжлэх
нь; хувь хүний хувийн аюулгүй байдал*

[66] Херберт Спенсер (1820–1903 он)

*Эрх чөлөө ба хөгжил дэвшил; нийгмийн эволюц буюу
хувьсал хөгжил; улстөрийн эрх; бүх нийтийн сонгуулийн
эрх*

[67] Жон Эллиот Кайрнес (1823–1875 он)

*Эдийн засгийн арга барил; төгс бус өрсөлдөөн; боолчлолын
эдийн засгийн муу тал*

[68] Эдвард Аткинсон (1827–1905 он)

*Аболиционизм; империализмийн-эсрэг үзэл; чөлөөт
худалдаа*

[69] Жозефин Батлер (1828–1906 он)

*Либерал феминизм; аливаа хязгаарлалтаас чөлөөлөх^[7]; бие
үнэлэх тухай хуулийн шинэчлэл*

7 *emancipation*

Орчин үеийн эрин

[70] **Лорд Актон** [Жон Далберг-Актон] (1834–1902 он)

Эрх мэдэл завхардаг; хувь хүн хамгийн дээд зорилго болох нь; эрх чөлөө бол зөвшөөрөл биш

[71] **Ооберон Херберт** (1838–1906 он)

Волунтаризм [буюу сайн дураараа оролцох явдлыг дэмжих хөдөлгөөн]; хамгаалах явдал бол төр засгийн цор ганц үүрэг

[72] **Хенри Жорж** (1839–1897 он)

Газрын үнэ цэнийн татвар

[73] **Карл Менгер** (1840–1921 он)

Австрийн эдийн засгийн онол; аргазүйн сүбъективизм болон индивидуализм

[74] **Брюст Смит** (1851–1937 он)

Консерватив болон либерал уламжлал; төр засаг хөндлөнгөөс оролцох явдлыг эсэргүүцэх

[75] **Бенжамин Таккер** (1854–1939 он)

Анархизм; өмчийн эрх; зохицуулалт болон төрийн хориг хяналтыг устгах

[76] **Волтаирин Де Клейр** (1866–1912 он)

Анархи-феминизм; жендерийн үүрэг болон гэрлэлтийг шүүмжлэх

[77] **Алберт Ж. Нокк** (1870–1945 он)

Стэйтизмийг-эсрэг радикал үзэл; төрийн нийгмийн эсрэг шинжтэй байр байдал

Чөлөөт эдийн засаг ба нийгэм

[78] **Лүдвиг фон Мизэс** (1881–1973 он)

Австрийн эдийн засгийн онол; социализмыг шүүмжлэх;

бизнесийн мөчлөг; хатуу валют

[79] Фрэнк Найт (1885–1972 он)

Эдийн засгийн эрх чөлөө бол суурь зүйл юм; зах зээл болон улстөрийн явц хоёулаа гажсан

[80] Изабел Патерсон (1886–1961 он)

Бүтээлч байдлыг хууль боомилдог; зохицуулалт монополь байдлыг бүтээж, бас хамгаалдаг

[81] Рөүз Вилдер Лэйн (1886–1968 он)

Хувь хүний эрх чөлөөг төр ганхуулж нураадаг; чөлөөт хүмүүсийн бүтээлч байдал

[82] Волтер Ойккен (1891–1950 он)

Ордолиберализм болон Германы эдийн засгийн гайхамшиг

[83] Сузанне Ла Фоллетте (1893–1983 он)

Либертари феминизмийн эдийн засгийн суурь үндэс

[84] Ф. А. Хаек (1899–1992 он)

Өөрөө-тогтдог дэг журам; рационал төлөвлөлтийн хязгаар; зээлийн мөчлөг

[85] Карл Поппер (1902–1994 он)

Харгис дарангуйллын түүхийн сургуулийн үндэс; хуурамч шинжлэх ухаан, үл хүлцэхүй; хүлцэхүй

[86] Айн Рэнд (1905–1982 он)

Объективизм; ёсзүй болон улстөрийн явц амьдралд үндэслэдэг; хөгжил дэвшилд эрх чөлөө шаардлагатай

[87] Исаяя Берлин (1909–1997 он)

Ёс суртахуун эсвэл улстөрийн цор ганц үнэн гэж байдаггүй; позитив-шинжтэй болон негатив-шинжтэй эрх чөлөө^[8]

[88] Роналд Көүз (1910–2013 он)

Хэлцлийн өртөг; өмчийн эрх ба зах зээлийн гарц

8 *positive and negative liberty*-Позитив эрх чөлөө гэхийн оронд ингэж буулгах нь буруу төөрөгдөл үүсгэхээс сэргийлнэ гэж санагдав.

[89] Милтон Фрийдмэн (1912–2006 он)

Монетаризм; зохицуулалтаас үйлдвэрлэгчид хождог; сургуулийн ваучер; сонголт хийх

[90] Жэймс М. Бачэнэн (1919–2013 он) болон

[91] Гордон Таллокк (1922–2014 он)

Олон-нийтийн Сонголтын Сургууль; шуналтай ашиг сонирхол ардчиллыг боомилох болно; төр засгийн бүтэлгүйтэл

[92] Муррэй Ротбард (1926–1995 он)

Анархи-капитализм; валют гаргах эрх чөлөө^[9]

Өнөө цагийн либерал сэтгэгчид

[93] Гари Беккер (1930–2014 он)

Эдийн засгийн ухааныг социологийн асуудалд хэрэглэх

[94] Израэл Кирзнер (1930–)

Ажил хэрэгч байдлын үүрэг нөлөө; эдийн засгийн онол дахь динамик байдлын ач холбогдол

[95] Жулиэн Л. Саймон (1932–1998 он)

Зах зээл хэрхэн ховор байдлыг үгүй хийдэг вэ; хүн ам эерэг нөөц баялаг болох нь

[96] Элинор Остром (1933–2012 он)

Олон нийтийн бараа үйлчилгээний менежмент^[10] дэх өөрөө-тогтдог дэг журам

[97] Волтер Виллиамс (1936–)

Нийгэм, улстөр болон эдийн засгийн либертарианизм; арьсны өнгөний тухай хуулийн бүтэлгүйтэл

[98] Роберт Нозикк (1938–2002 он)

9 free currency issuance

10 public goods management

Цомхон төр; улстөрийн явцаас өмнөх эрх; дахин-хуваарилалтын иррационал буюу ухаалаг бус байдал

[99] Хернандо де Сото Полар (1941–)

Хөгжил цэцэглэлт дэх өмчийн эрх болон институтуудийн ач холбогдол

[100] Дийдр МакКлоский (1942–)

Эдийн засгийн өсөлт дэх либерал үнэт зүйлийн үүрэг нөлөө

[101] Дэвид Д. Фрийдмэн (1945–)

Анархи-капитализм; хувийн хууль^[11]; хууль болон дэг журамд төр хэрэггүй

ЭНЭ НОМЫН ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

Иймонн Батлер тэргүүлэх судалгааны байгууллага болох Адам Смит Хүрээлэнгийн захирал билээ. Тэрбээр эдийн засаг, философи, психологийн ухааны эрдмийн зэрэгтэй бөгөөд 1978 онд Гэгээн Эндрюс Их Сургуулиас PhD авсан. 1970-аад оны дундуур Батлер АНУ-ын Төлөөлөгчдийн Танхимд ажиллаж, мөн Мичиганы Хиллсдэйл Коллежид философи зааж байв. Дараагаар нь НХУ^[1]-д ирж Адам Смит Хүрээлэнг байгуулалцжээ. Валлий Форж Сангийн Фрийдом Шагнал, мөн Үндэстний Чөлөөт Интерпрайз Шагналтан тэрбээр одоогийн Мон Пелерин Нийгэмлэгийн Нарийн Бичгийн Дарга билээ.

Иймонн олон номын, үүн дотроо анхны эдийн засагчид болон сэтгэгчид болох Адам Смит, Милтон Фрийдмэн, Ф. А. Хаек, Лүдвиг фон Мизэс, Айн Рэндийн тухай таниулга бичиг бичжээ. Тэрбээр мөн *Сонгодог Либерализмийн Цагаан Толгой*, *Олон Нийтийн Сонголт Сургуулийн Цагаан Толгой*, *Магна Харт*, *Эдийн Засгийн Австри Сургууль*, мөн *Үндэстний Цугларсан Эд Баялаг*, *Зах Зээлийн Тухайн Хамгийн Сайн Ном* зэргийг хэвлүүлжээ. Түүний Чөлөөт Нийгмийн Үндэс бүтээл нь 2014 онд Фишерийн Шагнал хүртсэн байдаг. Иймонн *Цалин болон Үнийн Хяналтын Дөрвөн Мянган Жил* болон IQ-гийн талаархи цуврал номын бүтээлийн хамтран зохиогч юм. Тэрбээр номын хэвлэл, өргөн нэвтрүүлэгт байнга оролцдог.

1 UK-Сүүлийн үед Нэгдсэн Вант Улс гэхийн Оронд Нэгдсэн Хаант Улс гэх болсон.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Оршил

Энэ номд юуны тухай өгүүлсэн вэ

Энэхүү номд хувь хүний эрх чөлөөт байдал буюу эрх чөлөө¹ний төлөө зогсдог зарим гарамгай сэтгэгчдийн амьдрал, үзэл санааг эрт цагаас авахуулаад өнөө цаг хүртэл өгүүлнэ.

Энэ либералчууд, хэрэв энэ үгийг Европ (Америк бус) утгаар ашиглавал бүгдээрээ л улстөр, нийгэм, эдийн засгийн амьдралын хамгийн дээд чухалчлах зүйл бол хувь хүний эрх чөлөөг хамгийн их байлгах, хүч хэрэглэх явдлыг хамгийн бага болгох явдал юм гэж ойлгоцгоодог. Гэвч энэ байдалд хэрхэн хүрэх тухай, мөн төр засгийн үүрэг нөлөө хэр их байх ёстой тухайд тэдний яг нарийн үзэл бодол нь өөр өөр байдаг билээ. Олон нь төр засгийн зарим эрх дарх ялангуяа батлан хамгаалах, цагдан сэргийлэх, шүүхийг явуулахад шаардлагатай гэж батлан өгүүлдэг. Бусад нь бүр төр засгийн илүү өргөн үүрэг нөлөө нийгмийн эсвэл эдийн засгийн амьдралд байна гэж ойлгоцгоодог.

Энэ номыг хэнд зориулсан вэ?

Энэхүү номыг улстөрийн ухаан, төр засаг, нийгмийн институт, капитализм, эрх, эрх чөлөөт байдал буюу эрх чөлөө, ёс суртахууны талаархи олон нийтийн хэлэлцүүлэг мэтгэлцээн сонирхдог, мөн энэхүү хэлэлцүүлгийн эрх чөлөөг-дэмжигч талыг нь ойлгож мэдэх гэсэн ухаантай жирийн уншигчдад голчлон зориулав. Бас энэ номыг чөлөөт нийгмийн зарчмуудыг нилээд ухаарч мэдсэн ч энэхүү концепцийг хэлбэржүүлж гаргасан үзэл санаа, сэтгэгчид, сэтгэлгээнийх нь сургуулиудын талаар илүү ихийг мэдэхийг хүссэн хүмүүст зориуллаа. Энэ номын зорилго

1 *liberty* -Англи хэлэнд *liberty* болон *freedom* гэсэн үгсийг хооронд нь сэлгэн нэг ижил утгаар хэрэглэдэг.

бол ямар ч шинжлэх ухааны маягтай эшлэл тайлбар, лавлагаа хэрэглэгдэхүүн эсвэл тайлбар толь үгүйгээр жирийн үгээр энэхүү мэдлэгийг түгээх явдал юм.

Гэлээ гээд энэ ном дунд сургуулийн сурагч, эдийн засгийн ухаан, улстөрийн ухаан, ёс зүй, философийн их сургуулийн оюутнуудад радикал үзэл санааны бүрдэл, тэдгээрийг гаргасан сэтгэгчдийн тухай богинохон оршил мэдээлэл агуулсан болно. Энэ номд нийгэм хэрхэн бүтэх ёстой тухай мэдээлэл олгох, шүүмжлэлт эргэцүүлэл бүхий мэтгэлцээн өдөөх олон зүйл бий.

Энэ номыг хэрхэн зохиомжлов

Либерал бодол санааны гол элементүүдийг дүрсэлсний дараагаар энэ номд либерал сэтгэгчдийг төрсөн цаг үеэр нь харууллаа. Энэ байдал нь либерал үзэл санаа хэрхэн цаг хугацааны туршид хувьсаж өөрчлөгдсөн талаархи төсөөллийг өгнө. Гэвч либерал бодол санааны хөгжлийн явц шулуун дардан байсангүй. Либерализм бол тогтчихсон сургаалын бүрдэл биш харин одоо хүртэл үргэлжилж буй мэтгэлцээн маргааны хэлхээ юм. Ихэнхидээ л нэг асуудлын талаар дэвшил гарсны дараагаар нь хэдэн арван жилийн туршид зарим нэг өөр сэтгэгч шинэ эргэлт гаргах хүртэл тэр нь зогсонги байдалтай оршдог. Дээр нэмэхэд зарим сэтгэгчид олон өөр сэдэвт хувь нэмрээ оруулсан байдаг. Тиймээс либерализмийн сэтгэгчдийг жагсаан бичих төгс арга зам гэж үгүй. Нэгэнт л энэ номын зорилго хувь хүмүүс, тэдний хувь нэмрийн талаар өгүүлэх явдал тул он цагийн дарааллын арга барилыг сонгон авлаа.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: СОНГОДОГ ЛИБЕРАЛИЗМ, ЛИБЕРАЛ СЭТГЭГЧИД

Энэ номд өгүүлсэн сэтгэгчид бол ихэнхи Америкчууд “либерал” гэж дууддаг тэр хүмүүс *биш*. Энэ хүмүүс болон тэр Америк либералчууд хувийн эрх чөлөөг чухалчлах явдалд санал нийлдэг ч Америк либералчууд нь үүнд хүрэхийн тулд нийгэм болон эдийн засгийн амьдралд төрийн илүү их интервенцийг дэмждэг ажээ. Иймэрхүү интервенцэд нь эд баялаг эсвэл орлогын дахин-хуваарилалт, ажилчид болон үйлдвэрлэлийн салбарт тусгай дэмжлэг үзүүлэх, хамгаалах, олон нийтийн бараа үйлчилгээг янз бүрээр олгох, зах зээлийг зохицуулах, хүмүүсийг өөрсдийн үйлдлээс хамгаалах явдал орж болно.

Хэдийгээр энэ номд жагсаан дурдсан либералчууд бусдын сайн сайхны төлөө бас л энэ хэмжээгээр сэтгэлээ чилээдэг ч гэсэн тэд ийм бодлогоос өөр бодлого санал болгодог. Тэд эдгээр бодлогыг эрх мэдэлтэн засаг захиргаанд хэт их эрх мэдэл олгох, иргэдээ чөлөөтэй эрх чөлөөтэй насанд хүрсэн хүн гэхээсээ илүү хүүхдүүдтэй адил хандах явдал эрх чөлөөний дайсан гэж ханддаг бас үздэг бөгөөд төр засгийн интервенцээс (голдуу байдагчлан) урьдаас харагдахгүй, хүсүүшгүй сүйрүүлэх үр дагавартай байх боломжтой гэдэгт итгэцгээдэг.

Либерал гэж юу юм бол?

Энэ утгаар либералчуудыг нэгтгэдэг хэдэн гол зарчмыг энд дурдая.

Эрх чөлөөг хамгийн их болгох. Либералчууд бид хувь хүний эрх чөлөөг хамгийн их болгохыг оролдох ёстой гэдэгт итгэдэг. Хүмүүс тэдний хүссэнээр, хаана сонгосноороо чөлөөтэй амьдрах, итгэл үнэмшлээ чөлөөтэй сонгох, чөлөөтэй ярьж хэлэх боломжтой байх, нэг нэгтэй чөлөөтэй арилжаа худалдаа хийх,

хамтдаа эвсэх цуглах, улстөрийн явцад оролцох, өмч өмчлөх, үйлдвэрлэсэн зүйлээ өөрөө өмчлөх хадгалах, дур зоргоор баривчлах эсвэл хохирол учруулах аюулаас ангид амьдрах нь чөлөөтэй байх ёстой. Тэдэнд бусад хувь хүмүүс эсвэл засаг захиргаанаас зөвхөн *хамгийн бага зайлшгүй хэрэгцээтэй хязгаарлалт* ирэх ёстой.

Хувь хүнийг чухалчилж үзэх. Хоёрдохь зүйл бол либералчууд *хамт олноос хувь хүнийг илүү чухал* гэж ойлгодог. Зөвхөн хувь хүн л алсын бодол, зорилго, ашиг сонирхолтой байдаг. Бүлэг хүнд байдаггүй: бүлэг хүн бол зөвхөн хувь хүмүүсийн бөөгнөрөл юм. Бид хувь хүмүүсийн ашиг сонирхлыг зарим нэг засаг захиргаа эрх мэдэлтэн эсвэл мэргэжилтэн эсвэл улстөрийн лидер удирдагчийн хэлсэн нийгмийн ашиг сонирхол гэдэг зүйлийн төлөө золиосолбол хувь хүмүүс эзэрхэг дарангуйлагчид заналхийлэлд өртөх болно.

Хүлцэх. Гуравдахь зүйл бол либералчууд *хүлцэх явдлыг* өмгөөлж хамгаалдаг – энэ бол тэдгээр үйлдлийг бид таалдаггүй эсвэл тэр хүмүүстэй санал нийлдэггүй учраас л хүмүүсийн үйлдлийг хориглох ёсгүй гэсэн үг юм. Хүн бүр бусад хүмүүс үзэл бодол болон үг хэл, амьдралын хэвмаягийг нь ёс суртахуунгүй эсвэл дайрч доромжилсон гэж үздэг байсан ч гэсэн өөрийн үзэл бодолтой байх, өөрийн бодсоноо ярих, сонгосноороо чөлөөтэй амьдрах ёстой. Хүмүүс бүр бусад хүмүүс тэднийг хорлон сүйтгэгч галзуу^[1] гэж бодож байсан ч клуб эвлэл эсвэл улстөрийн намд нэгдэж цуглах нь чөлөөтэй байх ёстой. Тэд бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээгээ, үүн дотроо (мансууруулах бодис буюу хар тамхи, мөрийтэй тоглох, биеэ үнэлэх) өргөн хэмжээнд хүлээн таашаадаггүй ийм зүйлсээ арилжих нь чөлөөтэй байх ёстой. Хүмүүс бүр дийлэнхи олонхи нь дургүй байсан ч гэсэн хүссэн шашнаа шүтэх нь чөлөөтэй байх ёстой.

Албадлагыг хамгийн бага болгох. Дөрөвдөх зүйл бол либералчууд *албадлагыг хамгийн бага байлгахыг* хүсдэг.

1 *subversive crackpots*

Тэд хүмүүс хүч хэрэглэдэг эсвэл бусдыг захирахын тулд хүч хэрэглэхээр заналхийлдэг ертөнцийг биш харин эв найртай санал нийлэх явдлаар бидний цогцлоодог ертөнцийг хүсдэг. Либералчууд төрийн шүүх эрх мэдэл, төрийн татварлах, эсвэл торгох, эсвэл шоронд хорих эсвэл өөр бусад байдлаар иргэдээ албадах эрх мэдлийг зайлшгүй хамгийн бага хэмжээтэй байлгах ёстой гэдгийг сахин хамгаалдаг: үгүй бол Лорд Актоны тэмдэглэж хэлснээрээ эрх мэдэл буруугаар ашиглагдах хандлагатай байдаг.

Төлөөллийн, хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засаг. Тавдахь нь либерал үзлийн өргөн хүрээний зарим либерал үзэлтэн ерөөсөө төр засгийн хэрэгцээ байхгүй гэж харж байхад ихэнхи либералчууд төрийн чухал үүрэг нөлөө байдаг гэдэгт итгэдэг. Гэвч тэр нь хязгаарлагдмал эрхтэй үүрэг, ө.х. хувь хүмүүсийг бусад иргэдийн эсвэл гаднын хүчний хүчирхийлэл болон хулгай дээрмээс хамгаалах, мөн хулгай дээрэм гарах эсвэл хүчирхийлэл гарахад шударга ёсыг хэрэгжүүлэх зэрэг үүрэг л байдаг.

Төр ёс журам юу байхыг хэн шийдэх, мөн тэдгээр ёс журмыг хэрхэн албадан хэрэгжүүлэхийг сонгох болоход ихэнхи либералчууд төлөөллийн, үндсэн хуулийн ардчиллыг өмгөөлж дэмждэг. Энэ байдал бол тэдний хэлэхээр төр засаг өөрийн эрх дархаа түүнийг бүтээдэг хувь хүмүүсээс л зөвхөн хүлээж авдаг гэдгийг явдлыг илэрхий болгодог ажээ. Төр засаг бол хүмүүсийн зарц болохоос ноён нь биш юм. Албаны эрх мэдлийг хэрхэн ашиглаж болохгүйг тусгайлан заадаг үндсэн хууль болон төлөөлөгчдийг нь албан байрнаас нь зайлуулдаг чөлөөт сонгууль бол энэхүү харилцааг сахин хамгаалахад зориулж одоохондоо олж нээсэн хамгийн сайн арга зам билээ.

Хууль ёс^[2]. Зургаадахь зүйл бол либералчууд хууль ёсыг шаргуу ятгадаг. Хуулийг жендер, арьсны өнгө, хэл яриа, гэр бүл эсвэл аливаа бусад тохиромжгүй шинж чанараас үл хамаарч хүн бүрд тэгш хэрэглэх ёстой. Хуулийг төр засгийн албан тушаалтанд жирийн хүнд хэрэглэдэгтэй яг адилхан байдлаар хэрэглэх ёстой.

2 *Rule of law*

Энэхүү зарчмыг батлан хамгаалахын тулд, мөн эрх мэдэлд буй хүмүүс хуулийг өөрийн ашиг тусыг төлөө залж чиглүүлэхээс сэргийлэхийн тулд ижил тэгш хандах, хувь хүний халдашгүй байдал^[3], иргэдийн төлөөлөгчдөөр шүүлгэх, шүүхийн зохистой үйл ажиллагаа^[4], тохирох ял шийтгэл оноох зэрэг шүүхийн үндсэн зарчим байх, тэдгээр нь хэрэгжих ёстой байдаг.

Өөрөө-тогтдог дэг журам. Долоодохь зүйл бол либералчууд хүмүүний институтууд ухамсартай төлөвлөлт гэхээсээ илүүтэй голчлон өөрөө-тогтох байдлаар ургаж гардаг гэж батлан өгүүлдэг явдал юм. Хэн ч албадмал байдлаар зах зээл, үнийн тогтолцоо, мөнгө, хэл яриа, шударга ёсны ёс журам эсвэл нийтийн хуул^[5]ийг зохион гаргаагүй. Эдгээр зүйл тэдгээр нь үр ашигтай байсан учраас л хувь хүмүүс хоорондын тоо томшгүй харилцаанаас зүгээр л үүсэж гарч, хувьсаж хөгжсөн байдаг. Тариан талбайг туулах хамгийн хялбар замнал зам хайж буй хүмүүсийн давалгаан дор гишгэгдэж үлдсэн хөлийн мөр адилаар иймэрхүү институтууд хүмүүний төлөвлөсөн бодлын үр дүн бус харин хүмүүний үйлдлийн үр дагавар байдаг. Эдгээр зүйл бол өөрөө-тогтдог дэг журмын жишээ юм – ийм дэг журам бол голдуу маш нийлмэл байдаг ч тэдгээрийг бүтээх, удирдан залахад эрх мэдэлтэн засаг захиргааны удирдамж хэрэггүй байдаг бүтэц билээ. Үнэндээ төр засгийн үйлдэл л эдгээр тогтолцоог улам ухаалаг болгох гэхээсээ илүүтэй бусниулж түйвээх нь элбэг.

Чөлөөт зах зээл. Наймдахь зүйл бол либералчууд зах зээлийн өөрөө-тогтдог дэг журмаар хувь хүмүүсийн харилцан ашигтай хамтын ажиллагаагаар эд баялаг бүтээж бий болгодог гэдгийг сахин хамгаалдаг явдал юм. Хөгжил дэвшил хувь хүмүүс шинийг зохион бүтээх, бүтээж үйлдвэрлэх, хадгалж хураах, хөрөнгө оруулах, харилцан ашигтайгаар эд зүйлээ солилцох үеэр гардаг ажээ. Бидний эдийн засгийн дэг журам үнэнч шударга байдал, өмчийг хүндлэх зэрэг энгийн ёс журмаас ургаж гардаг.

3 *habeas corpus*

4 *due process*

5 *common law*

Иргэний нийгэм. Ес дэх зүйл бол либералчууд сайн дурын эвлэлдэн нэгдэх явдал төр засгаас илүү сайн хүмүүсийн нийгмийн хэрэгцээг хангадаг гэдэгт итгэдэг явдал юм. Тэд хувь хүмүүсийн ач холбогдлыг өсгөхийн хажуугаар бас хувь хүмүүс гэр бүлийн гишүүн, мөн клуб, эвлэл, холбоо, шашин, сургууль, онлайн бүлгэм, кампанит буюу ухуулан таниулах ажил, буяны байгууллага зэрэг бүлгийн гишүүн байдгийг хүлээн зөвшөөрдөг. Иргэний нийгмийн эдгээр өөрөө-тогтдог институт бидэнд төвлөрсөн төр засгаас албадмал байдлаар байгуулсан эв хавгүй институтүүдээс илүүтэй асар том, хамаагүй өргөн хүрээнд хамтран ажиллах боломж олгодог.

Эрх мэдэлд эргэлзэх. Хамгийн сүүлийн зүйл бол либералчууд улстөрийн эрх мэдлийн буруугаар ашиглах явдлын үр нөлөөний талаар санаа зовнидог. Тэд чөлөөт нийгмийн хувьд хамгийн хэцүү асуудал нь эрх мэдлийг тархааж өгөх биш харин ийм эрхтэй болсон хүмүүсийг хэрхэн хязгаарлах вэ гэдэг асуудал байдаг гэж ойлгодог. Либералчууд улстөрчид болон албан тушаалтнууд бурхан биш, бас олон нийтийн ашиг сонирхлын чигч шударга хамгаалагчид биш гэж үздэг. Үүнээс илүүтэй тэд бүгдээрээ өөрийн ашиг сонирхолтой, бас улстөрийн эрх мэдлээ хувийн ашиг сонирхлоо урагшуулах ахиулахад ашиглах гэсэн цуцашгүй санаатай байдаг.

Либерал сэтгэгч гэж хэн бэ?

Товчхондоо бол либералчууд хөгжин цэцэглэж буй, харилцан биесээ хүндэтгэдэг нийгмийн өөрөө-тогтдог дэг журам, түрэмгийлэл үл үйлдэх, чөлөөт хүмүүс хамтран ажиллах хийгээд сайн дураараа солилцоо хийхэд итгэдэг. Ихэнхи нь энэ итгэлээ хувь хүний амьдрах суурь ёс суртахууны эрх, итгэл даах шүүхийн хүчтэй тогтолцоогоор хамгаалагдсан эрх чөлөө, өмчид тулгуурладаг бас үндэслэдэг. Либералчууд үг хэлэх эрх чөлөө, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, хууль ёс, хувь хүний эрх чөлөөнд халдаж буй эрх дархтай хүмүүсээс сэргийлж сэрэмжлэх төр засагт тавих хязгаарлалтын төлөө тэмцдэг. Гэвч либерализм үзэл

санаа өргөн хүрээтэй хэвээр байсаар байгаа бөгөөд либералчууд олон асуудалд хоорондоо санал нийлцгээдэггүй.

Зарим нэг голлох сонгодог либерал маргаан

Либералчуудын хувьд гол асуудал хэрэв гарах бол хувь хүний эрх чөлөөг хумих явдлыг юунд үндэслэх вэ гэдэг асуудал байдаг. Хүмүүст бусдынхаа ижилхэн эрх чөлөөнд халдах байдлаар юу хүссэнээ үйлдэхийг нь зөвшөөрөх боломжгүй гэдэг нь ойлгомжтой: таны гараа савах эрх чөлөө жишээлбэл миний хамарт дөхөхөөс илүү хэтрэх боломжгүй. Басхүү өмнөхтэй адилхан шалтгаанаар тонож дээрэмдэх, хууран мэхлэх, эсвэл биед нь халдах замаар бусад хүмүүсийг эрх дураараа хохироох ч боломжгүй. Гэвч олон либералчууд илүү их сайн зүйлийн төлөө жишээлбэл батлан хамгаалах, шүүх, жишээлбэл олон нийтийн ажилд зориулж татвар төлөхийг албадах эсвэл бусад хүмүүсийн агаар болон усыг бохирдуулахаас сэргийлж зэргээр эрх чөлөөнд хязгаарлалт шаардлагатай байж, зарим нэг нэмэлт хязгаарлалт эрх чөлөөнд тавих боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Эрх чөлөө ба олон нийтийн бараа үйлчилгээ⁶. Энэ байдлаас “олон нийтийн” асар сайн бараа үйлчилгээ гэж юу болох, хэн үүнийг шийдэх, ямар хязгаарлалт үүнд нь хүрэхэд үндэслэлтэй вэ гэдэг асуудал гардаг. Либералчуудад үүнд өөр өөр хариулт бий: зарим нэг нь эрх чөлөөнд тавих хэд хэдэн хязгаарлалтыг шаардсан ‘нийгмийн ашиг тус⁷’ байдаг гэж батлан өгүүлцгээдэг; бусад нь ийм байдлаар эрх чөлөөг хорих явдалд ямар ч үндэслэл байхгүй гэнэ. Гэлээ гээд либералчууд эрх чөлөөнд талтайгаар дээдлэх үзлийг явуулах хэрэгтэй, эрх чөлөөг хязгаарлахыг эрэлхийлж буй хүн бат нот шалтгаанаа үзүүлэх ёстой гэдэгт санал нэгддэг. Мөн тэд төр засагт эдгээр асуудлыг шийдвэрлэх боломж олгох нь ухаангүй хэрэг гэдэгт санал нийлцгээдэг. Учир нь илүү их засаглах, илүү бага эрх чөлөөтэй байлгах явдлыг төр

6 *public good*

7 *social utility*

засаг өмгөөлж хамгаалах хандлагатай байдаг.

Эрхийн шинж байдал, хязгаарлалт. Зарим либералчууд хувь хүний эрхүүд эрх чөлөөг хэр зэрэг хэмжээгээр хумих тухай хязгаарлалтыг тогтоодог гэж үздэг. Тэд амьдран суух эрх, эрх чөлөө буюу эрх чөлөөт байдал, ухамсартай байдал, өмчид хэн ч, үүн дотроо төр засаг ч халдах боломжгүй гэж шаргуу хэлдэг. Гэвч энэ байдлаас эдгээр эрх нь чухам юу болох, хэн хэрэг явдлыг шийдвэрлэх тухай, мөн энэ эрхүүд хаанаас гардаг, хэзээ тэдгээрийг давж дарах, тэр үед эдгээрийг юунд үндэслэх тухай нэг ижил асуулт урган гардаг.

Зарим либералчууд эрхүүдийг хүмүүн төрөлтний нэг хэсэг гэж ойлгодог; зарим нь эдгээр эрхийг тэдгээрийн нийгмийн хувьд ашиг тустай байдал эсвэл бүх нийтийн аз жаргал зөвтгөдөг, бас үндэслэлтэй болгодог гэж боддог; зарим нь бас эдгээр эрхийг биднийг хязгааргүй эрх мэдэлтэй төр засгийн хөнөөлтэй үйлээс хамгаалдаг (хэдийгээр эдгээр зарчмыг нээлттэй хэлэлцэж буй ч гэсэн) ёс суртахууны зарчим гэж хардаг; бусад нь ерөөсөө эдгээр эрх байдаг эсэхэд эргэлздэг. Гэвч хувь хүний эрхийн үзэл санааг зөвшөөрдөг либералчууд тэр эрхүүдийг зөвхөн онцгой тохиолдолд нөхцөл байдалд л үл хэрэгсэх, мөн эдгээр эрхийг зөрчсөн аливаа үйлдэл үргэлж сайтар үндэслэлтэй байх ёстой гэдэгт санал нэгдэцгээдэг.

Эрх мэдлийг хумих. Ихэнхи либералчууд төрөөс хүч хэрэглэхэд зориулагдсан үүрэг төрд бий гэдэгт итгэцгээдэг. Үүнээс нь энэхүү эрх дархны зорилго болон хязгаарын талаар, хэрхэн үүнийг хүрэн дотор байлгах тухай бүр их маргаан мэтгэлцээн гардаг. Энэ зорилгын үүднээс төр эрх мэдлээ дур зоргоороо ашиглахаас сэргийлдэг хууль ёсыг либералчууд хүндэлж дэмждэг. Зарим нь төрийн бүрэн эрхийг төр үйлчилдэг зөвхөн тэр хувь хүмүүс олгодог, мөн тэр хувь хүмүүс хэрэв төр засаг нь эрх дархаа хэтрүүлбэл түүний эсрэг хуульзүйн дагуу босож тэмцэх болно гэдгийг илэрхийлдэг. Гэвч дахиад л хэзээ яг ийм зүйл болох вэ?

Эдгээр асуулт болон бусад олон асуултад тогтчихсон нэг хариулт байдаггүй. Мэдээжийн итгэлтэй хэлж болох зүйл

бол либералчууд эдгээр мэтгэлцээн хэлэлцүүлэгт эрч хүчтэй оролцдог, шинэлэг байдлаар оролцдог, оролцсон хэвээр байх болно гэдэг зүйл юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ЭРТНИЙ ЛИБЕРАЛ СЭТГЭГЧИД

Либерализмийн түрүү үеийн уг сурвалж

Эрх чөлөө бол универсал үзэл санаа^[1] юм. Эрх чөлөөний үзэл санаа бараг бүх шашин, соёлд, Даоизмаас авахуулаад Исламаар дамжин Буддизмд хүртэл; дэлхий даяар Азиас авахуулаад Ойрхи Дорнодоор дамжин Өрнөд хүрсэн газар нутагт хүчтэй үндэслэж суужээ.

Эртний хятадын эрдэмтэн [1] **Лаоз**, заримдаа Лао Цзу эсвэл Лао-Цзе (ойр. НТӨ 600 он) бол Даоизмын үндэслэгч билээ. Өөрийн Тао Те Чинг^[2] гэсэн бүтээлдээ тэрбээр хүмүүний амьдрал өөр өөр хүчний нийлмэл тэнцвэрийн үр дүн байсан гэж батлан өгүүлсэн. Энэхүү тэнцвэрт хөндлөнгөөс оролцсон удирдагч өөрийн зориогүй үр дагаварт хүрэх болно. 'Бүх зүйлд хажуугаас нь оролцож, хүрч тэмтрэх нь буруугаар эргэж, сэтгэл гутралд хүргэх болно' гэж хэлээд тэрбээр дараахь зүйлийг бичсэн байдаг:

Хууль эсвэл албадлага байхгүйгээр хүмүүс амьдран суух болно ... Хориглох зүйл арвин байх тусам хүмүүс улам л ядуурна. Хуулийг ихээр томъёолон гаргах тусам тэнд хулгайч дээрэмчид улам олон болно. Тиймээс л ухаантай удирдагч дараахь зүйлийг хэлдэг: 'Би юу ч санаатайгаар үл хиймой, ард олон өөрсдөө өөрчлөгдөх болно. Би дуугүй байхыг илүүд үзнэ, ард олон өөрсдөө зөв болцгооно. Би санаа үл зовно, хүмүүс өөрсдийгөө баян болгох болно ...'

1 universal idea- бүх нийтийн үзэл санаа: энэ нь бүх газарт, бүх хүнд хамаатай гэсэн утгыг илэрхийлдэг.

2 Тао Те Чинг-"Арга зам ба нэр төрийн тухай ном" гэсэн утгатай, Даоизмын философи болон шашны 81 бүлэгтэй ариун судар ажээ.

Европт сонгодог Герег, эртний Ром нь либерал нийгэм байсангүй. Бүр ‘ардчилсан’ Афинд ч зөвхөн цөөн хүнээс бүрддэг цөөнхи л үнэндээ шийдвэр гаргадаг байсан. Хүмүүс хувийн ашиг сонирхлоо төрдөө захируулдаг гэж боддог байлаа. Гэлээ гээд цуу алдарт Афинчууд либерал үзэл санааг чангаар ярьсаар хэлсээр л байсан байдаг. Цэргийн генерал, уран илтгэгч **[2] Перикл** (НТӨ 495–429 он), жишээлбэл хуулиар бүх хүнд хэдийгээр тэд өөр өөр байсан ч гэсэн ижил тэгш шударга ёс олгох ёстой гэдгийг хэлэв. Тэрбээр хөршүүдээ хүлцэн тэвчихийг уриалж байлаа. Перикл чөлөөт худалдаа, чөлөөтэй шилжих нүүх явдлын ашиг тусыг дараахь байдлаар цохон хэлсэн: ‘Бид хотоо дэлхийд нээж орхино, хэзээ ч хэдийгээр дайсны нүд хааяа хааяа бидний өгөөмөр зангаас ашиг тус олж харж болох ч гэлээ суралцах эсвэл ажиглаж мэдэх явдлаас харь хүмүүсийг харилгах үйлээр орхигдуулах ёсгүй’. Гэвч түүний итгэж байсанчлан энэхүү тэгш байдал, хүлцэхүй, нээлттэй байдал Афинчуудад хор болсонгүй; харин энэ нь илүүтэй түүний аугаа байдлыг ихэсгэв.

Бас л Хятадын нэр нөлөөтэй философич **[3] Жуанг Жөү** буюу **Жуангци** (НТӨ 369–286 он) бидний мэдлэг хязгаарлагдмал, бидний үнэт зүйл хувь хүний л зүйл байдаг гэж батлан өгүүлжээ. Орчин үеийн либералчууд эдгээрийг яагаад засаг захиргаа хүмүүсийн амьдралд хөндлөнгөөс оролцох ёсгүй гэдгийн чухал шалтгаан гэж ойлгодог. Жуанг Жөү дараархь зүйлд санал нийлж байсан: тэрбээр дэлхийг ‘удирдах хэрэгцээ байхгүй; үнэндээ дэлхийг удирдах ёсгүй’ гэсэн байдаг.

Энэтхэгт мөн л эзэн хаан **[4] Аугаа Ашока** (НТӨ 304 – 232 он) эрх чөлөө, хариуцлагатай байдал, улстөрийн болон шашны хүлцэхүйг шаардаж уриалж байв. Тэрбээр магадгүй үүнийг гүрэн улсынх нь нарийн нийлмэл нийгмийг бүрдүүлж буй угсаатны олон бүлэг (Брахман, Шраманас, Кшатрия) болон үзэл санаа (Буддизм, Данизм, Ажикивизм)-нуудын хоорондохь хурцадмал байдлыг зөөллөх арга зам гэж харж байсан байж болох юм – ингэхдээ тэрбээр харилцан хүндлэл болон эв найр бол дайнаас илүү зүйл гэж батлан өгүүлж байжээ.

Эрх чөлөөний талаархи дундад зууны үзэл санаа

Англид тавдугаар зууны орчмоос нааш Англи-Саксончууд өмчийн өмчлөх эрхийн сайн-хөгжсөн тогтолцоо^[3]той байсаар иржээ. Эзэн хаан нь ч мөн л хязгаарлагдмал эрхтэй байсан: зарим хаадыг нь цэцдийн зөвлөл болох, мөн хаадын эрх мэдлийг хязгаарыг тогтоодог Витан томилдог байв. Хэдийгээр эдгээр эрх, хязгаарлалт 1066 онд [тус арлыг] Норманчууд эзлэн түрэмгийлэхэд устаж алга болсон бөгөөд эдгээр эрх хязгаарлалтыг өмчийн эрх болон шүүхийн чухал зарчмуудыг тодорхойлж гаргасан “аугаа тунхаг” болох 1215 оны *Магна Харт* буюу *Эрх Чөлөөний Тунхаг*^[4]т дахин гарч ирсэн байдаг. Хожим нь хаад өөрсдийн эрх мэдлээ дахин бататгахаар оролдож эрэлхийлсэн ч арвандолоодугаар зуунд **Эрхэм Эдвард Күүк**^[5] Магна Хартын зарчмуудыг сэргээн амилуулсан билээ – энэ нь өнөө ч Англиар-ярьдаг ертөнцөд гүн үндэслэсэн хэвээр л байна.

Италид Доминикан ламтан^[6] **[5] Тома Аквин** (1225–1274 он) *жам ёсны хуул*^[7]ийн тухай үзэл санааг илэрхийлэв. Бүх хүмүүн өөрсдийн жам ёсондоо үнэнч байх ёстой гэдэгт тэрбээр итгэж байжээ. Нэгэнт л хүмүүн рационал буюу эрүүл ухаантай бодгаль тул энэ нь бид өөрсдийн оюун ухаанаа ашиглаж бидний жам ёсны зорилгоо олж нээх, үүндээ хамгийн сайнаар хэрхэн хүрэхээ мэднэ гэсэн үг юм. Энэ нь эргээд бид чөлөөтэй сэтгэж бодох ёстой гэдгийг харуулдаг. **Айн Рэнд** долоон зууны дараа эдгээр үзэл санааг хөгжүүлэх болно.

Ойрхи Дорнодод болон түүнээс хальж тархсан газартаа,

3 *system of property tenure*

4 *American Declaration of Independence-Энэ баримт бичгийн Монгол орчуулгыг www.libraryforfreepople.mn гэсэн вэбхуудаснаас үзнэ үү.*

5 *Sir Edward Coke-Энэ номын бичигт бүдүүн үсгээр бичсэн нэр гарвал энэ нь энд өгүүлж буй 101 эрхмийн нэг болохыг илэрхийлнэ.*

6 *Dominican friar-Энэ хүний нэрийг Оросууд Фома гэх нь бий. Уул нь Аквины Тома гэж бичих учиртай.*

7 *natural law*

долоодугаар зуунд анх үүсэж эхэлсэн цагаасаа эхлэн Ислам нь Өрнөдийн ертөнцөд эдгээрийг үнэт зүйл гэж хүлээн зөвшөөрөхөөс хамаагүй өмнө эдийн засгийн эрх чөлөө болон чөлөөтэй аж ахуй эрхлэх явдалд нээлттэй байсан. Дундад зууны Түрк эзэн хаад тэр цаг үеийнхээ Европын эзэн хаадыг бодвол голдуу л хүлцэн тэвчих байдалтай байсан. Исламын эрдэмтэн, хуульч [6] **Ибн Халдун** (1332–1406 он) төр засаг эсвэл бусад хүмүүс хүмүүсийг ашиглаж мөлжих явдал ажил явуулах, хадгалж хураах, хөгжих дэвших явдлын асар их саад болохыг ойлгож мэджээ:

Хүмүүсийн өмч рүү халдах нь өмч олж авах, өмчтэй болох санаачилгыг үгүй хийдэг. Хүмүүс тэр үед өмчтэй болохын цор ганц үр дагавар бол бусдад үүнээ алдах явдал юм гэж дүгнэнэ. Өмчтэй болох гэсэн санаачилга алга болоход хүмүүс өмчтэй болох гэж хүч хөдөлмөр гаргахаа болино. Өмчийн эрхэд халдаж буй цар хүрээ болон зэрэг нь тухайн улсын албатуудын өмч олж авах гэсэн хүчин чармайлт хорогдох хэмжээ болон зэргийг тодорхойлдог.

Испанид [7] **Франциско де Витория** (1486–1546 он)-ийн бүтээлээс үүсэж гарсан *Саламанкагийн Сургуулийнхан*^[8] түрүү үеийн сүмийн ламтнууд^[9]ын үзэл санааг нийгэм, улстөр, эдийн засгийн Сэргэн Мандалтаас дэлгэрч гарсан бодит байдалд хэрэглэхийг оролдсон. Ингэж оролдох үеэрээ тэд, эдгээр схоластууд^[10] ерөнхий либерал бүтцийг гаргаж иржээ. Тэр үед тэднийг ингэж схоластууд гэж дууддаг байв. Испанийн Иезүт лам [8] **Франциско Суарез** (1548–1617 он) жишээлбэл жам ёсны хуулийн талаархи үзэл санааг улам цааш нь хөгжүүлсэн бөгөөд энэ нь амьдран суух жам ёсны эрх, эрх чөлөө, үзэл бодлоо эрх

8 *School of Salamanca*

9 *clerics*

10 *scholastics*- сургуультнууд гэж болох юм

чөлөөг илэрхийлдэг гэж батлан өгүүлж байлаа.

Тэрбээр мөн хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засгийн төлөө мэтгэлцэж байв. Нийгмийн амьтан болохынхоо хувьд бид нийтлэг зорилгын төлөө ажиллахын ашиг тусыг ойлгох ёстой гэдгийг тэрбээр тайлбарлажээ. Тиймээс бид улстөрийн төр байгуулж бүтээн, шийдвэр-гаргах эрх мэдлийг ямар нэгэн эзэн хааны эрх мэдэлд засаг захиргаанд өгдөг ажээ. Гэвч нэгэнт л эзэн хааны эрх мэдэл хүмүүсээс түүнд очдог тул хүмүүс эзэрхэг дарангуй эзэн хаадаа түлхэн унагаах эрхтэй. Энэхүү *нийгмийн гэрээний* тухай түрүү үеийн үзэл санаа хожмоо **Жон Локк, Хюго Гроци** зэрэг либерал сэтгэгчдэд нөлөөлөв.

Энэхүү схоластуудын хөдөлгөөн хоёр зуун жил цэцэглэн хөгжсөн. Хожим нь гишүүд нь эдийн засгийн *эрх чөлөөт байдал буюу эрх чөлөөнд* анхаарал хандуулсан байдаг. Тэд нийт нийгэм үр шимийг нь хүртэх тийм байдлаар хувийн өмчлөгч өмчтэй илүү сайн харьцдаг гэсэн үндэслэлээр хувийн өмчийн өмчлөлийг хамгаалж байлаа. Тэд мөн бараа бүтээгдэхүүний үнэ түүнийг бүтээж буй зардлаас зөвхөн хамаарахгүй бас түүний эрэлтээс хамаардаг гэж батлан өгүүлж байв – хэн нэгэн үүнийг нь ‘нийтийн үнэлгээ’ гэсэн байдаг. Схоластууд түрүү үеийнхээ ламтнуудыгаа бодвол зээллэг болон зээлийн хүүнд илүү талтай байсан бөгөөд зээл одоо хөрөнгө оруулалт (хийгээд зөвхөн хэрэглээг биш)-ыг санхүүжүүлж байна, мөн хүүгийн хэмжээ зээлдэгчид тулгарах эрсдэл болон олж авах боломжийг харуулдаг гэж таньж мэдсэн байв.

Энэ үед Могул Гүрний лалын шашинт удирдагч **[9] I Акбар** (1542–1605 он) хүлцэхүйн тухайд либерал дүгнэлт хийж байсан бөгөөд хүлцэх явдлыг Хиндү, Иезүтүүдэд бүр тэр үед Европд шашны тэрс үзэлтнүүдээ Залхаан Цээрлүүлэх Зөвлөл нь цаазалж байх тэр үед ч хамаатуулан хэрэглэж байсан байдаг^[11].

Эндээс харвал либерал үзэл санаанд хил хязгаар байдаггүй ажээ.

11 *Их Монгол улсын өв байж болох уу?*

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ОРЧИН ЦАГИЙН ЭХЭН ҮЕИЙН СЭТГЭГЧИД

Арванзургаа болон арвандолоодугаар зууны Англи либерализм өсөж өндийх магадлалгүй газар байлаа. Шашны маргаан, эзэн хаадын өв залгамжлагчдын зөрчилдөөн, гадаадын дайн Тюдорын эзэн хаад^[1]ад английн уламжлалт Англи эрх чөлөө буюу эрх чөлөөт байдалд сэтгэл бага л чилээхэд хүргэжээ. 1603 онд тэднийг залгамжилсан Стюартынхан ч бүр үүнийг мэдрэх ч үгүй байв: Скотынхон байснаараа тэд Английн нийтийн хуулийн уламжлалтай санал нийлцгээсэнгүй; тэд эзэн хаадын абсолют буюу үнэмлэхүй байдлын тухай эхгазрын үзэл санааг шингээн авч шүүх дээр Францаар ярьцгааж байв. Тэд гэсэн ч зардлаа санхүүжүүлэх мөнгөнийхөө төлөө Парламентыг гуйж байсан нь тэдний абсолютизмд ямар нэг хязгаарлалт болж байлаа. Гэвч I Чарлз (1600–1649 он) энэхүү саад тотгорыг гаалийн татвар ногдуулах, албадсан зээл олгох (ийм зээл төлөхийг татгалзсан улсыг шоронд хорих), Парламентыг тараах, феодалын татварыг дахин амилуулах, монополь эрх зарах, аль дээр мартагдсан хуулийг зөрчсөний төлөө торгууль ногдуулах замаар давж гарахаар эрэлхийлж байсан.

Хэдийгээр аажимдаа Парламентыг дахин байгуулсан ч гэсэн Парламентын таван Гишүүнийг баривчлах гэсэн Чарлзын бүтэлгүй оролдлого гал дээр тос нэмж орхив. Парламентыг дэмжигчид болон Эзэн хааныг дэмжигч фракцуудын хооронд иргэний цуст дайн эхэлж Чарлз баригдаж, шүүхээр шүүлгэн, цаазлуулснаар дууслаа. Гэвч шинэ ‘Хамгаалагч Эзэн^[2]’ болох Оливер Кромвелл (1599–1658 он) үүнээс дутуугүй харгис дарангуй этгээд гэдгээ харуулав. 1660 онд эзэн хаант засаглалыг

1 *Tudor monarchs*

2 *Lord Protector-Албан тушаал*

сэргээн байгуулсан; гэвч Парламент болон II Чарлз, мөн түүнийг залгамжлагч аажимдаа ширээнээс бууж, улмаар зугтан одсон II Жэймсийн хооронд хурцадмал байдал үргэлжилсээр л байлаа. Бахархалт Хувьсгал гэдэг цус үл урсгасан төрийн эргэлтээр Парламент Голландын харьцангуй либерал удирдагч Оранжийн Ханхүү Виллиам (1650–1702 он), мөн түүний гэргий Жэймсийн охин Мэри (1662–1694 он) нарыг хамтарсан засаг баригч^[3] болгохоор урьж ирүүллээ. Гэвч тэд шинэ үндсэн хуулийн гэрээ, 1689 онд *Эрхүүдийн Билл*^[4]ийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болсон байдаг.

Улстөрийн түүхийн иймэрхүү гэнэтийн золгүй явдлаас болж үндсэн хуулийн төр засаг, хувь хүмүүсийн эрх болон харгис түрэмгий этгээдийг иргэд нь түлхэн зайлуулах боломжтой нөхцөлийн үндэс суурийг улстөрийн онолчид бүхэлд нь дахин авч үзэхэд хүрсэн.

[10] Эрхэм Эдвард Күүк (1552–1634 он): Англи хүн, өмгөөлөгч^[5], шүүгч, улстөрч. **Гол үзэл санаа:** Эзэн хаадын эрх мэдлийг хязгаарлах хязгаарлалт; Парламентын эрх; дур зоргын татвар байхгүй байх явдал; буруутгагдаж буй хүний эрх; шүүх байгууллагын бие даасан байдал; гэрээний хууль. **Гол бүтээл:** *Хаанд хэлэх үг* (анг. *Remonstrance to the King*) (1621 он); *Эрхийн тухай хүсэлт* (анг. *Petition of Right*) (1628 он).

Норфолкод төрсөн, Кэмбрижид боловсрол эзэмшсэн Күүк ('Cook' гэж дууддаг) хуульзүйн мэргэжлээрээ явсаар I Элизабетийн үед Ерөнхий Прокурор, түүний залгамжлагч I

3 joint sovereigns

4 Bill of Rights

5 barrister

Жэймсийн үед Хааны суудл^[6]ын Ахлах Шүүгч болж дэвшиж байлаа. Гээд тэрбээр энэ хоёртой, мөн Жэймсийн залгамжлагч, I Чарлзтай ч маргалдаж хэрэлдэж байв.

I Элизабеттэй Күүк Эзэн Хаан батлан олгодог “зөвшөөрөл” болон монополи эрх^[7]ээс болж маргалдаж байсан. Анхандаа үйлдвэрлэлийг хамгаалахад хэрэгтэй зүйл гэж байсан эдгээр зүйл талтай хүмүүстээ шан болгож өгөх, орлогоо нэмэгдүүлэх арга хэрэгсэл болсон; Английн эзэн хаад эдгээр зүйлийг бүр өдөр бүр л давс зэрэг бараа бүтээгдэхүүнд хамаатуулан өргөжүүлж байв. Күүкээр удирдуулсан Парламент 1601 онд шүүхийн эрх мэдэлд монополиудыг оруулжээ. Гэвч I Жэймс эзэн хааны эрх мэдлийг энэ байдлаар хумихыг эсэргүүцсэн бөгөөд эдгээр давуу эрхийг батлан олгосоор л байв. Күүк Парламентын хариу болгож *Хаанд Хэлэх Үг* [анг. *Remonstrance to the King*] (1621 он)-ээ бичиж, Парламентын эрхийг ‘Английн албатуудын эртний, гарцаагүй төрмөл эрх^[8], өв хөрөнгө’ гэж батлан өгүүлсэн билээ.

I Жэймс албадсан зээллэгийг нь төлөхөөс татгалзсан газрын эзнийг шоронд хорьж эсвэл цэргүүдээ тэдний гэр оронд байрлуулахад Парламент дахиад л эсэргүүцлээ. Күүк олонд алдаршсан дараахь зүйлийг зарлан тунхаглав: ‘Хүн бүрийн гэр орон бол түүнд цайз, нэвтэршгүй хамгаалалт, мөн түүнийг гэмтээх, хүчирхийллээс хамгаалах хамгаалалт, басхүү тайван байх газар юм’. Эсвэл дахин өнөөдөр томьёолж хэлдгээр ‘Англи хүний гэр түүний цайз юм’ гэсэн байдаг.

Күүк *Магна Харт*^[9]ын зарчим одоо ч иргэдийг дур зоргоор

6 *King's Bench*

7 *Monopoly*-Зөв бичгийн журамласан тольд ингэж бичихийг заасан нь геологи [geology], философи [philosophy] гэж бичдэгтэй таарч буй ч бид монополь гээд оросыг дуурайн бичиж хэвшжээ.

8 *birthright*-жам ёсны гэдгийг заримдаа төрмөл гэдэг ба англи хэлбэр нь ажээ.

9 *American Declaration of Independence*-Энэ баримт бичгийн Монгол

баривчлагдах, парламентын зөвшөөрөлгүйгээр татвар оногдуулах явдлаас хамгаалсан гэдгийг Парламентаас зарлан тунхагласан Мэдэгдл^[10]ийн эхийг нь гаргав. Тэрбээр иргэдийн эрх, эрх чөлөөг дурдаж бичсэн, *Хабеас Корпус*^[11]д зориулсан замыг зассан, *Эрхийн тухай Хүсэлт* [анг. *Petition of Right*] (1628 он) гэсэн бүтээлийг бичих ажлыг удирдсан. Күүк мөн буруутгагдаж буй хүний дуугүй байх эрх, гэрээний хуулийг хөгжүүлж гаргах, шүүх байгууллагын бие даасан байдлыг үүсгэж тогтооход чухал үүрэгтэй байжээ.

[11] Хьюго Гроци (1583–1645 он): Голланд хүн, хуульч, улстөрийн философич. **Гол үзэл санаа:** Хувь хүний өвөрмөц чанар болон өмчийн тухай эрх. **Гол бүтээл:** *Дайн ба Энхийн Хуулийн Тухай* (анг. *On the Law of War and Peace*) (1625 он).

Голландад өөр нэг хуульч жам ёсны эрхийн тухай бодол болж байлаа. Хьюго Гроци бол олон либерал бус үзэл бодолтой байсан ч гэсэн либерал уламжлалд тустай хувь нэмэр оруулсан философич байсан юм. Ялангуяа тэрбээр хувь хүмүүс, мөн бүлэг хүн Бурхнаас-өгсөн эрхтэй, үүн дотроо өөрийгөө-хамгаалах эрх, өмчийн эрхтэй байдаг гэдгийг сахин хамгаалдаг байв. Бид тийм учраас өөрсдийгөө, өөрсдийн өмчөө бусдын, бүр төрийн дайралт түрэмгийллээс хуульзүйн дагуу хамгаалах боломжтой ажээ. Гроци мөн хэрхэн бидний эрх бусдад үүрэг болж очдогийг тайлбарлажээ.

Гэлээ гээд тэрбээр эрхүүдийг халдашгүй зүйл гэж хэлж байсангүй. Тэрбээр эдгээр эрхийг [эдлүүлэхээс] (магадгүй

орчуулгыг www.libraryforfreepople.mn гэсэн вэбхуудаснаас үзнэ үү.

10 resolution

11 Habeas Corpus

хүчээр) татгалзах нөхцөл байна гэж ойлгож байв. Нэгэнт л эдгээр эрх хувь хүнд байдаг тул тэдгээрээ арилжиж солилцох боломжтой: хүмүүс өөрсдийгөө боол болгож зарах ч боломжтой. Хэдийгээр хожмын либерал онолчид энэхүү сүүлд дурдсан гол санааг өөрийгөө-хохироосон гэж буруутгасан ч гэлээ эрхүүдийг зарж солилцох боломжтой гэсэн энэ үзэл санаа төрийн бүрэн эрх хувь хүмүүс болох хувь иргэд сайн дураараа татгалзсан тэр эрхүүдээс л зөвхөн үүсэж гардаг гэсэн Жон Локкийн үзэл бодолд нөлөөлж санаа нь буужээ.

[12] Томас Хоббэс (1588–1679 он): Англи хүн, улстөрийн философич. **Гол үзэл санаа:** Өөрийгөө-хамгаалах эрх; чөлөөт нийгмийн ашиг тустай байдал; нийгмийн гэрээний онол; төр засгийг хувь хүмүүс эрхээ хамгаалуулах гэж байгуулдаг; төр засагт тавих хязгаарлалт; муу төр засгийг түлхэн унагаах эрх. **Гол бүтээл:** *Атгаалжин Мангас* (анг. *Leviathan*) (1651 он).

Хоббес бүр **Хюго** нь **Гроцигоос** илүү муухан либерал үзэлтэн байв – түүний төгс нийгэм бүхнээс-хүчирхэг дээд удирдагчаараа өвөрмөц шинжтэй байдаг – гэвч түүнийг сэтгэлгээний зарим хэсэг нь хожмын либерал онолд тусгалаа олжээ. Жишээлбэл Хоббес эрх чөлөөнд тавих хязгаарлалт *үндэслэлтэй байх* ёстой гэж баталж өгүүлж байлаа. Тэрбээр хувь хүмүүс өөрсдийгөө хамгаалах, бүр төрөөс ч хамгаалах “жам ёсны эрх”-тэй гэдгийг сахин хамгаалж байв. Чөлөөт хүмүүс өөрөө-өөрсдийгөө захирах боломжтой гэсэн үзэл бодол нь **Адам Смит** болон **Ф. А. Хаек** зэрэг либералчууд нийгмийн өөрөө-тогтдог дэг журмын тухай бодоход хөтөлжээ.

Магадгүй хамгийн чухал зүйл бол Хоббесын *нийгмийн гэрээний* тухай эргэцүүлэл нь **Жон Локк** зэрэг дараа дараачийн

сонгодог либералчуудын амин чухал багаж хэрэгсэл болсон явдал байж болох юм. Түүний тайлбарласнаар хүмүүн төрөлтөн өөрийн-тусыг бодогч бодгаль ажээ. Хүн бүр л өөрөө өөрийнхөө төлөө зогсдог байвал “байгалийн төлөв”-д байгаа хүмүүн төрөлтний жам ёсны нөхцөл нь тэд бүгд бүх хүний эсрэг дайтсан дайн байх болно. Амьдрал “ганцаардмал, ядуу зүдүү, гутмаар, харгис, богинохон” байх болно. Зүгээр л өөрийгөө-хамгаалж үлдэх гэсэн үйлдэл л хүмүүс харилцан өөрсдийгөө хязгаарлах явдалд санал нэгдэхээр тэднийг ухаалаг болгожээ.

Гэвч хэлэлцээр эвдэгдэх боломжтой тул мөн нийгмийн гэрээгээр төр засагт зарим нэг эрх мэдэл аливаа маргааныг шийдвэрлүүлэх гэж олгох ёстой болдог. Хоббес энэхүү дээд удирдагч нь ганц хууль-гаргагч, захирагч, шашны болон боловсролын эрх мэдэлтэн байх ёстой, тэр нь өөрийгөө-гэмтээхээс бусад зүйл хийлгэхээр албатууддаа тушаал өгөх эрх дархтай байх болно гэж бодож байлаа.

Абсолютистч дүгнэлтийнхээ хажуугаар Хоббес зарим нэг чухал либерал санааг гаргаж ирсэн байдаг. Эхнийх нь тэрбээр төр засгийг чөлөөт хүмүүс байгуулдаг гэж ойлгож байв: хүмүүст төр засгийг нь хуульзүйн дагуу тулгаж оноох боломжгүй. Хоёрдох зүйл бол хувь хүмүүс өөрсдийн эрх дархынхаа зарим нэгийг төр засагт дамжуулах замаар түүнийг бүтээдэг гэсэн санаа юм. Гуравдахь нь төр засаг өөрийнхөө зорилгын төлөө оршин тогтнодоггүй: түүнийг өөрийг нь байгуулсан хувь хүний эрх чөлөөг хамгаалах, өргөжүүлэх гэж л зөвхөн байгуулдаг. Дөрөвдөх нь төр засаг зөвхөн хязгаарлагдмал л бүрэн эрхтэй байдаг – төр засаг тэр хувь хүмүүсээр бусдыг алуулах, эсвэл өөрсдийг нь гэмтээлгэх боломжгүй. Тавдахь нь төр засгийн бүрэн эрх зөвхөн иргэдийнхээ эрх чөлөөг хамгаалдаг, өргүүлж тэлдэг байсаар байх хүртэл л үргэлжилдэг: хэрэв төр засаг ингэхгүй бол хүмүүс түүнийг дагах түүнд захирагдах үүрэггүй байдаг гэсэн санаа юм.

Хоббесын цаг үед маш орчин үеийн зүйл байсан иймэрхүү

үзэл санаа дараа дараагийн либерал сэтгэгчдэд маш чухал хэрэглэгдэхүүн болсон бөгөөд эдгээр нь Бахархалт Хувьсгал болон Америкийн Хувьсгал^[12]ын цаана буй оюун санааны суурийг бүтээхэд дэм болжээ.

[13] Жон Милтон (1608–1674 он): Англи хүн, яруу найрагч, полемист, төрийн зүтгэлтэн. **Гол үзэл санаа:** Шашны хүлцэхүй, чөлөөт үгээ хэлэх, чөлөөтэй үзэл санаагаа илэрхийлэх^[13]; төр засгийг гэрээ гэж үзэх^[14]. **Гол бүтээл:** *Салалтын Сургаал ба Дэг* [анг. *The Doctrine and Discipline of Divorce*] (1643 он); *Арэопагитика* [анг. *Areopagitica*] (1644 он)^[15]; *Иргэний эрхийн сургаал* [анг. *A Treatise of Civil Power*] (1659 он).

“Алдагдсан Диваажин” [анг.] (1667 он) гэсэн шашны магтаал найрг^[16]аараа алдаршсан Милтон мөн гэр бүл салалтын хуульзүйн дагуухь байдал болон ёс суртахуунт байдал^[17], шашны хүлцэхүй, улстөрийн эрх дархаас сүм хийд ангид байхын төлөө маргаж мэтгэлцдэг байлаа. Тэрбээр хувь хүмүүсийн улстөрийн тэгш байдлыг илэрхийлж, төр засгийг удирдагч болон иргэдийнх нь хоорондохь дам гэрээ^[18] гэж ойлгож байв.

12 *Glorious Revolution and the American Revolution*

13 *free speech and conscience*

14 *an implied contract*

15 *Areopagitica* - Үг хэлэх явдлыг шүүлтүүрлэх, цензүрдэхийн эсрэг бичсэн энэ бүтээлийг үг хэлэх эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөөний хамгийн нэр нөлөөтэй, гүн утгатай философийн хэлсэн үг ажээ.

16 *religious epic*

17 *legality and morality*

18 *implied contract*

Милтон хэрэв хүмүүс чөлөөтэй мэтгэлцээн сонсох боломжтой байх аваас тэд буруу зүйлээс зөв зүйлийг ялгаж мэдэх чадалтай гэдэгт итгэж чөлөөтэй үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө^[19] (дор хаяж Протестантуудын дунд) – гөмгөөлж хамгаалдаг байсан. ‘Надад чөлөөтэй мэдэх, санаагаа илэрхийлэх, мэтгэлцэх эрх чөлөөг’ гэж тэрбээр эхлээд ‘бүх эрх чөлөөний дээр орших ухамсарт байдлын дагуу олгоно уу’ гэж хэлсэн байдаг.

1649 онд I Чарлзыг цаазалсны дараа Милтон оронд нь гарч ирж буй Оливер Кромвеллын бүгд найрамдах засаглалын полемицист^[20] болсон байдаг. Гэвч тэрбээр Кромвеллыг хүмүүстэйгээ байгуулсан дам гэрээгээ хүндэтгэхийг түүний засаглалаас шаргуу шаардан удалгүй автократч Кромвеллын ил цагаан эсэргүүцэгч болжээ. Хэдийгээр ардчилагч биш байсан ч тэрбээр илүү либерал бүгд найрамдах улс (‘чөлөөт гүрэн’) байгуулахыг мөрөөдөж байлаа; гэвч үнэндээ тэр цагт эзэн хаант засаглал л сэргэн тогтсон юм.

[14] Жон Лилбөрн (1614–1657 он) болон

[15] Ричард Овертон (ойр. 1599–1664 он): Английн иргэний эрхийн идэвхтнүүд (‘Левеллерчүүд^[21]’). **Гол үзэл санаа:** Амьдран суух жам ёсны эрх^[22], эрх чөлөө ба өмч; буруутгагдсан хүний эрх; шашны хүлцэхүй; хуулийн өмнөх тэгш байдал; ардчилал; төр засаг хүмүүстээ захирагдана. **Гол бүтээл:** *Английн Шинэ Гинжийг Олж Нээсэн нь* [анг. *England’s New Chains Discovered*] (Лилбөрн, 1649 он); *Бүх Харгис Дарангуйлагчдын Эсрэг*

19 *free speech and freedom of conscience*

20 *polemicist*–аливаа үзэл бодол, хүн, үзэл санаа, итгэл үнэмшлийг улайран хамгаалдаг эсвэл шаргуу эсэргүүцдэг хүнийг хэлнэ.

21 *Levellers*

22 *Natural rights of life*

Харвасан Сум [анг. n Arrow Against All Tyrants] (Овертон, 1646 он).

Жон Лилбөрний гарамгай мэргэжлийн замнал шударга ёс болон эрх дархны тухай үндэстэн даяархи маргаан мэтгэлцээнээс эхэлжээ. Тэрбээр буруутгагдаж буй хүнд түүнд тулгаж буй ял буруутгалыг мэдэх, буруутгагчтайгаа нүүрэлдэх, өөрийнхөө эсрэг мэдүүлгэ өгөхөөс зайлсхийх эрхийн төлөө маргалдаж мэтгэлцдэг байв. Тэр цаг үеийн төр засаг эдгээр эрхийг хүмүүст эдлүүлэхээс татгалздаг байсан ч энэ нь түүний эрх мэдэлд байх ёсгүй зүйл гэж батлан өгүүлж байлаа. Хүмүүс ийм эрхтэйгээ л төрцгөөдөг ажээ. Үүнээс улбаалаад түүний хоч нь ‘Эрх чөлөөтэй төрсөн Жон’^[23] болсон.

Лилбөрнийг тэрбээр санхүүгийн тэгш байдлыг өмгөөлж хамгаалдаг байсан учраас биш харин тэрбээр хувь хүмүүс ёс суртахуун, улстөр, хуульзүйн хувьд ижил тэгш гэдгийг ятгаж байсан учраас Левеллер гэж нэрлэжээ. Леверлерчүүд шашны хүлцэхүй, хуулийн өмнөх тэгш байдал, өргөн хүрээний ардчилал, төр засаг хүмүүсийн хүсэл зоригт захирагдах явдлыг өмгөөлж хамгаалдаг чухал шинэчлэлийн хөдөлгөөн болж өсөж өндийсөн. Лилбөрн голдуу түүнийх шиг радикал буюу хурц үзэл санааг дарж дарангуйлах гэсэн төрийн албаны утга санааны шүүлтүүр буюу цензүрийг үл тоодог байлаа. Одот Танхимын өмнө (тэрс үзэлтнийг сөхрүүлэн бут авдаг нууц шүүх) Лилбөрн тэр болон шүүгч нар ижил тэгш гэдгийг сахин хамгаалж бөхийхөөс татгалзаж байв; тэрбээр түүнийг юунд буруутгаж байгаа мэдэхийг шаардаж, өөрийгөө буруутгах үүрэгтэй болж болох учраас тангараг өргөхөөс татгалзаж байв. Шүүхийг үл хүндэтгэсэн эдгээр үйлдлийнхээ төлөө торгууль төлж, ташуурдуулж, шившиглэх шонд хүлэгджээ. Бүр шонд хүлүүлсэн байхдаа ч тэрбээр түүнийг буруутгагчдыг шүүмжилж,

23 *Freeborn John*

олон нийтэд илүү олон памфлет буюу таниулга хуудас тараасан нь цааш түүнийг гурван жил “шоронд хорих”-од хүргэсэн байдаг.

Английн Иргэний Дайны үеэр Лилбөрн хувьсгалч хүчинтэй нэгдсэн ч тэднийхээ шашны үл хүлцэхүйг нь дайрч давшилсан гэж Парламентад дуудагдаж байлаа. Тэрбээр энэ удаа шийтгүүлээгүй өнгөрсөн ч гэсэн удалгүй Парламентын Гишүүдийн тансаглалыг ил зарласан гэж шоронд оров. Хожим тэрбээр парламентын хороог ‘дүүжлэгдэхээс ч мууг хүртэх ... шударга бус, хэрэггүй хүмүүс’ гэж нэрлэснийхээ төлөө улсаасаа хөөгдөв. Англи руу зөвшөөрөлгүйгээр буцаж ирснийхээ төлөө тэр даруйдаа баривчлагдаж, дахин хоёр жил шоронд суужээ.

Лилбөрний хамтрагч Леверлерийн гишүүн Ричард Овертон түүний адилаар цаг үедээ баталгаатай зүйл биш байсан эрхийн төлөө маргаж мэтгэлцэж байв. Үүнд: шашны эрх чөлөө, өөрийгөө-мэдэх, амьдран суух жам ёсны эрх, эрх чөлөө болон өмчийн эрх орно. Түүнийг хамба ламтан руу үгээр дайрсан, үхэшгүй мөнх сүнс гэдгийг “зүгээр л хууран мэхлэлт” гэж үздэг бурхны эсрэг үзэл бодол, гэр бүл салалтын тухай либерал үзэл бодол болон зөвшөөрөлгүй сургаал ном хэвлүүлсэн гэж мөн л түүнийг Парламентад дуудсан ажээ. Парламентын иймэрхүү хэрэг явдлыг мэдэх юрисдикц буюу хуульзүйн хамаарах хүрээг үгүйсгэснээрээ тэрбээр шоронд орсон ч гэсэн жилийн дараа түүнийг суллуулах гэсэн кампанит ажлын дараагаар суллагджээ.

Хоёр жилийн дараа Овертон, Лилбөрн, бусад хүмүүсийн хамт Кромвеллийн дарангуйллыг дайрч давшилсан, түүнийг “шинэ Хаан” гэж хочилсон ухуулах хуудасныхаа төлөө баривчлагдсан байдаг. Тэдэнд тулгасан энэ хэрэг амжилтад хүрээгүй ч гэсэн тэднийг төр эргүүлэхээр бэлдэж байна гэсэн цуу яриагаар дахин баривчилжээ. Аажимдаа эзэн хааны засаглал ^[24] сэргэн тогтоход Овертон өөрийн зарчимдаа үнэнч хэвээр үлдэж, шинэ төр засгаа дайрч давшилсан ухуулах хуудасныхаа төлөө дахиад

л баривчлагдав.

[16] Алжернон Сидний (1622–1683 он): Англи хүн, улстөрч, бүгд найрамдах засаглалын онолч. **Гол үзэл санаа:** Төр засаг шударга ёс, эрх чөлөөний төлөө л оршин тогтнодог; харгис дарангуй төр засаг болон хуулийг эсэргүүцэх эрх. **Гол бүтээл:** *Төр засагтай холбоотой гажсан замнал* [анг. *Discourses Concerning Government*] (1698 он).

Сидний төр засаг хэрэгтэй байсан ч түүний үүрэг нь ‘шударга ёс болон эрх чөлөөт байдлыг үүсгэж тогтоох явдлыг хамгийн ихээр нөхцөлдүүлдэг’ байхаар хязгаарлагддаг байсан гэдэгт итгэдэг байв. ‘Чөлөөт хүмүүс’ гэж тэрбээр эхлээд ‘үргэлж харгис дарангуй төр засгийг эсэргүүцэх эрхтэй байдаг’ хэлж байлаа. Иймэрхүү үзэл санаа нь түүнийг Британи болон Америкт бүр **Жон Локкоос** илүү маш нэр нөлөөтэй болгожээ. Түүний хэлснийг Стюартын эзэн хаант засаглалыг шүүмжилсэн шүүмжид өргөн эшлэж, *Катогийн Захидлуудаараа* Америк хувьсгалчдыг сэрээсэн **Жон Тренчард** болон **Томас Гордон** нарыг сэтгэлийг эзэмдэж байсан. **Томас Жефферсон** Сиднийг Америк эрх чөлөөний бүтээгч архитекторч нарын нэг гэж зарлан мэдэгдэж байв.

Төр засаг Сиднийгийн хувьд хуулиас дээгүүр зүйл байсангүй: ‘Шударга бус хууль бол хууль биш’ гэж эхлээд ‘хууль биш зүйлийг дагаж мөрдөх, түүнд захирагдах ёсгүй’ гэж *Төр Засагтай холбоотой гажсан замнал* [анг. *Discourses Concerning Government*] (1698 он)-даа бичжээ. Сидний иргэд төр засагтаа санал хэлэх бүрэн эрхтэй гэдэгт итгэж үнэмлэхүй эрх мэдлийг муу зүйл гэж үздэг байлаа. Энэ талаараа тэрбээр намын фракцаас эрэлхэг байсан. I Чарлзын шүүх хуралд суусан бүгд найрамдах үзэлтэн тэрбээр хааныг цаазлах явдлыг өшөө

авч буй зүйл, утгагүй хэрэг гэж эсэргүүцэж байлаа. Хожим нь Кромвелл Парламент (Кромвеллд таалагдаагүй шинэчлэлийг дэмжсэнийх нь төлөө)-ийг тараахаар цэрэг илгээх үед Сидний суудлаа орхихоос татгалзаж түүнийг хүчээр тэндээс авч гарч байв. Хожим нь мөн л эзэн хаант засаглал сэргэн тогтоход тэрбээр өөр нэг харгис этгээд гэж үзсэн II Чарлзын амь насанд халдах явдлыг зохион байгуулахаар бодож төлөвлөж байсан байдаг. Үүнээс болоод тэрбээр эх орноосоо урвасан гэж шүүхээр оржээ. Хэдийгээр түүний эсрэг зөвхөн нэг гэрч байсан ч гэсэн (хуулиар хоёр гэрч байх ёстой) “дүүжлэгч шүүгч” гэсэн муу нэртэй шүүгч Жорж Жеффрийс (1645–1689 он) удирдсан шүүх Асуулт Хариултыг хоёрдохь гэрч гэж хүлээн зөвшөөрч Сиднийг цаазлуулахаар явуулсан юм.^[25] Тэрбээр амьдралынх нь бүх үйлдэл ‘хүмүүн төрөлтөний нийтлэг эрх, энэ улсын хуулийг хамгаалах ... завхарсан зарчим [болон] дур зоргын эрх мэдлийн эсрэг...’ зориулсан гэж зүтгэж зөрүүлдсээр байжээ.

[17] Жон Локк (1632–1704 он): Англи хүн, философич, физикч, идэвхтэн. **Гол үзэл санаа:** Хүмүүний мэдлэгийн хязгаартай байдал; амьдран суух, эрх чөлөөний жам ёсны эрх; төр засгийн гэрээний шинж байдал; төр засгийн эрх мэдэл хувь хүмүүсээс л гардаг; бие хүний өмчлөлд байх өмч; харгис дарангуйлагчийг түлхэн унагаах эрх. **Гол бүтээл:** *Хүлцэхүйтэй хамаатай захидал* [анг. *Letter Concerning Toleration* (1689 он)]; *Төр засгийн тухай хоёр сургаал* [анг. *Two Treatises of Government* (1690 он)].

Жон Локк арвандолоодугаар зууны тэргүүний философичдын нэг байлаа. *Хүмүүний Ухаарац Мэдлэгтэй Холбоотой Эссэ* [анг. *His Essay Concerning Human Understanding*] (1689 он) гэсэн

25 Лондон Тауэр цайзад толгойг нь авсан ч хожмоо цагаатгажээ.

бүтээлдээ байгалийн болон хүмүүний ертөнцийн талаархи бидний мэдлэг хязгаарлагдмал гэдгийг илэрхийлсэн байдаг. Гэвч *Хүлцэхүйтэй Хамаатай Захидал* [анг. *Letter Concerning Toleration*] (1689 он) болон *Төр засгийн тухай Хоёр Сургаал* [анг. *Two Treatises of Government*] (1690 он) нь “сонгодог” либерализмийн үндэслэгч гэсэн нэр төрийг нь баталгаажуулжээ. Эдгээр бүтээл хувь хүний эрхэм дээд байдал, төр засагт тавих хязгаарлалтын гаргалгаа нотолгоо агуулдаг.

Локк хөдөө газрын хуульчийн хүү байсан ч гэсэн орон нутгийн Парламентын Гишүүн [ПГ]-ий ивээлээр тэрбээр Вестминстер Сургууль болон Оксфордын Крист Чөөрч Коллежид суралцах боломжтой болжээ. Сургуулиа дүүргэснийхээ дараа Локк Герег хэл болон илтгэх урлаг^[26] зааж байгаад дараагаар нь шинжлэх ухаан, эмнэлзүй^[27] рүү орж Роберт Бойл (1627–1691 он), Исаак Ньютон (1642–1726 он), Кристиан Хюгенс (1629–1695 он), бусад олон гарамгай эрдэмтдийн найз нөхөр болов.

Тэрбээр Каролинагийн Суурь Үндсэн Хуул^[28]ийн эхийг нь бэлдэж өгөн (өөрөө элэгний идээлсэн ургацгийг нь авч амийг нь аварсан) Лорд Шафтесбери (1621–1683 он)-ийн дор төр засгийн албатай болсон. Гэвч Шафтесбэригийн II Жеймсд дайсагнадаг байдал нь түүнийг болон Локкийг гадагш дүрвэхэд хүргэжээ. Холланд болон Францад өнгөрүүлсэн он жилүүддээ Локк хүлцэхүйн тухай ном, мөн дээр нь *Хүмүүний Ухаарац Мэдлэгтэй холбоотой Эссэгээ* бичсэн. Шашин болон улстөрийн зөрчилдөөний шаварт унасан Жэймсийг Виллиам болон Мэри нарыг залж түлхэн унагахад Шафтесбэри, Локк хоёр эзэн хааны усан онгоцоор нутаг буцлаа.

26 *rhetoric*

27 *medicine*

28 *Fundamental Constitutions of Carolina*- Мөн “*Аугаа Загвар/Үлгэр* [анг. *Grand Model*]” ч гэдэг энэ баримт бичиг 1669-1698 оны хооронд Каролинагийн шилжин суурьсагчдын төр засаг болон нийгмийн хэлбэрийг тодорхойлж байжээ.

Локк үүний хойно нууц нэрээр хаадын “бурхны эрх”-ийг үгүйсгэн, хуульзүйн дагуухь төр засаг иргэдтэйгээ хийсэн гэрээнд үндэслэдэг гэж батлан өгүүлж II Жэймсийг түлхэн унагасан явдлыг үндэслэлтэй гэж харуулсан, өөрийн *Төр Засгийн тухай Хоёр Сургаал* [анг. *Two Treatises of Government*] (1690 он)-аа хэвлүүлжээ. Түүний гаргалгаа нотолгоо төр засгаас ч *өмнө байсан*, төр засгийн байгуулсан нийгмийн гэрээний тухай *жам ёсны эрхэд* үндэслэдэг.

Томас Хоббесын адилаар Локк төр засаг байхгүй байгалийн төлөвийг төсөөлж гаргасан байдаг. Түүний сахин хамгаалдгаар хэрэв хэн ч бусдаасаа улстөрийн хувьд илүү дээр эсвэл дор байхгүй бол улстөрийн тэгш байдлын төлөв тэр байх ажээ. Нэгэнт бид Бурханы бүтээл, өмч тул бусад хүмүүс биднийг өмчлөх эсвэл бидэнд тушаах боломжгүй: хүмүүн төрөлтнүүдийн хооронд захирах захирагдах ёс байдаггүй. Биднийг бүтээснээрээ Бурхан биднийг амьд үлдээсэй гэж шулуухан хүссэн: тиймээс бид өөрсдийгөө эсвэл бусдыг хохироох гэмтээх эсвэл алах талах эрх байхгүй. Үүний эсрэгээр бид бүгд Бурхнаас-өгсөн амьдран суух, эрүүл энх байх, эрх чөлөөний жам ёсны эрх^[29]тэй байдаг.

Гэвч *байгалийн* энэхүү хуулийг хүмүүн төрөлхтөний хуулийн адилаар зөрчих боломжтой. Байгалийн төлөвд цагдаа, шүүх, эсвэл шүүгч байхгүй тул бид бүгдээрээ хүчирхийлэл болон албадлагын аюул заналтай нүүр тулах болно. Бид буцаж тэмцэх дайтаж болох ч гэлээ гэмтэж хохирсон тал нь бүр ихээр хилэгнэн хариу барих болно. Тиймээс бид Локкийн батлан өгүүлснээр шударга ёсны зарим нэг дундын тогтолцооны талаар санал нэгдэх нь илүү таатай зүйл байх болно.

Мөн л байгалийн төлөвт оршиход *өмчөөс* болж зовлон бэрхшээл гарах боломжтой. Өмч өөрөө хуульзүйн дагуухь зүйл биш байсан: Бурхан бидэнд дундын газар өгсөн ч бид байгалийн нөөц баялгийг өөрийн юм шигээр олж авсаар л байна. Бид

29 *natural rights to life, health and liberty*

өөрийн өмчийг өөрийн бие хүнээрээ л өмчилдөг бөгөөд бид байгалийн баялгийг (жишээлбэл газрын нэг хэсэгт фермийн аж ахуйн эрхэлж) хөдөлмөртэйгөө холиход тэр байгалийн баялаг биднийх болдог. Учир нь бидний өмч болох бидний хөдөлмөрийг түүнээс салгаж чадахгүй учраас хувийн өмч болдог ажээ. Гэвч хязгаар бий. Бид ашиглах боломжгүй газар болон өмч олж авах эрхгүй. Өсөн нэмэгдэж буй хүн ам, нөөц баялгийн ховор байдал, хүмүүс арилжаагаар өмчөө хуримтлуулж өсгөж буй нь хүмүүст атаархал төрүүлж дэг журамгүй болоход хүргэх боломжтой.

Бид эдгээр “байгалийн төлөв”-ийн асуудлыг шийдвэрлэхийн тулд төр засгийг байгуулж бүтээсэн гэж Локк хэлдэг. Бид өөрсдийнхөө эрхийн заримыг төрд *дамжуулж өгөхөөр* санал нийлж, амьдран суух буюу амьд явах, эрх чөлөө, эрүүл мэнд, өмчийн эрхийг маань хамгаалах, эдгээр эрхийг зөрчсөн улсыг шийтгэх эрх дархыг түүнд зээлддэг ажээ. “Хэн нэгнийг өөрийн жам ёсны эрх чөлөөнөөсөө татгалзахад хүргэх цор ганц арга зам бол” гэж тэрбээр эхлээд ‘хүмүүс нэг нэгнийхээ дунд өөрийнхөө тав тух, айх аюулгүй эв найртай амьдран суухын төлөө бусад хүмүүстэй хүмүүсийн хүрээлэл болон нэгдэн нийлэхээр санал нийлэх явдал юм’ гэж өгүүлсэн байдаг. Энэхүү төр засаг хуульзүйн дагуухь бүрэн эрхтэй байхын тулд бидний хувийн эрх дархыг төр засагт хүчээр биш харин бидний зөвшөөрснөөр дамжуулж өгсөн байх ёстой. Гэвч тэр үед *нийгмийн энэхүү гэрээ* бидэнд үүрэг болж ирдэг: хуульзүйн дагуухь бүрэн эрхтэй төр засаг бидний өөрсдийн маань эрхийг хэрэв бид бусдын эрхийг зөрчсөн бол (жишээлбэл шоронд хорьж) түдгэлзүүлж зогсоож ч болно гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой болно.

Иймэрхүү асар их эрх мэдэл хууль ямар байхыг шийдэхэд маш их нөлөөтэй үүрэгтэй болдог. Нэгэнт л хүн бүр энэхүү нийгмийн гэрээнд сайн дураараа хамтрагч болсон тул хүн бүр энэхүү үйл явцад оролцох ёстой гэж хэлсэн байдаг. Ардчилал бол тиймээс нийгмийн гэрээний амин чухал хэсэг бөгөөд хуульзүйн дагуухь эрх дархтай төр засаг олонхийн засаглалд

захирагддаг ажээ. Үүнээс ялгаатай нь иргэдийн хүсэл зоригоор хоригдож хязгаарлагдаагүй төр засаг араатанлаг шинжтэй болж, иргэдийнхээ эрхэд халдах болно. *Хуульзүйн дагуухь эрх мэдэлгүй* ийм төр засгийн эсрэг босох, түүнийг түлхэн унагаах нь араатан амьтныг өөрсдийгөө хамгаалах гэж алах боломжтой лугаа адилаар бүрэн үндэслэлтэй байдаг:

[X]эзээ хаана хууль тогтоогч хүмүүсийн өмчийг булаан авах, устгахаар чармайна, эсвэл хүмүүсийг дур зоргын эрх мэдэлд боолчлуулахаар дор үзнэ тэр хууль тогтоогчид өөрсдийгөө хүмүүстэй дайны байдалд оруулдаг бөгөөд тэр үед хүмүүс цаашид захирагдахаа больж Бурхны тааллаар бүх хүмүүст хүч хүчирхийллээс хамгаалах гэж олгосон нийтийн хорогдох байраа орхин явцгаадаг.

Иймэрхүү үзэл санааг II Жэймсийг түлхэн унагаасныг үндэслэлтэй болгохоор эрэлхийлж асан хүмүүс даруй шүүрэн авсан бөгөөд мөн Америк болон Францад гарсан хувьсгалуудад хүчтэй нөлөөлжээ.

[18] Самуэл фон Пүфендорф (1632–1694 он): Герман хүн, улстөрийн философич, хуульч, түүхч. **Гол үзэл санаа:** Социал байдал^[30] жам ёсны хуул^[31]ийн үндэс болох нь; шударга ёс болон өмчийн эрх төвийн засаг захиргааг хэрэгцээгүй зүйл болгодог. **Гол бүтээл:** *Байгалийн болон Хүмүүсийн Хуулийн Тухай [анг. Of the Laws of Nature and Peoples] (1672 он).*

30 Sociality

31 natural law

Пүфендорфын байгалийн хууль болон нийгмийн гэрээний талаархи гол бүтээл **Жон Локк** болон **Монтескю**, мөн Америкийг Байгуулсан Үндэслэгчдэд нөлөөлжээ.

Пүфендорт хоёр фронт дээр **Томас Хоббестэй** маргалдаж байлаа. Эхнийхэд нь тэрбээр “байгалийн төлөв” гэх зүйл нь хүмүүн төрөлтөн тэднийг хязгаарладаг байгалийн тодорхой хэмжээний “социал байдал”-тай учраас дайны төлөв биш гэж батлан өгүүлж байсан. Тэрбээр энэхүү социал байдлыг байгалийн хуулийн үндэс гэж харж байв. Гэвч энэ нь хэврэг эв найр байх бөгөөд бид үүнийг сахин хамгаалахын тулд өөрсдийнхөө социал байдлаа бэхжүүлэх хэрэгцээтэй болно гэж байв.

Хоёрдохид нь Пүфендорт энэхүү хэврэг хэцүүхэн эв найраа хөгжүүлж цэцэглүүлэхийн тулд бидний байгуулсан төр бол өөрийн гэсэн бие, ухаантай атгаалжин мангас биш гэж баталж өгүүлж байжээ. Хэрэв бид эв найртай, хоорондоо эв зохицолтой амьдрахыг хүсвэл бидэнд хүчтэй төвийн засаг захиргаа хэрэггүй харин хүн-хоорондын-харилцааны эрх^[32], шударга зан үйлийн болон өмчийн ёс журам^[33], өмч л хэрэгтэй. “Төрийн хүсэл зориг” бол түүнийг бүрдүүлж буй хувь хүмүүсийн хүсэл зоригоос өөр биш гэж байв.

[19] Виллиам Волластон (1659–1724 он): Англи хүн, теологич, философич. **Гол үзэл санаа:** Өмчийн эрхийн зарчим; амьдран суух эрх; аз жаргалдаа хүрэхээр зорих эрх. **Гол бүтээл:** *Байгалийн Шашныг Дүрсэлж Өгүүлсэн нь* [анг. *The Religion of Nature Delineated*] (1722 он).

32 *interpersonal rights*

33 *rules of just conduct*

Штафффордшайрд төрсөн, Кэмбрижид боловсрол эзэмшсэн Волластон Бирмингхэмийн сүмийн номлогч болжээ; гэвч өв хөрөнгө залгамжилсан нь түүнийг философи, түүх, шашин судлах тэдгээрт суралцах цаг завтай болгов. Тэрбээр маш их нөлөөтэй хүн боллоо: түүний *Байгалийн Шашныг Дүрсэлж Өгүүлсэн нь* [анг.*The Religion of Nature Delineated*] (1722 он) гэсэн ном 10 000 хувь зарагджээ. Тэрбээр амьдран суух эрх, “аз жаргалдаа хүрэхээр зорих” эрхийн тухай өгүүлсэн нь **Бенжамин Франклин**д хүчтэй нөлөөлж, Америкийн Тусгаар Тогтнох Тунхаглал^[34]д тусгалаа олжээ.

Хүмүүсийн амь нас, бие бол тэдний өвөрмөц чанар^[35]ын нэгэн хэсэг байдаг бөгөөд эдгээр нь зөвхөн тэдний өмч юм гэж батлан өгүүлдэг байсан. Хүч чадал болон эрх мэдэл нь түүнийг тэднээс авах явдлын үндэслэл болохгүй. Гэвч оюун ухаан бол бүх хүний зүйл буюу универсал зүйл^[36] юм: бусдын хувьд хүлээн зөвшөөрөх ёстой зүйл гэж та нар юуг үзнэ түүнийгээ мөн өөрсдөдөө ч хүлээн зөвшөөрөх ёстой. Энэхүү нэг ижил логикоор бол хэн ч бусдын “аз жаргалыг тасалдуулах” ёсгүй: үнэндээ хүмүүс өөрсдийн амь нас, өмч, аз жаргалаа өөрсдөө хамгаалах эрхтэй байдаг ажээ.

Волластон мөн өмчийн эрхийн гол зарчмуудыг тогтоон гаргажээ. Үүнд: *цор ганц байх*^[37], *дамжуулах боломжтой байх, албадан хэрэгжүүлдэг байх*^[38] багтана. Өмчийн өмчлөл гэж ямар нэг зүйлийн ‘ашиглах, захиран зарцуулах цор ганц эрх’-ийг дам хэлдэг гэж тэрбээр хэлжээ. Өмчийг “тэрээ эсвэл бэлэглэх” замаар дамжуулж болно. “Бусад хүний өмчийг булаан авах^[39] эсвэл түүнд халдах” нь шударга бус зүйл гэсэн байдаг. Үүний

34 *American Declaration of Independence-Энэ баримт бичгийн Монгол орчуулгыг www.libraryforfreepople.mn гэсэн вэбхуудаснаас үзнэ үү.*

35 *individuality*

36 *universal*

37 *exclusivity*

38 *transferability and enforceability*

39 *usurp*

хохилогч нь хулгайлуулсан зүйлээ нөхөн төлүүлэх эсвэл түүнтэй таарах үнэ цэнийг олж авах эрхтэй.

[20] Жон Тренчард (1662–1723 он) болон

[21] Томас Гордон (ойр.1691–1750 он): Англи зохиогчид, шинэчлэгчид. **Гол үзэл санаа:** Жам ёсны эрх болон санал нэгдэж байгуулсан төр засг^[40]ийн зарчмыг орчин үеийн төр засагт хэрэглэх; Америкийн хувьсгалчдад урам зориг өгсөн. **Гол бүтээл:** *Катогийн Захидлууд [анг. Cato's Letters] (1720–1723 он).*

1720-оос 1723 оны хооронд Тренчард болон Гордон нар Юлий Цезарыг шүүмжилдэг байсан, өөртөө итгэлтэй шаргуу ребапликч^[41] шүүмжлэгчийн нэрээр нэрлэсэн, сонины цуврал 138 эссэ болох *Катогийн Захидлуудыг* хамтран бичжээ. Эдгээр эссэ орчин цагийн асуудлын талаархи эрс ширүүн үзэл бодол, либерал үзэл санааг ухаалгаар өгүүлснээрээ маш алдартай болсон.

Стюартыг ширээнд нь буцаах залах гэсэн Католик сүмийн оролдлогыг буруутгасан, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө сүмийн номлогч ч, улстөрч ч устгаж чадахгүй жам ёсны салшгүй эрх чөлөө юм гэж батлан өгүүлдэг, хурц ухаантай, сэргэлэн Гордонтой баян шинэчлэгч Тренчард анх долоохоног тутмын “*Де Индепендент Виг*”^[42]-д хамтран ажиллаж байжээ.

Алжернон Сиднийгийн араас *Катогийн Захидлууд* данхар төрийн улстөрчид болон албан тушаалтнуудын авилгал, эзэрхэг

40 *consensual government*

41 *republican*

42 *The Independent Whig*

харгис байдлыг бут ниргэж, **Жон Локкийн** байгалийн хууль болон жам ёсны эрхийг үг хэлэх эрх чөлөө^[43]г шаардахдаа ашиглаж байлаа. Тэд 1720 оны санхүүгийн хямралыг улстөрчид, сайд нар, эзэн хаадын шударга бус байдал, авилгалаар тэжээж асан (улстөрчид Сөүт Сий Компани^[44]д Өмнөд Америкийн худалдааны монополь эрх батлан олгоход эхэлсэн, хожим нь ямар ч үнэ цэнэгүй гэдэг нь батлагдсан) хөөж томорсон, интервенционист төр засагт хамаатуулж байв. Төр засаг хүмүүсийн санал нийлэх явдалд үндэслэдэг, мөн харгис дарангуй засаглалыг түлхэн унагаах олон нийтийн эрхийн талаар баталж хэлсэн зүйл нь *Катогийн захидлууд* (болон Сидний, Локк нарын үзэл санаа)-ыг ялангуяа Америкт алдартай болгожээ.

43 *freedom of speech*

44 *South Sea Company* -1711 онд үндэстнийхээ өрийн зардлыг нэгтгэж, бууруулах гэж олон нийт-болон-хувийн хөрөнгийн түншлэл (одоо манайд моодонд орсон төр-хувийн хэвшлийн түншлэлтэй адилхан)-ээр байгуулсан, Британийн хувьцаат компани. Цаг үеийнхээ хамгийн ухаантай хүний нэг Исаак Ньютон нэгэнтээ “Би одос эрхсийн хөдөлгөөнийг тооцоолж чадах ч харин хүмүүсийн галзуурлыг бол чадахгүй” гэж байв. Исаак Ньютон энэ компани (*South Sea*)-ийн бараг £22,000-гийн хувьцаа 1722 онд эзэмшиж байсан бөгөөд өнөөдөр (2023 он)-ийн ханшаар £3.68 сая фунт стерлингтэй тэнцэх мөнгөө, £20 000-ийг алдсан гэж үздэг.

ТАВДУГААР БҮЛЭГ: ОЮУН УХААНЫ ЭРИН

Чарлз Эдвард Стюарт 1746 онд ялагдсан нь ('Царайлаг Ханхүү Bonnie - англ. Prince Charlie') Франц-маягийн абсолютизм руу буцах ерөнхий хандлагыг төгсгөж, Британийн шинэ үндсэн хуулийн эзэн хаант засаглалыг баталгаажуулжээ. Шотланд ялангуяа 1707 оны Холбооны Актаар худалдааг нээж, шинэ тогтвортой байдал үүссэнээр ашиг тус хүртжээ. Шотландын Гэгээрлийн Эрин гэж нэрлэдэг цаг үед **Давид Юм, Адам Смит** зэрэг Шотландын сэтгэгчдийн түрлэг нийгмийн үйл ажиллагаа^[1], ёсзүй, эдийн засгийн ухаан, татварлах байдал, улстөрийн бүтэц, төр засгийн эрх мэдлийн хязгаар, хувь хүмүүсийн эрх чөлөөний тухай сэтгэл татам гайхалтай шинэ үзэл санааг судалж шинжилцгээсэн байдаг. Эдгээр үзэл санаа тархан түгэхийн хэрээр бүр Францад Католик Сүмийн эрх мэдэл болон эрх дархын талаар асар их эргэлзээ гарсан бөгөөд улам л олон язгууртан бус хүмүүс төр засагт гавьяа зүтгэлээрээ томилогдож байлаа.

Англи болон Франц либерализм хоёулаа төр засгийг рационал зарчимд дээр үндэслэж байгуулахыг эрэлхийлж байсан боловч нилээд ондоо ондоо арга зам үүсгэж хөгжүүлсэн. Англи либерализм эхгазрын-маягийн абсолют эрх мэдлийг эсрэг байх жирийн хүмүүсийн эрх, индивидуализм болон цомхон төрд анхаарал хандуулж байв. Үүнээс ялгаатай нь Франц либерализм давамгайлж буй хуульзүй, нийгэм, шашны инсититүцийг хүлээн зөвшөөрсөн боловч ардчилал төрийн ажлыг илүү ухаалаг болгоход үүрэг нөлөөтэй байх боломжтой гэдгийг илэрхийлж байлаа. Тиймээс ардчилсан ч гэлээ стэтистч шинжтэй байдаг Франц либерализм улстөрийн философич Жан-Жак Рүссо (1712–1778 он) нарийн замчилж илэрхийлсэнчлэн голдуу л

1 *workings of society*

Зүүнтэнтэй холбоотой байж иржээ – гээд ерөнхий санал нийлсэн энэхүү байдл^[2]ыг хожим нь **Волтаир, Монтеスキо, Бенжамин Константын Локкийн** либерализм илүү ихээр ганхуулав.

[22] Бернард МанDEVИЛЛ (1670–1733 он): Англи-Голланд хүн, физикч, ёс суртахууны философич, улстөрийн онолч, ёгт үлгэр зохиогч^[3]. **Гол үзэл санаа:** Өөрийн-тусыг бодох нь ажилладаг нийгмийн үндэс ажээ; хөдөлмөрийн хуваарь; санаачилгад нөлөөлдөг алтруизмын хөнөөлтэй нөлөө. **Гол бүтээл:** *Дүгнэлдсэн Зөгийд буюу Үнэнч шударга болсон Луйварчин* [анг. *The Grumbling Hive, or Knives Turn'd Honest*] (1705 он); *Зөгийн домог* [анг. *The Fable of the Bees*] (1714 он).

Роттердамд төрсөн МанDEVИЛЛ ихэнхи амьдралаа Англид өнгөрүүлжээ. Тэрбээр нийгэм сайн үйлс дээр биш харин өөрийн-тусыг бодоход үндэслэдэг гэж гайхаж цочирдмоор батлан өгүүлсэн. Тэрбээр энэхүү үзэл санаагаа *Дүгнэлдсэн Зөгийд эсвэл Үнэнч шударга болсон Луйварчин* (1705 он) гэсэн ^[4] ёгт яруу найрагтаа илэрхийлэв. Английн тэр үеийн байдлын талаархи энэхүү шуугиан тарьсан ч мэргэн ухаан шингэсэн ёгт үлгэрээ 1714 онд *Зөгийн Домог* гэсэн нэртэйгээр, ёс суртахуун болон нийгмийн онолын тухай нэмэлт эссэнүүдийн хамтаар дахин хэвлүүлжээ.

МанDEVИЛЛИЙН шүлэгт зөгийд нь гэнэтхэн алтруистлаг буюу бусдын төлөө өөрсдийгөө золиосломтгой болох хүртлээ цэцэглэж хөгжиж буй, “эд баялагтай, чин шударга байхаар ивээгдсэн” зөгийн бүлийг дүрсэлдэг. Дараагаар нь тэдгээрийг хөдөлгөж өдөөдөг хувийн ашиг сонирхол, алсын бодолгүй тэр зөгийд идэвхигүй, ядуу болдог байна. **Адам Смит** шинжлэх

2 consensus

3 satirist

4 doggerel poem

ухаанч байдлаар бүр илүү тайлбарласан түүний энэ гол санаа хэрэв зөв чиглүүлбэл шинэчлэл болон хүчин чармайлтыг, үүнээс улбаалаад хөгжил дэвшлийг урагшлуулдаг өөрийн-тусыг бодох^[5] явдал байсан – гэвч харин Мандевиллийн өөрийгөө золиослох нь хортой гэсэн үзэл бодолтой Смит санал нийлдэггүй байв. Шунал зэрэг бидний “хортой муу” гэх зан чанар^[6] л бидний сайн сайхны гол зүйл байдаг гэж Мандевилл батлан өгүүлж байжээ. “Муу”-г хумьж эсвэл “сайн”-ыг тэтгэхийн оролддог улстөрч ажиллаж байгаа нийгм^[7]ийг эвдэх болно. Гэвч тэр шуналыг чиглүүлж удирдсанаар ‘Хувийн муу зүйлийг ... олон нийтийн үр өгөөж болгож болно’.

Нийгмийн Байр Байдлыг Судалсан нь [анг. *Search into the Nature of Society*] (1723 он)-доо Мандевилл бидний ёс суртахуунт байдал өөрийгөө-үгүйсгэх, “ёс суртахууны сэтгэл”^[8] эсвэл оюун ухаанаас гардаг гэсэн ноёлж буй онолыг үгүйсгэсэн байдаг. Үүнээс илүүтэй бусад хүмүүсийн өөртөө-үйлчлэх гэсэн үйлдл^[9]ийн “муу зүйл”-тэй учрах үедээ өөрсдийгөө хамгаалах гэсэн бидний хүслээс ёс суртахуунт байдал үүсэж хөгждөг ажээ. Хоржоонтой нь тийм учраас ‘Муу зүйл ... бол биднийг нийгмийн амьтан болгодог аугаа зарчим юм ... энэ муу зүйл байхгүй болох цаг мөчид хэрэв бүрэн задарч устахгүй юм аа гэхэд нийгэм муудах ёстой’. **Ф. А. Хаек** 250 жилийн дараа цохон тэмдэглэж хэлсэнчлэн энэхүү өдөөн хатгаасан үг ярианы цаадахь санаа бол либерал онолын асар чухал зарчим ажээ: энэ бол нийлмэл нарийн нийгэм өөрийн-тусыг бодох явдлаар сэдэлжсэн байдаг хувь хүмүүсийн өдөр тутмын харилцаанаас хувьсаж хөгжиж гарсан гэх санаа юм. Бид хүмүүсийг өөр байдлаар зан байдал гаргуулахаар оролдох үедээ үйлдлийн энэхүү нийлмэл нарийн сүлжээг урж тасдах аюул тарьдаг.

5 *self-interest*

6 *traits*

7 *workings of society*

8 *self-denial, a 'moral sense'*

9 *self-serving actions*

[23] Монтескю [Шарл-Луй де Секонд, Барон де Ла Брюде де Монтескю] (1689–1755 он): Франц хүн, хуульч, улстөрийн философич. **Гол үзэл санаа:** Үндсэн хуулийн онол; эрх мэдэл хуваах; хуулийн зохих үйл ажиллагаа^[10]; шүүхийн зарчмууд; гэм буруугүй байдлыг дээдлэх^[11]; чөлөөт худалдааг төр засагт тавих хязгаарлалт гэж үзэх. **Гол бүтээл:** *Перс захидал* [анг. *Persian Letters*] (1721 он); *анг. Хуулийн Амин Сүнс* [анг. *The Spirit of the Laws*] (1748 он).

Эрх чөлөө болон хуулийн хоорондохь хамаарлын талаархи Монтескюгийн маш өвөрмөц сэтгэлгээ, эрх мэдэл зааглаж хуваах явдал^[12]д үндэслэсэн шинэлэг үндсэн хуулийн тогтолцоо нь *Персийн Захидал* (1721 он), *Хуулийн Амин Сүнс* (1748 он) номуудыг нь Франц болон Америкт онцгой нөлөөтэй болгожээ. Эдгээр нь хувьсгалын-дараахь төр засгийн талаархи алсын харааг тэдэнд олгосон байдаг.

Монтескю төрийн засаг захиргааны эрх мэдлийг хэрхэн хязгаарлах, түүнийг харгис дарангуй болгохоос хэрхэн сэргийлэх зэрэг улстөрийн гол асуудлыг ойлгож байжээ. **Жон Локкийн Хоёрдохь Сургаалд** тулгуурлаж тэрбээр ‘эрх мэдэл эрх мэдлийнхээ шалгуур байх ёстой’ гэх зэргээр эрх мэдлийг хуваахын төлөө маргаж мэтгэлцэж байв. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх байгууллагын эрх дарх нэг салбар нь эрх мэдлээ буруугаар ашиглахыг нь бусад нь хязгаарлах боломжтой байхаар өөр өөр байгууллагад байх ёстой. Хууль тогтоох байгууллага татвар тогтоох эрх мэдэлтэй байдаг нь гүйцэтгэх эрх мэдлийг хумьдаг. Гүйцэтгэх эрх мэдэл хууль тогтоох байгууллагын шийдвэрт вето буюу хориг тавих боломжтой байна. Хууль тогтоох байгууллага нь

10 *due process of law*

11 *presumption of innocence*

12 *separation of powers*

нэг танхим нь нөгөө нэгнийхээ шийдвэрийг зогсоох боломжтой байхаар хоёр танхимд хуваагдсан байна. Шүүх байгууллага бие даасан гэхдээ хуулийг ямар ч тал зассан байдалгүй хэрэглэх явдлыг бататгахаар хязгаарлагдах болно. Хуулийн зохих зөв ажиллагаа, үүн дотроо шударгаар шүүлгэх эрх, гэм буруугүй байдлыг дээдлэх^[13], гэмт хэрэгт дүйсэн шийтгэл зэрэг зүйл энд байх ёстой.

Монтескю Британи хэрхэн өөрийнхөө хаант засаглалыг хазаарласныг хараад сэтгэл нь хөдөлж байжээ. Гэвч тэрбээр төр засагт ер нь бол багахан эрх мэдэл хэрэгтэй, төр засгийн үүрэг нь биднийг хамгаалахынхаа хажуугаар биднийг аль болох эрх чөлөөтэй үлдээх явдал байдаг гэж бодож байв. Тийм учраас хуулиар зөвхөн олон нийтийн дэг журам болон аюулгүй байдалд анхаарал хандуулах, эрх чөлөөг хамгийн их болгохоор тэмүүлэх ёстой. Шашин эсвэл амьдралын хэвмаягийн тухайд ч гэсэнд хуульд хийх зүйл байхгүй. Хууль зөвхөн хүмүүсийн бодит үйлдэлд хамаатай байх ёстой бөгөөд харин тэдний болно гэж бодсон мэт сэдэлд хамаагүй байдаг. Хууль урьдаас мэдэгддэг, бүгдээрээ-дагаж мөрддөг, урьдаас таамаглахуйц байх ёстой. Харин дур зоргын, хувийн шинжтэй, өөрчлөгдөмхий байх ёсгүй.

Түүний дараа **Адам Смитийн** үйлдсэн шигээр, бас Монтескю арилжаа худалдаа (ялангуяа гадаад худалдаа) дахь төр засгийн интерференцийг солилцооноос зөвхөн зарагч этгээдээр зогсохгүй хоёр тал хоёулаа ашиг тус хүртдэг гэж батлан өгүүлэн шүүмжилж байлаа. Дайн болон эзлэн түрэмгийлэлтэй адилгүй нь олон-улсын худалдаа цэрэг арми эсвэл зардлын шаардлагагүйгээр ашиг тусаа өгдөг ажээ. Мөн энэ нь төр засгийн эрх мэдлийг хязгаарладаг: олон-улсын зах зээл^[14]ийг бие даасан салангид улсууд хянах боломжгүй; солилцооны ханшны хэмжээг аливаа улсын тушаалаар биш харин олон улс^[15]ын

13 *presumption of innocence*

14 *international markets*

15 *many countries*

худалдаачид тогтоодог; нэгэнт арилжаа худалдаа биднийг баян болгодог тул төр засаг үүнд саад тотгор болохоосоо илүүтэй үүнийг нөхцөлдүүлдэг байх ёстой; арилжаа хийж буй улсууд зээл даах чадвар^[16]тай хэвээр байх явдлын хэрэгцээ нь төсвийн хариуцлагагүй байдлыг хумихад дэм болдог. Эдийн засгийн бодит байдал тиймээс улстөрчдийн холын бодол буюу амбицыг хязгаарлах ашиг тустай хязгаарлалт байжээ.

[24] Волтаир [Франсуа-Мари Арөү] (1694–1778 он): Франц хүн, жүжгийн зохиолч, романч, полемицист. **Гол үзэл санаа:** Язгууртны засаглал, сүм хийдийн авилгалыг шүүмжлэх; ёс суртахуунт үйлдэл дэх оюун ухаан болон эрх чөлөөний үүрэг; хүлцэхүй, үг хэлэх эрх чөлөө; хууль ёс; меркантилизмийг шүүмжлэх; өмчийн эрхийн сайн тал^[17]. **Гол бүтээл:** *Английн тухай Философийн Захидлууд* [анг. *Philosophical Letters on the English*] (1734 он).

Волтаир бол Франц Гэгээрлийн Эриний чухал зүтгэлтэн байсан. Тэрбээр цаг үеийнхээ шударга бус байдал, мөн улстөрчид шашны зүтгэлтнүүдийн хоёр нүүр, завхралын талаархи өөрийнхөө хурц шүүмжлэл^[18]ээрээ хүчирхэг хүмүүсийн дургүйг хүргэв. Тэрбээр ‘Ерөнхийдөө төр засгийн ухаан бол иргэдийнхээ нэг хэсгээс аль болох их мөнгө хураан авч бусад хүмүүст өгөх явдлаас бүрддэг’ гэж ажиглан хэлсэн нь олонд алдаршжээ.

Хүн гүтгэсэн гэж буруутгагдсан, хүчирхэг эрх мэдэлтэй язгууртны заналхийлэлд орсон тэрбээр Англи руу цөлөгдсөн бөгөөд тэндээ гарамгай ухаантнууд болон шинэчлэгч нартай танилцаж, **Жон Локк**ийн бүтээлийг мэддэг болов. **Монтескю**гийн адилаар тэрбээр Британийн либерал институтууд, иргэний

16 *creditworthy*

17 *utility of property rights*

18 *polemics*

эрх чөлөө, үндсэн хуулийн төр засаг, үг хэлэх эрх чөлөө¹⁹⁾нд татагдсан байна. Тэрбээр үлдсэн амьдралаа эрх чөлөө, хүлцэхүй, чөлөөт үг яриа²⁰⁾, чөлөөт худалдааг дэмжихэд зориулахаар шийджээ. *Английн тухай Философийн Захидлууд* [анг. *Philosophical Letters on the English*] (1734 он)-даа Францыг язгууртны засаглалыг түлхэн унагаахыг уриалж, Сүм Хийдийн үл хүлцэхүйг шүүмжилсэн байдаг. Бастиллд хоригдсон нь Европ даяар тархаад байсан шударга бус байдал, хэлмэгдүүлэлтийн талаархи түүний дайралтыг зогсоосонгүй.

Волтаир Францад үндсэн хуулийн хаант засаглалын төлөө ухуулах ажил явуулж байжээ. Тэрбээр өргөн олны харалган зан ардчиллыг найдваргүй зүйл болгосон гэж боддог ч гэлээ гэгээрсэн өндөр боловсролтой эзэн хаан нийт хүн амынхаа сайн сайхныг сайжруулах шинэчлэл хийж чадна гэдэгт итгэж байсан. Волтаир эрх чөлөөний төлөө хүмүүн төрөлтөн байгалийн хуульд захирагддаг ч гэлээ тэд чөлөөтэй хүсэлтэй байдаг гэдгийг батлан өгүүлж мэтгэлцэж байв. Ёс суртахуунт үйл оюун ухаан, үүнийгээ үйлдэх эрх чөлөөнөөс гардаг, мөн чөлөөтэй үг хэлэх нь үүний амин чухал хэсэг ажээ. Тэрбээр хэзээ ч үнэндээ дараахь зүйлийг хэлээгүй: ‘Би таны хэлсэнтэй санал нийлэхгүй ч амиараа таны хэлэх эрхийг чинь хамгаална.’ Гэвч энэхүү богино хэллэг бол түүний үзэл бодлыг оновчтой хураангуй нь юм.

Волтаир дур зоргын эрх мэдлийг хууль ёсон дор оруулж хязгаарлахыг эрэлхийлж байв. Тэрбээр төр Загалмайтны Шашин зэрэг тодорхой сургаалыг дэмжих ёсгүй гэж хэлэн хүлцэхүйн төлөө маргаж мэтгэлцдэг байлаа. Мөн тэрбээр шударгаар шүүлгэх эрх, хүн бүр ямар ч мэргэжилтэй болох эрхтэй гэж батлан өгүүлж, мөн татварын илүү шударга дүрэмтэй тогтолцоо²¹⁾г шаардаж байсан. Тэрбээр эд баялаг тухайн улсын алт мөнгөнд оршдоггүй харин ажил хийдэг хүмүүсийнх нь

19 *freedom of speech*

20 *free speech*

21 *a fairer tax system*

шаргуу хөдөлмөр, бүтээлч байдал, ур чадварт л оршдог гэж хэлэн меркантилизм^[22]ыг шүүмжилж байв – энэ үзэл санааг хожим **Адам Смит** хөгжүүлж дэлгэрүүлэх болно. Тэрбээр сэдэлжиж тэмүүлэх^[23]ийн хүч чадлыг ойлгож байв: Волтаир хувийн өмчийг **Жон Локкийн** үздэг байсан шигээр жам ёсны хуулийн үүднээс биш харин хувийн өмч нь өөрийгөө-сайжруулах гэж тэмүүлэх хамгийн сайн хүсэл зоригийг хүмүүст өгдөг учраас л хамгаалж байлаа.

[25] Франсуа Кюснэй (1694–1774 он): Франц хүн, мэс засалч, эдийн засгийн ухааны Физиократ Сургуулийг үндэслэгч. **Гол үзэл санаа:** Меркантилизмийн тухай шүүмжлэл; эрх чөлөөнөөс гарах нийгмийн эв зохицол^[24]; дүрэм журмыг цөөлөх^[25], чөлөөт худалдаа. **Гол бүтээл:** *Эдийн засгийн тооцоо [анг. Economic Table] (1758 он).*

Үндэстний эд баялгийг алт мөнгөний хуримтлал, мөн эдгээр хуримтлалаа экспорт хийж нэмэх улсын чадвар гэж үздэг, давамгайлж байсан *меркантилизмээс* ялгаатай нь Кюснэй болон **Тюрго**гоор удирдуулсан ‘Физиократ’ эдийн засагчид үндэстний эд баялагийн суурь бол үр бүтээлч ажил хөдөлмөр юм батлан өгүүлж байсан.

Эдгээр үзэл санаа **Адам Смит** *Үндэстний Баялагтаа* меркантилизмийг шүүмжлэхэд нь асар их нөлөөлжээ. Гэвч нилээд хөдөө аж ахуйн орчинд амьдардаг Кюснэй зөвхөн хөдөө аж ахуйн буюу фермийн аж ахуйн хөдөлмөр л зөвхөн жинхэнээсээ үр бүтээлч, харин гар урчууд, худалдаачин, газрын эзэд, хөрөнгө оруулагч хүмүүс зэрэг бусад улс үүнийг л зөвхөн дэмждэг батлан өгүүлж байв. Арилжаа худалдааны талаар илүү нарийн гүнзгий

22 *mercantilism*

23 *motivation*

24 *social harmony*

25 *deregulation*

мэдлэгтэй Смит аливаа үр бүтээлч үйлдвэрлэл үндэстний эд баялагт хувь нэмэр оруулдаг гэдгийг ялгаж таньсан билээ.

Кюснэй нийгмийн эв зохицол лэзе-фээр бодлого^[26], чөлөөт өрсөлдөөнөөр л хамгийн сайн бий болдог гэдгийг сахин хамгаалж байв. Үүнийхээ дагуу тэрбээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тавьсан эртний хязгаарлалтуудыг зогсоохыг шаардаж байлаа. Кюснэй импортолдог бараа бүтээгдэхүүнд оноож буй тарифаа өгсөх, саад тотгор тавих гэсэн меркантилист бодлого үнэндээ ядуурлыг улам л их болгодог гэж батлан өгүүлж, өөрөө эмч нь байсан Мадам де Помпадүүр нөлөөтэй нууц амраг нь байсан XV Луй (1710–1774 он)-ээс иймэрхүү протекционизмыг зогсоохыг шаардаж байсан.

[26] Бенжамин Франклин (1706–1790 он): Америк хүн, төрийн зүтгэлтэн, полимат^[27]. **Гол үзэл санаа:** Америкийн Тусгаар Тогтнох Тунхаглал болон Үндсэн Хуулийн эхийг бэлтгэх; жам ёсны эрх; мөнгөний талаар няхуур бодох^[28]; арилжаа худалдаа болон эв найр. **Гол бүтээл:** *Хөөрхий Ричардын Алманах [анг. Poor Richard's Almanack] (1732–1758 он).*

Франклин Америкийн Нэгдсэн Улсыг байгуулах үйл явдлын тэргүүлэх зүтгэлтэн байжээ; тэрбээр Тусгаар Тогтнох Тунхаглал^[29]ын эхийг бэлдэхэд туслах үедээ 70 настай байсан бөгөөд хожим нь бас Үндсэн Хуулийн эх гаргахад туслав. Түүний гарын үсэг хоёуланд нь бий.

Зарим хүн Франклиныг консерватив үзэлтэн гэж үздэг ч гэсэн тусгаар тогтнох явдлыг өмгөөлж хамгаалсан, эрх чөлөөний талаархи гүнзгий агуулгатай бүтээл нь түүнийг либерал

26 *laissez-faire policy*

27 *polymath*

28 *monetary prudence*

29 *Унших газрыг нь зааж өгөх www.libraryforfreepeople.mn*

сэтгэгчдийн дунд оруулдаг. Хувьсгалын аюул занал байсаар байсан ч гэсэн тэрбээр ‘Чухал Эрх Чөлөөгөө [бусдад] өгсөн хүмүүс түр зуурын Аюулгүй Байдал л оронд нь авдаг бөгөөд ийм хүмүүс Эрх Чөлөөтэй бас Аюулгүй Байдалд байх ч эрхгүй’ гэж хэлэн эрх чөлөөг ямар ч үнээр хамаагүй хамгаалах ёстой гэдгийг батлан өгүүлж байлаа.

Франклин мэдээжээр шашинлаг либерал үзэлтэн байсан: Пүритан^[30] болж өссөн тэрбээр шашинд итгэгч хэвээр үлдсэн ч зохион байгуулалтад орсон бүх шашныг эсэргүүцдэг болсон. (Жишээлбэл Франклин удаан хугацаанд хамт амьдарсан эмэгтэйдээ хэзээ ч сүмд гэрлэж байгаагүй.) Тэрбээр **Жон Локк**ийн жам ёсны эрхийн тухай эргэцүүллийг дэмжиж байлаа: ‘Эрх чөлөө бол бидэнд бусад хүмүүс бэлэглэсэн бэлэг биш’ гэж эхлээд ‘харин Бурхан болон жам ёсны хуулиар бидэнд байдаг тэр эрх юм’ гэж бичиж байв.

Франклин иймэрхүү үзэл бодлыг өөрийнхөө хэвлэдэг, өөрийг нь баяжуулсан сонин, алманах^[31]аар дамжуулан нийтэд түгээж хөгжүүлж байлаа. Тэрбээр мөн хууль мөнгөн тэмдэгт хэвлэж мөнгө олж байсан ч энэ хоёр олдвол аюултай гэж дараахь зүйлийг бичин анхааруулж байв: ‘Цаасан мөнгө хэвийн тоо хэмжээтэй байхдаа ашиг тустай; гэвч арилжаа наймаанд шаардлагатайгаасаа илүү ихэдвэл үнэгүйдэж, муу нөлөөтэй болдог бөгөөд олон нийт хэрэгтэйгээс нь илүү ихийг шаардах хандлагатай байдаг’. Энэхүү чухал санааг **Милтон Фрийдмэн** хоёр зууны дараа дахин амилуулах болно.

Франклин олон жил Европд Пенсалваниагийн төлөөлөгчийн

30 *Puritan-I* Элизабетийн удирдлага доорхи Сүм Хийдийн Шинэчлэлийг дутуу дулимаг зүйл гэж үзэн, сүмд мөргөл үйлдэх явдлыг хялбаршуулах, хэлбэрийг нь зохицуулах гэж эрэлхийлж асан, 16-р зууны сүүл болон 17-р зууны үеийн Английн Протестантуудын бүлгийн гишүүнийг хэлнэ.

31 *almanacs*-голдуу жил бүр хэвлэдэг, чухал огноо, тоон мэдээлэл агуулдаг зурагт тайлбар сэтгүүлийг хэлнэ.

хувиар амьдарсан бөгөөд дараагаар нь Францад өөрийн шинэ улсын элчин сайдаар сууж байжээ. Тэнд тэрбээр эдийн засгийн өсөлт арилжаа худалдаа, өрсөлдөөн, чөлөөт худалдаанаас бий болдог гэж үздэг **Кюэснэй, Тюрго** нарын Физиократ үзэл санаатай танилцсан. Франклин энэхүү бодлогыг дараахь байдлаар маш ойлгомжтой товчхон буулгажээ: ‘Америкийн тогтолцоо бол бүх үндэстэнтэй хийх универсал буюу хаа сайгүй бүх газартай хийх арилжаа худалдаа юм; аль ч улстай үл дайтна’.

[27] **Дэвид Юм** (1711–1776 он): Шотланд хүн, философич, түүхч. **Гол үзэл санаа:** Оюун ухаанд бус харин үр ашигт суурилдаг нийгэм; өмчийн эрх; хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засаг. **Гол бүтээл:** *Эссэ, Ёс Суртахуун, Улстөр, Бичиг соёл* [анг. *Essays, Moral, Political, and Literary*] (1742 он).

Дэвид Юмын хүмүүний ухаарац мэдлэг, учир шалтгаант байдал, хэрэгцээт байдал, ёс суртахуунт байдал, шударга ёс, эдийн засгийн ухаан, улстөрийн онол, шашны талаархи гүнзгий мэдлэг нь түүнийг бүх цаг үеийн хамгийн чухал философичдын нэг болгожээ. Тэрбээр мөн өөрийн найз **Адам Смит**ээс авахуулаад (Юмыг өөрийг нь “догматик зүүд”^[32]нээс сэрээсэн гэж цохон хэлсэн) **Иммануэл Канта**ар дамжаад, **Ф. А. Хаек** зэрэг голлох либерал сэтгэгчдэд нөлөөлж, тэдэнд урам зориг өгчээ.

Юм тэр цаг үеийнхээ философийн уламжлалыг өөрийн гутранги шүүмжилсэн аястай, эмпирик арга замаараа үгүйсгэхдээ хурц ширүүн байжээ; гэвч тэрбээр эв найр, хөгжил цэцэглэлт, шударга ёсны тухайд уламжлалт ёс журмыг дагаж мөрдвөл хамгийн тустай гэсэн илүү консерватив дүгнэлтэд хүрсэн байдаг.

Юм арав эсвэл арван нэгэн настайдаа Эдинбургийн Их Сургуульд элсэн оржээ. Дөнгөж 23 насандаа өөрийн сод

32 ‘dogmatic slumbers’

бүтээл^[33] болох *Хүмүүний Байр Байдлын Тухай Сургаал* [анг. *Treatise of Human Nature*] (1739 он) бүтээлээ эхлүүлж байв. Хэдийгээр шинжлэх ухааны албан тушаал шашны талаархи олныг эгдүүцүүлсэн үзлээс нь болж олгохоос татгалзсан ч *Хүмүүний Ухаарац Ойлголттой холбоотой Санал* [анг. *Enquiry Concerning Human Understanding*] (1748 он)-ээ гаргасных нь дараагаар түүнийг Өмгөөлөгчдийн Тэнхимд Номын Санчаар ажиллахыг түүнд санал болгов. Тэнд тэрбээр хамгийн сайн борлуулалттай, түүнийг алдартай болгосон, мөн баяжуулсан *Английн Түүх* [анг. *History of England*] (1754–62 он)-ээ эхлүүлсэн. Юм 1763 онд Парис дахь Британийн Элчин Сайдын хувийн нарийн бичиг болов. Тэндээ Юм олонд алдаршсан найрсаг зан байдал нь түүнийг олон салон^[34]д уригддаг болгожээ. Тэрбээр амьдралынхаа туршид шашингүй үзэлтэн хэвээр үлдсэн ч гэлээ түүний хамгийн гайхшируулсан шүүмжлэлт бүтээл болох *Байгалийн Хуультай Холбоотой Яриа* [анг. *Dialogues Concerning Natural Religion*] (1779 он)-гаа зөвхөн үхсэнийх нь дараа л хэвлүүлэхээр болгож захиж үлдээсэн байдаг.

Юм бид бусад хүмүүстэй харьцахдаа мэдэрдэг сэтгэл татагдах явдал^[35] хүртэл нь ёс суртахууны сэтгэлийг судалж мөшгөжээ (өнөөдөр бид үүнийг эмпати^[36] гэж хэлдэг) – энэ бол **Адам Смит** *Ёс Суртахууны Сэтгэлийн Онол* [анг. *The Theory of Moral Sentiments*] (1759 он)-дээ үүсгэж хөгжүүлсэн хувьсгал болохуйц үзэлт санаа юм. Байгаль бидэнд буяны үйлс, найрсаг зан, эцэг эхийн хайр зэрэг хэрэгтэй, жам ёсны үнэт зүйлийг бэлэглэсэн гэж Юм хэлдэг. Гэвч өнөөдрийн том хэмжээтэй нийгэмд амьдрахдаа бүх үр өгөөжийг нь хүртэхийн тулд бидэнд өмчийн эрх, гэрээ, шударга ёсыг хүндлэх зэрэг илүү зохиомол,

33 *monumental*

34 *salon*-Энэ нь гоо сайхны үйлчилгээтэй холбоогүй харин нийгмийн дээд давхаргын эмэгтэй хүний гэрт ялангуяа зохиолчид, жүжигчин, урчууд цуглардаг, байнга болдог нийтийн арга хэмжээг хэлдэг ажээ.

35 *sympathy*

36 *empathy*

илүү сайн зүйл^[37] хэрэгтэй байдаг ажээ. Бид эдгээр сайн зүйлийг зөн совингоор биш харин үр өгөөжөөс нь болж, эдгээр нь хулгай дээрэм, хүчирхийллээс сэргийлэх, хамтдаа эв найртай амьдрах боломж олгодог учраас л хүндэлдэг. Аажимдаа эдгээр сайн зан төлөв бидний нийгмийн дадал зуршилд гүн сууж, бидний зан араншний хэрэг явдал болдог ажээ. Бид төр засгаас эдгээр үр өгөөжтэй дэг журмыг бүтээхийг шаарддаггүй: иргэний нийгэм төр засгаас ч урьд нь өмнө үүсэж гарах боломжтой.

Эдгээр сайн зүйлээс үүсэж хөгжсөн тодорхой ёс журам бол уламжлалын хэрэг явдал юм. Хэрэв эдгээр ёс журам хүлцэн тэвчихээр сайн ажилладаг, мөн хүлээн зөвшөөрөгдсөн байвал өмч эсвэл шударга ёсны ёс журам чухам ямар байх нь тийм ч ач холболдолтой биш. Тиймээс л эв найрыг баталгаажуулдаг шүүхийн тогтолцоотой байх нь шүүхийн үйл ажиллагаа тулгуурладаг яг тэр хууль ямар байхаас илүү чухал ажээ. Хүмүүс хөрөнгө оруулж, эд баялаг бүтээхэд нь өмчлөлийн эрх, өмч шилжүүлэх, гэрээний мэдэгдэж буй, хүлээн зөвшөөрөгдсөн, сайн ажилладаг ёс журам тэнд байх ёстой – бүр тэгээд тухайн тэр ёс журам нийгэм бүрд нилээд ялгаатай байж ч болно.

Юмын хувьд хөгжин цэцэглэх нийгмийн үндэс нь бүх нийтийн санал нэгдэх явдлаар хэлбэржсэн, туршлага сургамжаар хүндэтгэл хүлээсэн, ажилладаг, өөрөө-тогтдог дэг журам байжээ. Тэрбээр Жон Локкийн тайлбар зэрэг бүх рационалистч тайлбар^[38]ыг үгүйсгэж байв. Оюун ухаан бидэнд хүслээ гүйцээхэд тусалж болох ч биднийг энэ нь сэдэлжүүлдэггүй гэж батлан өгүүлж байсан. Оюун ухаан зүгээр л ‘таашаалын’^[39] боол’ ажээ.

Оюун ухаан болон туршлага сургамж бидэнд зааж сургасан нэг зүйл бол төр засгийн эрх мэдлийг хязгаарлах хэрэгцээ шаардлага байдаг тухай санаа юм: ‘Улстөрийн зохиогч нар төр засгийн тогтолцоог зохион гаргахдаа, мөн үндсэн хуулийн хэд

37 *artificial virtues*

38 *rationalist explanations*

39 *passions*

хэдэн шалгах, хянах шалгуурыг тогтоож гаргахдаа хүн бүрийг байж болох бүтэхгүй худалч, бүх үйлдэлдээ хувийн ашиг сонирхлоос өөр ямар ч өөр зорилгогүй хүн гэж үзэх ёстой гэдгийг дээд зарчим^[40] болгож тогтоожээ’.

[28] Адам Фергүсон (1723–1816 он): Шотланд хүн, нийгмийн онолч. **Гол үзэл санаа:** Өөрөө-тогтдог дэг журам; хөдөлмөрийн хуваарь; шинэчлэл, өсөлт. **Гол бүтээл:** *Иргэний Нийгмийн Түүхийн тухай Эссэ* [анг. *Essay on the History of Civil Society*] (1767 он).

Фергүсоныг *Иргэний Нийгмийн Түүхийн Тухай Эссэ* [анг. *Essay on the History of Civil Society*] (1767 он) бүтээлд нь үндэслэж “орчин үеийн социологийн ухааны үндэслэгч” гэж голдуу хэлдэг. Тэрбээр либерал бодол санаанд цөөн боловч өвөрмөц хувь нэмэр орчуулсан ч гэсэн өөрөө-тогтдог дэг журмын тухай гүн утгатай дараахь богино хэллэгээрээ дурсагддаг: ‘Бүр гэгээрлийн эриний утга санаагаар ч гэсэн олон давтагддаг алхам, хөдөлгөөн бүрийг ирээдүйг үл мэдэх байдлаар үйлддэг; үндэстнүүд хүмүүний төлөвлөсөн бодл^[41]ыг гүйцэлдүүлсний үр дагавар биш харин хүмүүний үйлдлийн үр дүнд үнэндээ үүсдэг суурь бүтэц^[42] дээр л өндийн босдог’.

Тэрбээр (**Самүэл фон Пүфендорфын** адилаар) хүмүүн төрөлтөн бол ерөөсөө л нийгмийн бодгаль гэдгийг цохон зааж **Томас Хоббесын** байгалийн дайсагнагч төлөвийн тухай үзэл санааг эсэргүүцсэн. Хэн ч бусдаасаа тусгаар амьдардаггүй: хүмүүс төрж өссөн гэр бүл, хэл яриа, ёс суртахууны хэм хэмжээгээрээ хэлбэрждэг бөгөөд тэд товчхондоо нийгэмд төрж хүмүүн болдог ажээ.

Фергүсон хожим нь **Адам Смит** хөгжүүлэх, хөдөлмөрийн

40 *maxim*

41 *human design*

42 *establishments*

хуваарийн тухай үзэл санааг дараахь байдлаар гаргав:

Зураач [уран хүн] тэрбээр өөрийн анхаарлаа аливаа ажлын тодорхой хэсэгт төвлөрүүлбэл түүний бүтээл илүү төгс болж, түүний гараас илүү их хэмжээгээр бүтээл гардаг болохыг олж мэдсэн. Үйлдвэр эрхэлдэг авсчин өөрийн ажилчдынхаа хийх ажлыг дотор нь илүү ихээр ангилах тусам өөр өөр эд зүйл хийхэд ажиллуулах боломжтой хүн илүү олон хийх хүн суларч буйг, мөн зардал нь илүү их буурч, ашиг нь нэмэгдэж байгааг олж мэддэг.

Тиймээс л хөгжил цэцэглэлтийг хурдасгадаг, бүтээлч олон янз байдал, үр ашигтай байдал, шинэчлэл шинэ санааны ертөнцийг өөрийн-тусыг бодох явдлаараа дамжуулан хүмүүс санамсаргүйгээр бүтээжээ. Гэвч Фергүсон хөдөлмөрийн хуваарь^[43] нь бүхэлдээ сайн нөлөөтэй байх эсэхэд эргэлзэж байв. Үүнээс болж нийгэм анги давхраажих, нийгмийн хурцадмал байдал үр дүнд нь гарах ч боломжтой, мөн хэрэв аюулгүй байдлыг бүхэлд нь цэргийн хүмүүст үлдээж орхивол тэр нь харгис дарангуйлагч болох бололцоотой гэж бодож байсан.

[29] Адам Смит (1723–1790 он): Шотланд хүн, философич, эдийн засагч. **Гол үзэл санаа:** Хүмүүний эмпати болон өөрөө-тогтдог дэг журам; меркантилизм рүү дайралт хийсэн; чөлөөт худалдаа харилцан өгөөжтэй; бүтээлч байдал; хөдөлмөрийн хуваарь; үл үзэгдэх гар; зах зээл нөөц баялагийг үр бүтээлтэй хэрэглээ рүү чиглүүлдэг; шударга ёс; хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засаг. **Гол бүтээл:** *Ёс суртахуунт Сэтгэлгээний Онол [анг. The Theory of Moral Sentiments] (1759 он); Үндэстний Баялаг [анг. The Wealth of Nations] (1776 он).*

43 *division of labour*

Адам Смит арваннайдуугаар зууны Шотланд Гэгээрлийн Эриний хамгийн гарамгай сэтгэгчдийн нэг байжээ. Ном улайран цуглуулагч, үзэл санааг шунан хуримтлуулагч тэрбээр ёсзүй, юриспруденц буюу хуульзүйн хамаарах хүрээ, утга зохиол, улстөрийн ухаан, шинжлэх ухааны философийн талаар бичиж, лекц уншдаг байв. Өнөөдөр түүнийг анхны шан татсан эдийн засагч гэж санан дурсдаг: маш нөлөөтэй *Үндэстний Баялагийн Байр Байдал, Учир Шалтгааны Талаархи Санал* [анг. *An Inquiry into the Nature and Causes of the Wealth of Nations*] (1776 он) гэсэн бүтээл нь чөлөөт зах зээл, нээлттэй өрсөлдөөн, хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засг^[44]ийг хамгаалах гаргалгаа нотолгоо болжээ.

Гээд бага залуугийнх нь *Ёс Суртахуунт Сэтгэлийн Онол* [анг. *The Theory of Moral Sentiments*] (1759 он) гэсэн ёсзүйтэй холбоотой ном нь Смитийг алдартай болгосон. Гэгээрлийн Эриний философичид шашны зүтгэлтэн болон удирдагчаас доош нь хүмүүст өгсөн догма буюу ягшмал сургаалаас ондоо ёс зүйн бат суурьтай үндэслэл шалтгааныг эрж хайж байжээ. Зарим нь “рационал” хувилбарыг нь эрж хайж байв. Үүнээс ялгаатай нь Смит ёс суртахуунт байдал хүмүүний нийгмийн психологийн хэвшинж байдаг гэж санал болгов. Бид бусадтай харьцахдаа байгалиасаа сэтгэл татагдамхай зантай (өнөөдөр бид үүнийг *эмпати* гэдэг) байдаг ажээ. Бусдын таашаал эсвэл зовиур бидэнд нөлөөлдөг; бид бусдын уур хүргэхээс илүүтэй тэдний хүндлэлийг хүлээх байдлаар л үйл хийх дуртай. Энэ ном дараахь үгсээр эхэлдэг: ‘Хүнийг хэр зэрэг амиа боддог гэж ч төсөөлж байж болох ч тэрбээр үүнээсээ түүнийг харж таашаал авахаас өөр зүйл олж авдаггүй ч гэлээ бусдын аз жаргалд анхаарал тавьж, тэр хүмүүст хэрэгтэй аз жаргалыг нь өгдөг түүний байр байдалд зарим нэг зарчим бий гэдэгт эргэлзэх хэрэггүй’. Бусдын төлөө тавьдаг энэхүү байгалийн мэдрэмж бидний үйлдэл хэрхэн бусад

44 *limited government*

хүмүүст нөлөөлөхийг [урьдаас] бодож үзэхэд хүргэдэг бөгөөд өөрсдийнхөө аминч үзлээ *чин шударга үзэгч* санал нийлж дэмжих боломжтой байхаар хязгаарлахад хөтөлнө. Энэхүү хязгаарлалт цаашид тэсэж үлддэг, нийгмийн сайн-ажилладаг дэг журам бий болоход тусалдаг гэдгийг Смит олж харжээ.

Энэ ном тэр дороо л амжилтад хүрэв. Энэ явдал Бакклогийн Герцог буюу Дюк^[45]ийн хойд эцэг нь Смитийг нас бага герцогт багшлах, мөн Европоор тойрон дагуулж явуулах гэж насан туршид нь хөлс өгөхөөр болжээ. Энэ явдал Франц болон Швейцарт байхдаа Смит Европын хамгийн аугаа сэтгэгчидтэй үзэл санаа хэлэлцэж мэтгэлцэх, арилжаа худалдаа болон зохицуулалтын янз бүрийн тогтолцооны талаар тоо томшгүй баримт цуглуулах боломжтой болгожээ. Тэрбээр өөрийн болон бусдын үзэл санааг эдийн засгийн ухааны шинэ, зүйтогтолжсон, орчин үеийн судалгааны хандлага болгож нэхэж, хожмоо *Үндэстний Баялаг* болох зүйлийн тухай бичиж эхлэв.

Смитийн цаг үед ноёлж асан эдийн засгийн тогтолцоо үндэстний эд баялагийг алт болон мөнгөний хуримтлалаар л хэмждэг меркантилизм байсан. Бодлого нь аль болох ихээр бусад улсад юм зарж, аль болох буцаад тэднээс бага зүйл худалдан авч энэхүү хуримтлалаа хөөргөж өсгөхөд л чиглэж байжээ. Импортлох явдал гаалийн тариф болон дүрэм журам зохицуулалтаар боомилгдсон байв; экспортыг татаасаар дэмжиж байлаа.

Гэвч Смит арилжаа худалдаанаас зөвхөн зарагч хүн биш харин хоёр тал хоёулаа ашиг тус хүртдэг гэдгийг хэлж байв. Бараа зарагч хүн мэдээжээр бэлэн мөнгө авдаг бол харин худалдан авагч нь төлж буй бэлэн мөнгөнөөсөө илүү үнэлж үзэж байгаа бараа бүтээгдэхүүнээ оронд нь авдаг. Аль ч тал нь наймаанд хэрэв тэд үүнээс ашиг тус хүртэхгүй бол оролцохгүй. Смит улс орныг баян болгодог зүйл бол алт болон мөнгө биш харин хийдэг арилжаа худалдаа нь юм гэж дүгнэжээ; үүний

45 *Duke*

хэмжээс нь жинхэнээсээ хэр ихийг үйлдвэрлэсэн, түүнийгээ хэр ихээр солилцсон тэр хэмжээ байдаг ажээ – энэ хэмжээсийг өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүн^[46] гэж нэрлэдэг. Тэр бараа бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх арга зам бол арилжааг чөдөрлөж хорих явдал биш харин түүнийг чөлөөлөх явдал гэж батлан өгүүлж байлаа.

Үнэндээ бид бидний бараа бүтээгдэхүүнээ нарийн мэргэжих явдал буюу хөдөлмөрийн хуваариар бий болгох боломжтой асар их үр бүтээлч байдлаар дамжуулан нэмэгдүүлж чадна. Зүүний үйлдвэрийн жишээг ашиглаж Смит үйлдвэрлэлийг олон мэргэжилтний хийх ажил болгож дотор нь хуваах явдал гарцыг мянга мянга дахин өсгөж сайжруулах боломжтой болохыг харуулсан. Үйлдвэрлэгч энэ үед өөрийн хэрэгцээнээс хамаагүй илүүг бүтээж үйлдвэрлэж чадах бөгөөд илүү гарсан зүйлээ өөр бусад зүйл үйлдвэрлэхдээ мэргэжсэн бусад хүмүүстэй солилцох боломжтой болно. Тиймээс л хүн бүр бусдынхаа онцгой сайн мэргэжсэн байдл^[47]аас ашиг тус хүртдэг. Үйлдвэрлэгчид мөн илүү гарсан зүйлийнхээ заримыг бүтээлч байдлыг нь өсгөх, ингэснээр үндэстний баялгийг бүр ч ихээр өсгөх үйлдвэр болон багаж хэрэгсэл зэрэг үндсэн тоног төхөөрөмж^[48]ид хөрөнгө оруулахад ашиглах боломжтой болно.

Энэ бол хэдийгээр хэн ч ингэж ажиллана гэж төлөвлөөгүй ч гэлээ маш ихээр хамтаараа ажилладаг тогтолцоо^[49] юм. Хүмүүс бусдын төлөө биш харин өөрсдийнхөө сайн сайхны төлөө бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, солилцоо хийдэг:

‘Махны худалдаачин, пиво исгэгч эсвэл талхчны өгөөмөр зангаас болж бид хоолтой хонодоггүй харин тэдний өөрийн ашиг сонирхлоо бодох явдлаас үүдэж бид хоолтой хонодог

46 *gross domestic product*

47 *specialisation*

48 *capital goods*

49 *cooperative system*

билээ'. Гэлээ гээд ингэхийг зориогүй ч гэсэн тэд мөн арилжаа хийж буй бусад хүмүүсээ, гарцаагүй нийт нийгмээ баяжуулж, амьдралыг нь сайжруулдаг: Хувь хүн бүр ... олон нийтийн ашиг сонирхлыг тэтгэхийг зорьдоггүй, мөн бас тэрбээр үүнийг хэр ихээр тэтгэж буйгаа ч мэддэггүй ... зөвхөн л өөрийн аюулгүй байдлаа л бэхжүүлэхийг зорьдог ажээ; бараа бүтээгдэхүүн нь хамгийн их үнэ цэнэтэй байж болохоор үйлдвэрлэлийг чиглүүлж удирдах замаар тэрбээр зөвхөн өөрийн ашиг тусын төлөө зорьдог бөгөөд үүнийгээ хийхэд нь олон тохиолдолд үл үзэгдэгч гар^[50] түүнийг чиглүүлэн замчилж, зорилгынх нь нэг хэсэг байдаггүй тийм зорилгыг тэрбээр тэтгэдэг.

Энэхүү урьдаас төлөвлөөгүй хамтын ажиллагаа маш их үр өгөөжтэй байдаг тул мэдэгдэж буй бүхэл дэлхийд түгэн тархжээ: бүр жирийн ноосон хүрэмд хэдэн улс дамнасан, хоньчноос ноос ээрэгч, будагч, далайчин, багаж үйлдвэрлэгч, жижиглэнгээр зарагч гээд хэдэн мянган хүний хөдөлмөр шингэснийг тайлбарласан байдаг.

Арилжаа худалдааны урьдаас төлөвлөөгүй өөр нэг ашиг тус бол энэ нь автоматаар нөөц баялгийг хэрэгцээтэй байгаа газар руу нь чиглүүлж залдаг явдал юм. Элдэв зүйл ховор байгаа газарт хэрэглэгчид түүний төлөө илүү их мөнгө төлөх гэж хүсэж байдаг; түүнийг нь нийлүүлэхэд нь илүү ашигтай байдаг тул үйлдвэрлэгч илүү ихийг үйлдвэрлэнэ. Бараа бүтээгдэхүүн илүүдэхэд үнэ нь буурч унадаг бөгөөд үйлдвэрлэгч хүчин чармайлтаа илүү их үнэтэй бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шилжүүлдэг. Тийм учраас үйлдвэрлэл хүмүүсийн хамгийн чухал хэрэгцээнд л анхаарал төвлөрүүлсэн хэвээр байдаг. Ийм зүйл ямар нэг зохицуулалт болон төлөвлөлтгүйгээр болдог ажээ:

[Энэ] жам ёсны эрх чөлөөний ойлгомжтой, энгийн

тогтолцоо өөрөө өөрийнхөө замнал хэмнэлээр үүсэж гардаг. Хүн бүр ... өөрийн арга замаараа өөрийн ашиг сонирхолдоо хүрэхээр тэмүүлж болохоор бүрэн чөлөөтэй байх аж ... Биелүүлэхэд нь хүмүүний цэцэн ухаан эсвэл мэдлэг хэзээ ч хангалттай байх боломжгүй байдаг үүргээс иргэн хүн^[51] бүрэн чөлөөлөгддөг; хувь хүмүүсийн ур чадварыг удирдах чиглүүлэх, мөн хүмүүсийн ур чадварыг ажил эрхлэх байдал руу залах явдал бол нийгмийн ашиг сонирхолд хамгийн сайн нийцдэг зүйл юм.

Гэвч энэ байдал хэрэв чөлөөт худалдаа болон өрсөлдөөн байгаа үед л автоматаар явагддаг. Төр засаг өөрийн таашааж буй үйлдвэрлэгчдээ татаас өгч эсвэл монополь байдал батлан олговол эсвэл гаалийн тарифын хананы цаана тэдгээрийг хамгаалбал тэр үед хэрэглэгчид эдгээр үйлдвэрлэгчдэд мөлжүүлж ашиглагдах болно. Ядуу хүмүүс амьдралаа залгуулдаг хэрэгцээт зүйлийнхээ төлөө илүү их төлбөр төлж хамгийн ихээр хохирдог.

Өмчийн эрхийг хамгаалдаг шүүхийн тогтолцоо мөн л маш чухал зүйл билээ. Хэрэв хүмүүс хөрөнгө бүрдүүлж бүтээх гэж байгаа бол тэд энэ хөрөнгө нь аюулгүй байдалд байх болно гэдэгт итгэлтэй байх ёстой. Хөгжиж цэцэглэж байгаа улс орнууд хүмүүсийн өмчийг хулгайлах дээрэмдэхээс хамгаалдаг институттэй байдаг билээ. Энэ зүйлд хулгайн үл мэдэгдэм төрөл ч багтдаг – энэ бол наймаачин хууль тогтоогчтой тогтоосон өөрийн улстөрийн нөлөөгөө ашиглаж монополь эрх олж авах, татварын хөнгөлөлт эдлэх, хяналт болон бусад давуу тал олж авдаг, зах зээлийг өөрт таатай байхаар гажуудуулдаг тийм хулгай юм – энэ зүйл бол крони буюу амин-найзын капитализм^[52] гэж өнөөдөр бидний нэрлэдэг зүйл ажээ.

Тиймээс л Смит төр засгийг хязгаарлагдмал эрх мэдэлтэй байлгах ёстой гэж дүгнэсэн байдаг. Төр засаг батлан хамгаалах,

51 *sovereign*

52 *crony capitalism* - орос. клановый капитализм

шүүх, дэд бүтэц, боловсрол зэрэг үндсэн функцтэй л байна. Гэвч төр засаг зах зээлийг нээлттэй, чөлөөтэй байлгах, түүнийг сарниулж бусниулахгүй байх ёстой. Ямар ч тохиолдолд хүмүүн төрөлтөн засаг захиргааны төлөвлөгөөнд саад болдог өөрийн гэсэн санаатай хувь хүмүүс байдаг:

Тогтолцооны хүн^[53] ... тэрбээр аугаа нийгмийн янз бүрийн гишүүдийг шатрын хөлөг дээр буй шатрын модыг гараараа байрлуулах мэтээр тийм хялбараар зохион байгуулж эмхэлж цэцэглэх чадалтай гэж төсөөлдөг мэт харагддаг. Тэрбээр хүмүүний нийгмийн аугаа шатрын-хөлөг дээр мод нэг бүр нь өөрийн гэсэн нүүдэлтэй бөгөөд энэ нь хууль тогтоогч түүнд тулгаж оноох боломжтой зүйлээс бүхэлдээ ондоо зүйл байдаг гэдгийг анхаардаггүй.

[30] Ричард Прайс (1723–1791 он): Вэйлсийн буулт үл хийгч ламтан^[54], памфлет гаргагч^[55], радикал үзэлтэн. **Гол үзэл санаанууд:** Эмэгтэйчүүдийн эрх; төр засгийн гэрээний үндэс суурь; сонгуулийн шинэчлэл; олон нийтийн өрийг эсэргүүцэх. **Гол бүтээл:** *Үндэстний Өрийн Тухай Сэдвээрхи Олон Нийтэд Хандсан Хүсэлт* [анг *Appeal to the Public on the Subject of the National Debt*] (1772 он); *Иргэний Эрх Чөлөөний Байр Байдлын Талаархи Ажиглалт* [анг. *Observations on the Nature of Civil Liberty*] (1776 он).

Прайс Америкийн шилжин суурьшигчид Британитай хийсэн маргааныг өмгөөлж хамгаалснаараа алдартай болсон ч гэсэн түүнийг эмэгтэйчүүдийн эрхийн талаархи үзэл санааг үүсгэж хөгжүүлсэн **Мэри Воллстөункрафтын** оюун санааны багш гэдгээр нь өнөөдөр дурсдаг.

53 *man of system*

54 *nonconformist preacher*

55 *pamphleteer*

Буулт үл хийгч ламтан^[56] Прайс эзэн хаад бурхнаас олгосон засаглах эрхгүй харин хүмүүсийн итгэлээр эрх мэдэлтэй болдог гэж батлан өгүүлж байв. Цор ганц хуульзүйн дагуух эзэн хаад^[57] бол 1689 оны Эрхийн тухай Билл^[58] гэж нэрлэдэг, хүмүүстэйгээ иргэдтэйгээ байгуулсан ойлгомжтой гэрээгээр эрх мэдэл нь хязгаарлагдсан Британийн хаан ажээ. Тэрбээр Америк хувьсгалчид (дараагаар нь Францын хувьсгалчид) үүнтэй адилхан гэрээний төрлийн төлөө зүтгэж зорьж байсан. *Хүний Эрхүүд* [анг. The Rights of Man] (1791 он) гэсэн **Томас Пэйний** бүтээлийн ихэнхи нь түүний гаргалгаа нотолгоонд суурилжээ; тэрбээр **Бенжамин Франклин** болон Жон Адамстай (1735–1826 он) найз болж, Иелийн хүндэт зэрэгтэй болон, бүр (хэдийгээр татгалзсан ч) Америкийн иргэн болгох хүсэлт хүлээн авч байв. Францын тухайд тэрбээр **Тюрготой** захидлаар харилцаж, Францын хувьсгалчдыг дэмжиж байсан ч Аллага Хядлагын бүх аюул дэгдэхийн өмнө нас баржээ.

Прайс Британийн парламентын олонд алдаршсан сонгуулийн авилгажсан тогтолцоог шинэчлэхийн төлөө, мөн боолын худалдааны эсрэг маргаж мэтгэлцэж байв. Тэрбээр 1771 онд үндэстний буюу улсын өр байгаа явдал руу дайрч давшилсан явдлыг ухаарсан Ерөнхий Сайд Виллиам Питт (1759 – 1806 он) арван жилийн дараа ийм өрийг багасгахаар хуримтлуулах сан^[59] үүсгэж байгуулжээ.

[31] Иммануэл Кант (1724–1804 он): Герман хүн, философич. **Гол үзэл санаа:** Эрх чөлөөний универсал буюу хаа сайгүй бүх хүнд байдаг эрх; төр эрхүүд болон эрх чөлөөг хамгаалахаар л хязгаарлагддаг; хувь хүн арга хэрэгсэл биш зорилго; ёс суртахуунт үйл чөлөөт сонголт

56 *nonconformist preacher*

57 *legitimate monarchs*

58 *1689 Bill of Rights*

59 *sinking fund-өр хожим төлөхөөр мөнгө хуримтлуулдаг данс*

байхыг шаарддаг; ёс суртахуун болон улстөрийн зарчим заавал универсал байх ёстой; эрх жам ёсны биш харин уламжлагдсан байх учиртай; ардчилсан биш харин гэрээний, хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засаг; хууль ёс. **Гол бүтээл:** *Ариун Оюун Ухааны Шүүмж* [анг. *Critique of Pure Reason*] (1781 он); *Ёс суртахууны Метафизик* [анг. *The Metaphysics of Morals*] (1797 он).

Кантыг метафизикийн ухааны үзэл бодол болон мэдлэгийн тухай онолынх нь төлөө л голчлон хүмүүс дурсдаг боловч тэрбээр мөн ёсзүй, улстөрийн онолыг судалдаг байлаа. Тэрбээр эрх чөлөөг бүх хүний буюу универсал эрх гэдгийг баримталдаг бөгөөд хувь хүмүүсийг бусад хүмүүсийн зорилгын *арга хэрэгсэл* гэж үзэх боломжгүй гэж батлан өгүүлж, тэд бол ижил тэнцүү, бие даасан гэж ойлгож, мөн эрх болон эрх чөлөөг хамгаалахын тулд төр засгийг хязгаарлахаар эрэлхийлж байсан. Энэ бүх зүйл түүнийг либерал хүн гэдгийг нь харуулдаг ч гэсэн түүний бусад гол санаа нь консерватив, авторитарич үзэлтэй байжээ.

Кантын хувьд ёс суртахуунт байдлын үндэс нь оюун ухаан байв. Гэвч оюун ухаанаа ашиглахын тулд бид чөлөөтэй байх ёстой – бид өөрсдийн үзэл бодлоо гаргаж тавих, батлан өгүүлэх нь чөлөөтэй байх, мөн үзэл бодолдоо үндэслэн чөлөөтэй үйл хийдэг байх ёстой. Хэрэв бид өөрсдийнхөө үйлдлийг хянаж чадахгүй бол тэднийг (бид) ёс суртахуунтай эсвэл ёс суртахуунгүй гэж хэлэх боломжгүй. Ёс суртахууны хууль бол хэн нэгэнд шийтгэл хүлээмээргүй бол хулгай хийж болохгүй гэж хэлэхтэй адилхан төсөөлөл биш. Энэ бол өөрийнхөө төлөө бүх цаг үед дагаж мөрдөх ёстой оюун ухаанаас минь гарсан тушаал болох *категорийн шинжтэй императив*^[60] ажээ. Оюун ухаан бидэнд хүн бүрд универсал хууль байдлаар хэрэглээсэй гэж хүсэхээр тийм байдлаар үйл зөвхөн хийх ёстой гэдгийг хэлж өгдөг.

Улстөрийн бодлого ч мөн л универсал буюу хаа сайгүй хүн

60 *categorical imperative*

бүр дагадаг зарчимд үндэслэх ёстой. Кант төр засгийн хэрэгцээ байдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг: нийгэм хэрэв (бусад эрх үндэслэж гардаг) эрх чөлөөг төр нь баталгаатай зүйл болгосон бол л ажиллах боломжтой ажээ. Гэвч эрх (үүнд дотроо өмчийн эрх)түүний хувьд жам ёсны зүйл биш харин төрөөс тусгайлан зааж тогтоосон зүйл байсан байдаг. Хэрэв үүнд хамаарахгүй ямар нэг байсан бол тэр нь эрх чөлөө өөрөө байх ёстой: ‘Эрх чөлөө (бусдын сонголтоор хязгаарлагдахгүй байх бие даасан байдал) ... бол хүн бүрд хүмүүнлэг шинж^[61]ийнх нь нэр төрөөр олгогдсон байдаг цор ганц анхдагч эрх^[62] юм.

Кант *Рехштаат* буюу “шударга төр”^[63] ямар байхыг анх судалж шинжилсэн хүмүүсийн нэг байжээ. Нэгэнт олонхийн засаглал болох төр засаг цөөнхийн эрх чөлөөт байдал буюу эрх чөлөөнд заналхийлдэг учраас ардчилсан байх боломжгүй гэж батлан өгүүлж байсан. Үүнээс илүүтэй хүн бүрийн эрх чөлөө, иргэний болон шүүхийн ижил тэгш эрхийг хүлээн зөвшөөрдөг байж л гэрээний шинжтэй, хуулиар хязгаарласан, үндсэн хуулийн төр засаг байх болно гэж бодож байв. Төрийн тэргүүн^[64] заавал мөн хуулийг дагаж мөрдөх ёстой (гэсэн ч либералчуудтай адилгүй нь Кант эсрэг нь тэмцэх эрхийг нь хүлээн зөвшөөрөөгүй ажээ). Тэрбээр хүнд хэцүү байдалд зовж буй хүмүүсийн хүнд ачаа нь тэр хүмүүсийг үйлдэлдээ хариуцлагатай байх явдлаас нь сэргийлдэг байж болох юм гэж хэлэн татвараар-санхүүжүүлдэг аюулгүй байдлын сүлжээ^[65]ний төлөө маргаж мэтгэлцэж байлаа. Гэвч эдгээр баталгаажуулсан хамгаалалтаас давсан, бидний үйлийг чиглүүлж замчлах ямар ч халамжлах хариуцлага^[66] төр хүлээх ёсгүй: ‘Хэн ч бусад хүмүүсийн сайн сайхны төлөө бодож байж болох тодорхой арга замаараа намайг аз жаргалтай болгох

61 *humanity-орос. человечность*

62 *original right*

63 *Rechtstaat or 'just state'*

64 *The sovereign*

65 *tax-funded safety net-нийгмийн даатгалд*

66 *paternal responsibility*

гэж албадах эрхгүй’ гэж тэрбээр бичиж байв. Гэвч ‘өөрсдийнхөө иймэрхүү адилхан зорилгодоо хүрэхээр тэмүүлэх гэсэн бусад хүний эрх чөлөөнд саад болохгүй бол хүн бүр өөрийн хамгийн сайн гэж үзсэн арга замаараа өөрийн аз жаргалаа эрэн явах бүрэн эрхтэй’ ажээ.

[32] Тюрго [Anne-Robert-Jacques Turgot, Baron de Laune] (1727–1781 он): Франц хүн, эдийн засагч, төрийн зүтгэлтэн. **Гол үзэл санаа:** Тэнцвэртэй буюу алдагдалгүй төсөв; зохицуулалтыг багасгаж, дүрэм журам цөөлөх^[67]; үнэ цэнийн субъектив онол. **Гол бүтээл:** *Эд баялаг Үүсэж Бүрэлдэх, Түүнийг Хуваарьлах тухай Бодрол* [анг. *Reflections on the Formation and Distribution of Wealth*] (1769–70 он).

Волтаирын найз, Физиократч үзэл санааны нөлөөнд автсан Тюрго цаг үеийнхээ хамгийн гарамгай либералчуудын нэг болжээ. Авьяаслаг эдийн засагч болох энэ хүн 1774 онд үндэстний төсвийн Ерөнхий Хянагч^[68] болсон бөгөөд тэнд байхдаа дефицит буюу төсвийн алдагдл^[69]ыг багасгаж, арилжаа худалдааг либералчилж чөлөөлжээ. Эдийн засгийн ухаанд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулсныхаа адилаар тэрбээр дэвшлийн тухай онол^[70]ын талаар бичдэг байсан.

Лиможе^[71]гийн татвар цуглуулагч болгож Тюргог томилоход нь түүнд либерал үзэл санаагаа хэрэгжүүлэх боломж олджээ. Тэрбээр (засгийн газрын төсөлд цалин хөлсгүй ажиллах) *корвей* буюу *албадлагын хөдөлмөр*^[72]ийг үгүй хийж, зам харгуй,

67 *deregulation*

68 *Controller- General of the national budget*

69 *deficit*

70 *theory of progress.*

71 *Limoges*

72 *corvée* - энэ бол жил бүр голдуу тодорхой тогтсон ажлын өдрөөр

суваг шуудуу барих ажлыг арилжаа худалдаанд тус болох гэж санхүүжүүлэв. Ерөнхий-Хянагч болохынхоо хувиар тэрбээр XVI Луйд ‘дампуурал байхгүй, татвар өсгөхгүй, зээллэг авахгүй’ гэж амлаж байсан. Тэрбээр хэдийгээр ургац муутай байх нь үнэ өсөхөд хүргэдэг, дараагаар үймээн гарахад хүргэж болох ч орон нутгийн худалдаачид алс хол буй албан тушаалтнуудаас илүү зах зээлээ илүү сайн үнэлж цэгнэдэг гэж батлан өгүүлж үр тарианы үнийн хяналтыг үгүй хийв. Тюрго Тавдахь Өдөр мах зарах Хотел Дюгийн монополь эрх^[73]ийг зогсоож, бас (хүмүүс язгууртан газрын эзний төлөө хийх үүрэг хүлээсэн үнэгүй ажиллах үүрэгтэй байсан) биеэр үйлдэх корве^[74]г үгүй хийн бизнес явуулах дүрэм журмыг цөөлжээ. Гэвч иймэрхүү шинэчлэл нь улстөрийн дайсантай болгож, Францын цэргийн зардал асар их байгааг шүүмжилснийхээ дараа халагдав.

Хөгжил дэвшлийн тухайд Тюрго бид нэг үнэнийг олох гэж мянган алдаа гаргах ёстой, бид цаашид алдаа гаргахгүй байхын тулд түүхийнхээ талаар гүнзгий мэдлэгтэй хэрэгтэй гэж бичиж байлаа. Тэрбээр өөрийн-тусыг бодох явдал хөгжил дэвшлийн гол зүтгүүр юм, чөлөөт зах зээлд хувь хүмүүсийн ашиг сонирхол үргэлж бүх нийтийн ашиг сонирхолтой давхацдаг гэдэгт итгэдэг байсан. **Волтаирын** адилаар тэрбээр гэгээрсэн үндсэн хуулийн хаант засаглалд итгэдэг байжээ. Тюрго либерал зарчмыг зааж сургах, Сүмийн Сургуулийн үл хүлцэхүйг эсэргүүцэхийн тулд төрийн сургууль буюу боловсролын тогтолцоог дэмжив.

Эдийн засгийн ухаанд Тюрго зээлийн хүүгийн хэмжээ^[75] заавал хадгаламж буюу хадгалж хураасан зүйлийн ховор байдал эсвэл элбэг байдал, үйлдвэрлэлд хэрэгтэй цаг хугацаа, үр дүнгийн тодорхой бус байдлыг харуулах ёстой гэдгийг цохон тэмдэглэж

хязгаарлагдмал хугацаанд үргэлжилдэг, байнгын бус, хөлс хүчгүйгээр хүчээр ажилладаг хөдөлмөрийн хэлбэр.

73 *Hôtel-Dieu's monopoly privilege*

74 *corvée en nature*

75 *interest rate- зээлийн хүү + хэмжээ = хүүгийн хэмжээ (СЭХ)*

“мөнгө хүүлэхийн эсрэг хууль”^[76]-тай эсрэг тэмцэхдээ эртний санаа бодлоор зэвсэглэсэн байдаг. Зээлдэгч тийм учраас зүгээр л идэвхигүй санхүүжүүлэгч биш харин ашигтай аж ахуйн газар эрж хайдаг, мөн зээллэгээс гарах эрсдэлийг хүлээх ур чадвартай, идэвхитэй ажил хэрэгч хүмүүс ажээ. Үнэндээ хөрөнгийн зах зээл л үйлдвэрлэгч хөрөнгө оруулах санхүүжилт авахыг хүсэж харин хөрөнгө өмчлөгч нар хадгаламжаа зарцуулах өөр хэрэглээ эрж хайхад хүргэдэг байна (энэ бол өнөөдөр бид боломж-хайх зардал^[77] гэж нэрлэдэг зүйл юм). Зээлийн хүүгийн хэмжээ их байх нь ёс суртахууны хувьд муу зүйл биш харин зүгээр л хамгийн эрсдэлтэй, удаан хугацаанд явагддаг аж ахуй^[78]н хөрөнгийн үнэ^[79] байдаг ажээ. Зах зээлийн иймэрхүү дарамт шахалт л хадгаламжийг хэрэгтэй ашигтай төсөл рүү замчилдаг.

Нэг зуунаас илүү хугацааны дараа **Карл Менгер**, **Лүдвиг фон Мизэс**, Фридрих фон Вайзер (1851–1926 он) **Ф. А. Хаек** зэрэг Эдийн засгийн Австри Сургуулийн эдийн засагчид эдгээр маш өвөрмөц үзэл санааг, Тюргогийн арай муухан хөгжүүлсэн хязгаарын ашиг болон хүмүүс тухайн эд зүйлд хамаатуулдаг субъектив үнэ цэн^[80]ийн хамтаар хөгжүүлэх болно. Тюрго багшийнхаа хувиар **Никола де Кондорсэд** бүр ихээр нөлөөлөв. Шавь нь Тюргогийн уналтын хойно ч чөлөөт худалдаа, мөн албадмал хөдөлмөрийг устгах, чөлөөт нийгмийн талаархи түүний үзэл санааны гаргуун өмгөөлөгч хэвээр үлдсэн.

[33] Андерс Чидениус (1729–1803 он): Скандинав үндэстэн, улстөрч, эдийн засагч. **Гол үзэл санаа:** Чөлөөт худалдаа; өөрийн-тусыг бодох явдал; чөлөөтэй үг

76 *usury*

77 *opportunity cost-боломж эрж хайх зардал-орос. альтернативный издержки*

78 *most risky and long-term ventures*

79 *price of capital*

80 *marginal utility and the subjective value*

хэлэх^[81]; зохицуулалт, дүрэм журам цөөлөх^[82]. **Гол бүтээл:**
Үндэстний Өгөөж [анг. The National Gain] (1765 он).

Тэр үедээ Шведийн хяналтад байсан Финландад төрсөн Чидениусын 1765 оны *Үндэстний Өгөөж* [швед. *Den Nationnale Winsten*] (анг. *The National Gain*) гэсэн памфлет буюу ухуулах хуудсанд **Адам Смитийн Үндэстний Баялаг** [анг. *The Wealth of Nations*] (1776 он)-таа дэлгэрэнгүйгээр хөгжүүлсэн үзэл санааг товчхон дүрсэлж харуулсан байдаг. Смитийн адилаар тэрбээр меркантилистч экспортын татаасыг хортой муу зүйл гэж хэлэн шүүмжилж эсэргүүцэн, мөн чөлөөт худалдаа, арилжаа, үйлдвэрлэлийг шаардаж байжээ. Эдийн засгийн ухааны замчлагч зарчим бол эрх чөлөө юм гэж батлан өгүүлж байв. Хүмүүс өөрийн-тусыг бодох явдлын учир шалтгаанаар л худалдаа хийж, цалингийн тухай гэрээ байгуулдаг. Гэвч тэд хөршийнхөө үнэлж үздэг зүйлийг л зөвхөн үйлдвэрлэх замаар ашиг олно – энэ бол нийт үндэстэнд зориулан эдийн засгийн ашиг бүтээх үйл ажээ: "[X]увь хүн бүр өөрийн мэдэлгүйгээр хуулиар ингэж хийхийг нь хориглоогүй бол үндэстнийхээ өгөөжийг хамгийн сайнаар нэмэгдүүлэх боломжтой газар орон олох, арилжаа хийхийг оролддог".

Бусад бүтээлдээ Чидениус иргэн болон төрийн хоорондох харилцааны талаархи либерал үзэл санааг судалсан. Тэрбээр **Жон Стюарт Милл**ээс зуун жилийн өмнө чөлөөтэй үг хэлэх явдал буюу үг хэлэх эрх чөлөөг юмсыг ухаарч ойлгох, мөн хөгжил дэвшлийн үндэс болгон харуулж, үзэл санааны өрсөлдөөнөөс үнэн үүсэж гарах болно гэдгийг батлан өгүүлж байлаа.

Парламентарич, шинэчлэгчийн хувиар Чидениус орон нутгийн худалдаачдад тавьсан худалдааны хориг хязгаарлалтыг хөнгөвчлөх кампанит ажилд идэвхитэй оролцож байжээ. Тэрбээр мөн цензүр буюу үзэл санааны шүүлтүүрийг устгаж,

81 *free speech*

82 *deregulation*

хүмүүст олон нийтийн хэрэг явдлын талаар чөлөөтэй бичих боломж олгох, төр засгийн мэдээлэл олон нийтэд чөлөөтэй олддог байлгах хуулийг дэмжиж байсан.

[34] Жозеф Прийстлий (1733–1804 он): Англи хүн, химич, физикч, тэрс үзэлтэн^[83], шинэчлэгч, либерал онолч.

Гол үзэл санаа: Чөлөөтэй үг хэлэх буюу үг хэлэх эрх чөлөө^[84]; шашны хүлцэхүй; иргэний болон улстөрийн эрх; боолчлолын эсрэг тэмцэл. **Гол бүтээл:** *Төр Засгийн Анхны Зарчмын тухай Эссэ* [анг. *Essay on the First Principles of Government*] (1768 он).

Өнөөдөр хүчилтөрөгчийг анх нээсэн нээлт, мөн цахилгаан эрчим хүчний талаархи бүтээлээр нь Прийстлийг дурсдаг ч тэрбээр тэр цаг үедээ хоорондоо зөрчилтэй^[85] либерал үзэл санаагаараа алдартай нэгэн байжээ. **Ричард Прайсын** нөлөөнд автсан тэрбээр үзэл санааны чөлөөт солилцоог дэмждэг, мөн хүлцэхүй, Тэрс Үзэлтн^[86]ий ижил тэнцүү эрхийн төлөө маргаж мэтгэлцэж байв – энэ бол үүсэж тогтчихсон Сүм Хийдээс салж гарсан, шашны бүлэг ажээ. Тэрс Үзэлтнүүд (Прийстлийтэй өөртэй нь адилаар)-ийг олон нийтийн албан тушаал, цэргийн албан тушаалд томилохыг албан ёсоор хориглосон байв. Хэдийгээр хэдхэнийг нь шийтгэсэн ч гэсэн тэд иймэрхүү ялгаварлан гадуурхалтыг эсэргүүцээр л байсан.

Төр Засгийн Анхдагч Зарчмын тухай Эссэ (1768 он) гэсэн бүтээлдээ Прийстлий иргэний эрхүүдийг хүмүүний нийгмийн гишүүдийн хувиар хүн бүрд жам ёсоор оршдог эрх болон гишүүдийн хувиар иргэддээ батлан олгодог улстөрийн эрх гэж дотор нь ялгаж зааглав. Тэрбээр иргэний эрхийг аль болох

83 *Dissenters*

84 *free speech*

85 *controversial*

86 *Dissenters*

өргөнөөр олгох ёстой гэж батлан өгүүлж байлаа. Прийстлий бидний амьдралд олон нийтийн болон хувийн оронзай^[87] гэдэг зүйл байдаг (хожим нь **Ф. А. Хаек** илүү сайн хөгжүүлсэн үзэл санаа), мөн төр засаг олон нийтийн хүрээ буюу оронзайд л зөвхөн оролцох ёстой гэж мөн шаргуу ятгадаг байсан. Прийстлийн хувьд боловсрол болон шашин төрийн хэрэг явдал биш харин хувь хүмүүсийн ухамсрын хэрэг явдал байж хувийн хүрээнд баттай хамаардаг зүйл байжээ.

Прийстлий шашны фанатизмын эсрэг гаргасан өөрийн гаргалгаа нотолгоогоо хэрэглэж хүмүүний амьдралын бусад хэсэгт хүлцэхүйг шаарддаг байв. Тэрбээр хэд хэдэн шинэчлэлийн хөдөлгөөнд идэвхитэй оролцож, албан тушаалтнуудын завхралыг ил зарлан, парламентын шинэчлэл (Прайсын адилаар), боолын худалдааг устгах явдал, Америкийн хувьсгалчдыг дэмжиж байжээ. Гэвч Францын Хувьсгалыг дэмжсэн хоорондоо-зөрчилтэй дэмжлэг^[88] нь түүний эсрэг хүчирхийллийг өдөөж, АНУ-д цагаачлан амьдралынхаа сүүлийн жилүүдийг тэндээ өнгөрүүлэхэд хүргэжээ.

87 *public and private sphere*

88 *controversial support*

ЗУРГААДУГААР БҮЛЭГ: ХУВЬСГАЛЧИД, РАДИКАЛЧУУД

1700-аад оны дундуур Америк дахь Британийн шилжин суурьшигчид Британи улс тэднийг хэрхэн засаглаж буйд, мөн худалдааг нь хэрхэн зохицуулж буйд улам бүр л дургүй болсоор байлаа. 1765 оны *Тамганы Хууль* [анг. *Stamp Act*] (хуульзүйн дагуухь бичиг баримт, сонин, хэвлэмэл болон бусад зүйлсийг Лондонд-үйлдвэрлэсэн, Английн мөнгөн тэмдэгтийн орлогын татварын тэмдэг^[1] бүхий цаасаар үйлдэхийг шаарддаг) моринд нь мордуулав. Үүнийг хүмүүсийн санал нэгдээгүй (эсвэл олонд алдартай хэллэгээр хэлбэл төлөөлөлгүй татвар^[2]) татвар гэж ойлгосон байдаг. Энэ явдал тэдний л нэг хэсэг шилжин суурьшигчид өөрсдийгөө үздэг Британи хүмүүсийн эртний эрхэд ил цагаан халдсан хэрэг байв.

Британийн засгийн газар шийтгэх тогтоол шийдвэр гаргаж, тэдний эсрэг зэвсэг барин ирэхэд шилжин суурьшигчид зэвсэгт тэмцл^[3]ээ бүхэлдээ үндэслэлтэй зөв зүйл гэж ойлгож байсан бөгөөд *Иргэний Дайн*, *Бахархалт Хувьсгалын* хэрэг явдалд дунд тэмцэлцэж асан Британийн либерал философичдоос өөрсдийн гаргалгаанотолгоогоо авчээ. Энэ шилжин суурьшигчид өөрсдийн шинэ бүгд найрамдах улсаа хэлбэржүүлэн байгуулахдаа *Магна*

1 *revenue stamp*

2 *taxation without representation* - Америкийн Хувьсгалаас үүсэж гарсан, Их Британийн эсрэг маш их дургүйцлээ илэрхийлж асан улстөрийн хөдөлгөөн. Тэдний эсэргүүцэл хууль тогтоох байгууллагад төлөөлөл нь суудаг шилжин суурьсагчдын хууль тогтоомжоор л зөвхөн тэр иргэдэд татвар оногдуулах эрх мэдэлтэй гэсэн хуульзүйн зарчимд үндэслэж байв.

3 *rebellion*

Харт⁴ болон Эрхүүдийн тухай Билл⁵д үндэслэсэн байдаг.

Америкийн Хувьсгалыг либералчууд магтан дуулж байсан байж болох ч тэд Франц Хувьсгалын хувьд хожим нь үзэл бодол нь бага зэрэг хуваагдсан байдаг. Эхэндээ *Хүн болон Иргэний Эрхийн Тунхаглал*⁶аас нь үйл хэрэг нь найдлага төрүүлэхээр харагдаж байлаа; гэвч эрх мэдлийн төлөө өөр өөр фракцууд тэмцэлдэх үед нэгэн цуст дарангуйлагч өөр нэг илүү цуст нэгнээр солигдов. **Кондорсе** болон **Бенжамин Констан** зэрэг франц либералчууд иймэрхүү дэглэм хэрхэн гарч ирдгийг, мөн хэрхэн түүнийг үндсэн хуулиар хязгаарлах ёстой талаар тархиа чадлаараа гашилгаж байжээ. Англи либералчууд олон конверватив үзэлтнүүдийнхээ хамтаар Францын эмх замбараагүй явдлаас сонгуулийн тогтолцоогоо шинэчлэх замаар зайлсхийхийг эрэлхийлж байсан. **Вилхелм фон Хамболфт** зэрэг Герман либералчууд либерал төрийн үүрэг нөлөөг, түүнийг бүрдүүлэгч хүмүүсийн ёс суртахууны хөгжлийн тухай эргэцүүлж бодож эхлээд байв.

Энэхүү халуурсан орчинд эрс ширүүн үзэл санаа ар араасаа урган гарч байсан. **Жереми Бентам** олон нийтийн бодлогын бүхэлдээ шинэ ёс суртахууны тогтолцоог санал болгов. **Виллиам Годвин** ерөөсөө төр засаг хэрэгтэй эсэхэд эргэлзэж байлаа. Годвины эхнэр **Мэри Волссстөункрафт** (тэр цаг үедээ маш эсэргүү зүйл байсан) эмэгтэйчүүд эрчүүдтэй адилхан эрхтэй байх ёстой гэж батлан өгүүлж байв. Ертөнц өөрчлөгдөж байлаа: аж үйлдвэржээд зогсохгүй нийгмийн хийгээд оюун ухааны хувьд ч өөрчлөгдөж байсан билээ.

[35] **Томас Пэйн** (1737–1809 он): Англи-Америк хүн,

4 *Magna Carta*

5 *Bill of Rights*

6 *Declaration of the Rights of Man and the Citizen*,

памфлет үйлдэгч^[7], сэтгүүлч, полемицист^[8]. **Гол үзэл санаа:** Америк Хувьсгалыг дэмждэг гаргалгаа нотолгоо^[9]; индивидуализм; шашны болон радикал хүлцэхүй^[10]; ёс суртахууны тэгш байдал; републикийн либерализм^[11]; иргэний нийгэм. **Гол бүтээл:** *Саруул Ухаан* [анг. *Common Sense*] (1776 он); *Хүний Эрхүүд* [анг. *The Rights of Man*] (1791–92 он).

Английн Квакер гэр бүл^[12]д төрсөн Пэйн Америк руу (Лондонд уулзсан Бенжамин Франклины санал болгосноор) ер нь бол өрнөөсөө зугтааж, үүнээс болж Англид мөрдөж мөшгөгдөх болно гэж үзэн цагаачилсан. Тэрбээр либерал үзэл санааг өөрийн алдартай ном, памфлет, сэтгүүлчийн нийтлэл^[13]ээрээ дамжуулан олон нийтэд маш сайн хүргэжээ.

Түүний *Саруул ухаан* [анг. *Common Sense*] (1776 он) гэсэн бүтээл Америкийн Хувьсгалч байр байдлыг өрдөв: энэ ном хагас сая орчим хувь зарагджээ. Түүндээ завхарч авилгалд идэгдсэн Британийн төр засгийн либерал бус үйлдлийн эсрэг гаргалгаа нотолгоогоо дэлгэрэнгүй зарлан тунхаглаж, одоо тусгаар тогтнох явдал яагаад гарцаагүй зайлшгүй болсныг тайлбарлан, дэлхийд жишээ болохоор шударга, ардчилсан, либерал бүгд найрамдах улс болно гэж Америкийн ирээдүйг магтан дуулсан байдаг.

Хожим нь 1970 онд Пэйн хувьсгал мандсан Францад айлчилж, *Хүний Эрх* [анг. *The Rights of Man*] (1791–92 он) гэсэн бүтээлээрээ **Эдмүнд Бөркийн** хувьсгалын эсрэг санаатай *Францын Хувьсгалын талаарх Бодрол* [анг. *Reflections on the*

7 pamphleteer

8 polemicist

9 Case for

10 racial toleration

11 republican liberalism

12 Quaker family

13 journalism

Revolution in France] (1790 он) гэсэн бүтээлийг нь үгүйсгэн, завхарсан хаант засаглал болон институтүүдийг нь бут ниргэж улам л их амжилтад хүрчээ. Түүний шинэ ном нь нэг сая хувь зарагдаж, Британийн засаг захиргаа бослогод уриалсан гэсэн яллах буруутгалаасаа татгалзахад хүрчээ. Тэрбээр Францын улстөрийн амьдралд өөрөө оролцсон боловч тэр цаг үеийнхний фракцаараа тэмцэлдэх галд оржээ: түүнийг шоронд хорьсон бөгөөд үхлийн ялаас ам мөлтөс зугтаав.

Пэйн индивидуализмийг өмгөөлж хамгаалан, хүлцэхүйг (үүн дотроо уугуул Америк хүмүүстэй зэрэгцэн орших тухай) бүх хүний ижил тэгш байдалд үндэслэж сурталдаж байлаа. Гэвч Квакер гаралдаа үнэнч байхын тулд ребапликанизмыг эгалитаринизм^[14]тэй нэгдүүлсэн байдаг: тэрбээр үндсэн хуулийн төр засгийг хүсэж байсан ч энэ нь прогрессив болон халамжийн хөтөлбөртэй байх болно гэж бодож байв; тэрбээр хувийн өмч өмчлөх явдлыг өмгөөлж хамгаалдаг байсан ч өмчийг нийтийн сайн сайны төлөө удирдаж залдаг байхыг хүсдэг байлаа.

Нийгэм нь төр засагтай адилхан байдаггүй гэж шаргуу ятгадаг байсан. Хамтран ажиллах хүсэл маань биднийг нийгмийн эв зохицлыг тэтгэдэг албан бус нэгдлийг хөгжүүлэхэд хүргэжээ. Энэ явдалд төр засаг хэрэгцээгүй бөгөөд үнэндээ төр засаг хөндлөнгөөс оролцохдоо бидний жам ёсны эрхэд халддаг байна. Гэвч бусад эрх (өмчийн эрх гэх мэт) нь тэдгээрийг хамгаалах төр засгаас хамаарсаар л байдаг. Төр засгийн хамгийн сайн хэлбэр болохынхоо хувьд бүгд найрамдах улс нь хаант засаглалаасаа илүү эв найртай байдаг гэж, мөн Америкийн хувьд тэрбээр төлөөллийн болон үндсэн хуулийн бүгд найрамдах улсыг санал болгож байлаа. Гэвч аливаа төр засгийн эрх мэдлийг бидний иргэний эрхийг маань бататгаж баталгаажуулах явдлаар хязгаарлах ёстой ажээ. Үүнээс цааш зүйлсийг бид хүмүүсийн саруул ухаанд л найдах ёстой гэнэ.

14 *republicanism with egalitarianism*

[36] Чезаре Беккариа (1738–1794 он): Итали хүн, ялын бодлого шинэчлэгч, философич. **Гол үзэл санаа:** Ялын онол; шийтгэлийн шинэчлэл^[15]; хуульзүйн шинэтгэл. **Гол бүтээл:** *Гэм хэрэг, Шийтгэлийн Тухай* англ. [*On Crimes and Punishments*] (1764 он).

Беккэриа Миланд Иезүйтийн боловсрол олгох сургуульд суралцсан^[16] ч гэсэн Монтескьюг уншсанахаа дараа эдийн засгийн ухаан сонирхдог болжээ. Амьдралынхаа сүүлээр тэрбээр эдийн засгийн шинэчлэлийг Миланы эдийн засгийн зөвлөлийн гишүүний хувиар дэмжиж байсан. Гэвч түүнийг өнөөдөр *Гэмт Хэрэг ба Шийтгэлийн Тухай* [англ. *On Crimes and Punishments*] (1764 он) гэсэн жижиг номоор нь дурсдаг. Энэ номыг **Жереми Бентам** магтдаг байсан бөгөөд энэ нь Европ даяар хуульзүй болон ял шийтгэлийг тогтолцоонд гүн гүнзгий нөлөөлжээ.

Беккэриа хууль болон шийтгэлийн зөв зорилго бол нийгмийн гэрээг сахин хамгаалах явдал гэж батлан өгүүлж байсан. Гэмт хэрэг хүмүүс өөрийн-тусыг бодох явдалдаа хүрэхээр хүсэж тэмүүлэх үед гардаг ч гэсэн тэд олсон боловсролоор тэдэнд тэдний жинхэнэ ашиг сонирхол нийгмийнхээ гэрээг хүндлэх явдалд оршдог гэдгийг харах боломжтой. Шийтгэл хүмүүс нийгмийн гэрээг зөрчих явдлаас сэргийлэх гэж, мөн бусдыг хохироож гэмтээхгүй эсвэл тийм үйлдэл хийж буй хүнээс “шүдийг шүдээр буюу цусыг цусаар” гэсэн өш хонзон авахгүй байлган, олон нийтийн сайн сайханд үйлчлэх гэж оршдог ажээ.

Тиймээс тэрбээр эрүүдэн шүүх, нууцаар буруутгаж яллах, дур зоргын хийгээд хүнд хэрцгий шийтгэл, цаазын ялыг буруутгадаг байсан. Шийтгэл гэмт хэрэгтэй тохирсон байх ёстойг тэрбээр шаргуу ятгадаг байв. Хорьж зогсоодог хамгийн сайн нөлөөтэй байхын тулд шийтгэлийг даруй оноодог байх ёстой ч энэ нь заавал хүнд хэрцгий байх ёсгүй. Гэмт хэргийг хуулийг хялбар болгох

15 *penal reform*

16 *Jesuit schooling*

замаар багасгах боломжтой бөгөөд энэ нь шүүх тогтолцоог илүү үр дүнтэй болгож, боловсролыг сайжруулж, сайн үйлсийг урамшуулна^[17].

[37] Томас Жефферсон (1743–1826 он): полимат^[18], конституционалист, Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч асан. **Гол үзэл санаа:** Америкийн хувьсгалын оюун санаа суурь; жам ёсны, үл хагацах эрх; төр засгийн гэрээний үндэс; харгис дарангуй төр засгийг түлхэн унагаах эрх; эрх мэдлийг зааглаж хуваах^[19]; чөлөөт хэвлэл; шашны хүлцэхүй. **Гол бүтээл:** *Тусгаар Тогтох Тунхаглал [анг. Declaration of Independence (хамтран зохиогч)] (1776 он); Виржиниа Муж Улсын тухай Тэмдэглэл [анг. Notes on the State of Virginia] (1785 он).*

Жефферсон Америкийн хамгийн том хувь хүний номын санг бүрдүүлэн, маш өргөн сэдэвтэй зүйлс, үүнд дотроо урлаг, шинжлэх ухаан, улстөрийн философийн талаар уншдаг байжээ. Түүний олон алдар суу дундаас **Жон Локк** болон **Алжернон Сидний**гийн үзэл санаанаас оруулсан, Америкийн Тусгаар Тогтнох Тунхаглал^[20]ын эхийг бэлдсэн нь хамгийн ихээр дуурсагддаг. Үүндээ өөрийнхөө бичсэн тэргүүн хэсэгт Локкийн үзэл бодлыг ‘Бид бүх хүмүүсийг ижил тэгш бүтээсэн, тэдэнд Бүтээгч тодорхой салшгүй эрхүүд, үүн дотроо Амьд Явах, Эрх Чөлөөт Байдалтай Байх, Аз Жаргалдаа хүрэхээр тэмүүлэх эрх хүртээсэн гэсэн эдгээр үнэнийг өөрөө илэрхий зүйл гэж үздэг’ гэж зарлан мэдэгдэж агуулга дүүрэн хураангуйлсан байдаг. Хуульзүйн бүрэн эрхтэй төр засаг хүмүүстэй хийсэн гэрээнд

17 *reward virtue*

18 *polymath-олон талын мэдлэгт суралцсан хүн*

19 *separation of powers*

20 *independence declaration- www.libraryforfreepeople.mn гэсэн вэбхуудаснаас монгол орчуулгыг нь үзнэ үү.*

тулгуурладаг: хэрэв энэ гэрээ нь зөрчигдвөл ‘ийм Төр Засгийг түлхэн унагааж, ирээдүйн аюулгүй байдалдаа шинэ хамгаалагч тавих явдал бол энэ хүмүүсийн эрх, бас үүрэг юм.’

Жефферсон олон нийтийн болон хувийн эрх мэдэлд хоёуланд нь итгэлгүй байж, (**Монтескюг** дагаж) эрх мэдлийг зааглаж хуваасан Үндсэн Хууль бүтээхэд оролцож явсан. Тэрбээр мөн олон нийтийн боловсрол, чөлөөт хэвлэлийг төр засгийн эрх мэдлийг хязгаарлах арга зам гэж дэмждэг байв. Тэрбээр хувь хүний шашны үзэл бодол бусад хүмүүсийг хохироодоггүй гэсэн үндэслэлээр шашны үл хүлцэхүйг эсэргүүцэж байсан. Тэрбээр бусад хүмүүсийн ижилхэн эрх чөлөөг хязгаарлаж хориогүй бол хүмүүс хүссэнээрээ үйл хийх нь чөлөөтэй байх ёстой (**Жон Стюарт Милл** хожим нь үл хохироох зарчим гэж нэрлэсэн үзэл санаа) гэдэгт итгэж байлаа.

Бүр гайхалтай нь Жефферсон болон түүний хамтрагч Жон Адамс (1735–1826 он) өөрсдөө бичихэд нь тусалсан, Тусгаар Тогтнох Тунхаглалын 50 дахь ойн өдөр 1826 оны 7-р сарын 04-нд хэдхэн цагийн зайтай нас барцгаажээ.

[38] Никол де Кондорце [Marie Jean Antoine Nicolas de Caritat, Marquis de Condorcet] (1743–1794 он): Франц хүн, математикч, эрдэмтэн, улстөрийн онолч. **Гол үзэл санаа:** Олон нийтийн сонголтын бэрхшээл; эмэгтэйчүүдийн сонгуулийн эрх; арьстнуудын тэгш байдал. **Гол бүтээл:** *Негрүүдийг Боолчлох тухай Бодол* [анг. *Reflections on Negro Slavery*] (1781); *Олонхийн Шийдвэрийн Магадлалд Шинжилгээ Хэрэглэх Тухай Эссэ* [анг. *Essay on the Application of Analysis to the Probability of Majority Decisions*] (1785).

Кондорсег сонгуулийн үр дүнгийн талаархи математик судалгаагаар нь хамгийн сайн мэддэг. Тэрбээр өөрийнхөө нэрийг *Кондорсе Парадокстоо* өгсөн бөгөөд энэ бол хүмүүс А-г

Б-гээс (хайч, даавуу) , Б-г В-гээс (даавуу, чулуу) илүүд үздэг ч байж болох ч тэд бас В-г А-гаас (чулуу, хайч) илүүд үзсээр байж ч бас болно гэдэг “чулуу, хайч, давуу”-ны бодлого юм: тиймээс сонгуулиас тогтвортой үр дүн гарахгүй байж болох ажээ. Тэрбээр бүх нийтэд хамгийн ихээр таалагдаж буй нэр дэвшигчийг сонгох санал өгүүлэх, хэд хэдэн үе шаттай байх *Кондорсегийн Арга*^[21] гэдгийг гаргасан. Эдгээр хувь нэмрийнх нь төлөө түүнийг Олон Нийтийн Сонголт Сургуулийг анхлан санаачлагч гэж үздэг бөгөөд **Жэймс Бачэнен, Гордон Таллок**, бусад хүмүүс орчин үе дэх түүний хойчис юм.

Кондорсе Физиократ үзэл санааны нөлөөнд автаж, либерал эдийн засгийг дэмжиж байв: Тюрго түүнийг Парисын Минт^[22]ийн Ерөнхий Байцаагчаар томилж байжээ. Тэрбээр үндсэн хуулийн төр засаг, олон нийтийн үнэгүй боловсрол, эмэгтэйчүүдийн сонгуулийн эрхийг дэмжиж байсан. Аболиционист^[23] болох тэрбээр бүх арьстны тэгш эрхийн төлөө зүтгэж байв. Францын Хувьсгалын дараа тэрбээр гэгээрсэн рационалист төр засаг гарна гэж найдаж байсан бөгөөд боловсрол болон бусдын зүйлийн шинэчлэлийг санал болгож байсан. Гэвч тэрбээр энэ Хувьсгалын нэрийг баастсан фракц хоорондын зөрчилдөөнд өртөж баривчлагдан, шоронд нас баржээ.

[39] Жереми Бентам (1748–1832 он): Англи философич, нийгмийн шинэчлэгч. **Гол үзэл санаа:** Утилитарианизм. **Гол бүтээл:** *Ёс Суртахуун болон Тогтоол Шийдвэрийн Зарчим [анг. The Principles of Morals and Legislation] (1789 он).*

Бентамыг утилитарианизмын ёсзүйн философиор нь хамгийн сайн мэддэг – энэ нь үйлдлийн ёс суртахууны стандарт бол

21 *Condorcet Method*

22 *Paris Mint-The Monnaie de Paris (Paris Mint)* бол Францын зоос дэлдэхийг хариуцдаг засгийн газар-өмчилдөг институт.

23 *abolitionist*

эрх биш харин түүнээс гарч буй аз жаргал эсвэл аз жаргалгүй байдлын хэмжээ юм гэж үздэг философи юм. Зөв болон буруу зүйлийг тиймээс объектив байдлаар хэмжих боломжтой: эдгээр нь төр урьдаас хамаатуулж өгөх боломжгүй тийм зүйл байдаг ажээ.

Бентам олон либерал зарчмыг, үүнд дотроо хүйсийн хоорондох тэгш байдал зэргийг өмгөөлж хамгаалдаг байсан. Тэрбээр ийм хууль бол хувийн үйлдэлд үзүүлж буй олон нийтийн тохиромжгүй хариу үйлдэл гэж батлан өгүүлж, хомосексуал байдлыг эсэргүүцсэн хуулийг либералчлахыг шаардаж (энэхүү сэдвийн талаар гаргасан, анхны зүйлтогтолжсон гаргалгаа нотолгоо) бичиж ч байв. Бентам авилгал, амьтадтай харгис харьцах явдал, гэмт хэрэгтнүүдтэй хэтэрхий харгис хандах явдалтай тэмцсэн. Тэрбээр Лондонгийн Их Сургуулийн Коллежийг байгуулахад баян чинээлэг бус, мөн үүсэж тогтчихсон Сүм Хийдийн гишүүн бус хүмүүст боловсрол олох замыг нээж тусалжээ. Бентам нь хамгийн гарамгай сонгодог либерал онолчийн нэг **Жон Стюарт Милл**д зааж сурган түүнд урам зориг өгч байв.

Гэвч Бентам нийтийн хуулийг статутад “коджуулан оруулах”^[24]ыг хүсэж байсан бөгөөд *АНУ-ын Тусгаар Тогтнох Тунхаглал* болон *Францын Эрхүүдийн Тунхаглал* руу дайрсан зүйл бичиж байлаа. Эрх бол ‘жам ёсны’ зүйл биш харин ‘аз жаргалын ерөнхий хэмжээ’ (ө.х. тэдгээрийн ашиг тустай байдал) дээр нь үндэслэж хүмүүст оноож өгөх ёстой, хууль-тогтоогч зааж өгдөг зүйл гэж тэрбээр батлан өгүүлж байсан байдаг. Түүний хувьд жам ёсны эрх бол “зүгээр л утгагүй зүйл байсан: жам ёсны болон салшгүй эрх бол хэт хөөрөгдсөн утгагүй зүйл – [гудамжны циркчдийн ашигладаг] өндөр хөлөн дээр тогтсон утгагүй зүйл”^[25] байв.

24 codify

25 nonsense upon stilts

[40] Жэймс Мадисон (1751–1836 он): Америкийн конституционалист, Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч. **Гол үзэл санаа:** эрх өмч болох нь^[26]; бага, нэг жигд татвар; дур зоргын эрх мэдлийн талаархи шүүмжлэл; үндсэн хуулийн харилцан хяналт болон эрх мэдлийн тэнцвэр^[27]. **Гол бүтээл:** *Федералист хүн* [*анг. the Federalist*] (1787–88 он).

Мадисон Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн Хуулийн гол эх баригч байж, эрх мэдлийг Монтеスキогийн санал болгосноор зааглаж хуваах явдлыг багтаан бататгахад нь тусалжээ. Тэрбээр энэ явдлаа *Федералист* [*анг. The Federalist*]-даа батлан өгүүлсэн. Гэвч үндсэн хуулийн “үг бүр” эрх мэдэл болон эрх чөлөөний хоорондох зөрчлийг шийдвэрлэдэг байсаар байх үед тэрбээр энэ үндсэн хуулийн зөвхөн цор ганц бодит хүч чадал бол “хувь иргэн бүрийнхээ хувийн амьдралыг хамгаалах ёстой түүний соргог байдал юм” гэдгийг л зөвхөн сахин хамгаалсан байдаг.

Мадисон эрхийн талаар эрхийг өмчийн нэг хэлбэр гэж дүрсэлж тайлбарлан шинэлэг үзэл бодолтой байв: ‘Хүнд өмчтэй байх эрх байдаг гэж хэлдэгчлэн хүн үүнтэй адилаар өөрийн эрхээ өмчилдөг^[28] байх ёстой гэж хэлж болно’. Түүний хувьд төр засгийг “төрөл бүр^[29]ийн өмч”-ийг “хамгаалах” гэж л институтцүүлж байгуулсан бөгөөд нэгэнт л өмчид нь хувь хүний амьд явах эрх, эрх чөлөө, чөлөөтэй үг хэлэх эрх чөлөө, шашин болон оюун санааны эрх чөлөө^[30] ордог учраас энэ нь эрх чөлөөний үндэс суурь ажээ. Бид бусад хүмүүс бидний газар руу дайрч орохыг зогсоох нь хуульзүйн дагуух зүйл байдаг шигээр бид бидний эрх рүү халдах явдлыг хуульзүйн дагуу зогсоох боломжтой.

26 *Rights as property*

27 *constitutional checks and balances*

28 *the property in rights*

29 *every sort*

30 *freedom of speech, religion and conscience*

Мадисон тиймээс л ‘өмчийн эрхийг болон эрхээ өмчлөх явдлыг ижил тэнцүү хүндэлдэг” тийм төр засгийг шаардаж байжээ. Тиймээс л татварлах явдал энэ нь өөрөө өмчид тавьж буй татвар болдог тул маш хязгаарлагдмал байх ёстой. Эдгээр нь ажиллах эрмэлзлийг унтраадаг учраас шатлан нэмэгдэх татвар, дахин-хуваарилалт бол шударга бус, бас хэт үр ашиггүй зүйл ажээ.

Төр засаг хүмүүсийн үзэл бодол, шашин, хувийн өвөрмөц чанар, хөдөлмөр, чөлөөт таашаалд хяналт тавих эсвэл юм тулгаж хамаатуулах явдал мөн л хязгаарлагдмал байх ёстой. Цэргийн зарлан дуудах явдал^[31] бол бидний эрх чөлөөнд байдаг өмчид халдаж ‘иргэдийн нэг ангийг бусдынх нь үйлчилгээнд зориулж дур зоргоороо баривчлах явдал’-ыг харуулж буй байдал юм. Үүнтэй адилаар хүмүүс мэргэжлээ чөлөөтэй сонгох, үйлдвэрлэсэн зүйлээ чөлөөтэй хэрэглэх явдлыг хориглодог дур зоргын дүрэм журам, давуу тал, монополь эрх ч шударга бус ажээ.

[41] Каролины Жон Тэйлор (1753–1824 он): Америк хүн, улстөрч, зохиолч. **Гол үзэл санаа:** Жам ёсны эрх; хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төрийн дор өөрөө-өөртөө засаглах^[32]. **Гол бүтээл:** *Америкийн Засгийн Газрын Зарчим болон Бодлогод Хийсэн Судалгаа [анг. An Inquiry into the Principles and Policy of the Government of the United States] (1814 он).*

Виржиниад төрсөн Тэйлор хууль судалдаг байсан ч үүнийгээ хөдөө аж ахуй болон улстөрийн ухааны төлөө хаяжээ. Тэрбээр хөдөө аж ахуйн шинэ арга барил анхлан гаргасан бөгөөд муж улсынхаа засгийн газар болон АНУ-ын Сенатад хоёуланд нь ажиллажээ. Мөн төвийн засаг захиргаанд тавих чанд хязгаарыг

31 *The military draft*

32 *self-government under a limited state*

өмгөөлж хамгаалдаг, анд Томас Жефферсонийхоо “бүгд найрамдагч” хандлагын гарамгай зүтгэлтэн болов. Тэрбээр хязгаарлагдмал эрх мэдэлтэй, төвлөрсөн удирдлагагүй төр^[33] дор амьдардаг, бие даасан, өөрийгөө-мэддэг өмч өмчлөгчийн Америк идеалийг дүрсэлж гаргажээ. Түүний сэтгэлгээ хувь хүний эрхийн үзэл санаа, сайн төр засгийн бүгд найрамдагч үзэл санаа^[34], нийгэмд татагддаг консерватив үзэл бодлыг, эрх мэдэл болон санхүүг жигшдэг олон-таалагддаг бодолтой холбож нэгтгэжээ.

Тэйлор хүмүүсийг сайн муу хосолсон бодгаль гэж ойлгодог байсан ч сайн санааны зарчим^[35]д үндэслэдэг үндсэн хуулийн төр засаг өөрийн-тусыг бодох болон үл мэдэх явдлын муу нөлөөг багасгах^[36] боломжтой гэдгийг баримталдаг байсан. Хэдийгээр тэрбээр АНУ-ын үндсэн хуулиар хэт их эрх мэдэл ерөнхийлөгчид өгсөн гэдэгт санаа зовдог байсан ч Тэйлор үүнийг нилээд өргөн хүрээтэй ашиг тустай гэж ойлгож байв. Учир энэ байдал үндсэн хуулиар эрх мэдлийг тэнцвэржүүлсэн, бүгд найрамдах шинжтэй^[37], төлөөллийн тогтолцоо^[38]нд хүмүүсийг бие даасан байдал^[39]тай болгодог ажээ.

Тэйлор эрх чөлөө нь хамгийн чухал байдаг ч жам ёсны эрх үүд объектив ёс суртахууны хуулийн статустай байдаг гэж батлан өгүүлж байсан. Эрх нь төр засгаас өмнө оршиж байсан тул түүнийг төр засаг үгүйсгэх, эдлүүлэхээс татгалзах боломжгүй ч төр засаг эдгээр эрхийг албадлага, деспотизм буюу дарангуйлал, үл мэдэх явдл^[40]аас хамгаалах бамбай хамгаалалт нь байх ёстой

33 *decentralised state*

34 *republican ideas*

35 *virtuous principles*

36 *ignorance*

37 *republican*

38 *republican, representative system*

39 *sovereign*

40 *ignorance*

ажээ. Тэрбээр эрх мэдлээ буруугаар ашиглах явдлаас гардаг, давуу эрх болон авилгалд гүн суусан байдаг гэж үзэн нийгмийг анги эсвэл эд хөрөнгөөрөө хуваагдах явдал гарцаагүй зүйл гэдгийг үгүйсгэж байлаа.

Улстөр болон эдийн засгийн эрх чөлөө хоорондоо салшгүй зүйлс гэж Тэйлор шаргуу ятгаж байв. Тэрбээр фермерүүд буюу өрхийн аж ахуй эрхлэгч болон ажилчдаас хураан авч банкны эзэн болон бараа үйлдвэрлэгч хөрөнгөтнүүдэд өгдөг эд хөрөнгө дахин-хуваарилдаг татвар гэж цаасан мөнгийг ойлгодог байсан. Тэйлор их татвар, протекционизмыг шүүмжлэн тэдгээр рүү дайрч байв. Мөн тэрбээр баян хүмүүст давуу тал өгөх, хянаж шалгах аргагүй байгууллага гэж үзэн Александр Хамилтоны санал болгосон үндэстний буюу улсын банк байгуулах саналыг буруушааж, дайрч довтолж байжээ.

[42] Антойне Десто де Трэйси (1754–1836 он): Франц хүн, Гэгээрлийн Эриний философич. **Гол үзэл санаа:** Өмчийн эрх; субъектив үнэ цэнэ; арилжаа худалдааны үр өгөөж; анти-интервенционизм; татаас болон төрийн монополийн муу хортой нөлөө. **Гол бүтээл:** *Монтескюгийн “Хуулийн Амин Сүнс”ийн Тайлбар* [анг. *Commentary on Montesquieu’s ‘Spirit of the Laws’*] (1808 он); *Монтескюгийн Гоц болон Бүтээлийн тухай Эссэ* [анг. *Essay on Genius, and the Works of Montesquieu*] (1808); *Идеологийн Элементүүд* [анг. *Elements of Ideology*] (1817–18 он).

Де Трэйси цол хэргэм зэргээсээ татгалзаж улстөрд орсон язгууртан байв. Тэрбээр ам мөлтөс Франц Хувьсгалын дараа өрнөсөн Хядлагаар цаазлуулахаас мултарчээ; гэвч шоронд удаан хоригдох үеэрээ тэрбээр өөрийнх нь сэтгэлгээнд нь нөлөөлсөн **Жон Локк** болон бусад либералуудын бүтээлийг уншлаа. Эдийн засгийн ухаан, улстөрийн ухаан, нийгмийн асуудлыг идеологиор нэгтдэг гэж бодож байсан; **Жан-Бастист Сэй, Кондорсе, Мадам**

де Стаэйл болон бусад хүмүүсийн адилаар хамтаар Идеологи^[41] гэсэн нэртэй философийн бүлгийг байгуулж байжээ. Тэрбээр **Адам Смит**ийн үзэл санааг олонд түгээж, бүгд найрамдах төр засаг^[42] болон чөлөөт зах зээлийг дэмжиж байсан. Тэрбээр дэлхий даяар нөлөөтэй байв: **Томас Жефферсон** түүнийг бичсэн бүтээлийг магтаж, тэдгээрийг нь орчуулж байсан билээ.

Нийгэм бол тасралтгүй үргэлжилсэн, цуварсан солилцоо гэж де Трэйси тайлбарладаг байв. Солилцооноос хоёр тал үр өгөөж хүртдэг: талбүрийн өгч буй үнэ цэнэ нь тэдний олж авч буй зүйлээс нь илүү бага байдаг: ‘Бид өөрийн хөдөлмөрөө цалингаар солих үедээ би тэр цалинд өөрийнхөө хөдөлмөрөөр өөртөө зориулж үйлдвэрлэх боломжтой байх ёстой зүйлээс илүү их үнэлж байгаа болно; надад цалин өгч буй хүн би түүнд үзүүлж буй үйлчилгээг тэрбээр тэр надад оронд нь өгч буй зүйлээс илүү ихээр үнэлж буй тул төлдөг байна’. Энэ явдал бол солилцооны эдийн засгийг маш их үр өгөөжтэй болгодог зүйл юм. Эдийн засгийг хөрөнгө хуримтлуулж, хөрөнгө оруулдаг, хүмүүс хөлсөлдөг, үнэ цэнэ бүтээдэг, түүгээрээ дахин хөрөнгө оруулдаг ажил хэрэгч хүн бүр л өгөөжтэй болгодог ажээ.

Де Трэйси мөн засаг захиргааны хууран мэхлэлт гэж ойлгож байсан цаасан мөнгөнөөс л гарах боломжтой инфляцийн муу нөлөөний талаар бичиж байсан. Инфляц зээлдэгч болон татварын хөнгөлөлт эдлэгчд^[43]ийг баяжуулдаг, мөн эдийн засгийн үйл ажиллагааг сулруулдаг тодорхойгүй байдлын шалтгаан болдог гэж гомдоллож байжээ. Үүнтэй адил үндэслэлээр төр засаг зээлийн хүүгийн хэмжээг хянах эрх мэдэлгүй байх ёстой гэв.

Тэрбээр төрөөс-дэмждэг, төрөөс-давуу эрх авсан компаниуд ыг төрөөс-байгуулсан монополь байдал бидний дураараа худалдан авч, зарж борлуулах жам ёсны эрхэд халдаж байна гэж

41 *Ideologues-1796-1815 оны хооронд цэцэглэж асан, философичид, физикчдийн Франц дугуйлан.*

42 *republican government*

43 *taxes savers,*

батлан өгүүлж, хортой муу зүйл гэж дүрсэлж тодорхойлж байв. Татвар, ялангуяа хэрэгцээт зүйлд тавих татвар хор хөнөөлтэй зүйл ажээ. Олон нийтийн ажил бусад хэрэгтэй төслийг шахаж зайлуулах болно. Лэзе-фээр эдийн засаг^[44]т үүний эсрэгээр бид хүчирхэг хүний ашиг сонирхолд үйлчилдэг болцгоохгүй харин бидэнд хамгийн чухал байх зүйл рүүгээ зорьж тэмүүлцгээдэг билээ.

[43] Виллиам Годвин (1756–1836 он): Англи хүн, ёс суртахууны болон улстөрийн философич. **Гол үзэл санаа:** Анархизм; утилитаринизм; ёс суртахууны тэгш байдал. **Гол бүтээл:** *Улстөрийн Шударга Ёстой Холбоотой Судалгаа* [анг.*An Enquiry Concerning Political Justice*] (1793 он).

Буулт үл хийгч ламтны хувиар амьдралаа эхэлсэн Годвин бол утилитарианизмын түрүү үеийн дэмжигч, анархизм^[45]ын орчин цагийн анхны гарамгай хамгаалагч байжээ ([анархизм бол] өнөөдөр олон хүн бослого тэмцэл, гар бөмбөг шидэх гэж улайрдаг гэж үүнийг төсөөлдөг шиг зүйл биш харин нийгэм төр засгийн засаг захиргаагүйгээр цэцэглэн хөгжих боломжтой гэж үздэг итгэл үнэмшил юм.) Тэрбээр мөн түүх бичиж, хүүхдийн ном ч хэвлүүлж байв.

Дуулиан шуугиантай амьдрал, үзэл санаа нь Годвиныг алдартай болгожээ. Тэрбээр өөртэй нь ижилхэн тэгш эрхийн хамгаалагч Мэри Воллстөункрафттай гэрлэж, уянгын шүлэгч Самуэл Тэйлор Колериж (1772–1834 он), Лорд Байрон (1788–1824 он), Роберт Сөөтий (1774–1843 он), өрийг нь төлсөн Перси Байсш (1792–1822 он)-тэй найз нөхөд байж, мөн түүний охин, ирээдүйд *Франкенштайн*^[46]ы зохиогч болох охин Мэри

44 *laissez-faire economy*

45 *proponent of anarchism*

46 *Frankenstein-Энэ зохиол бас Индонезид дэлбэрсэн галт-уулаас болж Газар Дундын Тэнгис хөлдсөн тэр жилтэй холбогддог.*

(1797–1851 он)-тэй нь зугтааж ч байлаа. Эхнэр нь үхэхэд тэрбээр түүний янз бүрийн хайр дурлал болон амиа хорлох гэсэн оролдлогыг тоочсон цочирдмоор намтрыг нь бичсэн бөгөөд энэ явдал найрсаг тайван нийгэм нь түүнээс жийрхэхэд хүргэжээ.

Улстөрийн Шударга Ёстой Холбоотой Судалгаа [анг. *An Enquiry Concerning Political Justice*] (1793 он)-ндаа Годвин улстөрийн бүх институтийг бут ниргэсэн байдаг. Тэрбээр зарим хувь хүн нь бусдыгаа захирах явдлыг үл хүлцэх зүйл гэж бодож байсан. Төрсөн орчин болон зэрэг дэв хүмүүстэй хэрхэн харьцахад нөлөөлөх ёсгүй гэж шаргуу ятгаж байлаа. Хаант засаглал завхарчихсан зүйл харин язгууртны давуу эрх бол шударга бус зүйл гэв. Үнэндээ төр засгийн аливаа хэлбэр хамааралтай байдал болон үл мэдэх явдлыг мөнхийн зүйл болгож нийгмийг завхруулдаг гэж батлан өгүүлж байсан.

Үүнийхээ дагуу Годвин хууль, өмч, бусад институтийг бүрэн түлхэн унагаахыг уриалж байлаа. Засаг захиргаа байхгүй гэсэн утгатай энэхүү анархи байдал^[47] албадлагаар бус харин хэлэлцүүлэг яриа хөөрөөгөөр л ажиллах болно. Түүнд чөлөөтэй ярих, нээлттэй яриа хөөрөө шаардлагатай байх боловчиг хүмүүс үнэнийг ялгаж таньдаг чадвартай байх ёстой бөгөөд технологийн дэвшил тэдэнд үнэнийг олж мэдэхдээ илүү их цаг зав гаргах боломж олгох ажээ. Ёс суртахууны ухаарац ойлголт улстөрийн явцын хэрэгцээ шаардлагыг орлох болно. Үйлдлийг рационал утилитарич зарчимд үндэслэн шийдэх болно: ‘Хэрэв шударга ёс ямар нэг утгатай байсан бол’ гэж тэрбээр эхлээд ‘энэ нь бид өөрийн чадах бүх зүйлээрээ нэг бүхэл зүйлийн сайн сайханд хувь нэмэр оруулах ёстой явдал байх болно’ гэж бичсэн нь бий.

[44] Мэри Воллстөункрафт (1759–1797 он): Англи хүн, эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалагч. **Гол үзэл санаа:** Феминизм; тэгш эрх; республиканизм^[48]. **Гол бүтээл:**

47 *anarchy*

48 *republicanism*

Эрчүүдийн Эрхийг Өмгөөлсөн нь [анг. A Vindication of the Rights of Men] (1790 он); Эмэгтэйчүүдийн Эрхийг Өмгөөлсөн нь [анг. A Vindication of the Rights of Women] (1792 он).

Виллиам Годвины эхнэр Мэри Воллстөункрафт (Мэри Шеллийгийн ээж) ер бусын байдлаар амьдралаа хөөсөн, радикал буюу хурц ширүүн сэтгэгч байлаа. Тэрбээр роман зохиогч, мөн эрчүүдийн эрхийг мөн эмэгтэйчүүдэд хамаатуулан олгох ёстой гэж итгэдэг, түрүү үеийн улстөрийн феминист философич байв. Түүний үзэл бодлыг **Ричард Прайсын** сургаал өдөөжээ. Прайсыг түүнтэй радикал нийтлэлч Жозеф Жонсон танилцуулсан нь үзэл санаагаа хөгжүүлэх, улам ихээр нийтэд түгээх боломж олгов.

Эрэгтэйчүүдийн Эрхийн Өмгөөлөл [анг. A Vindication of the Rights of Men] (1790 он)-дөө Воллстөункрафт язгууртны тогтолцоог бүгд найрамдах тогтолцоогоор солих тухай санал болгож, мөн Эдмүнд Беркийн уламжлализм^[49]ыг хөгжил дэвшил болон рационал байдлыг саатуулагч гэж дайрч давшилжээ. *Эмэгтэйчүүдийн Эрхийн Өмгөөлөл [анг. A Vindication of the Rights of Women] (1792 он)-дөө* тэрбээр эмэгтэйчүүд нийгэм, хүүхдийн боловсролд хэрхэн амин чухал болохыг харуулсан байдаг; хүмүүн төрөлтний рационал бодгаль болохынхоо хувьд эмэгтэйчүүд эрчүүдтэйгээ адилхан эрхтэй байх гавьяатай ажээ. Тэрбээр эмэгтэйчүүдэд эрчүүдийн ашиг тусын төлөө бус харин эмэгтэйчүүдийн төлөө, энэ боловсрол нь эрчүүдийнхтэй адилхан ‘нэг ижил загвартай боловсрол’ байх ёстой гэж шаргуу ятган өргөн хэмжээнд боловсрол олгохыг өмгөөлж хамгаалж байв. Эмэгтэйчүүдийг нийгэмд гоо сайхан, даруу байдал, бусад дундаж ангийн худал үнэ цэнийн төлөө арагш нь татаж байдаг гэж тэрбээр бодож байжээ. ‘Өнөө цагийн иргэншсэн эмэгтэйчүүд’ гэж тэрбээр эхлээд ‘хэдхэн тохиолдлоос бусдад нь адилхан хүндлэл хүлээх өөрийн чадвар, сайн үйлсээрээ илүү

49 *traditionalism*

шинэлэг алсын бодолдоо хүрэх гэж тэмүүлэхийг эрэлхийлэхийн оронд зөвхөн хайр дурлалд татагдах болжээ’ гэж бичиж байлаа.

[45] Жермайне де Стаэл (1766–1817 он): Швейцар-Францын иргэн, сэхээтэн, роман туурвигч. **Гол үзэл санаа:** Републикч либерализм^[50]; төлөөллийн төр засаг^[51]; хувийн өмч эрхийн үндсэн суурь болох нь; үндсэн хуулийн хаант засаглал^[52]; анти-абсолютизм; төвлөрлийг бууруулах. **Гол бүтээл:** *Францын Хувьсгалын Гол Үйл Явдлын тухай Эргэцүүлэл* [анг. *Considerations on the Principal Events of the French Revolution*] (1817 он).

Тэр цагийн үеийнхээ эмэгтэйчүүдэд баймгүйгээр де Стаёл цаг үеийнхээ тэргүүлэх сэхээтэн, зохиолч болжээ. Энэ бүсгүйн нэр нөлөө олон-улсынх байж, өндөр төвшинд хүрч байв: тэрбээр Наполеон Бонапарт (1769–1821 он)-тай маргалдаж, **Томас Жефферсон**той захидлаар харилцан, Оросын эзэн хаан I Александртай (1777–1825 он) танил байжээ. Гэрэл цацруулсан хувь хүний чанар, хурц ухаан, роман туурвигч болон улстөрийн сэтгэгч гэсэн нэр хүнд түүнийг Герман, Англи, Швед, Орос, Австрийн салон^[53]ы байнгын үзэсгэлэн гоо од болгов. Тэрбээр цаг үеийнхээ зарим нэг тэргүүлэх алдартнуудтай, үүн дотроос Иоханн Гёте (1749– 1832 он), Виллиам Питт (1759–1806 он), Бенжамин Константтэй романтик учир ургуулж байв. Үе чацуутан нь нэгэнтээ хэлснээр ‘Европд гурван аугаа гүрэн байв. Үүнд: Англи, Орос, Мадам де Стаёл ордог’ ажээ.

Стаёл бүсгүй баян гэр бүлд төрсөн. Түүний эцэг Швейцарын

50 *Republican liberalism*

51 *representative government*

52 *constitutional monarchy*

53 *salons* - энэ бол нийгмийн дээд зиндааны олонд алдартай эмэгтэйн гэрт ялангуяа зохиолч, жүжигчид, зураачид гээд хүмүүс байнга уулзалддаг цуглаан юм.

банкны эзэн Жак Неккер (1732–1804 он) XVI Луй (1754–1793 он)-гийн санхүүгийн сайд байсан бөгөөд эрх чөлөө, төр засаг, үндсэн хуулийн тухай хэд хэдэн номын зохиогч байв. Неккер эзэн хааны албанаас халагдахад гэр бүлээрээ өөрсдөө Швейцар руугаа буцацгаав. Эцэг эх нь түүнийг өөрөөс нь хоёр дахин ахимаг настай Шведийн дипломаттай суулгахаар хүчилсэн нь түүний нийгмийн статусыг нь өсгөв. Тэрбээр улстөрийн хямралын тухай бичиж эхэлсэн ч Наполеоны туршуулууд түүний үйл хөдлөлийг ажиглаж мөшгөн, түүнийг энэ ажлаа цөллөгт үргэлжлүүлэхэд хүргэсэн.

1814 онд Парист Борбоны Цагаатгал^[54]аар буцаж очиж 1817 онд *Францын Хувьсгалын Гол Үйл Явдлын тухай Эргэцүүлэл*э гүйцээжээ. Энэ ном орчин үеийн Франц либерализмийн суурь болсон юм. Түүндээ зуун жилийн өмнө Англид болсон цус асгаруулаагүй хувьсгалыг бий болгосон нийгэм, соёл, улстөрийн нэг ижил хүчин зүйлийн гарцаагүй үр дүн бол Франц Хувьсгал байсан гэж батлан өгүүлсэн. Де Стаёл дур зоргоороо шоронд хорих, цөлөх зэргээр Францын эзэн хаад эрх мэдлээ олонтоо буруугаар ашигласан нь энэхүү Хувьсгалын хэсэгчилсэн зөвтгөл гэж харж байлаа; гэвч энэ бүсгүй Бонапарт улстөрийн үймээн самууны дараагаар булаан авсан абсолют буюу үнэмлэхүй эрх мэдлийг үүний адилаар шүүмжилж байлаа.

Францыг хуулиар биш харин дүр зоргын эрх мэдлээр захирдаг гэж тайлбарлаж байсан. Удаан үргэлжилж буй улстөрийн хурцадмал байдлыг шийдвэрлэх боломжтой цор ганц тогтолцоо бол конституционализмын либерал тогтолцоо^[55], төлөөллийн төр засаг, хууль ёс^[56], хувийн өмч гэв. Улстөрийн төлөөлөгчдийг захирагдаж байгаа хүмүүсийнх нь хүсэл зоригоор хязгаарладаг, чөлөөт үг яриа, чөлөөт хэвлэл^[57]ээр хүчитгэсэн, хууль ёс, ёс

54 *Bourbon restoration*

55 *system of constitutionalism*

56 *rule of law*

57 *free speech and a free press*

суртахуунт байдал, улстөрийн эрх чөлөөнөөс эдийн засгийн хөгжил цэцэглэлт гардаг батлан өгүүлж байсан. Энэ явдал эргээд нийгмийн эв зохицл^[58]ыг тэтгэдэг байна: ‘Эрх чөлөөнөөс өөр юу ч’ гэж тэрбээр эхлээд ‘нийгмийн дэг журмын төлөөх ашиг сонирхлыг өдөөн дуудаж чадахгүй’ гэж бичиж байлаа.

[46] Вилхелм фон Хамболдт (1767–1835 он): Прүсс, философич, боловсрол судлаач^[59], дипломат, хэлзүйч. **Гол үзэл санаа:** Ёс суртахууны хөгжил дэвшилд эрх чөлөө амин чухал болох тухай; харуулын үүрэгтэй төр. **Гол бүтээл:** *Төрийн Үйлдэлд тавих Хязгаарлалт [анг. On the Limits of State Action] (1850 он).*

Хамболдтод **Жон Локк** маш их нөлөөлжээ. Түүнийг нас барсных нь дараа хэвлэгдсэн ном нь болох *Төрийн Үйлдэлд тавих Хязгаарын Тухай [анг. On the Limits of State Action] (1850 он)* бүтээл Жон Стюарт Миллд нөлөөлж, харин түүний *Эрх Чөлөөний Тухай [анг. On Liberty] (1859 он)* эссэ нь Хамболдтын үзэл санааг Англи хэлтэнд тархаан түгээжээ.

Төрийг түүнийг бүрэлдүүлдэг хувь хүмүүсийн аюулгүй байдлыг батлан хангахаар л хязгаарлах ёстой гэж бичсэн байдаг. Хүмүүн төрөлтний хамгийн дээд зорилго өөрийгөө хөгжүүлэх^[60], ёс суртахууны хөгжил байсан. Эрх чөлөө энэхүү зорилгод амин чухал байдаг. Учир нь эрх чөлөө янз бүрийн өргөн хүрээнд сургамж туршлагатай болох, түүнээсээ суралцаж мэдэх хувилбар боломжууд олгодог байна. Тиймээс бид олон янз байдл^[61]ыг хүлцэх ёстой ажээ. ‘Эрх чөлөө бол аугаа, биднээс хагацашгүй нөхцөл юм’ гэж тэрбээр бичиж байв. Гэвч эрх чөлөө гэдэг нь олон янз байдал гэсэн утгатай байдаг: ‘Бүр хамгийн их

58 *social harmony*

59 *educationalist*

60 *self-cultivation*

61 *diversity*

эрх чөлөөтэй, өөртөө-итгэлтэй хүмүүс хөгжиж дэвжихэд нэг ижил нөхцөл байдалтай байх явдал^[62] саад болно’.

Хамболдтын хувьд эрх чөлөө бол хүмүүс өөрийн хүссэнээрээ гэхдээ өөрийн эрх болон чадвараа л зөвхөн хязгаарлагдах боломжтой, өөр хэн ч ингэж хийхийг нь хориглох боломжгүйгээр өөрийн өвөрмөц чанараа хөгжүүлэх “хамгийн үнэмлэхүй эрх чөлөө” эдэлдэг нөхцөл ажээ. Төр тиймээс биднийг өөрийгөө хөгжүүлэхэд хөндлөнгөөс үл оролцдог, биднийг гаднын халдлагаас хамгаалдаг зөвхөн харуулын үүрэг^[63]тэй л байх ёстой.

[47] Бенжамин Констан [Henri Benjamin Constant de Rebecque] (1767–1830 он): Швейцар–Францын иргэн, роман туурвигч, улстөрч, улстөрийн зохиолч, идэвхтэн. **Гол үзэл санаа:** Үндсэн хууль төр засгийг хязгаарладаг хязгаарлалт болох нь; харилцан хяналт болон эрх мэдлийн тэнцвэр^[64]; хуульзүйн дагуухь бүрэн эрхгүй төр засгийг эсэргүүцэх эрх. **Гол бүтээл:** *Бүх Төр Засагт Хэрэглэх Боломжтой Улстөрийн Зарчмууд* [анг. *The Principles of Politics Applicable to All Governments*] (1815 он).

Констан өөрийгөө “либерал” гэж нэрлэсэн анхны сэтгэгчдийн нэг байжээ. Олон газар аялсан тэрбээр Герман, Шотландад сурч байв. Шотландад байхдаа **Адам Фергүсон** болон **Адам Смит**ийн үзэл санааг олж мэджээ. Хэдийгээр үндсэн хууль хаант засаглал болон хууль тогтоох байгууллагын язгууртны дээд танхимд итгэдэг байсан ч Констан улстөрийн либерал онолд чухал хувь нэмэр оруулсан.

Ялангуяа Констан үндсэн хууль бидний удирдагчийг хүч чадалтай болгох гэж биш харин тэднийг хязгаарлах гэж оршдог гэж батлан өгүүлж байв. Бүр олон нийтэд таалагддаг төр засаг

62 *uniformity of position*

63 *night-watchman role*

64 *checks and balances*

түүнийг хязгаарлахгүй л бол олонхийн дарангуйлал болох болно: **Монтескюгийн** адилаар тэрбээр эрх мэдлийг хянаж хязгаарлахад үндсэн хуулийн хяналт, эрх мэдлийн тэнцвэр шаардлагатай гэдэг байлаа. Бидний хэн нь ч аливаа бусад нэгнээ захирах эрх дарх^[65]гүй байдаг гэж шаргуу ятгадаг байсан: захирах захирагдах явдал бол тэр хүмүүсийн санал нэгдэх явдал юм. Хэрэв төр засаг [түүний талаар] олон нийтийн санал нэгдсэн байдл^[66]аа алдсан бол бүхий л бүрэн эрхээ алддаг бөгөөд түүний албадлагын эрх мэдэл хуульзүйн дагуухь бус зүйл болдог байна. Хүмүүс тэдний эрх чөлөөнд халдаж буйг эсэргүүцэх эрхтэй – энэ бол төр засгийн эрх мэдлийг хязгаарлах үнэ цэнэтэй өөр нэг хязгаарлалт ажээ.

Гэвч энэ бүхэн биднээс бүр холдчихжээ. Амьдралаа гэж завгүй яваа хүмүүст улстөрд идэвхитэй оролцоход цаг бага л байдаг. Тиймээс хүмүүст эрх чөлөө нь улстөрийн саналын эрхтэй байхаас илүү үнэ цэнэтэй байдаг. Констан үндсэн эрх чөлөөний урт жагсаалтыг гаргасан. Үүнд нь: хувь хүний эрх чөлөө, шашны эрх чөлөө, үг хэлэх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө^[67], өмчийн эрх, засаг захиргаанд байгаа хүмүүсийн дур зоргын шийдвэрээс хамгаалагдсан хамгаалалт ордог.

[48] Жан-Баттист Сэй (1767–1832 он): Франц бизнесмэн, эдийн засагч. **Гол үзэл санаа:** Сэйгийн хууль; эдийн засгийн нийлүүлэлтийн тал; хөгжил дэвшилд хүргэх либерал санаачилга. **Гол бүтээл:** *Улстөрийн эдийн засгийн тухай Сургаал* [анг. *A Treatise on Political Economy*] (1803 он).

Нэрээр нь нэрлэсэн ('нийлүүлэлт өөрийнхөө хэрэгцээг бий болгодог' гэж хорьдугаар зууны нэг эдийн засагч хураангуйлж томьёолсон) Хуулиараа хамгийн сайн танигдсан Сэй Лионд Протестант гэр бүлд төржээ. Амьдралаа арилжаа наймаанд

65 *entitlement*

66 *consent of the public*

67 *free speech and opinion-эдгээр нь freedom of conscience*

зориулсан тэрбээр Англид чихрийн худалдаачинд, дараагаар нь Францад даатгалын компанид ажиллаж байсан. Гэвч ажлын энэхүү замнал түүнийг Францын санхүүгийн сайдын нарийн бичгээр, дараагаар нь төр засгийн бусад албанд томилоход өөрчлөгдөв – энэ явдал түүнийг Наполеон Бонапарт (1769–1821 он)-ын дургүй хүргэсэн (**Адам Смит**ийн либерал зарчмыг тайлбарлаж таниулсан) бүтээлээ бичих хүртэл үргэлжилсэн бөгөөд үүний дараагаар бизнес рүүгээ буцан орж, хөвөн даавууны том хэмжээтэй тээрэм ажиллуулав.

Сэйгийн Хууль үйлдвэрлэл бол бүх эрэлтийн үүсгүүр (энэ бол **Жэймс Милл** болон **Жон Стюарт Милл** зэрэг зохиогчид аль хэдийнээс хэлэх гээд байсан санаа юм) болохыг харуулдаг. Сэйгийн тайлбарласнаар бол хувь хүмүүс зөвхөн тэд амжилттай бараа бүтээгдэхүүн бүтээж эсвэл үйлчилгээ гаргасан бол мөнгө олдог - үүний дараа тэд бусад бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ худалдан авах чадалтай болдог.

Үүнээс хоёр чухал либерал дүгнэлт гардаг. Эхнийх нь бүтээлч байдал болон хөрөнгө оруулалт бол хөгжил цэцэглэлтийг хурдлуулж тэтгэх цор ганц арга зам байхад харин төр засгийн зарцуулалт зардал болон зохицуулалт буюу дүрэм журам үүнийг жинхэнээсээ үгүй хийж ч болно. Хоёрдох нь эдийн засаг өөрөө-өөрийгөө зохицуулдаг явдал юм: хэрэв хэт үйлдвэрлэл зах зээлд гарвал зах зээл төр засгийн хөндлөнгийн оролцоогүйгээр өөрөө эргээд тэнцвэрт орох болно – энэ нь нэг бол үйлдвэрлэгч илүү ихийг нийлүүлж чадахгүй эсвэл хэрэглэгчид нь илүү ихийг худалдан авч хүчрэхгүйгээс шалтгаалдаг байж болно.

Сэй мөн инфляц үнийн харьцангуй дохиог сарниулж бусниулдаг гэж үзсэн учраас мөнгөний хязгаарлалт^[68]ыг өмгөөлж хамгаалдаг байжээ (энэ гол санааг нь хожим **Лүдвиг фон Мизэс**, **Ф. А. Хаек** гаргаж ирсэн). Тэрбээр мөнгөний бодлогын тогтвортой байдал, хувийн өмч, өрсөлдөөн, бага татвар, алдагдалгүй төсвийг ажил хэрэгч хүмүүс хүмүүсийн хэрэгцээг

хамгийн сайн шийдэхээр шинэчлэл хийж, хөрөнгө оруулахыг сэдэлжүүлж урам оруулдаг гэж өмгөөлж хамгаалж байв.

[49] Дэвид Рикардо (1772–1823 он): Англи хүн, эдийн засагч, хувьцааны арилжаачин, улстөрч. **Гол үзэл санаа:** Эдийн засгийн онол; чөлөөт худалдаа; харьцуулсан давуу тал. **Гол бүтээл:** *Улстөрийн Эдийн Засаг болон Татварлах Явдлын Зарчмуудын Тухай* [анг. *On the Principles of Political Economy and Taxation*] (1817 он).

Рикардогийн ажлын замнал амжилттай брокер, дамчны ажлаас эхэлжээ. Тэрбээр зах зээл дээрх тоглогчдод төөрөгдөлд оруулж Франц Ватерлоогийн Байлдаанд ялсан гэж төөрөгдүүлэн, дараагаар нь хувьцаа болон бондыг нь худалдаж авч 1 сая фунт стерлинг олсон гэж яригддаг.

Түүний эдийн засагчийн ажлын замнал **Адам Смитийн Үндэстний Баялаг** [анг. *Wealth of Nations*] (1776 он) уншсанаар эхэлжээ. Смитийн үзэл санаанд хатуу чанга логик хэрэглэснээр тэрбээр рент буюу түрээс, цалин хөлс, ашиг, татварлах явдал, үнэ цэнийн тухай онолд чухал нээлт хийсэн. Рикардо 1809 онд Английн өндөр инфляц мөнгөн тэмдэг хэт их хэвлэсний үр дагавар байсан гэж батлан өгүүлж байсан нь түүнийг түрүү үеийн монетарист^[69] болгосон билээ. Смитийн адилаар тэрбээр протекционизмыг (улаан буудайны импортыг хязгаарласан) *Үр Тарианы Хууль* [анг. *Corn Laws*] дотоодын үйлдвэрлэлийг өгөөж муутай болгож, рентийг нэмэгдүүлдэг гэж батлан өгүүлж эсэргүүцсэн.

Рикардогийн либерал сэтгэлгээнд оруулсан хамгийн том хувь нэмэр бол магадгүй харьцангуй өртгийн онол (одоо *харьцуулсан давуу тал*^[70] гэдэг болсон) байж болох юм. Улс орнууд юуг бусад улсуудаасаа *харьцангуй* хямд үйлдвэрлэдгээрээ (тэд юу

69 *monetarist*

70 *comparative advantage*

үйлдвэрлэх боломжтой байх вэ гэдэг утгаар) мэргэжин төрөлжиж өөрсдөө баян тарган болох боломжтой гэж хэлсэн байдаг. Бүр хэрэв улс орон бусад улсуудаасаа бүх зүйлийг (*абсолют* утгаар) илүү хямд үйлдвэрлэх боломжтой байсан ч харьцуулсан давуу талтай байдаг бараа бүтээгдэхүүнээрээ төрөлжих, мэргэжих, арилжаа худалдаа хийх нь илүү сайн байсаар л байх болно. Энэхүү зарчим чөлөөт худалдааг дэмждэг гаргалгаа нотолгооны нэг гол үндэслэл болсон бөгөөд одоо ч байсаар байна.

[50] Жэймс Милл (1773–1836): Шотланд хүн, эдийн засагч, түүхч, улстөрийн эрдэмтэн, философич. **Гол үзэл санаа:** хууль, шоронгийн шинэчлэл; утилитарианизм; хүлцэхүй, үг хэлэх эрх чөлөө; төлөөллийн төр засаг; парламентын шинэчлэл. **Гол бүтээл:** *Улстөрийн эдийн засгийн Элементүүд [анг. Elements of Political Economy] (1821 он); Төр Засаг, Юриспруденц, Хэвлэл, Боловсрол, Шорон, Шоронгийн Дэгийн Тухай Эссэ [анг. Essay on Government, Jurisprudence, Liberty of the Press, Education, and Prisons and Prison Discipline] (1823 он).*

Жэймс Миллийн ээж түүнд гайхалтай боловсрол олгож, бүр гэр бүлийнхээ нэрийг Милн гэснийг нь Милл болгон Шотландтай адилхан дуудагдахаар болгож өөрчлөн, гуталчны хүүдээ хөгжиж дэвжих үүдийг нь нээн өгчээ. Жэймс Эдинбүргийн Их Сургуульд нэртэй Герег хэлний эрдэмтэн болж, лицензтэй ламтан болсон; гэвч түүний жинхэнэ авьяас нь зааж сургах, бичиж найруулах байв.

Лондон руу шилжсэнээр тэрбээр экспортын татаасыг шүүмжилсэн памфлет зохиогч болж, байнга л нийтлэл хянан шалгах, сэтгүүлд нийтлэл бичих болов. Энгийн, ойлгомжтой, учирзүйтэй хэвмаягаар тэрбээр улстөрийн ухаан, хууль болон боловсролын талаар *Британника Нэвтэрхий Тольд* оруулга мэдээлэл бичиж байсан бөгөөд (гэмт хэрэг үйлдэх байдал муу

боловсролоос болдог бөгөөд эрүүгийн хэрэгтнүүдийг тэднийг гэмтээж хохироохоосоо илүүтэй дахин боловсрол олгох ёстой гэж батлан өгүүлж) шоронгийн шинэчлэл талаар нийтлэл бичиж байсан. Тэрбээр *Британийн Энэтхэгийн Түүхийн Тухай* [анг. *on The History of British India*] (1818 он) гэсэн асар том гурван боть ном бичсэн бөгөөд хэдийгээр тэрбээр Британийн засаглалыг шүүмжилдэг ч гэсэн Лондон дахь Энэтхэгийн иргэний албанд орсон.

Гучаад насныхаа эхээр шашны хүлцэхүй, хуулийн шинэчлэл, чөлөөт хэвлэл, ардчилсан шинэчлэлийнх нь итгэл үнэмшилтэй санал нийлдэг **Жереми Бентам**тай уулзжээ. Тэрбээр Бентамын анд нөхөр болсон бөгөөд Бентамын эрс ширүүн үзэл санааг олонд таалагддаг ихэд тархсан философи болгож, мөн утилитарианизмынх нь тэргүүлэх өмгөөлөгч болов.

Миллийн *Төр Засгийн Тухай Эссэ* [анг. *Essay on Government*] (1820 он) бол улстөрийн ухааны өргөн хүрээний судалгаа юм. Хүмүүс хүрээлэл буюу нийгэм^[71] дэх хувь хүмүүсийн аз жаргалыг тэтгэх гэж л төр засаг оршдог гэж утилитари зарчмыг ашиглаж батлан өгүүлсэн. Нэгэнт л хүмүүс цаанаасаа л хамгийн бага хүчин чармайлтаар аз жаргалтай болохыг хүсдэг, бусдын хөдөлмөрөөр (ингэснээр аз жаргалыг нь бууруулдаг) сайхан амьдрахдаа дуртай байдаг тул төр засаг иймэрхүү мөлжлөгийг хязгаарлаж аз жаргалыг хамгийн их болгохоор зорих ёстой ажээ. Хаант засаглал, язгууртны засаглал ийм зүйлд хүрч чадахгүй. Учир нь тэдгээр нь мөлжлөг дээр тогтдог; гэвч шууд ардчилал^[72] хүмүүсийн цаг хугацаа болон хүчин чармайлтыг асар ихээр сорно. Төлөөллийн төр засаг л тиймээс хамгийн сайн нь байдаг.

Гэвч хувь хүмүүс өөрийн ашиг сонирхлоо хамгийн сайн үнэлж цэгнэдэг бөгөөд төлөөлөгчдийг бусдад өөрийн ашиг сонирхлоо нялзаах тулгаж хүлээлгэхээс нь хязгаарлах шаардлагатай. Тиймээс Милл радикал шинэчлэл үүн дотроо байнга явуулдаг

71 *community*

72 *direct democracy*

сонгууль, богино хугацааны мөчлөг, өргөн хүрээтэй сонгох сонгогдох эрхийн төлөө маргаж мэтгэлцдэг байсан – гэвч өөрийн хүү Жон Стюарт Миллийнхээ сэтгэлийг гонсойлгож эмэгтэйчүүдийн санал өгөх явдлыг үүнд оруулаагүй байдаг. Миллийн үзэл санаа *1832 оны Шинэчлэлийн тухай Билл*^[73] гарахад хүргэсэн парламентын эрс шинэчлэлийг дэмждэг гаргалгаа нотолгоог улам ихээр хөгжүүлжээ.

73 *1832 Reform Bill*

ДОЛООДУГААР БҮЛЭГ: ШИНЭЧЛЭЛИЙН ЭРИН

Америкт арванесдүгээр зууны эхний хагасыг боолчлолын эсрэг, хөдөлгөөн болон үзэл санаа гайхалтай урагшилсан үе гэж хардаг. Мөн олон аболиционист хүн жендерийг арьсны өнгөнөөс илүүтэй тэгш бус харьцах хандах явдлын үндэслэл болох ёсгүй гэж ойлгон эмэгтэйчүүдийн ижил тэгш эрх, улстөрийн оролцоог дэмжиж байсан. Олон нь шашны зарчимд, бусдад нь байгалийн хууль^[1]д эсвэл АНУ-ыг үүсгэж байгуулсан либерал зарчимд хандаж байжээ. Зарим аболиционист хүн гэвч эмэгтэйчүүдийн эрхийг боолчлолын-эсрэг үндэслэлийг хордуулж муутгах боломжтой радикал, маргаантай асуудал гэж ойлгож байсан. АНУ-д 1865 онд боолчлолыг устгасан ч гэсэн эмэгтэйчүүд сонгууль санал өгөх эрхээ 1920 онд Үндсэн Хуульд түүнийг нь бичсэнээр л сая олж авчээ.

Британид 1772 онд шүүхийн алдартай шийдвэрээр боолчлолыг энэ улсад байх нь хуульзүйн ямар үндэслэлгүй гэж тогтоосон. 1808 он гэхэд Парламент нь боолын олон-улсын худалдааг хууль бус гэж үзсэн^[2] бөгөөд Британийн эзэмшилд ч гэсэн боолчлолыг хууль бус гэж үзэх явдал улам нэмэгдэж байв. Энэ нь 1833 оны Боолчлолыг Устгах Актаар биеллээ олжээ.

Эдийн засгийн либерал үзэл санаа мөн л хуучны дэг журмыг сорьж байлаа. Хувьсгалын дараахь Францад нийгмийн асар их хөдөлгөөн гарсанд **Фредерик Бастиа** зэрэг зарим нэг сэтгэгчид яагаад монополь байдал болон протекционизмыг үргэлжүүлэх ёстой гэж асууцгаах болжээ. Хурдтай аж үйлдвэржиж буй Британид **Ричард Кобден** болон **Жон Брайт** нар үүнтэй адилаар хөдөө аж ахуйн тарифын хамгаалалт одоо нэгэнтээ олон нийтийн

1 *natural law*

2 *outlawed*

ашиг сонирхолд хэрэг болохоо больж харин ч түүнийг хохироох болсон гэж батлан өгүүлж байв. [Британид байгуулсан] шинэ төмөрзам иймэрхүү шинэчлэгч нар ухуулж таниулах ажлаа үндэсний хэмжээнд явуулах боломж олгожээ. Аз үйлдвэрлэлийн Хувьсгалаар бүх гүн гүнзгий өөрчлөлт гарахын хамтаар төрийн үүрэг хариуцлагын талаар үндэстний болон олон-улсын хэмжээнд маргаан мэтгэлцээн гарах цаг ирлээ.

[51] Виллиам Эллери Чаннинг (1780–1842 он): Америк хүн, Унитарич ламтан, шашин судлаач, аболиционистч, нийгмийн шинэчлэгч. **Гол үзэл санаа:** Жендерийн тэгш байдал; амьд явах эрх^[3]; боолчлолыг устгах. **Гол бүтээл:** *Боолчлол [анг. Slavery] (1835 он).*

Чаннинг эмэгтэйчүүдийн хөдөлгөөний анхдагчдын нэг байсан бөгөөд жендерийн тэгш байдлын төлөө олон нийтийн өмнө гаргалгаа нотолгоо гаргаж тавьж байжээ. Тэрбээр үүнээ шашны зарчимд голчлон үндэслэсэн байдаг. Учир нь сэтгэл зүрхний универсал байдл^[4]аас харвал эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд Бурханы нүдэнд ижил харагддаг байсан ч “зөн совин, ашиг сонирхол, хүч” л нийгэмд үүнийг тусгалаа олохоос сэргийлж байсан ажээ.

Чаннинг мөн ном, сургаалаараа боолчлолын эсрэг үндэслэлийг олны анхааралд оруулсан. Өмчийн эрхийн байр байдлаараа хүмүүн төрөлтөн бусдынхаа өмч байх боломжгүй. Хэдийгээр тэрбээр Африкчуудыг ямар нэг дээрээс хянах зүйлгүй болгож боолоос чөлөөлбөл^[5] тэд амьдарч чадахгүй гэж итгэсээр л байсан ч Британи Карибын улсуудад эв найртайгаар боолчлолыг устгасан явдал түүнийг АНУ-ыг ч мөн даруй боолуудаа чөлөөлөхийг шаардах итгэлтэй болгов.

3 *right to life*

4 *universality*

5 *emancipation*

[52] Сара Гримке (1792–1873 он): Америк аболиционистч, эмэгтэйчүүдийн сонгуулийн эрхийн хөдөлгөөний удирдагч **[53] Анжелина Гримке (1805–1879 он)**: Америк, аболиционистч, сонгуулийн эрхийн төлөө тэмцэгч. Гол үзэл санаа: Абсолютизм, эмэгтэйчүүдийн эрх. Гол бүтээл: *Хүйсийн Тэгш Байдал ба Эмэгтэйчүүдийн Нөхцөл Байдал* [анг. *The Equality of the Sexes and the Condition of Women*] (Сара, 1839 он); *Өмнөдийн Загалмайтан Эмэгтэйчүүдэд Хандах нь* [анг. *An Appeal to the Christian Women of the South*] (Анжелина, 1836 он).

Сара Гримке эмэгтэйчүүдийн сонгуулийн эрхийн төлөөх хөдөлгөөнийг удирдсан, гарамгай Америк аболиционистч байв. Өмнөд Каролинагийн Боол-өмчилдөг гэр бүлд төрсөн тэрбээр боолуудаа унших сурахад нь (ил цагаан) тусалдаг байжээ. Филадельфия руу нүүснийхээ дараа тэрбээр Квакер^[6] болсон. Гэвч Сара өөрийн охин дүү Анжелинатайгаа Квакерын удирдлагын төлөө хоорондоо сонинд захидал бичиж, эмэгтэйчүүдийн нөхцөлийн талаар эргэцүүлэл бичих^[7] зэргээр зөрчилдөж байжээ. Сарагийн 1839 оны ном *Хүйсийн Тэгш Байдал болон Эмэгтэйчүүдийн Нөхцөл* [анг. *The Equality of the Sexes and the Condition of Women*]-ыг нь маш ихээр уншицгааж байв. Тэрбээр боолчлолын-эсрэг үндэслэл нь эмэгтэйчүүдийг чөлөөлөх явдл^[8]ын үндэслэлээс ялгаагүй: эмэгтэйчүүд мөн л ёс суртахууны зүйл^[9]ийг эрх үүргийн хамтаар ухаж ойлгодог гэж батлан өгүүлж байлаа. Гэвч зарим аболиционст хүмүүс эгч дүү Гримкегийн радикал феминизмийг хэрэггүй дэмий зүйл гэж

6 Quaker-Протестант шашны нэг бие даасан чөлөөт урсгал, Найзуудын Шашны Нийгэмлэг ч гэж нэрлэдэг. Анх Англид үүссэн.

7 clergy

8 female emancipation

9 moral agents

ойлгож байв.

Анжелина нь нэртэй аболиционист, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө кампанит ажил буюу ухуулах ажил явуулдаг хүн байжээ. **Хюго Гроцийг** дагаж тэрбээр ‘боол эзэмшигч бүр хүний-хулгайч’. Учир нь ‘хүн л бол хүн, тэрбээр салшгүй эрхтэй, түүний дотор нь өөрийн хувийн эрх чөлөөтэй эрх байдаг’ гэж батлан өгүүлж байв. Боолын эзэд хоёр сая хүний ийм эрхийг дээрэмдэн авсан ажээ. Боолтой анх болсон бие хүн нэг ийм дээрэм хийсэн; харин боолын эзэн ‘үүнтэй ижил гэмт хэргийг мөнхөд үргэлжлүүлэн үйлдсээр л байдаг’ гэж тэрбээр өгүүлж байв.

[54] Фредерик Бастиа (1801–1850 он): Франц, улстөрийн эдийн засагч, чөлөөт худалдаачин. **Гол үзэл санаа:** Протекционизмын эсрэг; чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалт; боломж-хайх зардал^[10]. **Гол бүтээл:** *Эдийн Засгийн Хоосон Үлгэр* [анг. *Economic Sophisms*]^[11] (1845 он); *Төр* [анг. *The State*]^[12] (1848 он); *Хууль* [анг. *The Law*] (1850 он)^[13].

Аль ч талаасаа арван настайдаа өнчирсөн Бастиаг хамаатнууд нь өргөж авсан бөгөөд арилжаа худалдаанд татвар болон дүрэм журам хэрхэн нөлөөлдөгт суралцаж мэдсэн нагац ахынхаа экспорт хийдэг бизнест ажиллаж байжээ. Нагац нь нас барахад Бастиа 24 настай байж гэр бүлийнх нь өмч түүнд үлдсэн явдал түүнийг философи, түүх, улстөрийн ухаан, улстөрийн эдийн засгийн талаар оюун санааг чармайн судлах боломжтой олгожээ. Тэрбээр Иргэний Шүүгч^[14], 1848 оны Хувьсгалын дараа Үндэстний Ассемблейн Либерал гишүүн байж улстөрийн

10 *opportunity cost*

11 *Монгол хэлээр орчуулсан.-Молиго орчуулбал дээр санагдав.*

12 *Монгол хэлээр www.libraryforfreereople.mn вэбхуудаснаас уншина уу.*

13 *Монгол хэлээр www.libraryforfreereople.mn вэбхуудаснаас уншина уу*

14 *Justice of the Peace*

идэвхитэй байв.

Гэлээ гээд түүнийг эдийн засгийн болон улстөрийн гарамгуун тайлбарлагч, памфлет гаргагч гэж дурсдаг. Түүний бичсэн зүйл голчлон л алдартай эссэ, ёгөөдөл байсан бөгөөд заримыг нь дүрэм журам, зохицуулалт болон протекционизмыг бутниргэсэн, чөлөөт зах зээлийн ач тусыг дэлгэж харуулсан, *Эдийн Засгийн Софизм буюу Хоосон Үлгэр* [анг. *Economic Sophisms*] (1845 он)-тээ багтаажээ. Түүний эссэнүүд хурц ухаан^[15], ухаанд шууд буух гаргалгаа нотолгоогоороо хамгийн сайн борлуулалттай болжээ. Тэдгээрийн гаргалгаа нотолгоо нь голдуу хэтрүүлсэн, бараг байж боломжгүй зүйл^[16]д үндэслэсэн байдаг бөгөөд түүндээ протекционист бодлогын талаархи учир утгатай гэхдээ хүлээн зөвшөөрөхөд зохимжгүй дүгнэлтэд хүрдэг байв.

Хамгийн алдартай нь лаа болон тос үйлдвэрлэгчдийн худалдааны эвлэл тэднийг шударга бус өрсөлдөөнөөс хамгаалаач гэж Депатутын Танхим^[17]д хандаж буйгаар харуулсан ёжилсон бүтээл болох *Лаа Үйлдвэрлэгчийн Хүсэлт* [анг. *The Petition of the Candle-Makers*] (1846 он)^[18] ажээ. Гэвч тэдний өрсөлдөгч гэж гомдол мэдүүлсэн зүйл нь *Нар* байдаг. Тэд өөрсдөө илүү их лаа үйлдвэрлэж, үйлдвэрлэлээ улам их өргөжүүлж, тэдний ажлын байр нэмэгдэх явдлыг ихэсгэхийн тулд хүмүүс өдрийн турш хөшгөө татдаг болгох дүрэм журам хэрэгтэй байна гэж батлан өгүүлсэн байв. Өөр нэг ёгт үлгэр^[19] тээ тэрбээр Франц болон Испанийн хооронд төмөрзам барих нь тэдгээрийн хоорондох бараа бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнийг тэтгэж дэмжих боловч энэ хоёр улсын үйлдвэрлэгчид үйлдвэрлэлээ хямд импортын зүйлээс хамгаалахын тулд тариф тавихыг шаардаж, хэрэглэгчдээ хохироох л болно гэж сэрэмжлүүлж сануулсан

15 *acerbic wit*

16 *reductio ad absurdum*

17 *Chamber of Deputies*

18 *Монгол хэлээр орчуулан гаргасан.*

19 *parable*

байдаг.

Түүний *Юу Харагддаг, Юу Харагддаггүй Вэ* [анг. *That Which Is Seen and That Which Is Not Seen*] (1850 он)^[20] гэсэн алдартай нийтлэлд нь “хагархай цонхны ёгт түүх^[21]” багтжээ – энэ бол Австрийн эдийн засагч Фридрих фон Вайзер (1851– 1926 он) 1914 онд хөгжүүлсэн, одоо эдийн засгийн ухааны стандарт зарчим болсон, боломж-хайх зардл^[22]ын үзэл санааны түүрүү үеийнхний өгүүлсэн зүйл юм. Хэрэв болгоомжгүй хүү дэлгүүрийн цонх хагалчихвал энэ нь шилчинд зургаан франкын үнэтэй ажил бий болгоно – энэ шилчин одоо тухайн газрынхаа эдийн засагт зургаан франк илүү зарах болж, нутгийнхаа бизнесийг хөгжүүлэх болно. Гэвч харагдаж байгаа зүйл нь бид зориудаар цонх хагалж эдийн засгийн өсөлтийг дэмжиж тэтгэх ёстой гэсэн үг биш (гэвч үүнтэй адилхан зарчмаар ‘харамсалтай нь бидний эдийн засгийн институтүүдийн асар их хэсгийг зохицуулдаг’). *Харагдахгүй байгаа зүйл* нь үнэндээ дэлгүүрийн эзэн тухайн нутгийн эдийн засагт зургаан франк одоо дутуу зарцуулах болсон явдал энэхүү олзыг бүрэн үгүйсгэдэг.

Эдийн засгийн өсөлтийг хурдасгадаг зүйл бол чөлөөт зах зээл, чөлөөт худалдаа байдаг гэж Бастиа бодож байв. Тэрбээр Францын Чөлөөт Худалдааны Холбооны удирдагч болж, **Ричард Кобдентай** захидлаар харилцаж байлаа. Бастиа чөлөөт худалдаа болон наймаа үндсэн үндсэн тоног төхөөрөмж болон хөдөлмөрт хөрөнгө оруулах боломжтой орлого нэмэх болно – энэ нь эдийн засгийн үр ашгийг улам л их болгож, ажил хийдэг хүн ам үүнээс нь ашиг тусыг хүртэнэ гэж батлан өгүүлдэг байв.

Төр [анг. *The State*] (1848 он)^[23] Бастиа төрийг ‘хүн бүр бусад хүмүүсийнхээ хүч хөдөлмөрөөр амьдрах гэж чармайхдаа

20 Монгол хэлээр орчуулан гаргасан.

21 *parable*

22 *opportunity cost idea*

23 Үүнийг www.libraryforfreerepeople.mn гэсэн сайтаас монгол орчуулгыг нь уншина уу.

зохиосон аугаа зохиомол зүйл’ гэж шүүмжилсэн бөгөөд харин *Хууль* [анг. *The Law*] (1850 он)-даа тэрбээр чөлөөт нийгмийг зохицуулах болно гэж түүний бодсон хуульзүйн тогтолцоог дүрсэлж харуулсан. Хувь хүмүүс өөрийн өвөрмөц чанар, эрх чөлөө, өмчөө хамгаалах эрхтэй – эдгээр эрх хууль болон төр засгаас ч өмнө оршиж байсан гэж батлан өгүүлсэн байдаг. Төрийн үүрэг бол зөвхөн эдгээр эрхийг хамгаалахад “нийтийн хүч”-ийг хэрэглэх явдал ажээ.

Төрд зарим нэг хүмүүсээс мөнгө болон өмчийг нь авч бусад хүний тусад зарцуулах эрх байхгүй – энэ бол “хуульжсан тонуул”^[24] байх болно. Төр засаг бидний эрхийг л зөвхөн хамгаалахаас илүү зүйл, жишээлбэл буяны ажил гэж боддог зүйлдээ мөнгө зарцуулах учиргүй – ийм ажилд эцсийн зогсох цэг гэж байдаггүй ажээ. Сонгогчдын идэвхигүй байдал, хуулийн хүч чадал, ардчилсан хууль гаргагчдыг алдаа үл гаргамтгай гэж бодомхой байдлаас удирдагч нь “шаварчин шавраар юм хийдэг”-тэй адилхнаар олон нийтийг хэлбэржүүлж стэтизм л үр дүнд нь гарах болно гэж үзжээ.

Бастиа 49 насандаа сүрьеэ өвчнөөр оюун санааныхаа ид хийж бүтээх насандаа нас баржээ^[25].

[55] Харриет Мартинөү (1802–1876 он): Англи хүн, нийгмийн онолч, улстөрийн эдийн засагч. **Гол үзэл санаа:** Либерал феминизм; либерал эдийн засагчдын хийсвэр төсөөлөл. **Гол бүтээл:** *Улстөрийн Эдийн Засгийн Төсөөлөл* [анг. *Illustrations of Political Economy*] (1832–34 он).

Харриет Мартинэү гэдэг эрхмийг либерал улстөр, эдийн засаг, социологийн сэдвээр гаргасан олон ном, эссэнүүдээр нь дурсдаг.

24 ‘legal plunder’

25 Бастиа Амсемблейн гишүүн байхдаа Ромд уушгиа эмчүүлж байгаад нас барсан бөгөөд шарил нь энэ хотын Франц сүмд байдаг. Тэнд бас дурсгалынх нь самбар бий.

Эмэгтэй хүний үзэл бодол нь орчин үеийн зохиолчдын дунд маш ховор зүйл байсан бөгөөд түүний бүтээлүүд эмэгтэйчүүдэд хандах байдал, охидуудын боловсролд хандах явдалд маш их өөрчлөлт авчирчээ. Мартинөү хатагтай социологич Августе Комте (1798–1857 он)-ийн бүтээлийг (батлан хэлбэл илүү сайжруулан) орчуулсан бөгөөд түүнийг анхны эмэгтэй социологич гэж голдуу үздэг.

Эцгийнх нь даавууны бизнес бүтэлгүйтсэн нь түүнийг бүтэн цагийн зохиолч болоход хүргэжээ. Цаг үеийнхээ эмэгтэй хүнд ер бусын байхаар тэрбээр өөрийнхөө амьдралыг ном бичих ажлаараа авч явах боломжтой байв – роман туурвигч, кампанит ажил явуулагч Чарлз Дикенс (1812–1870 он)-ийн номуудаас түүний ном хэд дахин их алдартай байсан байдаг.

Мартинөү *Улстөрийн Эдийн засгийн Жишээ* гэсэн цувралаа 1832 онд **Адам Смит**ийн үзэл санааны уран сайхны сургаалаар гаргаж эхэлсэн. Энэ нь бүтээл нь удалгүй амжилтад хүрч, хүлээн зөвшөөрөгдөн, Адам Смитийг олон-улсад алдартай болоход нь тус болжээ. Тэрбээр үүний дараагаар **Жэймс Милл**, **Жереми Бентам**, **Дэвид Рикардо**гийн үзэл санааны тухай бусад уран сайхны зурагт сэтгүүл гаргав. Эдгээр бүтээл цаг үеийнхээ эмэгтэйчүүдэд гэр орны аж ахуй нь хэрхэн илүү өргөн эдийн засгийн сэдэвт хэрхэн тусгалаа олохыг нь харуулж эдийн засгийн ертөнцтэй танилцуулсан.

АНУ-д удаан хугацаанд аялж явахдаа **Жеймс Мадисон** болон Шинэ Английн олон аболиционистуудтай уулзжээ. Тэрбээр охидын боловсролын талаар энэ цагийн үеийн хэм хэмжээ хэрхэн охидыг боловсролгүй, идэвхигүй, эрчүүдэд захирагддаг хэвээр үлдээж буй талаар гомдол мэдүүлэн судалж шинжлээд ном бичиж байлаа.

Социологич болохынхоо хувиар тэрбээр гэр бүл, шашин, арьстныг судалдаг байв. Тэрбээр нийгэм бүгдээрээ-дагадаг хуулиар хэлбэрждэг бөгөөд үүнийг ухаарч ойлгохын тулд шинжлэх ухаан, хүн ам, шашин, нийгмийн институт, үүнд дотроо эмэгтэйчүүдийн үүрэг нөлөө зэрэг өргөн сэдвийг заавал тооцож

үзэх ёстой гэдгийг баримталж байв.

[56] Ричард Кобден (1804–1865 он): Англи хүн, аж үйлдвэрийн эзэн, улстөрч.

[57] Жон Брайт (1811–1889 он): Англи, шинэчлэгч, улстөрч. **Гол үзэл санаа:** Чөлөөт худалдааны эд баялаг бүтээгч ашиг тус; протекционизмын эсрэг жишээ баримт; Манчестерийн Либерализм; Үр Тарианы хуулийг цуцлуулах. **Гол бүтээл:** Англи, Ирланд, Америкийн талаар *Манчестерын Аж Үйлдвэрийн Эзэн бичив* [анг. *England, Ireland and America, by a Manchester Manufacturer*] (Кобден, 1835 он); *Парламентын Шинэчлэлийн Талаар Хэлсэн Үг* [анг. *Speeches on Parliamentary Reform*] (Брайт, 1866 он).

Ричард Кобден дэлхийн даавууны үйлдвэрлэлийн төв болсон Манчестерын калико хэвлэл^[26]ийн бизнес дэх хувьцаагаараа дамжуулан баян болжээ. Олон улсад хийсэн аялал, Адам Смитийг уншсан явдал түүнийг чөлөөт худалдааны гавьяанд гүн итгүүлсэн байдаг.

1838 онд Кобден Үр Тарианы Эсрэг Нэгдлийг Чөлөөт Худалдааны Хөдөлгөөний тэргүүний уран илтгэгч болсон Жон Брайтын хамтаар байгуулав. Үр Тарианы Хуулиар импортолсон үр тарианд өндөр тариф оноосон байсан: Британийн хөдөө аж ахуйг хамгаалах гэж л гаргасан тэр хууль талхны үнийг өсгөсөн ч түрээс нь үүнээс хамаардаг хүчирхэг газрын-эзэд энэ хуулийг хамгаалж байжээ. Энэ Нэгдэл шинэчлэл хийхийг шаардсан том кампанит ажил буюу ухуулах ажил хийх хүч болж, памфлет гаргаж, улс орон даяар жагсаал цуглаан хийж байлаа.

Кобден хөдөө аж ахуйн тарифын хамгаалалтыг үгүй хийх нь зөвхөн алслагдмал газрын ядуурлыг бууруулах болно гэж

26 *calico printing business*

батлан өгүүлж байсан; энэ явдал хөдөө аж ахуйг улам л үр ашигтай болгож, ерөнхийдөө фермерүүд болон хөдөөгийн баян хүн амаас үйлдвэрлэгчдэд ирэх эрэлтийг нэмэгдүүлэх болно. Мөн энэ нь бусад улстай хийх худалдааг огцом өсгөх бөгөөд ингэснээр үндэстнүүдийн хоорондох эв найр болон ойлголцлыг бүтээхэд туслах болно.

Кобден болон Брайтын энэ хандлага *Манчестерын Либерализм* эсвэл *Манчестер Сургууль* гэдэг нэрээр алдаршжээ. 1840-өөд онд энэ хоёр Парламентад орсон бөгөөд Брайт нь Кобдены гаргалгаа нотолгоогоор тулгуураа хийсэн, дайчин шинэчлэгч уран илтгэгч болжээ. Төмсний муу ургац байсан, мөн төмсний өвчин гарсны дараа 1846 онд тэдний хүчин чармайлт амжилтад хүрч Үр Тарианы Хуулийг хүчингүй болгожээ.

Кобден хожим нь Британи болон Францын хоорондох арилжаа худалдааг нээхэд тус болсон бөгөөд чөлөөт худалдааны тухай үзэл санаагаа Франц, Испани, Итали, Орост заан сургаж явжээ. Брайт үндсэн хуулийн шинэчлэлд ажилчин ангийг илүү их оролцоотой болгон, Ирландын Католик шашинтнуудыг улстөрийн хувьд ялгаварлан гадуурхах явдлыг зогсооход гол үүрэгтэй байсан.

[58] Алекси де Токвил (1805–1859 он): Франц хүн, улстөрийн сэтгэгч. **Гол үзэл санаа:** Үндсэн хуулийн шинэчлэл, хоёр-танхимтай төр засаг; олонхийн ардчилалд хязгаарлалт тавих хэрэгцээ шаардлага. **Гол бүтээл:** *Америк дахь Ардчилал* [анг. *Democracy in America*] (1835, 1840 он).

Де Токвилийг Америкаар аялах үедээ хийсэн өөрийн ажиглалтдаа үндэслэж бичсэн *Америкийн Ардчилал* [анг. *Democracy in America*] (1835, 1840 он) гэсэн хоёр боть номоор нь сайн мэддэг. Социологи, улстөрийн ухааны талаархи эхэн үеийнхээ бүтээлдээ Америкийн улстөрийн бат бөх, сул талыг, ялангуяа эрх чөлөө болон тэгш байдлын хоорондох хурдацмал

байдлыг судалсан байдаг бөгөөд Францын хувьсгалын дараахь ардчилсан бүтцийн өөрчлөлтийг дэмждэг сургамж туршлагаудыг тоочин гаргав.

Де Токвил Францын Хувьсгалын үеэр Англи руу дүрвээд, буцаад хожим нь Франц руугаа ирсэн Нормандын язгууртны гэр бүлд төржээ. Хэдийгээр эцэг эхдээ дуулгавартай хэвээр үлдсэн ч Алекси 1814 оноос хойш Францыг засаглаж буй үндсэн хуульт хаант засаглалын идэвхитэй шүүмжлэгч болсон байдаг. 1848 оны Хувьсгалын дараа тэрбээр шинэ төр засагт түр зуур ажиллаж, шинэ үндсэн хууль дээр ажиллажээ.

Язгууртан гаралтай ч либерал үзэл бодол нь элитизм болон популизм^[27], эрх чөлөө болон тэгш байдлын хоорондох түүний харж байсан хурцадмал байдалд тусгалаа олов. Либерал, парламентын төр засгийн өмгөөлж хамгаалахынхаа хажуугаар тэрбээр ардчиллыг заавал хязгаарлах ёстой гэж бодож байв – энэ нь Жон Адамс (1735– 1826 он) тамгалан хэлсэн “олонхийн дарангуйлал” гэсэн хэллэгийг улам л алдаршуулжээ. Энэхүү аюул заналыг багасгахын тулд тэрбээр хоёр танхимтай парламенттай байх, ерөнхийлөгчийг олонхийн саналаар сонгохыг шаардаж байсан. Ерөнхийдөө тэрбээр улстөрийн тогтолцоог илүү олон янз байдалтай болгох, эрх мэдлийн төвлөрлийг үгүй хийхийг шаардаж байв.

Америкийн Ардчиллын тухай бүтээлээ тэрбээр АНУ-ын шоронгийн тогтолцоог шалгах хороонд орсноор эхэлжээ – гэвч энэ ажил нь Америкийн нийгэм болон улстөрийн судлах гэсэн урьдач нөхцөлтэй байсан. Иймэрхүү судалж шинжлэх гэсэн сэтгэлээр тэрбээр Англи, Алжир, Ирландад айлчилсан байдаг.

Де Токвил *ардчилалд учрах* боломжит аюул заналын тухай зөвхөн эрэлхийлж хайж байсангүй мөн түүнээс *гарах* аюул заналыг ч эрж хайж байлаа. Америкчуудад бий болсон ардчилсан тэгш байдалд өөртөө итгэх явдалд тэрбээр алмайрч байсан ч хуучны нийгмийн эрэмбэ дарааны бууралтаас болж ардчилал

27 *elitism and populism*

хязгаарлалтгүй үлдсэн явдлаас тэрбээр эмээж байжээ. Хүн бүрийн бодол санааг (хэдийгээр мэдээлэл муу мэддэг байдаг ч) ижил тэнцүү тооцож анхаарч үздэг нийгэм дэх ёс суртахууны болон улстөрийн цор ганц бүрэн эрх^[28] нь олонхийнх байх болно. Гэвч хувь хүмүүс олонхийн эсрэг зогсох эсвэл түүний эсрэг эрхээ хамгаалах боломжгүй байдаг ажээ.

Хүмүүс нийгмийн эрүүл саруул байдлын талаар өргөн хүрээнд бага бодож харин өөрсдийнхөө тухай улам их боддог, тэлж буй дундаж ангийн материализм болон “индивидуализм” (ө.х. өөрөө-шингээж авах^[29]) ардчилсан тэгш байдлыг тэтгэдэг учраас хувь хүмүүс олон нийтийн хүчинд ийм байдлаар автах явдал гарах магадлал улам л их байна гэж Токвил бодож байсан. Ардчилал тийм учраас урьдаас тааварлашгүй популизм руу гулсан орох болно. Олонхийн энэхүү депотизм буюу дарангуйлал зохион бүтээх, өөрийгөө-илэрхийлэх явдлыг боомилох ажээ.

Де Токвил Америк мөн л тэгш байдал руу хэтэрхий зүтгэж буйгаасаа бус харин эрх чөлөөнд хангалттай үнэнч бус байгаагаасаа болж хохирдог гэдгийг мэдэрч байсан. *Нийгмийн үнэт зүйл*^[30]ийг ардчилал руу суулгаж оруулах улстөрийн ухааны өөр нэг шинэ төрөл хэрэгтэй гэж үзэв. Хүмүүс өөрийн-тусыг бодох явдалдаа зорьж тэмүүлэх нь эрх чөлөөтэй байх ёстой боловч “өөрийн-тусыг бодох гэдгийг зөвөөр ойлгох” ёстой – энэ нь нийгмийн үнэт зүйл, алсын хараа, өөрийгөө-хянах явдлаар хязгаарлагддаг байх ёстой ажээ.

Зогсоох аргагүй популизмын өөр нэг хязгаарлагч *иргэний нийгэм* Америкт хүчтэй байгааг олж мэджээ. Тэрбээр хэрхэн Америкчууд “зугаа цэнгэл үүсгэх, семинар явуулах, дэн буудал байгуулах, сүм байгуулах, ном тараах, алс газар руу элч лам илгээх гэж; мөн энэ байдлаараа эмнэлэг, шорон, сургууль байгуулах гэж” байнга л нэгдэл холбоо байгуулж байгааг нь

28 *authority*

29 *self-absorption*

30 *social values*

хараад цочирдож байв.

Тэрбээр бие даасан шүүх байгууллага, хоёр танхимт төр засаг^[31], эрх мэдэл-төвлөрөөгүй байдлаар шийдвэр-гаргадаг явдал, нийтийн олонхийн саналаар сонгогддог ерөнхийлөгч^[32]ийнхээ хамтаараа Францад ардчилсан үндсэн хуулийн сайхан суурь болох юм байна гэж бодож байв. Гэвч тэрбээр сонгуулийн богинохон мөчлөгөөрөө зуучлагч хууль тогтоогчд^[33]ыг бий болгодог хууль тогтоох байгууллагыг хэт их эрх мэдэлтэй болгожээ гэдгийг (магадгүй өөрийн язгууртан гарлаасаа болж) мэдэрсэн байдаг. Франц хүчтэй гүйцэтгэх эрх мэдэлтэй байхыг зорих ёстой гэж бодож байв; гэвч үүнтэй адилаар бас эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, шашин, хэвлэлийн эрх чөлөө чухал байлаа.

[59] Виллиам Ллойд Гаррисон (1805–1879 он): Америк хүн, аболиционист, сэтгүүлч. **Гол үзэл санаа:** Боолчлолыг халах; эмэгтэйчүүдийн эрх; идэвхигүй эсэргүүцэл. **Гол бүтээл:** *Чөлөөлөгч [анг. The Liberator] (1831–65 он).*

Худалдаа эрхэлдэг далайчин эцэг нь гэр бүлээ орхиж, Баптист эх нь хүүхдүүдээ бүх чадлаараа халамжлахаар үлдэхэд Виллиам Ллойд Гаррисон дөнгөж нялх байжээ. 13 настай байхдаа, бас хэд хэдэн аж ахуй оролдсоны дараа тэрбээр Ньюбарипорт Хералд сонины редакторт шавь орж тэндээ сонины ажил хэрхэн явуулахад суралцжээ. Тэрбээр 20-оод насандаа Ньюбарипорт Фрий Пресс гэсэн нэртэй бас нэг сонин өөрийн гэсэн сонинтой болох гэж зээл авсан. Гэвч дараагаар нь энэ нь санхүүгийн дэмжигчидтэйгээ редакторын гаргалгаа нотолгооноосоо болж зөрчилдсөнөөс бүтэлгүйтэв.

31 *decentralised decision-making, bicameral government*

32 *popularly elected president*

33 *mediocre legislators*

Гаррисон Бостон руу тэвчээртэй байхын-төлөөх^[34], шинэчлэлийн-төлөөх^[35] сонины хэвлэгч, редакторын хувиар нүүсэн бөгөөд тэндээ аболиционист буюу боолчлолыг халах ажил руу уруу татсан, *Боолоос Чөлөөлөх Явдлын Суутан* [анг. *Genius of Emancipation*] бүтээлийн зохиогч Бенжамин Ланди (1789–1839 он)-тэй уулзжээ. Гаррисон Нью Инглэндийн Боолчлолын Эсрэг Нийгэмлэгийг байгуулах үед тэргүүлэх аболиционист сонин, Либератор буюу Чөлөөлөгч сониноо хэвлүүлж эхэлжээ.

Гаррисон боолчлол бүх хувь хүн чөлөөтэй байх эрхэд халддаг гэж батлан өгүүлдэг байсан. Тэрбээр анхнаасаа л Америк боолуудыг Баруун Африкт эргүүлэн буцаах явдлыг өмгөөлж хамгаалж байсан боловч энэхүү үзэл санаагаа зарим нэг үзэл санаа нэгтнүүд нь энэ явдлыг чөлөөт хар арьстан хүмүүсийг зайлуулах арга зам гэж ойлгодог байсан учраас орхижээ.

Түүнийг эмэгтэйчүүдийг боолчлолын эсрэг гомдол гаргаач гэж шаардсан явдал нь эмэгтэйчүүдийн улстөрийн эрхийн тухай маргаан мэтгэлцээнийг өрдлөө. Либератор сонин **эгч дүү Гримкегийн** нийтлэлийг хэвлэж, боолоос чөлөөлөх явдлыг өмгөөлж хамгаалдаг тэргүүний сонин болсон байна. Энэ явдал болон **Фредерик Дугласын** хамтаар АНУ-ын Үндсэн Хууль үндсээрээ боолчлолыг дэмждэг, мөн Энэ Холбоо тараах ёстой гэж маргаж мэтгэдэг байсан Гаррисоны конституционализмын-эсрэг үзэл аболиционист хөдөлгөөнийг зарим нэг дэмжигчид нь эдгээр учир шалтгаан нь аболиционист мессеж буюу нийтэд түгээх үзэл санааг будлиантуулах болов уу гэж айсан байсан тул задалж хуваав. Энэхүү хагарал үйлдэл даруй хийх^[36], мөн хүчирхийлэл үйлдэхээс Гаррисон татгалзаж ирсэн явдал бүр л гүнзгийрүүлжээ.

Хэдийгээр пацифист буюу энхийг эрхэмлэгч үзэлтэй хүн ч

34 *temperance*

35 *pro-temperance and pro-reform*

36 *direct action-ажил хаялт, эсвэл жагсаалт зэрэг шууд гарах үр дүнд хүрэх гэж явуулдаг үйл ажиллагааг хэлнэ.*

гэлээ Гаррисон радикал буюу хурц ширүүн үзэлтэй, шулуун үгтэй хүн байжээ: ‘Олон хүн миний хурц ширүүн үг ярианд дургүйцдэг гэдгийг би ухамсарлаж байна; гэвч хурц ширүүн ярихгүй байх шалтгаан байна уу? Би үнэн мэт гашуун, шударга ёс мэт үл буулт хийх болно ... Би дуугаа хадаасаар л байх болно’. Үнэндээ тэрбээр боол-өмчлөгч Жеоржиа муж-улс түүний толгойны төлөө мөнгө санал болгохоор тийм шулуухан хэлж байжээ. 1835 онд түүний яриа хийж байсан Бостоны байрыг нь хэдэн мянган цугларсан хүн бүсэлж, засаг захиргаанаас хөндлөнгөөс оролцохоос өмнө түүнийг гудамжаар уяагаар чирч явсан байдаг.

Боолчлолыг устгасны дараагаар зорилго нь гүйцлээ гэж Гаррисон батлан өгүүлэхэд боолчлолын-эсрэг хөдөлгөөн дахин хуваагджээ. Тэрбээр эндээс явсан ч гэсэн иргэний эрх, эмэгтэйчүүдийн сонгуулийн эрх^[37] зэрэг шинэчлэлийн бусад хөдөлгөөнд оролцсоор л байв. Европт тэрбээр **Жон Брайт**, **Жон Стюарт Милл**, **Херберт Спенсер**, бусад либералчуудтай уулзжээ. Карл Маркс (1818–1883 он)-ын эсрэг Гаррисон арилжаа худалдаа нийгмийн бүх ангиудад харилцан ашиг тустай байдаг гэж, мөн чөлөөт худалдааны бүх хязгаарлалтыг устгахыг өмгөөлж хамгаалж маргаж мэтгэлцэж байсан.

[60] Жон Стюарт Милл (1806–1873 он): Англи хүн, философич, шинэчлэгч. **Гол үзэл санаа:** Сонголт, хариуцлагатай байдал; олонхийн дарангуйлал; үл хохироох зарчим; халамжлагч үзлийн асуудал бэрхшээл; чөлөөтэй үг хэлэх буюу үг хэлэх эрх чөлөө^[38]; эвлэлдэн нэгдэх эрх чөлөө^[39]; амьдралын хэвмаягийн эрх чөлөө^[40]; төлөөллийн

37 *female suffrage*

38 *free speech*

39 *free association*-Бас чөлөөтэй эвлэлдэн нэгдэх гэж орчуулж болох юм

40 *lifestyle freedom*

төр засаг^[41]; федерализм; утилитарианизм. **Гол бүтээл:** *Эрх Чөлөөний Тухай [анг. On Liberty] (1859 он); Төлөөллийн Төр Засгийн тухай Эргэцүүлэл [анг. Considerations on Representative Government] (1861 он); Утилитарианизм [анг. Utilitarianism] (1863 он).*

Хүү Жон Стюарт Миллдээ эцэг **Жэймс Милл** нь **Жереми Бенетамийн** туслалцаатайгаар боловсрол олгожээ. Түүнд хичээл боловсролын ажил маш эрчтэй шахуу байв: гуравтай байхад нь Герег хэл; наймтай байхад нь Латин хэл заасан; бөгөөд аравтай байхдаа бүх сонгодог зохиогчийг уншиж чаддаг болжээ; арван хоёртой байхдаа логик ухаан болон улстөрийн эдийн засгийг судалж байсан байдаг; арвандөрөвтэй байхдаа шинжлэх ухаан, математикийн курсэд явж байсан. Гэвч энэхүү түргэтгэсэн шахуу суралцах явдлын гор бас гарчээ: хорин настай байхдаа мэдрэл нь муудаж^[42] түүндээ жинхэнэ хүүхэд нас өөрт нь байгаагүй явдлыг буруутгасан байдаг.

Хэдийгээр түүнийг эмпирицизм, утилитарианизм, оюун ухаанд хүчээр сургасан, мөн шашин эсвэл бусад “иррационал” үзэл санаанд автуулаагүй ч гэсэн нас биед хүрэхдээ тэрбээр хүмүүний олон янз байдал, бие даасан байдал, өвөрмөц чанар, давтагдашгүй байдал, цор ганц байдл^[43]ыг рационал байдлаас илүүд үзэх болжээ. **Вилхелм фон Хамболдтын** адилаар Милл хүмүүн төрөлтний өвөрмөц чанар, ёс суртахууны хөгжлийн ач холбогдлыг сануулж илэрхийлдэг байсан бөгөөд эрх чөлөө бол үүний амин чухал зүйл юм гэж ойлгож байв. Тэрбээр хүмүүс өөрсдийнхөө үйлдлийн төлөө хариуцлага хүлээдэггүй бол хэзээ ч юм сурч мэдэх, хөгжих дэвшихгүй гэж боддог байсан. Хүмүүн төрөлтөн жишээлбэл амьдралын хэвмаягаа сонгох сонголт хийх чадвараараа тодорхойлогддог – тэдэнд хүмүүнлэг чанараа зөв

41 *representative government*

42 *nervous breakdown*

43 *diversity, spontaneity, individuality, originality and uniqueness*

байдлаар эдлэхэд нь тэдэнд сонголт хийх хувилбарууд байх ёстой ажээ. Европын олон янз байдал л түүнд “дэвшилтэт, олон-талт хөгжил дэвшил” авчирсан гэж тэрбээр батлан өгүүлж байлаа.

Исайя Берлин Миллийн *Эрх Чөлөөний Тухай* [анг. *On Liberty*] (1859 он) бүтээлийг ‘нээлттэй, хүлцэхүй давамгайлдаг нийгмийн хүсдэг хүмүүсийн үзэл бодлын гол санаануудын хамгийн ойлгомжтой, хамгийн илэрхий, хамгийн шаргуу ятгасан, сэтгэл хөдөлгөм’ бүтээл гэсэн байдаг. Милл энэ бүтээлээ (**де Токвилын** адилаар) эрх чөлөөнд халдах эртний аюул занал хаант засаглал болон язгууртны засаглал байсан бол шинэ аюул занал нь олонхийн эзэрхэг дарлал^[44] юм гэсэн анхааруулгаар эхэлдэг. Олонхи улстөрийн шийдвэр гаргах явцад л зөвхөн давамгайлдаггүй бас тэд хүмүүсийг өөрийн гэсэн бодол санаагүй “аж үйлдвэрлэлийн хонь^[45]” болгож хувиргах соёлыг хэлбэржүүлдэг.

Милл энэхүү номынхоо эхэн хэсэгт *эрх чөлөө* буюу *эрх чөлөөт байдл*^[46]ыг тодорхойлсон байдаг. Хувь хүмүүс хэрэв *бусдыг хохироохгүй л бол* хүссэнээ хийх нь чөлөөтэй байх ёстой гэж батлан өгүүлжээ. Гэр бүл, хүмүүсийн бүлэг, төр засаг бас л энэхүү үл хохироох зарчим^[47]д захирагддаг:

Хүмүүн төрөлтөнд батлан олгосон, хувь хувиараа болон хамтаараа ямар ч тоотой хүмүүсийн үйлдлийн эрх чөлөөнд хөндлөнгөөс халдах цор ганц зорилго бол өөрийгөө-хамгаалах явдал юм ... [И]ргэншсэн нийгэмлэгийн аливаа гишүүнд хүслийг нь үл харгалзан эрх мэдлийн хүчийг үндэстэй хэрэглэх боломжтой цор ганц зорилго бол бусдыг хохироохоос [түүнийг] сэргийлэх явдал ажээ.

44 *tyranny of the majority*

45 *industrious sheep*

46 *liberty* - Англи хэлэнд *freedom* болон *liberty* гэсэн үгсийг сэлгэж нэг утгаар хэрэглэдэг. Нарийндаа тун бага ялгаатай зүйлс.

47 *no-harm rule*

Милл хохирол гэдгийг зүгээр дайрч доромжлох явдал биш харин биет хохирол гэмтэл гэж ойлгож байсан. Биет хохирлыг шуудхан харах боломжтой байдаг бол харин дайрч доромжлох явдлыг харах аргагүй: тиймээс л энэ энэхүү хил заагийг нарийн чанд тодорхойлохгүй бол ёс журмыг буруугаар ашиглах боломжтой ажээ. Мөн тэрбээр “тэдний сайн сайхны төлөө” тэр хүмүүсийн эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцох үзэл болох патернализм буюу халамжлах үзлийг дараахь хэдэн шалтгаанаар эсэргүүцэж үгүйсгэсэн: төрийн эрх мэдлийг эдгээр үндэслэлээр хялбархан буруугаар ашиглах боломжтой; бүр сайн санаатай сайхан сэтгэлтэй удирдагч ч иргэдэд нь жинхэнээсээ юу сайн байх талаар буруу бодож байх боломжтой; зүгээр л нэг тооны оронцог биш харин бүрэн бүтэн хүмүүн төрөлтөн байхын тулд хүмүүс өөрийн сонголтоо өөрөө хийдэг, тэдгээрийнхээ төлөө хариуцлага хүлээдэг байх ёстой.

Мөн үл хохироох зарчмыг биет хохирол учруулах эрсдэлд ч хэрэглэдэг – энэ эрсдэлд (Миллийн алдартай жишээ болох) олон хүнтэй театрт “Тал Гарлаа!” гэж орилох явдал орно. Хэрэв хялбархан урьдчилан сэргийлэх боломжтой бол, жишээлбэл живж буй хүүхдийг усан сангаас аврахдаа өөрсдийгөө хохироох гэж буй хүмүүст энэ зарчмыг хамаатуулан хэрэглэх бололцоотой ажээ. Гэвч Милл энэхүү хил зааг хаана яг таг оршдогийг, ө.х. бид хөндлөнгөөс оролцох хүртэл хэр их эрсдэл хүлээх боломжтой болох эсвэл бид бусад хүн хохирох боломжтой байхад энэ эрсдлийг зогсооход хэр их хүчин чармайлт гаргах ёстой гэдгийг тодорхойлж заасангүй.

Милл үл хохироох зарчим бидний амьдран суух, өвөрмөц чанар, өмчийн эрхийг хамгаалдаг гэдэгт итгэдэг байсан. Тэрбээр эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, таашаалын эрх чөлөө^[48], зорьж тэмүүлэх, амьдралаа төлөвлөх эрх чөлөө^[49]г хамгаалж байв. Мөн

48 *freedom in taste*

49 *freedom of association, and freedom in taste, pursuits and life plans*

тэрбээр үг хэлэх эрх чөлөөг нээлттэй хэлэлцүүлэг бидний оюун санаа болон нийгмийн дэвшлийн хувьд амин чухал үүрэгтэй байдаг гэж батлан өгүүлж дуртайяа хамгаалж байжээ. Үзэл санааны шүүлтүүр тавих эсвэл үг хэлэх эрх чөлөө^[50]г хориглож зогсоох нь аюултай: оюун санааны шүүлтүүрт орж хасагдсан бодол санаа жинхэнээсээ үнэн байх боломжтой гэж маргалдаж байлаа; эсвэл энэ нь худал байж болох ч үнэний зарим нэг хэсгийг агуулж ч байж болно гэж батлан өгүүлдэг байв; ийм зүйл бидний хүлээн авсан бодол санаанд учруулж буй сорилт нь биднийг бидний бодол санаа маань үндэс суурьтай бат нот зүйл юм гэдгийг маань бататгахад хүчилдэг ажээ; сорилтод ороогүй үлддэг бодол санаа ёс суртахуун эсвэл оюун санааны хүч чадалгүй үхширсэн үзэл болж хувирах болно.

Төлөөллийн Төр Засгийн Тухай Эргэцүүлэл [анг. *Considerations on Representative Government*] (1861 он)-дээ Милл хязгаарлагдмал эрх мэдэлтэй, төлөөллийн ардчилл^[51]ыг дэмждэг гаргалгаа нотолгоогоо гаргаж тавьсан. Шууд ардчилал^[52] том хэмжээтэй, нарийн нийлмэл хүмүүсийн хүрээлэлд тохиромжгүй гэж тэрбээр зөвлөсөн байдаг: төлөөллийн ардчилал бодлогын асуудлыг нарийвчлан хэлэлцэх боломж олгодог ч гэлээ иргэдээ ёс суртахууны чадвараа хөгжүүлэхэд нь чухал байдаг улстөрийн үйл явцад оролцуулахгүй хэвээр үлдээдэг байна. Ийм ардчилал тухайн орон нутгийн асуудлыг тухайн газраа л шийдвэрлэдэг байхаар тийм *федерал* буюу *холбооны* тогтолцоотой байх ёстой гэж бодож байжээ; гэвч төвийн зарим нэг хязгаарлалт тухайн газрын олонхийн гэнэтийн төвөг тарьсан үйлдлээс орон нутгийн цөөнхийг хамгаалах явдлыг бататгахад шаардлагатай байдаг. Гэсэн хэдий ч төр засгийн үндсэн үүрэг бол олонхийг хүчирхэгжүүлэх явдал биш байдаг: түүний үүрэг бол олон янз байдал болон чөлөөт сонголтыг дэмждэг тэтгэдэг нөхцөлийг бий болгох явдал юм.

50 *free speech*

51 *limited and representative democracy*

52 *Direct democracy*

Миллийг энэхүү хандлага руу чиглүүлсэн хүн нь өөрийн оюун санаа нэгтэн (хожим нь эхнэр нь болсон) Харриет Тэйлор байж болох юм. Тэрбээр мэдээжээр эхнэрийнхээ феминизмийг дэмжиж байсан. *Эмэгтэйчүүдийн Захирагддаг Ёс* [анг. *The Subjection of Women*] (1869 он)-дээ тэрбээр эмэгтэйчүүд яагаад төгс тэгш байдлыг эдлэх ёстойг тайлбарлажээ.

Мөн Милл оюун санааныхаа багш Жереми Бентамын утилитарианизмыг хөгжүүлжээ. Тэрбээр нэгэнт л хүмүүн төрөлтөн нь олон янз байдаг, тооцоолол нь алдаатай байдаг тул аз жаргалыг хялбархан хэмжиж, тооцоолох боломжтой гэдэгт эргэлзэж сэжиглэнгүй хандаж байв. Тэрбээр тооцоололд нөлөөдөг “эрхэм” болон “дорд” таашаал^[53] байдаг гэж бодож байлаа: ‘Сэтгэл хангалуун гахайнаас илүүтэй сэтгэл ханаагүй Сократ хэрэгтэй’. Дээд таашаалыг илүү үздэг байх хэрэгтэй. Учир нь энэ хоёроос сонгуулахад хэн ч дорд таашаалыг нь сонгодоггүй. Гэвч бүр ингэн хувиргаж өөрчилсөн ч гэлээ Миллийн утилитарианизм эрхийн хамгаалалтаараа гажиг харагддаг (Бентам илүү байнга “утгагүй зүйл” гэж үл тоодог байсан): нийгмийн сайн сайхны төлөө эсвэл бүх нийтийн аз жаргал^[54]ын төлөө хувь хүний эрхэд хэр их халдах боломжтой вэ?

[61] Харриет Тэйлор Милл (1807–1858 он): Англи хүн, феминист, шинэчлэгч. **Гол үзэл санаа:** Эмэгтэйчүүдийн боловсрол, сонгуулийн эрх; ажилчдын хамтын-өмчлөл^[55]. **Гол бүтээл:** *Эмэгтэйчүүдийн Энфранчайзмент* [анг. *The Enfranchisement of Women*] (1851 он).

Харриет Тэйлор хүлээсээсээ чөлөөлөгдөх явдал^[56] болон

53 'higher' and 'lower' pleasures

54 social utility or the general happiness

55 worker co-ownership

56 Enfranchisement-Нийгэм эсвэл хүмүүсийн хүрээлэл эсвэл

байгууллагад бүрэн хэмжээгээр оролцох эрх эсвэл давуу эрх,

бие даасан байдлынхаа төлөө маргаж мэтгэлцэхийн оронд эмэгтэйчүүд буулт хийж, гэр бүлийн үүргээ гүйцэтгэдэг гэсэн уламжлалыг эвджээ. Орон гэрт эмэгтэй хүн давамгайлдаг явдал эмэгтэйчүүдийн боловсрол болон өвөрмөц чанараа хөгжүүлэх боломжийг нь хаадаг гэж шаргуу ятгаж байсан бөгөөд эмэгтэйчүүд улстөрийн эрх мэдэл өгдөггүй (үүн дотроо санал өгөх эрх) учраас хуулиар эрэгтэйчүүдэд ашиг тус хүргэх явдал үргэлжлүүлсээр л байсан ажээ.

Унитарич хүн болж өссөн Харриет 18 настайдаа Жон Тэйлор (1787– 1849 он)-той хэдийнээ 39 настай болсон хойно нь гэр бүл болов. Тэдний гэрлэлт аз жаргалгүй холбоо байсан бөгөөд удалгүй тэрбээр **Жон Стюарт Милл**тэй дотно харилцаатай болсон байдаг (тэр цаг үедээ маш их дуулиан шуугиантай байв). Тэр хоёр Жон Тэйлор нас барсны хойно хоёр жилийн дараа гэрлэцгээжээ.

Эмэгтэйчүүдийг Чөлөөлөх Явдал [анг. *The Enfranchisement of Women*] (1851 он) бол хэдийгээр Милл түүнийх биш харин эхнэр Миллийнх нь бүтээл гэдэг байсан ч Миллийн нэрээр гарсан сонгууль, улстөрийн албан тушаал, хууль дахь эмэгтэйчүүдийн улстөрийн тэгш байдлыг радикал байдлаар буюу хурц ширүүнээр шаардсан уриалга юм. Тэрбээр үүнтэй адилаар хуулиар эмэгтэйчүүд болон хүүхдүүдийн эсрэг хүчирхийлэл үйлддэг хуулийн тухай шүүмжилсэн сонины хэд хэдэн нийтлэл, памфлет буюу ухуулах хуудсыг зохиогч эсвэл хамтран зохиогч нь гэж эхнэрээ ил зарлаж байлаа. Милл *Улстөрийн Эдийн Засгийн Зарчим* [анг. *Principles of Political Economy*] (1848 он)-ийнхээ Универсал буюу бүх нийтийн боловсрол, үйлдвэрийг ажилчид хамтран эзэмших явдлыг өмгөөлж хамгаалсан бүлэгт эхнэрийнхээ үзэл бодлыг мөн тусгасан байдаг. Харриет нөхрийнхөө бүтээлд хэр их нөлөөтэй байсныг үнэлэхэд хэцүү ч гэлээ тэрбээр нөхөр нь эхнэрээ нас барахад хоёр хүн нэг ижил

ялангуяа бодлого эсвэл дуу хоолойгоо хүргэх боломж аливаа бие хүн эсвэл бүлэг хүмүүст олгох үйлдлийг хэлдэг байна.

үзэл бодолтой байхад ‘хэн үзгээ барих нь ... ямар ч ялгаагүй’ гэж хэлэн түүний талаар маш их магтсан байжээ.

[62] Лисандер Спүүнер (1808–1887 он): Америк хүн, анархист, аболиционист, хуульзүйн онолч. **Гол үзэл санаа:** Дүрэм журмыг хорогдуулах буюу зохицуулалтыг багасгах, өрсөлдөөн; муу үйл гэмт хэрэг биш^[57]; боолчлол болон үндсэн хууль; анархизм. **Гол бүтээл:** *Боолчлолын Үндсэн Хуульд Үл Нийцэх Байдал* [анг. *The Unconstitutionality of Slavery*] (1845 он).

Спүүнер Массачусеттсэд өмгөөлөгчийн ажил эрхэлж, дээд боловсролгүй хүн удаан хугацаанд дадлагажих ёсгүй гэсэн мужулсын хуулийг зөрчиж байсан. Тэрбээр иймэрхүү хууль баян, дээд боловсролтой хүмүүсийг хамгаалдаг гэж гомдоллон, цааш нь үргэлжлүүлэн бүх хуульчид, эмч, бусад мэргэжлийнхний лицензжүүлэх явдлыг гэрээний жам ёсны эрхийг үгүйсгэж буй байдал гэж ойлгож байжээ. Бүр тэрбээр Америкийн Нэгдсэн Улсын Шуудангийн байгууллагын монополь эрхийг авах гэж өөрийн гэсэн шуудангийн компани байгуулж байв – гээд засгийн газар энэхүү өрсөлдөөнийг хуульзүйн тулгалт шаардлагаар зогсоожээ.

Спүүнер хүмүүс өөрийн бизнесээ эхлэх явдлыг хэцүү болгодог бүх дүрэм журмыг эсэргүүцэж байв. Мөнгө хүүлэлтийн эсрэг хууль^[58] гаргах нь жишээлбэл зээлдэгч [хүн эсвэл байгууллага] шинэ бизнест зээл өгөхтэй холбоотойгоор өөрсдөд нь гарах өндөр эрсдэл болон аюулгүй байдал багатай байгаа байдлаа нөхөх зээлийн их хүүг бусдаас авах боломжгүй гэсэн үг юм: үр дүнд нь гарааны хэдхэн бизнес гарах, өрсөлдөөн муутай

57 *vices are not crimes*

58 *Usury laws-Зээлийн төлөө суутган авда хүүгийн хэмжээг зохицуулдаг хууль. Энэ хуулиар зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоохыг зорьдог. Үүнээс илүү хүү авах ёсгүй ажээ.*

байх болсон бөгөөд зээл авах боломжтой зөвхөн хэдхэн үүсэж тогтчихсон бизнестэй болдог.

Спүүнер аливаа төр засаг хувь хүмүүсийн хувийн үйлдэлд хэрэв тэд жинхэнээсээ бусдад хохирол учруулах шалтгаангүй л бол хөндлөнгөөс оролцох эрхийг үгүйсгэж байв. *Гэмт хэрэг* хувь бие хүн эсвэл өөр хэн нэгний хувийн өмчийг хохироох гэмтээх сэдэлтэй үйлдэл байдаг бол муу бодол ийм хортой зүйл агуулдаггүй бөгөөд үйл хийж буй хувь хүндээ л хортой (байх магадлалтай) байдаг. Нэгэнт хуульд “гэмт хэргийн агуулгагүй гэмт хэрэг байх боломжгүй”, ‘иймэрхүү гэмт зорилготой муу бодол хэн ч хэзээ ч боддоггүй’ гэсэн байдаг тул хөндлөнгөөс оролцох явдлыг зөвтгөх аргагүй зүйл ажээ. Үнэндээ энэ нь харгис дарангуйллын үүдийг нээх болно: ‘муу бодол болон гэмт хэрг^[59]ийн хоорондохь тодорхой ойлгомжтой хил заагийг хуулиар тогтоож, ялгаж гаргахгүй бол дэлхий дээр хувь хүний эрх, эрх чөлөө эсвэл өмч гэх зүйл байхгүй, мөн хүн өөрийн өвөрмөц чанар болон өмчөө хянах эрх гэдэг зүйл ч байхгүй байх болно...’ гэсэн байдаг.

Цаашилбал хөндлөнгөөс оролцох явдлын урт хугацааны үр дагавар голдуу л бүрхэг байдаг нь “ хаана муу зүйл төгсөж, хаанаас сайн зүйл эхлэхийг тодорхойлох явдлыг бараг бүх тохиолдолд хэцүү болгодог” ажээ. Бид зөвхөн үүнийг өөртөө л тодорхойлж чадах бөгөөд бусдад юу тэднийг урт хугацаанд аз жаргалтай эсвэл аз жаргалгүй байх явдлыг нь юу дэмжиж тэтгэж буйг өөрсдөөр нь шийдүүлэх ёстой: ‘Хэрэв энэхүү аугаа эрхийг чөлөөтэй, бүх хүнд нээлттэй орхихгүй бол’ гэж эхлээд тэрбээр ‘тэр үед хүн бүрийн хүмүүн төрөлтний хувьд оногддог, “эрх чөлөөтэй байх, аз жаргалдаа хүрэхээр зорих” бүрэн дүүрэн эрхийг түүнд эдлүүлэхээс татгалзсан’ гэсэн үг юм гэж дүгнэсэн байдаг.

Өнөөдөр Спүүнерийг 1845 оны *Боолчлолын Үндсэн Хуульд Үл Нийцэх Байдал* [анг. *The Unconstitutionality of Slavery*]

гэсэн бүтээлээр хамгийн сайн мэддэг. Олон аболиционистууд буюу боолчлолыг-эсэргүүцэгчид Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн Хууль хуульзүйн дагуу боолчлолыг хүлээн зөвшөөрсөн байдаг, мөн [үндсэн хуулийн] зөвхөн нэмэлт зүйл эсвэл боол-өмчилдөггүй муж улсуудын шинэ холбоо л энэ байдлыг залруулах боломжтой гэдэгт итгэдэг байжээ. Гэвч Спүүнер Улсыг Үндэслэгчид^[60] үндсэн хуулийн эхийг бэлтгэж байхдаа юу ч гэж хэлсэн байлаа жинхэнэ эх бичигт нь боолчлолыг дэмжээгүй байдаг гэж батлан өгүүлдэг байсан. Тиймээс л **боол-эзэмшдэг муж улсууд** шинэ холбоо байгуулж салах ёстой байсан ажээ. Үүнийхээ дагуу тэрбээр Иргэний Дайныг одоо байгаа холбоогоо хадгалж үлдэхийн тулд төр засгаа түлхэн унагаах гэсэн жам ёсны эрхийг үгүйсгэсэн, албадлагын шинжтэй төвлөрүүлэх-санаатай буюу центристч оролдлого гэж үзэн эсэргүүцэж байв.

Иймэрхүү үзэл санаа нь Спүүнерийн анархизмыг улам хүчтэй болгожээ. Тэрбээр 1870-аад онд Үндсэн Хууль бол логикийн хувьд түүнд гарын үсэг зурсан хүмүүст л холбоотой байх боломжтой гэрээ юм, үүнээс улбаалаад энэ нь орчин үед хүч чадалтай^[61] байх бололцоогүй гэж батлан өгүүлж байлаа. Нэгэнт л жам ёсны хууль болон захирагдаж буй хүмүүсийн зөвшөөрсөн саналаас зөрж төр засаг өөрийн эрх мэдлээ сахин хамгаалахад албадлага ашигладаг тул Үндсэн Хуульд ил тодоор харгис дарангуйллаас хамгаалах аюулгүй байдлыг бататгаж өгөөгүй байгаа ажээ. Тэрбээр мөн [шүүхийн] иргэдийн төлөөлөгчид буюу шүүхийн тангарагтнууд шүүхэд танилцуулсан нотолгооны талаархи шийдвэр гаргахаар зөвхөн зогсохгүй, мөн хуулийн хууль ёсны байдл^[62]ын талаар шийдвэр ч гаргах ёстой – бас бүр тэдний шударга бус гэж үзсэн хуулиар хэн нэгнийг мөрдөн шалгаж буй бол түүнийг нь хэлэлцэхээс татгалзах ёстой гэж гэдгийг сахин хамгаалж байв.

60 *Founders*

61 *contemporary force*

62 *legitimacy of the law*

[63] Хенри Дэвид Төрүэ (1817–1862 он): Америк философич, аболиционистч, татвар бүртгэгч^[63], анархист. **Гол үзэл санаа:** Иргэний үйл захирагдах байдал^[64]; анархизм; аболиционизм; олонхийн санал өгөх явдлын шударга бус байдал. **Гол бүтээл:** *Иргэний Үл Захирагдах Ёс* [*анг. Civil Disobedience*] (1849 он).

Аав нь харандаа-үйлдвэрлэдэг (өөрөө бас оролцож байсан) бизнестэй байсан, ээж нь Канад руу зугтааж буй босуул боолуудыг орон гэрээр хангадаг, боолчлолын-эсрэг шинэчлэгч байсан Төрүэ Массачүсеттсийн Конкордод төржээ. Тэрбээр Харвардад суралцаж, түүнийг радикал үзэл санаагаараа алмайруулж хөглөдөг эссэчин, хурлын дарга Ралф Валдо Эмерсон (1803–1882 он)-ы хүүхдүүдийг сургах урилга хүлээн авахаасаа өмнө дунд сургуульд богино хугацаанд багшилж байжээ.

Гэвч тэрбээр анхнаасаа л хөдөө газарт дуртай байв. *Валден* [*анг. Walden*] (1854 он) гэдэг номдоо дүрсэлж тайлбарласанчлан Төрүэ ой мод руу өөрөө-өөрийгөө болгож амьдрахаар оджээ. Тэрбээр мөн үнэт зүйлийг нь үзэн ядаж байсан (ялангуяа боолчлол болон дайнтай холбоотойгоор) төр засгаас хол ‘хөндий зогсох, орхиж явах’-ыг хүсэж байсан. Гэвч тэрбээр хүн амын татвар^[65]аа төлөөгүйнхээ төлөө шоронд хоригдов. Хэдийгээр найз нь татварыг нь төлөхөд удалгүй суллагдсан ч гэлээ амьдралынх нь энэхүү мөчлөг түүнийг хүчирхэг анархимзээ буулгаж харуулсан *Иргэний Үл Захирагдах Ёс* [*анг. Civil Disobedience*] (1849 он)-оо бичихэд нь түлхжээ. ‘Ерөөсөө бусдыг захирдаггүй төр засаг л хамгийн сайн нь юм’ гэж тэрбээр бичсэн байдаг. ‘[Т]өр засгийн бүрэн эрх^[66] ... заавал үйлдэх зөвшөөрөлтэй, захирагдаж буй

63 *tax resister*

64 *civil disobedience*

65 *poll tax*

66 *authority of government*

хүмүүсийн зөвшөөрсөн санал^[67]тай байх ёстой. ... Би, Хенри Төрүэ өөрөө нэгдэж ороогүй аливаа нэгдмэл нийгмийн гишүүн гэж харагдахыг хүсэхгүй байна'. Хуульзүйн дагуухь бүрэн эрхтэй төр засаг^[68] түүнд үнэнч бус захирагдахыг хүсдэггүй над шиг хүмүүсийг хүлцэн тэвчих чадалтай байх ёстой гэж байв.

Төр засаг үйлдэл, худалдаа, дэвшилд зөвхөн л саад тотгор бүтээдэг гэж бичиж байв. Тэрбээр олонхийн засаглал^[69] шудрага ёс гэхээсээ илүүтэй хүч чадалд тулгуурладаг гэж шүүмжилдэг байсан. Хуульзүйн дагуухь бүрэн эрхтэй төр^[70] олонхийн эрх мэдлийг биш харин хувь хүмүүсийн эрхийг баталгаажуулдаг байх ёстой. Шударга бус хуулийг зөрчих ёстой: бүр татвар төлөх явдал төр засгийн шударга бус байдлын талаархи санал нэгдэж буй байдлыг дам харуулдаг ажээ.

[64] Фредерик Дугласс (1818–1895 он): Африк-Америк хүн^[71] аболиционистч, шинэчлэгч. **Гол үзэл санаа:** Аболиционизм; хүмүүний сонголт, хариуцлага. **Гол бүтээл:** *Америк Боол Фредерик Дугласын Амьдралын Сонин Хачин [анг. Narrative of the Life of Frederick Douglass, An American Slave] (1845 он); Миний Хүлээс, Миний эрх чөлөө [анг. My Bondage and My Freedom] (1855 он); Фредерик Дуглассын Амьдрал, Цаг Хугацаа [анг. Life and Times of Frederick Douglass] (1881 он).*

Дугласс боол болж төрсөн ч түүнээсээ оргож, Филадельфиягийн Квакер хотод очиж чадсан бөгөөд тэндээ тэрбээр аболиционист бүлэгт нэгдэж, ламтан, боолчлолын-эсрэг гарамгай илтгэгч

67 *consent of the governed*

68 *legitimate government*

69 *majority rule*

70 *legitimate state*

71 *Afro-American abolitionist -Негр гэдгийн эерүүлсэн утга биш харин Африк хүн, бас Америк хүн гэдгийг зохиогч харуулж ингэж бичжээ.*

болжээ. Тэрбээр 1800-аад оны дундуур Британи, Ирландад зочилж аболиционист үндэслэлээ батлан өгүүлж явав.

Хэдийгээр голчлон кампанит ажил буюу ухуулах ажил хийдэг байсан ч гэсэн Дугласс боолчлол хүмүүний хариуцлагын зарчмыг зөрчдөг гэсэн либерал гаргалгаа нотолгоог хөгжүүлсэн байдаг: хувь хүмүүс хэрэв тэднийг хэн нэгэн удирдаж чиглүүлж байвал ёс суртахууны хувьд бүрэн бүтэн байх боломжгүй. Мөн тэрбээр төр засаг хүмүүний оюун ухааны хүч чадлын хагасыг өөрсдөдөө өгөхөөс татгалзаж байдаг гэж батлан өгүүлж эмэгтэйчүүдийн улстөрийн эрхийн төлөө дарамт шахалт үзүүлдэг байсан. Тэрбээр өөрийгөө-мэдэх тухай либерал зарчим, өөрийнхөө хөдөлмөрөө хэрэглэх эрх, хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засаг, өөртөө итгэх явдлыг хүлээн зөвшөөрдөг байжээ. Тэрбээр хувийн өмчийг дэмжиж, үнэндээ өмч ирээдүйнхээ тухай санаа тавихыг хүмүүний үүрэг болгодог гэдгийг ойлгож байсан.

Гээд **Виллиам Ллойд Гаррисон** түүний эхэн үеийнх нь найз байсан ч гэсэн Гаррисоны пасифист анархизмыг Дугласс зохимжгүй зүйл гэж бодож байжээ - учир нь төр хэрхэн боолчлох явдалд зөвшөөрөл өгсөн, мөн бүр боолчлолыг халсны дараагаар хууль болон институтууд (үйлдвэрчний эвлэл зэрэг^[72]) арьсны өнгөөр үргэлжлүүлэн ялгаварлан гадуурхсаар байна гэж бодож байсан. Тэрбээр хэсэг газар олгох баталгаа байдлаар төлөөс төлөх^[73], АНУ-ын Үндсэн Хуулийг чанд сахихыг шаардаж, төр өөрийн бүтээсэн тэгш бус байдалтайгаа идэвхитэй тэмцэх ёстой гэж шаргуу ятгаж байлаа. Түүний алсын хараа нь тэгш байдал болон эрх чөлөө байв: 'Негр хүнтэй шударга харьц' гэж хэлээд 'түүнийг тайван орхи' гэсэн байдаг.

[65] Густав де Молинали (1819–1912 он): Бельги хүн, чөлөөт зах зээлийн эдийн засагч. **Гол үзэл санаа:** Анархи-капитализм; төр, эрх мэдэл, давуу эрхийг шүүмжлэх;

72 *trade unions*- Үүнийг бас *labor union* буюу хөдөлмөрийн эвлэл гэдэг

73 *restitution*

хувийн аюулгүй байдал. **Гол бүтээл:** *Аюулгүй Байдлыг Бүтээх* [анг. *The Production of Security*] (1849 он); *Маргаашийн Нийгэм* [анг. *The Society of Tomorrow*] (1899 он).

Муррэй Ротбардынхаар бол Молинари анархи-капитализмын анхны өмгөөлөгч хамгаалагч ажээ – энэ бол төр засаггүй эдийн засгийн эрх чөлөө юм. Бельгид төрсөн, Фредерик Бастиагийн бишрэн шүтэгч тэрбээр арванесдүгээр зууны Францын лэзе-фэерийн тэргүүлэх хамгаалагч болов. Сэтгүүлч болон эдийн засагчийнхаа удаан амьдралынхаа туршид тэрбээр чөлөөт худалдаа, цомхон төр, эв найр, аболиционизмын үзэл санааг дэмжин, протекционизм, империализм, милитаризмийн эсрэг анхааруулж байсан байдаг.

Гаргуун индивидуалист болох тэрбээр **Жон Локк**, бусад сонгодог либералууд бүгдээрээ баталгаатай олгогдсон зүйл гэж үздэг, аюулгүй байдалтай холбоотой төрийн монополийг үгүйсгэв. Төр засаг жам ёсоор харилцан хамгаалалтаас ургаж гарсан тухай санааг эсэргүүцэж, тэрбээр яагаад ийм байх ёстойг асуусан байдаг. Үүний эсрэгээр хэрэв хүмүүс болон тэдний өмч рүү бусад хүмүүс дайрах аваас тэд зүгээр л тэдгээрээ хамгаалахын тулд мэргэжилтэн л хөлслөх болно гэж тэр бодож байжээ. Энэ явдал аливаа бусад бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний төлөө тэдний хийдэгтэй адилхан зүйл байх болно: яагаад аюулгүй байдал болон бусад олон нийтийн үйлчилгээ өөр байх ёстой гэж?

Монополь байдал хүчинд тулгуурладаг гэж Молинари тайлбарладаг. Хүмүүс тэдэнд хүч хэрэглэхгүй л бол монополь үнэ төлөхгүй. Хувийн монополь эрхийг хамтын монополь байдлаар солих боломжтой ч энэ мөн л хүчинд тулгуурласаар л байх болно. Хамгийн хөнөөлтэй монополь байдал бол аюулгүй байдал ажээ. Учир нь аюулгүй байдлаар хангадаг тэр улс түүнийгээ өргөжүүлэх албадлагын эрх мэдэл аль хэдийнээ эзэмшдэг бөгөөд үүнийгээ ашиг сонирхлоо урагшлуулж бусдыг

албадахад л ашиглах болно. Энэ байдал бол яагаад хүч хэрэглэх төрийн монополь байдал дайныг багасгадаггүй харин түүнийг дэмждэгийн шалтгаан ажээ.

Хүмүүс хүч хэрэглэх явдлыг талаархи парламентын зарим нэг хяналтыг баталгаатай болгож болох ч албадлагад тулгуурласан монополь байдал хэвээр үлддэг. Үндсэн Хуулийн тонуул бол мөн л тонуул билээ – энэ бол хүмүүсийн удирдагчдаа итгэх итгэл, тэднийг захирах эрхэд итгэх итгэлийг ганхуулдаг. Гэвч нийгмийн зохицол^[74] аллага хядлагаас илүүтэйгээр ашиг тус^[75] аар дамжин бий болох боломжтой. Хамгаалалт хэрэгтэй байгаа хүмүүс түүнийг өгч чадах хүмүүстэй гэрээ байгуулж, мөн үр ашигтай байдал болон төлсөн мөнгөний үнэ цэнэ буюу үнэ болон чанарын харьцаанаас ашиг тус олох болно. Эдгээр үзэл санаа **Дэвид Фрийдмэнд** ихэд нөлөөлжээ.

[66] Херберт Спенсер (1820–1903 он): Англи хүн, социологич, полимат. **Гол үзэл санаа:** Эрх чөлөө, хөгжил дэвшил; эв зохиролтой нийгмийн эволюц; улстөрийн эрх; универсал буюу хүн бүрийн сонгуулийн эрх; муу төр засагтай хамтран үл ажиллах явдал. **Гол бүтээл:** *Нийгмийн статистик* [анг. *Social Statics*] (1851 он); *Хүнийг Төртэй харьцуулбал* [анг. *The Man Versus the State*] (1884 он).

Гэрийн боловсролтой Спенсер *Экономист* сэтгүүл^[76]д орохоосоо өмнө төмөрзамын иргэний инженерээр ажиллаж байжээ. Тэрбээр энэхүү сэтгүүлийн чөлөөт худалдаа, лэзе-фээр, хязгаарлагдмал эрх мэдэлтэй төр засгийг дэмжих явдалтай санал нийлдэг байсан ч түүний сонирхол хүмүүний социал психологи рүү эргэв. Тэрбээр *Төрөл Зүйлийн Үүсэл Гарал* [анг. *The Origin of Species*] (1859 он) бүтээлийг хэвлүүлсэн Чарлз Дарвин

74 *social arrangement*

75 *utility*

76 *The Economist*.

(1809–1882 он)-аас өмнө хэдэн жилийн урьд хувьсал хөгжил буюу эволюцын онолоор оролдож азаа туршиж байсан. Гэвч Дарвинтай адилгүй нь тэрбээр байгалийн шалгарлын зарчмыг ухааж ойлгоогүй байсан бөгөөд олж авсан шинж чанар нь удам дамждаг гэж итгэж байжээ (одоо Ламарккизм гэж мэддэг болсон алдаа). Тэрбээр мөн эволюцын онолыг психологи, соёл руу өргөжүүлсэн хамаатуулсан; Дарвин эволюцыг цор ганц зорилготой байдаггүй, тасралтгүй үргэлжилдэг үйл явц гэж ойлгодог байсан бол Спенсер бидний эволюцын үйл явц “төгс нийгэм дэх төгс хүн” рүү чиглэж явагддаг гэж төсөөлж байжээ. Хүмүүний нийгэм энгийн байснаа эрэмбэ дараатай, дайнч байгаад нарийн нийлмэл, хамтран ажилламтгай, аж үйлдвэржсэн болж хувьсаж хөгждөг гэж санал болгов. Үр дүнд нь хүмүүн төрөлтөн илүү зөөлөн бодгаль болж хувьсаж өөрчлөгдсөн ажээ.

“Хамгийн сайн зохицсон нь амьд үйлдэх болно”^[77] гэсэн хэллэгийг Дарвин биш харин Спенсер бодож буулгажээ. Энэ байдал түүнийг “Социал Дарвинистч” гэж алдаатай бодоход хүргэв – энэхүү сэтгэгдлээ дараахь мэт, илүү өргөн хүрээтэй хэллэгээр хүчитгэсэн байдаг: “Тэнэглэлийн нөлөөнөөс хүмүүсийг хамгаалах явдлын цор ганц үр нөлөө нь ертөнцийг тэнэгүүдээр дүүргэх явдал байх болно”. Гэвч хэдийгээр тэрбээр социал эволюционист байсан ч Спенсер өөрөө Социал Дарвинизм^[78]ээс “хамгийн сайн нийцсэн” нь заавал “хамгийн сайн” нь байх албагүй гэж зааж хэлэн зайгаа авсан байдаг.

Спенсер үнэндээ *либерал утилитарич* байжээ. *Ёсзүйн Зарчим* [*анг. The Principles of Ethics*] (1879–93 он)-даа тайлбарласнаар эволюц бол хамтын ажиллагаа зэрэг хэрэгтэй шинж чанарыг тэтгэдэг ажээ. Энэ явдал бүлэг хүмүүс амьд үлдэх, тэдний тав тухад тустай – тиймээс л энэ нь мөн түүн дотор байгаа хувь хүмүүсийн амьд үлдэх, сайн сайханд тустай байна. **Жон Стюарт Миллийн** адилаар тэрбээр чөлөөт нийгэм бусад нийгмээсээ

77 *survival of the fittest*

78 *Social Darwinism*

илүү хурдан хөгжиж дэвжих болно гэдэгт итгэдэг байсан: хүмүүст туршлагажиж сургамж авах боломж олгосноор эволюцэд хэрэглэгдэх хэрэглэгдэхүүн илүү их болно гэж тэрбээр тайлбарласан. Хувь хүний эрх чөлөө мөн л дахиад амжилттай хувьсал хөгжилд нэмэр оруулдаг, үүнээс улбаалаад бүх нийтийн аз жаргалд нэмэр болдог ёс суртахууны тэгш байдал, ижил тэгш шударга ёс, амьдран суух эрх болон эрх чөлөөтэй холбоотой байдаг. Эдгээр үзэл санаа хувь хүмүүс болон нийгэмд гүн бат суун шүүхийн либерал тогтолцоо^[79] зэрэг нийгмийн институтууд үүсэж гарахад хүргэдэг; эдгээрийг хүлээн авсан нийгэм л хөгжиж цэцэглэдэг ажээ.

Тиймээс Спенсерийн хувьд сайн сайхан^[80] маш гүнзгий либерал үзэл санаа байжээ – энэ бол хувь хүний эрхтэй зөрчилддөггүй түүнд суурилдаг зүйл юм. *Хүнийг Төртэй Харьцуулбал* [анг. *The Man versus the State*] (1884 он)-доо тэрбээр сүйрэл дагуулдаг социализмын эсрэг хамгийн сайн хамгаалалт гэж эрхийг дэмждэг гаргалгаа нотолгоонуудаа гаргав. Бид ёс суртахууны хувьд өв тэгш бус учраас бидэнд бусад хүн бидний ёс суртахууны эрхэд халдахаас хамгаалах гэж бидэнд төр засаг хэрэгтэй гэж тэрбээр тайлбарлажээ; гэвч тэр үед бидэнд төр засаг өөрөө бидний ёс суртахууны эрхэд халдахгүй байлгах *улстөрийн эрх* хэрэгтэй ажээ. Нэгэнт л бусдын амьдралд оролцох гэсэн сэдэл хүчтэй байдаг учраас энэ эрх маш чухал: ‘Хэдийгээр бид хүмүүсийг тэдний оюун санааны сайн сайхны төлөө албадлага хэрэглэхээ больсон ч гэлээ бид одоо ч материаллаг сайн сайхн^[81]ых нь төлөө тэдэнд албадлага хэрэглэсээр л байдаг: ингэхдээ энэ нь нөгөөхтэйгөө л адил хэрэггүй, бас үндэслэлгүй зүйл гэдгийг хардаггүй^[82].

Спенсер төрийг хязгаарлах боломжтой хэд хэдэн улстөрийн

79 *liberal system of justice*

80 *utility*

81 *material good*

82 *useless and as unwarrantable as the other*

эрхийг анхаарсан байдаг. *Төрийн Статистик мэдээлэл* [анг. *Social Statics*] (1851 он)-дээ тэрбээр хэдийгээр хожим нь *Ёсзүйн Зарчим* [анг. *Principles of Ethics*] (1879 он)-даа “хэт их тогтоол шийдвэр”^[83]-ийг дэмждэг гэж үүнээсээ татгалзсан ч гэлээ улстөрийн амин чухал эрх гэж универсал сонгуулийн эрхийг өмгөөлж хамгаалж байв. Төртэй холбоогоо таслах эрх чөлөө бол түүний анхнаасаа л чухал үзэж байсан, өөр нэг эрх юм – үүнд татвар төлөхөөсөө татгалзаж эргээд мөн түүнээс ашиг тус үл хүртэх явдал ордог ажээ; гэвч дахиад л амьдралын сүүлийн жилүүдэд тэрбээр хожим нь энэхүү үзэл санаа зохимжгүй хэрэггүй зүйл гэж дүгнэв. *Социал Статистик*-дээ тэрбээр газрын хувийн өмчлөл^[84] нэгэнт л энэ нь ихэнх хүмүүст амин чухал нөөц баялаг өгдөггүй учраас ижил тэгш эрх чөлөөний зарчимтай дүйхгүй гэж бодож байжээ; гэвч Ёсзүйн Зарчимдаа тэрбээр дахиад л энэхүү үзэл санаагаа үгүйсгэсэн байдаг.

Хэдийгээр Спенсер үзэл санаагаа туршлага сургамж дээрээ үндэслэж нэмэлт оруулж, өөрчлөхөд бэлэн байсан ч гэсэн өөрийн дараахь үндсэн зарчимдаа үнэнч үнэн хэвээр үлдсэн: энэ нь ‘бүх хүний үүнтэй адил эрх чөлөөгөөр хязгаарлагддаг хүн бүрийн эрх чөлөө буюу эрх чөлөөт байдал бол нийгмийг зохион байгуулах ёстой ёс журам юм’ гэсэн зарчим ажээ.

[67] Жон Эллиотт Кэйрнес (1823–1875 он): Ирланд хүн, улстөрийн эдийн засагч. **Гол үзэл санаа:** Эдийн засгийн арга барил; төгс бус өрсөлдөөн; боолчлолын эдийн засгийн дутагдалтай тал. **Гол бүтээл:** *Улстөрийн Эдийн Засгийн Шинж Чанар, Логик Арга* [анг. *The Character and Logical Method of Political Economy*] (1857 он); *Боолын Хүч* [анг. *The Slave Power*] (1862 он).

Шинжлэх ухаанд суралцах гэж тэмүүлдэг, Ирландын пиво

83 ‘over-legislation’

84 private land ownership

исгэгчийн хүү Кэйрнес Тринити Коллеж Дүблинд элсжээ. Тэрбээр хууль судалсан бөгөөд барын шалгалт^[85]ад тэнцсэн ч мэргэжлээрээ ажилласангүй, харин эдийн засгийн асуудалд сонирхолтой болжээ. Алдартай найз нь түүнийг Улстөрийн Эдийн Засгийн Тэнхимийн эрхлэгч болгов.

Түүний уншдаг лекцийг *Улстөрийн Эдийн Засгийн Шинж Чанар, Логик арга барил* [анг. *The Character and Logical Method of Political Economy*] (1857 он) гэсэн нэртэй хэвлүүлжээ. Өөрөө шавь нь байсан, **Жон Стюарт Миллийн** зохиосон, улстөрийн эдийн засгийн тухай хамгийн чухал ном болох *Улстөрийн Эдийн Засгийн Зарчим* [анг. *Principles of Political Economy*] (1848 он)-д сонгодог эдийн засгийн ухааны хамрах хүрээн болон арга замыг тодорхой гаргаж тогтоосон байдаг. Улстөрийн эдийн засаг бол шинжлэх ухаан юм, тиймээс нийгмийн тогтолцоо болон бодит байдалд зайнаас харьцах ёстой гэж Кэйрнес хэлдэг байсан. Гэвч эдийн засагчид судалгааны сэдвээ байгалийн ухааны эрдэмтэд судалгаандаа ханддаг шигээр туршилт хийж чаддаггүй, учир нь эдийн засгийн ухаан хэзээ ч математик тооцооллолтой байх боломжгүй. Үүнээс илүүтэй эдийн засаг бол дедүктив буюу таамаг-дэвшүүлэмтгий шинжтэй байж, үүсэж тогтчихсон бодит байдлаас зарчим гаргаж авдаг шинжлэх ухаан ажээ.

Баримттай тун чадварлаг харьцдаг байдал нь Австрали болон Калифорни дахь алтны үйлдвэрлэлийн судалгаагаараа *мөнгөний тоо хэмжээний онол*^[86]ыг амьдарч асан зууныхаа мөнгөний тухай хамгийн чухал шинжилгээ^[87] болгож дахин амилуулав. (**Милтон Фрийдман** энэхүү онолыг зуун жилийн дараа дахин амилуулах болно.) Үүнтэй адилаар Кэйрнесийн боолчлолын талаархи баримтын судалгаа нь боолчлолын дутагдалтай талыг тодруулж гаргасан: боолчлол технологийн шинэчлэлийг саатуулж, газрын хөрсийг хэт их ашиглахад хүргэж, ажил хэрэгч

85 *the bar*-Хуульчаар ажиллахын тулд заавал өгч, тэнцдэг шалгалт

86 *quantity theory of money*

87 *monetary analysis*

байдлыг бууруулдаг бөгөөд энэ нь ерөөсөө ч амьдрах чадваргүй зүйл ажээ. *Боолын Хүч* [анг. *The Slave Power*] (1862 он) ном нь Британийн бодол санааг Америк дэх Конфедерац^[88]ын эсрэг хандуулсан.

Бусад бүтээлдээ Кэйрнес сонгодог тогтолцооноос болж хэрхэн хөдөлмөр маш хөшүүн байгааг харуулжээ. Тиймээс л ‘төгс өрсөлдөөн’-ний загварыг ашиглах аргагүй: нийгэм хоорондоо өрсөлддөггүй аж үйлдвэрлэлийн бүлгүүдийн бүрдэл илүүтэй байдаг ажээ. Эдгээр үзэл санаа *төгс бус өрсөлдөөний* орчин үеийн сургаал^[89]ыг өдөөж сэдэлжүүлсэн.

[68] Эдвард Аткинсон (1827–1905 он): Америк хүн, анти-империалист кампанит ажил явуулагч. **Гол үзэл санаа:** Аболиционизм; анти-империализм; чөлөөт худалдаа. **Гол бүтээл:** *Татварлах явдал, Ажил* [анг. *Taxation and Work*] (1892 он).

Хөрөнгө мөнгөгүйгээсээ болж коллежээ орхиход хүрсэн Аткинсон даатгал болон хөвөн даавууны үйлдвэрлэлд амжилттай ажил хэрэгч хүн болжээ. Мөн тэрбээр Aladdin Cooker^[90] гэдэг сайжруулсан зуух зохион бүтээсэн бөгөөд Урлаг болон Шинжлэх Ухааны Америкийн Академийн Гишүүн болсон. Гэвч түүнийг анти-империализм, аболиционизм, чөлөөт зах зээлийн либерал үзэл санаануудыг нэгтгэснээр нь дурсан санадаг – өөрийн идэвхи зүтгэлээрээ, мөн либерал улстөр болон эдийн засгийн сэдэвтэй

88 *Confederacy*

89 *modern treatment of imperfect competition*

90 *the Aladdin Cooker*- Аладдины Зуух гэдгийн талаар, *Scientific American Magazine* гэсэн сэтгүүлийн 54-р дугаар (1886 оны 5-р сар)-т ийм нэртэй нийтлэлд анх хэвлүүлжээ. Тэрбээр амьжиргааны өртгийн тухай судалж үзээд хоол хийхдээ үр ашиггүй байдлаар нүүрс галлаж буйг олж мэдэн сайжруулсан арга боловсруулсан нь ийм нэртэй байв.

асар олон нийтлэл болон памфлет буюу ухуулах хуудсаараа дамжуулан түүний шаргуу ятгаж байсан үзэл санаанд нь банкны салбар, чөлөөт худалдаа, өрсөлдөөн, зохицуулалт буюу дүрэм журам, цаасан мөнгөний муу тал^[91] багтдаг.

АНУ-ын ерөнхийлөгч Виллиам МакКинлий (1843–1901 он), Теодор Рузвелт (1858–1919 он) нарын Испани - Америкийн дайны дараахь нутгаа тэлэх, империалистч, колончлох бодлогод цочирдсон Аткинсон Америкийн Империализмын Эсрэг Лийг (Нэгдэл)-ийг байгуулахад тусалж, АНУ-ын гадаадад буй цэргүүдийг удирдаж буй генералуудад анти-империалист памфлет буюу ухуулах хуудаснууд илгээж, түүний тэргүүний идэвхитэн, памфлет-гаргагч нь болжээ.

Тэрбээр мөн боолуудыг оргоход нь туслах хөдөлгөөнийг дэмждэг байсан бөгөөд аболиционист Жон Браун (1800–1859 он)-ы зэвсэглэсэн бослогыг дэмжих гэж мөнгө ч цуглуулж байв. Түүний үхлийг “зүрхэнд нь нөлөөлсөн, хоол үл шингэх явдал”^[92]-аас шалтгаалсан гэж тайлагнасан байдаг.

[69] Жозефин Батлер (1828–1906 он): Англи хүн, социал шинэчлэгч, суффрагистч^[93]. **Гол үзэл санаа:** Либерал феминизм; эмансипац^[94]; бие үнэлэх тухай хуулийн шинэчлэл. **Гол бүтээл:** *Эмэгтэйчүүдийн боловсрол ба Ажил эрхлэлт [анг. The Education and Employment of Women] (1868 он).*

91 *evils of paper money*

92 *'a bout of indigestion, affecting the heart'*

93 *suffragist*-сонгуулын эрхийг өргөжүүлэх, ялангуяа эмэгтэйчүүдэд эдлүүлэх явдлыг өмгөөлж-хамгаалагч хүн

94 *emancipation* - Энэ хэллэг Латины *ēmancipō* (эцэг эхийн мэдлээс хүүхдийг чөлөөлөх) гэсэн үгнээс гаралтай бөгөөд энэ латин үг нь *ē manū capere* (хүний эрхэнд буй хүнийг суллах) гэсэн утга үгнээс үүсжээ. Үүгээр голчлон нийгмийн хамааралтай байдлаас татгалзах явдал, жишээлбэл эцэг эхээс нь хүүхдийг салгаж авахыг хэлдэг.

Нийгмийн шинэчлэгч болохынхоо хувьд Жосефин Батлер эмэгтэйчүүдийн боловсрол, олон нийтийн эрүүлмэнд^[95]ийг сайжруулахад тусалжээ. Тэрбээр хууль тогтоогчидтой тэмцэх, мөн нийгмийн хэцүү асуудлыг олон нийтийн хүрээнд^[96] оруулж ирэн либерал феминизмийг хүчирхэг хүч болгосон байдаг. Кампанит ажил явуулагч^[97] болохынхоо хувьд тэрбээр хожмын эмэгтэйчүүдийн сонгуулийн эрхийн төлөөх хөдөлгөөнд хүч чадал өгөх улстөрийн шинэ хандлагыг үүсгэж хөгжүүлэв. Тэрбээр ер гаруй ном болон памфлет бичсэн.

Батлер ерөнхий сайд Ээрл Грэй (1764–1845 он)-ийн үел байсан, шинэчлэгч, аболиционистчийн охин байлаа. Тэрбээр гэрлэх үедээ нөхрийнхөө ажилд сүмийн багшаар ажиллаж байсан бөгөөд нөхөр нь түүнийг Либерпүүл рүү авч явж, тэндээ тэрбээр гэр бүлийн халамжийн асуудалд оролцох болсон байдаг. Тэрбээр гэрийн-ажлаас^[98] охидыг гарган аварч, хэрэгтэй ажил тэдэнд өгч, хүүхдийн биеэ үнэлэлтийн эсрэг кампанит ажил явуулж байв. Биеэ үнэлэгчид 12 настай хүртэл байгаа явдал боолчлолын худалдаа болохыг олж нээж үүний эсрэг ухуулах ажил явуулж байсан. Энэхүү туршлага сургамжаасаа санаа авч тэрбээр эцэст нь Британийн [бэлгийн харьцаанд орох] зөвшөөрлөө өгөх эрхтэй хуульзүйн нас^[99]ыг 13-аас 16 болгож өсгөх хөдөлгөөнийг амжилттай удирджээ.

Түүний хоёрдохь кампанит ажил нь халдварт өвчний талаархи хуультай тэмцсэн ажил байв. Арми болон тэнгисийн цэргийн дунд бэлгийн замын өвчин тархахаас сэргийлэх зорилготой эдгээр хууль цагдаад боомт болон цэргийн хотхонд байгаа эмэгтэйчүүдийг баривчлах, албадан эмнэлгийн үзлэгт

95 *public health*

96 *public domain*

97 *campaigner*

98 *workhouse*

99 *legal age of consent*

оруулах эрх мэдэл өгсөн байв. Хэрэв тэд үүнийг нь эсэргүүцвэл эсвэл өвчний шинж тэмдэгтэй байвал тэднийг шоронд хорих ч боломжтой байсан. Батлер залуу эмэгтэйчүүдийг цагдаа ялгаварлан гадуурхаж буйг энэ хууль дэмжиж байна, мөн хүн амынхаа тэн хагасаас нь тэдний хуульзүйн дагуухь эрхийг булаан авсан мөртлөө өвчлөлийн тархалтыг ч тавин хувь бууруулж чадахгүй байна гэж батлан өгүүлж байв. Иймэрхүү “ичмээр” сэдвийн талаар эмэгтэй хүн ярих нь эмэгтэйчүүд бүр санал өгөх ч эрхгүй байсан тэр цаг үед тун хачин хэрэг байсан байдаг; гэвч Батлер өөрийн гаргалгаа нотолгоогоороо бүр олон нийтийн уулзалт дээр ч маргаж мэтгэлцэхээсээ ичсэнгүй. Дахиад л түүний кампанит ажил нь мэдээлжсэн байдл¹⁰⁰ыг нэмэгдүүлж, эцэст нь амжилтад хүрчээ.

Дээр нэмээд хэлэхэд Батлер эмэгтэйчүүдийн эхнэр, ээж гэсэн “жам ёсны” үүргийн талаар эргэлзээ төрүүлсэн, ингэхдээ энэ нь гэрлээгүй сая сая эмэгтэйчүүдийн хувьд ямар утгатай байх тухай асууж байсан. Тэрбээр эмэгтэйчүүдийн дээд боловсролыг тэлэхийг төлөө тэмцэж, мөн Кэмбрижийн Их Сургуулийг зөвхөн-эмэгтэйчүүдийн Ньюнхам Коллеж¹⁰¹ийг үүсгэж байгуулахад нь түлхээс болж тусалжээ.

100 awareness

101 women-only Newnham College

НАЙМДУГААР БҮЛЭГ: ОРЧИН ҮЕИЙН ЭРИН

Арванесдүгээр зууны дундуур гэхэд дэлхий ертөнц арилжаа худалдааг тэлснийхээ үр шимийг хүртэж байлаа. Америк болон Азийн хөвөн даавуу дэлхий даяар хувцас хэрэглэл, даавууны үнийг асар ихээр бууруулж, түүнийгээ дэлхий даяар экспортлох боломж олгосон (уур болон усны хүчинд тулгуурласан) автоматжуулалт бүхий Британийн өргөн хүрээтэй даавууны бизнесийг тэжээж байв. Уурын хүч бараа бүтээгдэхүүн тээвэрлэх, хүмүүс зорчих хугацаа болон зардлыг ийн хувьд бууруулжээ. Мод, нүүрс зэрэг түүхий эдийг олон-улсын хэмжээнд цай, кофе, содон халуун ногоо зэрэг тансаг зүйлсийн адилаар зарж байлаа. Жилээс жилд арилжаа худалдааны ертөнц улам бүр л баян болсоор л байв.

Эд хөрөнгөтэй болохын хамтаар хүмүүс нийгэм болон улстөрийн бодлогын талаар бодож сэтгэх, ямар нэг зүйл хийх чөлөөт цагтай ч болцгоосон байна. Британи аль хэдийнээ боолчлолыг устгаж, Парламентаа шинэчилж, протекционист *Үр Тарианы Хуулиа* цуцалчихсан байв. Гэвч либералчууд өөрийнхөө бүхий л арга барилаараа мэтгэлцээн маргаан явуулж байсангүй. Хурдтай аж үйлдвэржих явдал гэр бүл, нийгмийн институт, зам харгуй, гол зэрэг олон нийтийн дэд бүтцийг ачаалалд ороход хүргэсэн. Бидэнд хүмүүсийг зөнд нь орхидоггүй харин чөлөөтэй болгодог шинэ, *нийгмийн* либерализм хэрэгтэй гэсэн өргөн хүрээнд тархсан сэтгэгдэл улам бүр өсөж нэмэгдэж байжээ. Хурдтай өөрчлөлт зарим нэг кампанит ажил явуулдаг хүмүүсийг анархизм (төргүй нийгэм) болон коммунизм (нөөц баялгийн хамтач өмчлөл^[1])-ын шинэ үзэл санаа руу хандахад, мөн бусдыг нь консерватив хуучны үе рүүгээ буцахад хүргэсэн;

1 *collective ownership*

эдийн засгийн болон эволюцын шинэ онолууд улстөрийн болон нийгмийн сэтгэлгээг хараахан явна гэж бодож байгаагүй өөр чиглэл рүү хөтлөв.

[70] Лорд Актон [John Dalberg-Acton] (1834–1902 он): Англи хүн, Католик түүхч, улстөрч. **Гол үзэл санаа:** Эрх мэдлийн завхрал^[2]; хувь хүн улстөрийн хамгийн дээд зорилго болох нь; эрх чөлөө зөвшөөрөлгүй байхад оршдог; эрх чөлөөт байдлыг хадгалж үлдэхэд үзэл санаа чухал болох нь. **Гол бүтээл:** *Эрх Чөлөөний Түүх, Бусад Эссэ* [анг. *The History of Freedom and Other Essays*] (1907 он).

Хэдий Актон либерал гэхээсээ илүүтэй илүү консерватив үзэлтэн байсан ч гэсэн түүнийг дараахь хэлсэн үгийнх нь төлөө либералчуудын зүрхэнд байраа эзэлжээ: ‘Эрх мэдлийг завхруулах хандлагатай байдаг бол үнэмлэхүй эрх мэдлийг үнэмлэхүй байдлаар завхруулдаг’.

Өрнөдийн иргэншил хувь хүмүүс бол хамгийн дээд үнэт зүйл юм гэдэг үзэл санааг зуун зуунаар үүсгэж хөгжүүлсэн байдаг тул бусдаас дээд зэрэгтэй иргэншил юм гэдэгт Актон итгэдэг байжээ. Тиймээс хувь хүний эрх чөлөө буюу эрх чөлөөт байдал ‘бол улстөрийн дээд зорилгод хүрэх арга хэрэгсэл биш. Энэ нь өөрөө улстөрийн дээд зорилго билээ’. ‘Засаг захиргаа болон олонхи, уламжлал, бодол санааны нөлөө”-нөөс хамгаалсан хамгаалалт эрх чөлөөнд хэрэгтэй. Гэлээ гээд үнэнч Католик шашинтан болохынхоо хувьд тэрбээр эрх чөлөөг лиценз буюу зөвшөөрл^[3]өөс ялгаж зааглах гэж тэмүүлдэг байлаа: ‘Эрх чөлөө буюу эрх чөлөөт байдал бол бидний юу хүссэнээ хийх хүч чадал биш харин хийх ёстойгоо хийх бололцоотой байх бидний эрх юм’ гэсэн байдаг.

Актон АНУ-ын Үндсэн Хуулийн холбооны бүтцийг хувийн эрх

2 *Power corrupts*

3 *distinguish liberty from licence*

чөлөөний хамгаалалт гэж талархан дэмждэг байсан. Тэрбээр Конфедерацийг энэ нь муж-улсуудын төвийн төр засгаас өөрийгөө хамгаалах эрхийг нь хамгаалдаг гэж дэмжсэн – энэ төвийн төр засаг нь хэрэв түүнийг хяналт шалгалтгүй үлдээвэл харгис дарангуйлал болж хялбархан хөгжиж боломжтой гэж сануулж байв.

Гэвч үндсэн хууль ганцаараа эрх чөлөөг хадгалж үлдэж чадахгүй. Эрх чөлөө бидний институтууд үндэслэсэн тэр үзэл санаанаас хамаардаг. Бүр либерал институтууд ч гэсэн хэрэв хувь хүмүүсийн сэтгэл зүрх, оюун ухаанд амьд байхгүй бол цагийн эрхээр муудаж мөхнө. Хэдийгээр төр засгийн институтууд хэлбэрээрээ либерал гэж харагдаж байж болох ч тэдгээр нь амьдрал дээр заавал эрх чөлөөг хамгаалдаг байдаггүй гэдгийг анзаарсан байв.

[71] Өөберон Херберт (1838–1906 он): Англи улстөрч, индивидуалист философич. **Гол үзэл санаа:** Волитариизм; хамгаалах үйлдэл бол төр засгийн цор ганц үүрэг. **Гол бүтээл:** *Төрөөс явуулдаг Албадлагын Зөв болон Буруу тал* [анг. *The Right and Wrong of Compulsion by the State*] (1885 он); *Волитариизмын төлөө Волантарист Шунал, Гуйлт* [анг. *The Voluntarist Creed and a Plea for Voluntarism*] (1906 он).

Карнарвоны Гүн буюу герцог^[4]ийн бага хүү Херберт Британийн армид алба хааж, богино хугацаанд Парламентын Либерал Намын гишүүн болж байжээ. Херберт Спенсерийн нөлөөнд автсан тэрбээр чөлөөт зах зээл, сайн дурын хамтын ажиллагааг улстөрийн явцаас илүү хөгжил дэвшилд хүрэх хамгийн илүү сайн арга зам гэж ойлгох болжээ:

4 *Earl of Carnarvon*

Тэгвэл зүгээр л машин механизм, намын байгууллага, Парламентын Акт буюу Хууль тогтоомж хийгээд сайнтай муутай, няхуур болон болгоомжгүй, тэмүүлдэг болон тэмүүлдэггүй хүмүүстэй нэг л ижил төлөвлөгөөний дагуу харьцдаг, мөн асар том, төсөөлшгүй хэмжээ, тэдгээрийн нарийн нийлмэл байдал, төвийн албан ёсны удирдлага, таны удирдлагаас бүхэлдээ гарсан асар том, залахад хэт том тогтолцоонуудад итгэхээ болино уу.

Херберт төр засгийг ‘хувь хүний өвөрмөц чанар болон өмчийг хүч болон хууран мэхлэлтээс хамгаалах’ гэсэн ‘түүний хуульзүйн бүрэн эрхтэй үүргээр л үйл ажиллагааг нь чанд хязгаарлах ёстой’ гэдэгт итгэж байсан. Энэ байдал бол хүч хэрэглэх явдлын цор ганц үндэс байдаг гэж тэрбээр батлан өгүүлж байв. Төр засаг хүмүүсийн амьдрал болон өмчид цэрэгт татах^[5], эсвэл албан журмын боловсрол олгох, эсвэл тэдэнд татвар ногдуулах замаар “түрэмгийлэх” боломжгүй ажээ. Тиймээс чөлөөт байдал буюу эрх чөлөө болон өмчийг төр засаг хамгаалахад хэрэгтэй орлогыг сайн дураараа цуглуулах учиртай:

Хүч энэ нь ямар ч хэлбэртэй байсан ч гэсэн таны төлөө юу ч хийж чадахгүй. Энэ нь юуг ч эдгээж илааршуулж чадахгүй; энэ танд өөрт чинь хэрэгтэй байх, урт удаан эдэлгээтэй зүйл өгөх боломжгүй; энэ нь таныг материаллаг байдлаар хөгжүүлж цэцэглүүлж бүр чадахгүй ... Бүх хүн, эрэгтэй ба эмэгтэй хүн тэдний өмч болох өөрийн ур чадвар, оюун ухаан, бие хаа, өмчийнхөө жинхэнэ цор ганц өмчлөгч гэдгийг үүнээс хойш мөнх^[6] өд зарлан тунхаглаж байна; та нар шинэ нийгмийг өөрийгөө-өмчлөх, өөрийгөө-мэдэх, өөрийгөө-замчлах^[7]ын цор ганц үнэн үндэслэл дээр л зөвхөн

5 *conscriptio*,

6 *once and for good*

7 *self-ownership, self-rule, and self-guidance*

бүтээх болно...

Херберт *волантирийзм*^[8]ээ дэмжиж түгээхийн тулд яриа хөөрөө явуулж, нийтлэл бичиж, тогтмол хэвлэл (нэгийг нь *Чөлөөт Амьдрал*^[9] гэдэг байсан) хэвлэж байжээ. Үндэстний төр засгийн хэрэгцээг гэхдээ маш хязгаарлагдмал-эрх мэдэлтэй, [хүмүүс] сайн дураараа санхүүжүүлдэг төр засгийг хүлээн зөвшөөрсөн учраас түүнийг “анархист” гэж нэрлэхэд тэрбээр дургүй байсан. Тэрбээр бүр олонхи удирдаж залдаг бүгд найрамдах төр засаг^[10] байх болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг байв. Гэвч тэрбээр хүчийг буцааж эсэргүүцэхээс өөрөөр хүч хэрэглэх ямар нэг эрх олонхид бэлэг болгож олгоогүй гэж батлан өгүүлсэн. Өөрийн-биеийг өмчлөх зарчим^[11] гэдэг нь ‘хувь хүн ч, бас олонхи ч, мөн төр засаг ч бусад хүмүүсийг өмчлөх эрхгүй^[12]’ гэсэн үг ажээ.

Херберт ‘эрх мэдэл бол хамгийн муу, хамгийн үхлийн аюултай зүйлийн нэг юм, мөн хүмүүсийн гарт өгөх боломжтой бүх авьяасыг хүчгүй болгодог зүйл юм’ гэж бодож байв. Тиймээс **Бенжамин Таккер** түүнийг “нэрээрээ биш юмаа гэхэд бүх зүйлээрээ жинхэнэ анархист” гэж хэлсэн нь зарим талаараа үндэслэлтэй.

[72] Хенри Жорж (1839–1897 он): Америк хүн, сэтгүүлч, эдийн засагч [анг. American journalist and economist].
Гол үзэл санаа: Газрын үнэ цэнийн татвар^[13]. **Гол бүтээл:** *Хөгжил Дэвшил, Ядуурал* [анг. *Progress and Poverty*] (1879 он).

8 *voluntaryism*

9 *Free Life*

10 *republican government*

11 *principle of self-ownership*

12 *rights of ownership in other men*

13 *Land value tax*

Хенри Жорж ажлын гараагаа усан онгоцны хүү^[14], хэвлэгчийн туслахаар эхлүүлжээ; гэвч тэрбээр өөрөө эдийн засгийн ухаанд суралцаж, ахлах сэтгүүлч, дараагаар нь *Хөгжил Дэвшил, Ядуурал* [анг. *Progress and Poverty*] (1879 он) гэсэн бүтээлийнхээ тусаар чухал, алдартай эдийн засагч, шинэчлэгч болов.

Жорж татварлах явдлын ихэнхи хэлбэр өсөлт хөгжлийг саатуулдаг: жишээлбэл орлогын татвар боолчлолын адилаар, хүмүүс ажлын байр бүтээх, ажилд орох явдлыг урамгүй болгох болно гэж батлан өгүүлж байсан. Үүнтэй адилаар импортын тариф хэрэглэгчдийн хувьд үнийг өндөр болгодог бөгөөд үүсэж тогтчихсон байр сууриа олчихсон, монополистч байдалтай компаниудыг өрсөлдөөнөөс хамгаалдаг ажээ. Зөвхөн *газрын үнэ цэнийн татвар* л (**Дэвид Рикардо** тэмдэглэж хэлсэнчлэн) газар тоо хэмжээгээр хязгаартай, газрын “үйлдвэрлэл” татварын нөлөөнд автахгүй учраас нөлөөгөөрөө хоргүй байдаг гэж бодож байв.

Жорж хүмүүс хуульзүйн дагуухь бүрэн эрхтэйгээр өөрсдийн бүтээснээ өмчилдөг боловч тэд газрыг бүтээдэггүй тул байгалийн нөөц баялаг ерөнхийдөө нийт нийгэм буюу хүмүүсийн хүрээлэлд ижил тэнцүү оногдох ёстой гэж батлан өгүүлж байлаа. Үүний хажуугаар чөлөөт зах зээл, чөлөөт худалдаа өргөн олныг ядуурлаас гаргах хамгийн сайн арга зам байдаг ажээ.

[73] Карл Менгер (1840–1921 он): Австри хүн, эдийн засагч. **Гол үзэл санаа:** Эдийн засгийн австри онол; аргазүйн субъективизм, индивидуализм. **Гол бүтээл:** *Эдийн Засгийн Зарчим* [анг. *Principles of Economics*] (1871 он).

Менгер бизнесийн сэтгүүлч болохынхоо өмнө Прага болон Венад суралцаж байв. Энэ үүргээ гүйцэтгэж байхдаа тэрбээр давамгайлж буй, “сонгодог” эдийн засаг^[15] болон бодит амьдрал

14 *ship's boy*-

15 *mainstream, 'classical' economics*

дээр зах зээл ажиллах явдлын хооронд үл нийцэл байгааг олж харжээ. Тиймээс 1867 онд тэрбээр [судалгааны] шинэ хандлагынхаа тухай *Эдийн Засгийн Зарчим* [анг. *Principles of Economics*] (1871 он) гэсэн шинэ бүтээлээ бичиж эхлэв. Дөнгөж 33 настай залуухан байхдаа тэрбээр Венийн Их Сургуульд эдийн Засгийн Онолын Тэнхимийн эрхлэгч болсон байна. Түүнийг өнөөдөр Эдийн Засгийн Ухааны Австри Сургуулийн үндэслэгч гэж дурсдаг.

Менгер сонгодог эзийн засагчид бараа бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл эсвэл тэдгээрийн нийт эрэлт зэрэг эд зүйлийн нийт бүхэл хуримтлалд анхаарал төвлөрүүлэхдээ алдсан гэж бодож байв. Энэ явдал эдгээр нийт дүнтэй зүйлийн хоорондохь ('тэнцвэрт байдал' зэрэг) механик холбоосыг хий хоосон эрж хайх шалтгаан болжээ. Тэрбээр үүнийг *аргазүйн коллективизм*^[16] гэж нэрлэсэн. Эдийн засгийн амьдралыг жинхэнээсээ хөдөлгөдөг зүйл бол хувь хүмүүс хувь бараа бүтээгдэхүүнийг хэрхэн үнэлж цэгнэж буй, тэд тэдгээр үнэ цэнийн дагуу хэрхэн үйл хийж буй явдал юм гэдгийг сахин хамгаалж байсан. Тиймээс эдийн засгийн ухаан үнэ цэнэ, хувь хүмүүсийн үйлдлээс эхлэх ёстой – судалгааны энэхүү хандлагыг тэрбээр *методологийн буюу аргазүйн индивидуализм*^[17] гэж нэрлэжээ.

Энэхүү шинэ арга барилын гол хэсэг нь *субъективизм* байсан. Олон эдийн засагч бараа бүтээгдэхүүний үнэ объектив байдлаар хэмжигдэхүйц зүйл гэж бодож байлаа – түүний үнэ нь түүнийг үйлдвэрлэхэд орсон хөдөлмөрийн тоо хэмжээ гэж бодож байв. Менгер бараа бүтээгдэхүүнд ерөөсөө өөрт нь дотоод үнэ цэнэ^[18] гэж байдаггүй гэж үүнийг эсэргүүцсэн: *хувь хүмүүс тусгай хэрэгцээ болон илүүд үзэж чухалчлах байдлаасаа хамааруулж тэр бараа бүтээгдэхүүнийг өөрийнхөөрөө үнэ цэнэ (ялгарах үнэ цэнийг)-ийг тогтоодог ажээ. Бид одоо үүнийг үнэ цэнийн тухай*

16 *methodological collectivism*

17 *methodological individualism*

18 *inherent value*

субъектив онол гэж нэрлэдэг.

Судалгааны эдгээр арга барил буюу хандлага Менгерт (одоо давамгайлж буй эдийн засгийн ухааны гол зарчим болсон) хязгаарын ашигт байдлын тухай үзэл санаа¹⁹гаа амин чухал бараа таваар болох ус яагаад ерөөсөө бараг хэрэгцээгүй зүйл болох алмаазнаас илүү бага үнэлэгддэг тухай сонгодог парадокс зөрчилтэй байдлыг шийдвэрлэж хөгжүүлэх боломж олгосон. Тэрбээр үнэ цэнэ бараа бүтээгдэхүүний өөрийнх нь чанараас зөвхөн хамаардаггүй мөн бидэнд олдоцтой байгаа тоо хэмжээнээс хамаардаг гэдгийг харуулав.

Менгерийн индивидуализм болон субъективизм нь түүнийг (мөн **Лүдвиг фон Мизэс, Ф. А. Хаек** зэрэг Эдийн засгийн ухааны Австри сургуулийн дагагч нарыг) интервенционизмийг үгүйсгэхэд хөтөлсөн: эдийн засаг бол түүнийг чирч явдаг машин биш харин харилцан тохиролцох үйл явц ажээ. Капитализм хүмүүсийг бусдад үйлчилж хөгжиж цэцэглэх боломжоо эрэлхийлэх явдлыг нь урамшуулдаг гэдгийг ажиглаж мэдсэн. Интервенц буюу хөндлөнгөөс оролцох явдал энэхүү хамтран ажиллах явдлыг тасалдуулж, ингэхдээ үл таарах байдлыг бүрдүүлэн улам л их интервенц хийхийг шаардахад хүргэж, дээр нь бүр л ихээр түүнийг бусниулж эвддэг ажээ.

[74] Брюс Смит (1851–1937 он): Австралийн улстөрч, зохиогч. **Гол үзэл санаа:** Консерватив, либерал уламжлал; интервенц хийж буй төр засгийг эсэргүүцэх явдал. **Гол бүтээл:** *Чөлөөт байдал болон Либерализм [анг. Liberty and Liberalism (1887)].*

Төв Лондонтой ойрхон Ротерхитийн Инглиш боомтод төрсөн ч Смитийн гэр бүл Мелбурн рүү цагаачлахад тийш явжээ. Тэрбээр эцгийнхээ усан онгоцны тээврийн бизнес рүү буцаж орохынхоо өмнө Нью Сөүт Вэйлсийн хууль тогтоох байгууллагын

19 *idea of marginal utility*

гишүүн байсан бөгөөд тэр бизнэсээ 1887 онд маргааны улмаас [нотолгоо олдсоны дараа] өв залгамжлахаас татгалзсан. Тэрбээр хуулийн ажлаа үргэлжлүүлэн хийсэн бөгөөд Холбооны хууль тогтоох байгууллагын гишүүн болов (1901–1919 он). Бизнес хийхдээ тэрбээр хөдөлмөрийн эвлэл [үйлдвэрчний эвлэлтэй]-тэй гэрээнд хүрэхийг эрэлхийлж байсан бөгөөд Викториа мужийн Эвлэрүүлэх Зөвлөл^[20]ийг байгуулсан – гээд мөн тэрбээр Нью Сөүт Вэйлс болон Викториагийн ажил олгогчдын холбоог байгуулжээ.

36 насандаа Смит Австралид либерализмын анхны том судалгаа болох *Чөлөөт байдал болон Либерализм* [анг. *Liberty and Liberalism*] (1887 он)-аа бичсэн. Том хэмжээтэй, агуулга арвин энэ номд философи, улстөрийн ухаан, эдийн засгийн ухааны Англи, Франц, Америкийн либерал болон консерватив уламжлалыг нягталж үзжээ. *Төр Засгийн Шударга Бусаар Хөндлөнгөөр Оролцох Улам Нэмэгдэж Буй Ерөнхий Хандлагатай Хувь Хүний Эрх Чөлөө, Хувийн Аж Ахуй Эрхлэлт, Өмчийн Эрхээр Тэмцэх* [анг. *A Protest against the Growing Tendency toward Undue Interference by the State, with Individual Liberty, Private Enterprise and the Rights of Property*] гэсэн урт, дэд гарчгаараа Смит өөрийнхөө “хууль тогтоох явцад саад болох^[21]”-ыг илүү ихээр шаарддаг “шинэ” либералууд эсрэг тэмцэхийг зорьсон. Спенсер, волантарийзм, Манчестер Либерализмийн нөлөөнд автсан тэрбээр амьдралынхаа туршид чөлөөт худалдаа, лэзе-фээрийн төлөө маргаж мэтгэлцэж байв. Мөн тэрбээр эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хүчтэй дэмжигч, Цагаан Австрали бодлог^[22]ын шүүмжлэгч байжээ.

[75] Бенжамин Таккер (1854–1939 он): Америк хүн, нийтлэгч, индивидуалист анархист, эгоист. **Гол үзэл санаа:**

20 *Board of Conciliation in the state of Victoria*

21 *meddling legislation*

22 *White Australia policy*

Анархизм; өмчийн эрх; хувийн эрх чөлөө; дүрэм журам, зохицуулалт болон төрийн хяналт хязгаарлалтыг зогсоох.
Гол бүтээл: *Эрх чөлөөт байдал* [анг. *Liberty*] (1881–1908 он).

Таккер Массачүсеттсийн Технологийн Инститүцэд суралцаж байхдаа анархист үзэл бодолтой нүүр тулж танилцав. Тэрбээр мутуалист^[23] Пиерр-Жозеф Прүүдон (1809– 1865 он), индивидуалист анархист Макс Стирнер (1806–1856 он), **Херберт Спенсер, Лисандер Спүүнер** зэрэг радикал сэтгэгчдийн ном болон нийтлэлийг орчуулах, хэвлүүлэх ажилдаа оржээ. 1881-ээс 1908 оны хооронд тэрбээр *Либерти* гэдэг нэр нөлөөтэй анархистч сэтгүүл хэвлүүлж байсан. Мэргэжлийнхээ замналын үеэр тэрбээр индивидуалистч анархизмын өөрийн урсгалыг хөгжүүлэв.

Хэдийгээр өөрийгөө “социалист” гэж нэрлэдэг ч гэлээ тэрбээр аливаа хамтач засаг захиргааны эрх дарх^[24]ны үзэл санаанд дайсагнадаг байсан. Тэрбээр ‘анархист ажилчид^[25]’ өөрийн хөдөлмөрийн үр шимийг эзэмших ёстой, тэд үүнийгээ зах зээл дээр эрх мэдэл болон давуу эрхээр солилцох эрхтэй, боломжтой байх ёстой гэж бодож байжээ. Тэд бүр “үрэлгэн байх, ром дарс, гэрлэлт, бие үнэлэлт, буруу гэж итгэж болох олон бусад хэрэг явдал”-аар үүнийгээ наймаалалцах эрх чөлөөтэй ... ажээ

Гэвч энэ явдал нь зах зээлийн хэд хэдэн ‘монополь байдал’-ыг, үүн дотроо банкны зохицуулалт^[26] (тэрбээр мөнгө хүүлэлтийг хорьдог, санхүүгийн зардлыг өсгөдөг гэж хэлсэн), газар (энэ нь зөвхөн жинхэнээсээ эзлэн сууж буй, түүнийг ашиглаж буй хүмүүс л өмчлөх эзэмших эрхтэй ёстой), тариф (импортолж, хэрэглэгчдийн өртгийг өсгөдөг зардал) мөн зөвшөөрөл буюу

23 *mutualist*-Мутуализмыг баримтлагч хүн

24 *collective authority*

25 *anarchistic workers*

26 *bank regulatioen*

патент (нэгэнт л үзэл санаа нь бодит өмч биш тул чөлөөтэй хүмүүс авах ёстой учраас)-ыг дуусгавар болгоно гэсэн үг билээ. Тэрбээр мөн батлан хамгаалах, болон аюулгүй байдлын төрийн монополь байдлыг хоорондоо өрсөлдөж буй ханган нийлүүлэгчдийн чөлөөт зах зээл [илүү дээр хангана гэж үзэн] эсэргүүцэж байсан.

Амьдралынхаа сүүлээр эд баялаг нэг дор хуримтлагдах, улстөрийн мэдэл нэг дор цугларах, өргөн олноороо нийгмийг индивидуалист бус болгох зэрэг зүйлийг олж харж Таккер илүү гутранги болсон. Гэвч түүний үзэл санаа хорьдугаар зууны **Муррэй Ротбард** болон бусад анархи-капиталистуудад урам зориг өгчээ.

[76] Волтайрин де Клейре (1866–1912 он): Америк хүн, анархи-феминист. **Гол үзэл санаа:** Анархизм; жендерийн үүрэг болон гэрлэлтийн тухай шүүмжлэл. **Гол бүтээл:** *Үйлдэл Даруй Хийх [анг. Direct Action] (1912 он).*

ДеКлэйретөрийн бүрэнэрх, СүмХийд, гэрлэлтийг эсэргүүцдэг бүтээл арвинтай яруу найрагч, эссэчин, яриа хийгч байжээ. Энэ бүсгүйг эсэргүүцлийн хөдөлгөөнийхэн хамгийн ихээр эшлэдэг *Үйлдэл Даруй Хийх [анг. Direct Action] (1912 он)* гэсэн эссэгээр нь хамгийн ихээр дурсдаг.

Мичиганд ядуу зүдүү байдалд төрсөн түүнийг эцэг нь Францын либерал үзэлтэн Волгаирын нэрээр нэрлэжээ. Католик боловсрол нь түүнийг атеизм руу хөтөлсөн бөгөөд тэр бүсгүй **Томас Пэйн, Томас Жефферсон, Мэри Воллстөункрафт** (түүний тухай бичиж, лекц уншиж байсан), **Лисандер Спүүнэр, Хэнри Дэвид Төрүз, Либерти** сэтгүүлд нь нийтлэл бичиж байсан **Бенжамин Таккэр** зэрэг либералчууд, анархистуудын нөлөөнд автжээ. Амьдралынхаа сүүлээр энэ бүсгүй төр засаггүй үл хүчирхийлдэг аливаа төр засгийг хамгаалах ёстой тогтолцоо гэж

ойлгож мутуализм^[27] руу эргэсэн боловч “тэмдэг нэрээр ялгах аргагүй анархист^[28]” байдалтай дуусжээ.

Төрийн бүрэн эрх^[29]ийг үгүйсгэх явдал нь ажил хаялтад оролцсон цугласан олон руу өмнө цагдаа нар буудсаныг анархистууд эсэргүүцэж байхад Чикагогийн Хэймаркэт Талбайд болсон эмгэнэлт явдлаас болж гүнзгийрчээ. Цагдаа нар гар бөмбөг шидсэн хэд хэдэн хүнийг анархист гэж буруутган баривчилсан бөгөөд тэдэнд цаазлах ял оноосон. Де Слейре үүнийг засаг захиргааныхны явуулсан, улстөрийн гэмгүй өрсөлдөгчдөө алсан, шүүх засаглалын аллага гэж ойлгож байв.

Де Слейре мөн л феминист байлаа. Тэрбээр эрт нийгэмшүүлэх явдал охидыг хязгаарлаж, хөвгүүдийг өөгшүүлж хүүхдүүдийг жам ёсны бус жендерийн үүрэг^[30]т албадаж байгаа тухай батлан өгүүлж байсан. Үр дүнд нь гэрлэлт эмэгтэйчүүдийг өөрөө хүсээгүй боол болгосон байна: эрчүүд болон эмэгтэйчүүд үүний оронд амьдралаа чөлөөт бодгаль байдлаар явуулах ёстой ажээ. Гэвч тэрбээр нийгмийн болон иргэний дэг журмыг ‘энэ бол дэг журмыг инээдэм болгосон, шударга ёсыг ханиадам болгосон зүйл’, хүйсийг хоёулыг нь дарангуйлдаг гэж үзэн өөрийгөө анархист гэж үздэг байжээ. Үүний шийдэл нь зөвхөн эмэгтэйчүүдийг биш бүх хүмүүн төрөлтнийг эрх болон боломжийг өргөсгөх явдал^[31] байв.

‘Би яаж ч амьдарсан үхнэ’ гэж эхлээд “чөлөөтэй сэтгэл зүрхтэйгээр, анархист үзэлтний хувиар, бурхны эсвэл жирийн удирдагчид үл захирагдсан байдалтайгаар үхэх болно” гэж үхэхийнхээ өмнө бичиж байжээ.

27 *mutualism*-Энэ нь хамтач болон индивидуалист анархимзыг холбоос болдог. Учир нь энэ нь хамтын өмчлөл болон хувийн өмчийн хэлбэрийг магтан дуулдаг.

28 *anarchist without adjectives*

29 *state authority*

30 *unnatural gender roles*

31 *empowerment*

[77] **Алберт Ж. Нокк** (1870–1945 он): Америк хүн, либертари зохиогч. **Гол үзэл санаа:** Стэтизмийн-эсрэг хурц ширүүн үзэл; төр нийгмийн байр байдлын эсрэг зүйл болох нь. **Гол бүтээл:** *Бидний Дайсан, Төр* [анг. *Our Enemy, The State*] (1935 он).

Өнөөдөр ч тэр цаг үеийнхийгээ бодвол тийм ч их алдартай биш энэ бичгийн хүн^[32] Нокк индивидуалистуудын бүтэн үеийг сэрээж, индивидулист бүтээл туурвилыг хөглөж байв. Гэрээр боловсрол олсон, гангийн үйлдвэрийн ажилчны хүү, гэгээрсэн ламтнаар ажиллаж асан тэрбээр либерал, капитализмыг-дэмжигч, дайны эсрэг сэтгүүл болох *The Nation* сэтгүүлийн эрхлэгч болсон бөгөөд *The Freeman* сэтгүүлийн үндэслэгч билээ. Эдгээр ажлаа эрхлэхдээ тэрбээр **Сузанн Ла Фоллетт**ыг олж нээж дэмжиж тусалдаг байв. Хожим нь *Хүмүүний Үйл Явдал, Үндэстний Судалгаа* [анг. *Human Events, National Review*] сэтгүүл, мөн *Индивидуалистуудын Коллеж Хоорондын Нийгэмлэг* [анг. *Intercollegiate Society of Individualists*] гэдэг байгууллагыг шүтэгч нар нь үүсгэж байгуулж байлаа.

Ноккийн нийгэм жам ёсны эрх чөлөө буюу чөлөөт байдал дээр үндэслэсэн, төрийн улстөрийн нөлөөнөөс ангид байх ёстой гэж шаарддаг “радикал анархист” хандлагыг нь **Муррэй Ротбард** болон бусад либертаричууд цааш үргэлжүүлсэн. Тэрбээр Зах зээл болон нийгэм төгс бус байхад төр иргэншил болон ёс суртахуунт байдлыг сайжруулж чадахгүй гэж шаргуу ятгаж байв. Үнэндээ төр юмсыг улам л муутгадаг байж болох юм.

Төр бол ‘эзлэн түрэмгийлэх, булаан авах гарцаагүй гарал үүсэлтэй учраас үндсээрээ анти-социал буюу нийгмийн эсрэг зүйл юм гэж *Бидний Дайсан Төр* [анг. *Our Enemy, The State*] (1935 он) бүтээлдээ тайлбарласан нь бий. Түүний өөртөө байхыг зөвшөөрдөг цор ганц эрхээ өөрөө өөртөө баталгаажуулан авчээ.

Энэхүү давамгайллага хүчитгэхийн тулд төр шүүх ажлыг хэцүү, зардал ихтэй болгосон бөгөөд өөрийгөө хуулийн дээр тавьсан: жишээлбэл өөрөө монополь байгаа хэрнээ төр монополь эрхийг хориглосон байдаг. Төр бусад эрх чөлөө эдийн засгийн эрх чөлөөгүй бол байх боломжгүй учраас түүнийг дарж дарангуйлдаг. ‘Төрийн эрх мэдэлд өөрийнхөө төлөө юм хийлгэх гэж өгсөн эрхийн тэр хэмжээгээр’ гэж тэрбээр эхлээд ‘та нар төрд өөрт чинь ямар нэг юм хийх тэр эрх мэдэл өөрсдөө өгчихдөг’ гэж сануулж болгоомжлуулж байжээ. Төр сул байх тусмаа түүнд гэмт хэрэг үйлдэх эсвэл “коллективизм, империализм, национализм, далбаанд мөргөх^[33]”-ийн муу талуудыг тэтгэдэг дайн өдөөх бага л эрх мэдэл байх болно.

Нокк 1920-оод оны АНУ-ын засаг захиргааг зээл дээр зээл овоолж Их Хямралыг бүтээсэн гэж буруутгаж байв – дараагаар нь энэ нурултыг зогсоох гэж “бүр их татаас шахсан” ажээ. Тэрбээр мөн “Шинэ Бодлого”-ыг төрийн эрх мэдэл болон хяналтыг өргөжүүлэх урьдач ажил гэж үгүйсгэж буруутгасан бөгөөд үүнийг түр зуурын гэж сурталчилж байгаа ч гэсэн байнгын зүйл болно анхааруулж байжээ.

Тэрбээр төвлөрөл, дүрэм журам буюу зохицуулалт, орлогын татвар, төрийн халамж, албадлагын боловсролыг эсэргүүцдэг байсан. Төрийн боловсрол бол төрийг шүтэх хортой шүтлэг, үзэл санаа, зан үйл, амьдралын хэвмаяг, итгэл үнэмшлийг нэг зүйл болгох явдал^[34] гэж гомдоллож байв: энэ нь боловсрол гэхээсээ илүүтэй *сургалт дадлагажуулах ажил* ажээ. Төрийн халамж бол хүмүүсийг зардлыг нь өөрөө биш харин бусад хүмүүс төлж буй гэж сэтгэхэд хүргэдэг хууран мэхлэлт юм. Орлогын татвар бүр анзаарахааргүй тийм ерийн зүйл болсон зэвүүцмээр үр дүнтэй зүйл ажээ.

Нокк эрх чөлөөний ирээдүйд гутранги хандаж байсан бөгөөд өөрийгөө төр болон нийгмийн мөн чанарыг ойлгодог, өнөөгийн

33 *flag-worship*

34 *uniformity*

тогтолцоог нураахаар нөлөөгүй цөөнхийн нэг ‘үлдэгдэл’ гэж ойлгож байлаа. Тэр болтол хамгийн сайн явах чиглэл бол өөрийгөө өөрсөдтэй нь санал нийлдэг аугаа үзэл санаа, хүмүүсээр хүрээлэх явдал гэж тэрбээр санал болгож байв.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: ЧӨЛӨӨТ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ

Арванесдүгээр зууны төгсгөл, хорьдугаар зууны эхээр эдийн засгийн салбарт олон ч хөгжил дэвшил гарав. Эдийн засагчдын бат итгэл нэмэгдэхийн хэрээр олон нь тэдний салбар байгалийн ухааныхтай адилхан зүйл гэж ойлгодог болж ирлээ. Тэд эдийн засагчид эдийн засгийн хэрэг явдлыг эгээ л физикч байгалийн юмс үзэгдэлтэй хандахтай үйлддэг шигээр урьдаас таамаглаж, төлөвлөж, хэлбэржүүлж явуулах боломжтой гэдэгт итгэх болсон. Либералууд ‘шинжлэх ухаанч’ социализм, төвлөрсөн төлөвлөлт, аж үйлдвэрлэлийн төрийн хяналт зэрэг шинэ сорилттой нүүр тулав.

Индивидуализм, лэзе-фэерд тулгуурладаг либерализм улам бүр л үеэ-өнгөрөөсөн, тохиромжгүй гэж харагдах болжээ. Орос, Хятад, бусад улс коммунизмаар замналаа – тэр улсуудыг өөрийнхөө улс орны гайхалтай, зоригтой, рационал загвар гэж хардаг Өрнөдийн сэхээтнүүд коммунизмыг бүрэн дэмжиж байв. Өрнөдийн улсуудад ч Дэлхийн II Дайнд ялалт байгуулсан үүнтэй адилхан коллективизм буюу хамтач үзэл одоо “энх тайвны үед ялсаар л байв” – халамж, орон сууц, боловсрол, ажил бүх хүнд олгож ялалт байгуулж байлаа.

Либералуудын социализмыг шүүмжлэх шүүмжлэл социализмын урагшлах хөдөлгөөн эсвэл түүний сэтгэл татам байдлыг эсэргүүцэхэд багахан л зүйл хийлээ. Хэдхэн үлдэж хоцорсон либералчууд **Ф. А. Хаекийн** Мон Пелерин Нийгэмлэг зэрэг аюулгүй хорогдох байрандаа цугларч Либерализмийн галаа манаж байв. Тэд бүгдийн хийж чадах зүйл иймэрхүү коллективист туршилтаас гарна гэж тэдний таамагласан гайтай, аймшигтай үр дагавар жинхэнээсээ өөрөө илэрхий болж гарч ирэхийг нь хүлээх л байсан юм. Энэ үеэрээ тэд хурдтай өөрчлөгдөж буй

дэлхийн бодит байдалтай илүү нийцсэн, үйл явдал өөрөөр эргэх үед бэлэн байлгах гэж шинэ либерал хандлагаа хөгжүүлэх гэж ажиллах болно.

[78] Лүдвиг фон Мизес (1881–1973 он): Австри хүн, эдийн засагч. **Гол үзэл санаа:** Эдийн засгийн австри байдал; зохицуулалт дүрэм журмын эсрэг гаргалгаа нотолгоо; социалист тооцоо хийх боломжгүй байдал; бизнес мөчлөг; хатуу валют^[1]. **Гол бүтээл:** *Мөнгө, Зээлийн Тухайн Онол* [анг. *The Theory of Money and Credit*] (1912 онол); *Социализм* [анг. *Socialism*] (1922 он); *Либерализм* [анг. *Liberalism*] (1927 он); *Хүмүүний Үйлдэл* [анг. *Human Action*] (1949 он).

Мизес цаг үеийнхээ хамгийн их нөлөөтэй, либерал эдийн засагч, улстөрийн эрдэмтдийн нэг байжээ. Тэрбээр эдийн засгийн ухааны Австри Сургуулийн хошуучлагч зүтгэлтэн болжээ – тэрбээр олон бусад хүнд, үүн дотроо **Ф. А. Хаек, Муррэй Ротбард** нарт нөлөөлсөн байдаг.

Мизес чөлөөт зах зээл, хөдөлмөрийн хуваарь, чөлөөт солилцоо тогтвортой хөгжил цэцэглэлтийг л бий болгох эдийн засгийн цор ганц механизм гэж батлан өгүүлж, лэзе-фэерийн бат нот гаргалгаа нотолгоог гаргасан. Төр засаг зах зээлийн эдийн засгийг саатуулж бусниулж эхлэхдээ засаж залруулахад нь улам л их интервенц шаардлагатай болох илүүдэл болон хомсдол үүсгэж, тэдгээрээс нь гажуудлын олон давлагаа бий болно. Эдгээр нь эргээд эцэстээ нийт зах зээлийн үйл явцыг боомилж дуусгах хүртэл улам л их үйлдэл хийхийг шаарддаг бусад хүсүүшгүй үр дагавартай байдаг. Энэ явдал эргээд нэгэнт эрх чөлөө хувийн өмч, чөлөөт худалдаанд тулгуурладаг тул мөн нийгмийн либерал дэг журмыг ганхуулах болно. Төр засаг тийм учраас ерөөсөө интервенц хийхгүй буюу хөндлөнгөөсөө

1 *hard currency*

оролцохгүй байх ёстой ажээ.

Мизэс эдийн засагчийнхаа амьдралаа (Ф. А. Хаекийн адилаар) аядуу социалист үзэлтнээр эхлүүлсэн. Гэвч тэрбээр **Карл Менгерийн Эдийн Засгийн Зарчим** [анг. *Principles of Economics*] (1871 он)-тэй таарч уншсанаар үзэл бодлоо үндсээр нь өөрчилжээ. Тэрбээр Карл Менгерийн *методологийн буюу арга барилын индивидуализм* болон *субъективизмийг* авч хөгжүүлээд зүйтогтолжуулсан билээ. Давамгайлж буй эдийн засагчид^[2] *коллективист* буюу *хамтач ёсны* хандлагаасаа болж бүтэлгүйтдэг гэж батлан өгүүлж байлаа. Байгалийн ухааны амжилтыг хуулбарлахыг оролдох, гэхдээ тэд агрегатан эрэлт, агрегатан нийлүүлэлт, үнийн төвшин зэрэг хэмжээсийн хоорондохь механик холбоог энэ мэдлэгээ эдийн засгийн илүү “рационал” тогтолцоог төлөвлөхөд ашигладаг мэдлэг гэж найдан эрж хайж байжээ. Гэвч үнэндээ зөвхөн статистик мэдээллийг бүлэглэх л явдал болох эдгээр зүйлийн хоорондохь шинжлэх ухаанч харилцан хамаарал байдаггүй. Бодитой хувь зүйлс нэг нэгэндээ нөлөөлөх боломжтой байдаг бол статистик мэдээлэл хэзээ ч нөлөөлөх боломжгүй гэж тэрбээр батлан өгүүлдэг байсан. Үнэндээ маш ондоо бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг жишээлбэл алим, тоосго, үсчин, бяслаг, гутал, шилэн хэрэгсэл, кассын машин, автобусны аяллыг хамтад бөөгнүүлж цуглуулбал эдгээр агрегат зүйлс ард нь юу болж буйг зөвхөн халхалж дардаг ажээ. Үнэндээ агшин бүрд нэг бүр нь өсөж эсвэл буурч байдаг, зөвхөн сая сая хувь үнэ байх үед жишээлбэл “үнийн төвшин” гэж ярих нь утгагүй тэнэг хэрэг юм.

Эдийн засгийн амьдралыг жинхэнээсээ хөдөлгөдөг зүйл бол олон янз хувь хүмүүсийн сая сая тусгай үнэ, үйлдэл юм гэж хэлсэн нь бий. Гэвч хүмүүний үнэ цэнийг томъёогоор хэмжих, тооцоолох боломжгүй. Хүмүүс өөр өөр байдлаар эдийн засгийн өөрчлөлтөд хариу үйлдэл хийдэг: элсэн чихрийн үнэ өсөхөд зарим хүмүүс үүнийг яаравчлан худалдаж авах бол бусад нь

2 *Mainstream economists*

түүнийхээ хэрэглээг бууруулдаг ч байж болно. Бид тэр хүмүүс маргааш ямар үйлдэл гаргахыг нь урьдаас таамаглаж чадахгүй.

Энэхүү үзэл санааг эдийн засгийн янз бүрийн юмс үзэгдэлд зүйтогтолтойгоор хэрэглэснээр Мизэс маш олон шинэ гүнзгий мэдлэг³⁾ олж авчээ. Давамгайлж буй эдийн засагчдад жишээлбэл мөнгө *солилцооны* амьгүй *орчин* байсан. Харин Мизэсийн хувьд мөнгө хэрэгтэй байдгийнхаа төлөө бусад зүйлсийн адилаар үнэлэгдэж цэгнэгддэг эдийн засгийн бараа ажээ. Мөнгөний үнэ (ө.х. түүний бусад бараа бүтээгдэхүүний утгаар *худалдан авах чадвар*⁴⁾)-ийг эдийн засгийн бусад аливаа бараа бүтээгдэхүүний үнийг тодорхойлдог зах зээлийн тэр л нэг хүч тодорхойлдог ажээ. Хүмүүс гарынхаа ойрхон байлгахаар (жишээлбэл түрүүвч эсвэл банкны дансандаа) сонгож авсан мөнгөний тоо хэмжээ тэр хүмүүс ирээдүйн худалдан авалтад мөнгө хэр зэрэг хэрэгтэй гэж бодож буйгаас хамаардаг. Тэр хүмүүс үүнийг илүү их хэрэгтэй гэж үзэж байвал мөнгөний худалдан авах чадвар өсөх болно; илүү бага хэрэг болно гэж бодвол түүний худалдан авах чадвар буурна. Хувь хүний үнэ цэнэ, болон үйлдлийн талаархи энэхүү гүнзгий мэдлэг бидэнд давамгайлж буй эдийн засагчид *методологийн коллективизмаасаа* болж хэзээ ч ухаж ойлгодоггүй инфляцийн тухай хэлж өгдөг.

Бизнес мөчлөг бол үүний өөр нэг жишээ нь юм. Мизэс, Хаек хоёр эдгээр огцом өсөлт-хямралын үе шатыг төв банкууд эдийн засгийн өсөлтийг тэтгэх гэж оролдсон хялбар зээлийн бодлогоос болсон гэдэг хүртэл нь мөшгөж тогтоосон. Харамсалтай нь зээлийн хүүгийн бага хэмжээний энэхүү *худал дохио* зээллэг авах, зарцуулах, хөрөнгө оруулах явдлыг сумлаж өдөөдөг боловч тэр л зээлийн бага хүү хүмүүсийн хадгалж хураах явдлыг нь урамгүй зүйл болгодог. Хадгаламжгүй буюу хадгалж хураасан зүйл байхгүй бол энэ огцом өсөлтийн санхүүжилт дуусах болно: бизнесүүд хөрөнгө оруулалтынхаа төлөвлөгөөг зогсоож, хүмүүс

3 *insights*

4 *purchasing power*

ажлаасаа халагдах болно. Цаасан мөнгө банканд иймэрхүү сүйрэл дагуулсан циклийг бүтээж цогцлоох хэтэрхий их боломж өгдөг гэж Мизэс бодож байсан. Зөвхөн алт зэрэг хатуу валют^[5] эдгээр үйлдлийг хязгаарлах боломжтой ажээ.

Нэг ижил арга замыг хэрэглэж *Мөнгө болон Зээлийн Онол* [анг. *The Theory of Money and Credit*] (1912 он)-дээ Мизэс хөрөнгө болон зээлийн хүүгийн байр байдлыг илүү сайн ухаж ойлгох боломж мөн олгосон. *Хүүгийн хэмжээ* хадгаламжийн автомат “ашиг” биш гэдгийг сахин хамгаалж байв. Харин энэ нь илүүтэй *ирээдүйгээ* зээллэгт оролцож буй хүмүүс хэрхэн үнэлж цэгнэж буйгаас хамаардаг байна – энэ нь хүмүүс өнөөдрийнхөө хэрэглээнээсээ маргаашийнхаа үйлдвэрлэлийг огцом нэмэгдүүлэх боломжтой загасны тор, анжис хэрэглэл, машин бүтээхийн тулд татгалзах нь өгөөжөө өгнө гэж бодсон эсэхээс хамардаг ажээ. Энэхүү дундын буулт хийх цэг *цаг хугацааны* маш чухал ач холбогдлыг, хүмүүс түүнийг хэрхэн үнэлж цэгнэж буйг, бас бүх эдийн засгийн тооцоололд түүнийг чухал болохыг харуулдаг. Гэвч цаг хугацаа, мөн үнэ цэнийг судалгааны давамгайлж буй хандлагад анзааралгүй үл тоодог.

Үүнтэй адилаар зөвхөн статитик дүн мэдээнд анхаарал хандуулснаар давамгайлж буй эдийн засагчид *хөрөнгийг* нэг төрлийн нэгэн жигд ямар нэг зүйл гэж андуу түүнтэй харьцацгаадаг ажээ. Гэвч яг нарийндаа хүмүүс *аль* үндсэн тоног төхөөрөмж^[6]ид хөрөнгө оруулсан нь, ө.х. *хөрөнгийн бүтэц* маш чухал зүйл юм гэж Мизэс шаргуу ятгадаг байсан. Гээд буруу үндсэн тоног төхөөрөмжид хөрөнгө оруулсан, ө.х. *алдаатай хөрөнгө оруулалтын* тоо хэмжээ нийтдээ их эсвэл бага байсан ч зовлонтой зүйл л байх болно. Зөвхөн индивидуалист арга зам л үүнийг ил гаргах боломжтой ажээ.

Социализм [анг. *Socialism*] (1922 он) гэсэн бүтээлдээ Мизэс зах зээл оршихоо больчихвол эдийн засгийн тооцоолол хийх

5 *hard currency*

6 *capital goods*

боломжгүй болдог гэж Мизэс батлан өгүүлсэн. Төрийн өмчлөлд үйлдвэр болон тоног төхөөрөмж зэрэг үйлдвэрлэлийн үрашигтай хэрэгсэл^[7] хэзээ ч түүнийг худалдан авдаггүй эсвэл зардаггүй тул хэзээ ч үнэтэй байх боломжгүй. Оруулга үнэ^[8]гүйгээр бид байж болох олон үйлдвэрлэлийн үйл явцаас аль нь хамгийн хямд болохыг мэдэж чадахгүй. Тиймээс бидэнд тэдгээрийн дундаас сонгох рационал арга зам байхгүй. Гарцаагүй л хэт-өртөгтэй үйл явцыг сонгон авч, нөөц баялгийг муугаар зарцуулна. Үүнээс ялгаатай нь зах зээлийн эдийн засаг үйлдвэрлэгчдэд хамгийн зардал-багатай арга зам^[9]ыг сонгуулахаар өрсөлдөөний дарамт үзүүлдэг – тиймээс энэ нь бусад зорилгод ч амин чухал байдаг нөөц баялгийг хэмнэж, хадгалж үлддэг ажээ.

Энэхүү сүйрэл дагуулахуйц шүүмжлэлийн хариу болгож социалист эдийн засагчид нөөц баялгийг зах зээл “оршиж байсан мэт”^[10]-ээр байршуулдаг “зах зээлийн социализм”^[11] гэдгийг санал болгов; гэвч Мизэс зах зээлийн социализм зөвхөн хэрэв түүнээс хуулбарлах зах зээлийн бодит үнэ байгаа тохиолдолд л ажиллах боломжтой гэж эсэргүүцсэн; социализм улам их өргөн хүрээнд тархахад үйлдвэрлэлийг рационал байдлаар төлөвлөх улам л боломжгүй болно. Социализм зүгээр л өөрөө өөрийгөө боомилж алах болно.

[79] Фрэнк Найт (1885–1972 он): Америк хүн, эдийн засагч, моралистч. **Гол үзэл санаа:** Эдийн засгийн эрх чөлөө бусад эрх чөлөөний үндэс болдог; зах зээл, улстөрийн явц хоёулаа төгс бус; интервенционизм сайн гэхээсээ илүүтэйгээр муу зүйл хийх боломжтой. **Гол бүтээл:** *Эрсдэл, Тодорхойгүй Байдал, Ашиг* [анг. *Risk, Uncertainty and Profit*] (1921 он).

7 *productive inputs*

8 *input prices*

9 *costeffective methods*

10 *'as if'*

11 *'market socialism'*

Франк Найт бол түүний шавь **Милтон Фрийдмэн, Жорж Стиглер, Жэймс Бачэнэн** нар ордог, эдийн засгийн ухааны Чикаго Сургуул^[12]ийн үндэслэгч юм. Мөн тэрбээр Дэлхийн II Дайны дараахь либерал үзэл дахин сэргэх явдлыг манлайлсан, Мон Пелерин Нийгэмлэг (Фрийдмэн, Стиглер, **Лүдвиг фон Мизес, Ф. А. Хаекийн** хамтаар)-ийн үүсгэн байгуулагч гишүүн байжээ.

Найт оюутан цагийн амьдралаа шашин судлал^[13]аар суралцаж эхэлсэн ч гэсэн Корнеллийн эдийн засгийн ухааны докторын зэрэг авч дуусгав. Сонгодог сэдэв болох *Эрсдэл, Тодорхойгүй Байдал, Ашиг* [анг. *Risk, Uncertainty and Profit*] (1921 он)-таа шинэ бараа бүтээгдэхүүн болон үйл явцыг ерөөсөө ойлгох боломжгүй үйл явдлын *тодорхой бус байдал*, мөн ухаж ойлгох боломжтой ч далайц, болон үзүүлэх нөлөөг нь урьдаас нарийн тодорхой таамаглах боломжгүй үйл явдлын *эрсдэл*ээр дамжуулан залж чиглүүлэх ажил хэрэгч хүмүүсийн маш чухал үүргийг нь тодосгож харуулжээ.

Тэрбээр эдийн засгийн эрх чөлөө бидний бусад эрх чөлөөний суурь юм гэж батлан өгүүлж байв. Эрх чөлөө өөрөө зорилго байгаад зогсохгүй мөн бусад үнэт зүйлд хүрэх арга хэрэгсэл байдаг ажээ. Чөлөөт зах зээл тэр эрх чөлөөний амин чухал хэсэг байдаг бөгөөд хүмүүсийн хоорондоо зөрчилддөг алсын бодол буюу амбицыг зохицуулж удирдахдаа бусад тогтолцооноос хамгийн сайн нь байдаг. Гэвч зах зээл хэзээ ч төгс байдаггүй: лэзе-фээр бодлого эдгээр алдаатай байдлыг засахгүй зүгээр л хэвээр нь үлдээх болно гэж анхааруулж байжээ. Бас зах зээл нийгэм, ёс суртахуун, хувь хүний бүх зөрчлийг шийдэж чадахгүй – энэ нь төр засаг эрх чөлөөнд хязгаар тогтооно гэсэн үг юм.

Гэвч энэ байдал улстөрийн зөрчлийг бий болгох болно. Нэгэнт л хүмүүс өөрсдийн санал нийлдэггүй улстөрийн нийгмийг зүгээр л орхиод явах нь тохиромжгүй тул буулт хийх хэрэгтэй болдог. Энэ

12 *Chicago School of economics*

13 *clergy,*

байдал нь үүний тулд эргээд ардчилсан хэлэлцүүлэг, төлөөллийн төр засгийг шаардах болно. Гэвч ардчилал бол зах зээл шиг хоорондоо өрсөлдөж буй ашиг сонирхлуудын хоорондохь дайн бөгөөд зах зээлтэй адилхан олон алдаа дутагдалтай билээ.

Найт улстөр болон эдийн засгийн явц *хоёулаа гажигтай* байдаг учраас улстөрийн бүр сайн-зорилготойгоор зах зээл рүү хөндлөнгөөс оролцох нь юмс үзэгдлийг улам л хялбархан муутгах болно гэж дүгнэсэн. Бид тодорхой хүндрэл бэрхшээл гарах, амжилт гарах нь ойлгомжтой биш л бол хөндлөнгөөс оролцох ёсгүй. Бас бид хэрэв ийм зүйл тохиолдвол үйл хийхээс татгалзах ч ёсгүй. Гэвч бидэнд нийгмийн асуудал бүрд шийдэл байдаггүй гэдгийг маш сайн ухаарч мэдэх хэрэгтэй.

[80] Изабел Патерсон (1886–1961 он): Канад-Америкийн сэтгүүлч, роман туурвигч, шүүмжлэгч, анархист философич. **Гол үзэл санаа:** Хуулиар боомилогдсон бүтээлч байдал; дүрэм журам, зохицуулалт хүчирхэг бизнесийг тэтгэж, монополь байгууллагуудыг бий болгодог. **Гол бүтээл:** *Машины Бурхан [анг. The God of the Machine] (1943 он).*

Изабел Патерсон, **Рөүз Вилдег Лэйн, Айн Рэнд** нарыг Америк либертанианизмийн гурван “эх” гэж дурсдаг. Патерсон Онтариогийн алслагдмал Манитүүлин Арал дээрхи гэр бүлийн есөн хүүхдийн нэг болж төрсөн бөгөөд (Лэйний адилаар) голчлон өөрөө-боловсролтой болж, өсвөр насандаа олон янзын бага-цалинтай ажил, үүн дотроо үйлчлэгч, нярав, стенографч зэрэг ажил хийж байжээ. Тэрбээр 1910 онд гэрлэсэн боловч (дахиад л Лэйний адилаар) хожим нь арав хүрэхгүй жилийн дараа салав. Тэр бүсгүй АНУ-д ном бичиж, редактор хийх ажил хийсэн бөгөөд хурдан тушаал дэвшсээр, хурц ухаанаараа алдаршсан, нэр нөлөөтэй утга зохиол шүүмжлэгч болов. Мөн тэрбээр вестерн болон түүхэн роман бичиж байжээ.

Тэрбээр 1943 онд хэвлүүлсэн *Машины Бурхан* [анг. *The God of the Machine*] (Лэйн Эрх Чөлөөг Олж Нээсэн нь бүтээлээ гаргасан тэр жил) нь индивидуалист философийн суурь болсон ном болжээ. Түүндээ тэрбээр яагаад зарим улс орон хөгжиж цэцэглэсэн хэвээр байсаар байхад зарим нь ядуурч доройтдог вэ гэсэн зүйлийг нягталж мөшгөлөө. Түүний хариулт нь эхэнд нь дурдсан улсуудын эдийн засгийн болон хуульзүйн зарчим хувь хүмүүсийн бүтээлч байдал цэцэглэн хөгжих боломж олгодог гэсэн дүгнэлт байв. Ромын Эзэнт Гүрэн тэлж томорсон нь цэргийн хүч чадал биш харин бүтээлч байдлыг чөлөөтэй болгодог түүний нээлттэй институт, арилжаа худалдаа, нийгмийн хөдөлгөөнт байдал^[14] л нөлөөтэй байсан гэж батлан өгүүлсэн.

Патерсоны хувьд монополизм байгууллага төр засгаас олгосон давуу эрхээс голчлон үүсэж гардаг ажээ. Монополийн эсрэг хуул^[15]ийг муу нөлөө үүгээр дуусчихдаггүй. Үнэндээ хямд үйлдвэрлэгчдийг “үнийн араатанлаг бодлого^[16]” явууламтгай гэж буруутгах, харин зардал их үйлдвэрлэгчийг “үнэ хөөрөгдөгч” гээд, бас ижил үнээр зардгийг нь “үнэ тогтвортой баригч” гэж буруутгах боломжтой байдаг ч улстөрийн холбоотой, аль хэдийнээ үүсэж тогтчихсон компаниуд тэдний өөрсдийн давуу тал болгож эдгээр гаргалгаа нотолгоог өөртөө хамгийн сайнаар эргүүлэх бололцоо олгоно.

Бид бодлогыг зорилгоор нь биш харин үр дүнгээр нь үнэлж цэгнэх ёстой: ‘Дэлхий дээрхи муу явдлын ихэнхийг нь сайн хүмүүс үйлдсэн. Гэхдээ үүнийгээ санамсаргүй, үл анзаарч эсвэл харалгүй өнгөрч үйлдэж байсангүй’^[17] гэж тэрбээр бичиж байв. ‘Энэ бол тэдний сайн зорилгод зорьсон дээд үзэл санаагаар сэдэлжсэн, удаан хугацаанд шаргуу үйлдсэн, тэдний зориудын үйлдлийн үр дагавар юм’.

14 *social mobility*

15 *Antitrust laws*

16 *predatory pricing-бодит байдлаас доогуур үнэ тогтоох явдал*

17 *lapse, or omission*

Байнга нийтлэл бичдэг *Нью Йорк Хералд Трибун* сонинд байхдаа **Айн Рэнд**тэй уулзаж танилцжээ. Тэд найзууд болж, бие биенийхээ номыг дэмжиж тэтгэдэг байсан ч 1948 онд нэг гаргалгаа нотолгооноос болж салцгаажээ. Үүний дөнгөж дараагаар Патерсоныг дараахь зүйлийн төлөө *Трибун* сониноос халжээ: тэрбээр нийгэм, халамж, эдийн засгийн хэрэг явдалд төр засаг бага оролцохыг тэр цаг үеийнхээ хүмүүсийн зан авирт үл нийцэхээр шаардсан байна. Гэвч тэр үедээ тэрбээр саяхнаас үүсэж тогтчихсон, түүний “залилан мэхлэлт” гэж дүрсэлж тодорхойлдог, Нийгмийн Хангалт^[18] (Америкийн үндэстний тэтгэврийн тогтолцоо) гэсэн газраас халамж хүртэх явдлаас татгалзахаар тийм их мөнгө хийчихсэн байжээ (хэдийгээр Рэнд бүгдэд мэдэгдэж буйгаар өөртэйгөө зөрчилдөж энэхүү ашиг тусыг авахаар шийдсэн ч Лэйн жишгийг дагаж татгалзсан байдаг.)

[81] Рөүз Вилдер Лэйн (1886–1968 он): Америк сэтгүүлч, роман туурвигч, улстөрийн онолч. **Гол үзэл санаа:** Төр хувь хүмүүсийн эрх чөлөөг ганхуулж сулруулж байна; чөлөөт хүмүүсийн бүтээлч байдал. **Гол бүтээл:** *Эрх Чөлөөг Олж Нээсэн нь* [анг. *The Discovery of Freedom*] (1943 он).

Өмнөд Дакотад төрсөн, Прэрий дэх Жижиг Байшин [анг. *the Little House on the Prairie*] номуудын зохиогч Лаура Ингаллс Вилдер (1867–1957 он)-ийн охин болж мэндэлжээ. Голчлон-өөрөө боловсрол олсон, тэрбээр 1909 онд гэрлэж, бичиг хэргийн эрхлэгч, зохиол бичих, сонины ажил эрхэлж байв. Тэрбээр 1915 онд *Сан Франциско Бюллетинд* ажилд орж тэндээ удалгүй чадварлаг редактор, зохиолч гэж үнэлэгдсэн. 1918 он гэхэд гэрлэлтээ салгаж, роман бичих, намтар бичих, мөн *Харперс болон Сатердэй Эвенинг Пост* зэрэг үндэсний хэмжээний

18 *Social Security (America's national pension system)-Манайхаар*
Нийгмийн Даатгал

сэтгүүлд богино өгүүллэг, нийтлэл, шүүмж бичиж эхэлжээ – аажимдаа тэрбээр Америкийн хамгийн өндөр цалинтай эмэгтэй зохиолч болов.

Америк болон Европоор удаан хугацаанд аялах үеэрээ тэрбээр залуу цагийнхаа социализмын үзлээсээ татгалзаж, анх удаа ойроос Зөвлөлт Оросын харгис дарангуйлал, дайны завсарт дэгдсэн захиргаадалтын дарамт шахалт, хэлмэгдүүлэлт¹⁹ийг харжээ. Эдийн засгийн төлөвлөлт эрх чөлөө буюу чөлөөт байдал болон хөгжил цэцэглэлтийн найз нөхөр биш гэж дүгнэсэн байдаг:

Одоо би фундаменталист үзэлтэй Америк хүн болов; намайг сонсооч, би та бүхэнд яагаад индивидуализм, лэзе-фээр, капитализмын бага зэрэг хязгаарлагдмал анархи байдал хүмүүний сэтгэл зүрхийг хөгжүүлэхэд хэрэгтэй хамгийн сайн бололцоог нээдэг тухай ярих гэсэн юм. Мөн би та бүхэнд яагаад хүмүүний сэтгэлгээний харьцангуй эрх чөлөө коммунист, Фашист, эсвэл материаллаг зорилгын төлөө зохион байгуулалтад орсон ягшмал зүйлээс илүү сайн, илүү үр бүтээлтэй, бүр материаллаг байдлаараа ч илүү сайн болохыг хэлж өгмөөр байна.

Түүний үүний дараахь бүтээлийн ихэнхид нь төр хувь хүний чөлөөт байдал буюу эрх чөлөөг устгаж алга болгож буй тухай өөрийнх нь улам бүр ихсэж буй түгшүүрийг тодосгосон байдаг. Хамгийн алдартай ном *Эрх Чөлөөг Олж Нээсэн нь* [анг. *The Discovery of Freedom*] (1943 он) бүтээлдээ олонхийн бодол санааны эсрэг үйл хийн хөгжил дэвшлийг урагшлуулдаг хувь хүний ач холбогдлыг харуулсан байдаг – мөн түүндээ төрийн төлөвлөлт тэдэнд саад болдгийг харуулжээ. Тэрбээр **Айн Рэнд**ийн найз нь, мөн оюун санааны багш болсон бөгөөд Айн Рэнд энэхүү үзэл санааг нь авав.

Лэйн Шинэ Бодлогыг “гулсамтгай социализм” гэж дайрч

19 *bureaucratic oppression*

давшлав. Тэрбээр бүсжүүлэх хуул^[20]ийг өмчийн эрхэд халдсан зүйл гэж эсрэг нь кампанит ажил явуулж байсан бөгөөд энэхүү тэтгэвэртээ гарах хүртлээ төлөх тэтгэврийн энэхүү тогтолцоо^[21]г “Понзи бүдүүвчтэй хууран мэхлэлт” гэж нэрлэн, Нийгмийн Даатгал^[22]д татвар төлөхгүй гэж нийтлэлч, редакторынхаа ажлыг өгч байжээ. Тэрбээр дараахь зүйлийг бичиж үлдээн чөлөөт хувь хүмүүсийн бүтээл хүч чадалд ганхашгүйгээр итгэх итгэлээ сахин хамгаалсан байдаг (дэлхийн хүн ам өнөөгийн тооноос гучин хувиар бага байсан тэр цаг үед): ‘Хувьсгал бол зөвхөн эхлэл. Бүх амьд буй хүмүүс төрөхдөө л эрх чөлөөтэй төрдөг гэдгээ мэдсэн цагт энэ дэлхийн дээр хоёр тэрбум хоёр зуун сая хүмүүн төрөлтний энерги эрч хүч чөлөөлөгдөх болно. Өмнө нь зуун сая нь Америкийг бүтээсэн билээ. Энэ хоёр тэрбум хоёр зуун сая хүн нь юу хийх бол?’

[82] Волтер Ойккен (1891–1950 он): Герман хүн, эдийн засагч. **Гол үзэл санаа:** Ордолиберализм, Германы эдийн засгийн гайхамшиг. **Гол бүтээл:** *Эдийн Засгийн Дэг Журам [анг. The Order of Economics] (1937 он).*

Ойккенийг дайны-дараахь эдийн засгийн агшилтыг эсрэг эргүүлэхэд тусалсан, Германы эдийн засгийн “гайхамшиг” (*Wirtschaftswunder*)-ийг бүтээсэн Германы неолиберал үзэл санаа болох ордолиберализмийг үндэслэгч гэж дурддаг.

Шинжлэх ухаанч гэр бүлд төрсөн Ойккен эдийн засгийн ухаанд суралцаж, Берлинд дараагаар нь Фрайбүргд профессор болсон. Тэндээ тэрбээр эдийн засгийн ухааны Фрайбүрг

20 zoning laws - Газарзүйн мужид үл хөдлөх хөрөнгийг хэрхэн ашиглах ёстой, бас ашиглах ёсгүй байхыг заадаг хотын эсвэл орон нутгийн тогтоол шийдвэр.

21 payas- you-go pension

22 Social Security

Сургуул^[23]ийг бүтээхэд туслав. Энэ сургууль нь нилээд либерал боловч төр засгийг нийгмийн хүсүүшгүй үр дагавраас сэргийлэх гэж зах зээлийг хязгаарлах хуульзүйн дагуухь бүрэн эрхтэй гэж үздэг сургууль юм. 1930-аад оны сүүлээр Хитлерийн эсрэг дугарч байсан Ойккен болон бусад хамтрагч нар нь Нацистуудын төвлөрсөн төлөвлөгөөг илүү либерал өрсөлдөөнд суурилсан тогтолцоогоор солих дайны дараахь эдийн засгийн стратегийг Фрайбург Сургуулийнхаа зарчимд үндэслэж гаргав. Нацизмыг эсэргүүцсэн тэднийг эсэргүүцлийнх нь төлөө Ойккеныг баривчилж харин бусдыг нь цаазлав.

Гэлээ гээд ордолиберализм хожим нь дайны дараахь эдийн засгийн бодлогыг хэлбэржүүлэн гаргаж, “гайхамшиг” бүтээх болно. Ойккены хандлагаар төр өмчийн эрх, нээлттэй зах зээл, мөнгөний тогтвортой байдал^[24]д үндэслэсэн либерал эдийн засгийн бүтцийг бий болгох болно. Энэ нь картел үүсгэх болно, корпорацын хүч чадлыг хэт төвлөрүүлэх болно гэж Ойккений бодож байсан лэзе-фээр биш байх болно. Үүнээс илүүтэй төр нь өрсөлдөөнийг тэтгэж, компаниудын хүч чадлыг хязгаарлах болно.

Дайны дараахь Германы чухал Британи-Америкийн секторын Эдийн Засгийн Захирал болох Лүдвиг Эрхард (1897–1977 он) *ордолиберал* зарчмыг хүлээн зөвшөөрч цалин болон үнийн хяналтыг үгүй хийж, илүү тогтвортой валют (Герман Марк^[25]) -ыг нэвтрүүлэв. Хэдхэн жилийн дотор Герман улс “гайхамшигтай”-гаар сэргэн боссоныхоо үр шимийг хүртлээ.

[83] Сузанн Ла Фоллетт (1893–1983 он): Америк хүн, либертариач феминист сэтгүүлч. **Гол үзэл санаа:** Либертариач феминизмийн эдийн засгийн суурь үндэслэл. **Гол бүтээл:** *Санаа Зовнисон Эмэгтэйчүүд [анг. Concerning*

23 *Freiburg School of economics*

24 *monetary stability*

25 *the Deutsche Mark*

Women] (1926 он).

Ла Фоллетт АНУ-ын өрнөдөд фермд өсжээ. Үеэл нь бас сенатор байсан, АНУ-ын конгрессын гишүүний охин болох тэрбээр Капитол Хиллд богино хугацаанд ажиллаж байв. Нью Йорк руу нүүж, богино хугацаанд оршиж байсан *Фриймэн* сэтгүүл^[26]д ажилд авсан **Алберт Жэй Нокк**той танилцжээ.

Нокк Ла Фоллеттыг *Санаа Зовниж буй Эмэгтэйчүүд* [анг. *Concerning Women*] (1926 он)-ээ бичихэд нь түлхсэн бөгөөд энэ нь **Мэри Воллстөункрафт**ын *Эмэгтэйчүүдийн Эрхийг Өмгөөлөх нь* [анг. *Vindication of the Rights of Women*] (1792 он)-ээс хойш гарсан либертарич феминизм^[27]ийн хамгийн чухал ном юм. Түүнд боолчлолын адилаар эмэгтэйчүүдийг захирч дарлах явдал төрөөс дэмжлэгтэй эдийн засгийн институтцэд гүн үндэслэсэн гэж батлан өгүүлэв. Төр хөдөлмөрийн тогтоол шийдвэр^[28], хамгийн бага цалин, биеэ үнэлэлтийг хориглосон хууль, төрөлтийн хяналт, хуул^[29]иас дагуурхи төрөлтийн хуулиараа дамжуулан эмэгтэйчүүдийг тэдний олонхийнх нь хувьд цор ганц үүнээс гарах шийдэл нь гэрлэлт байхаар эдийн засгийн сул дорой байдалд оруулдаг ажээ. Гэвч гэрлэлтийн тухай хуулиар эрэгтэй хамтрагчид нь бүх эрхийг өгч, салахад хэцүү болгож, эмэгтэйчүүдийн хамааралтай болгож, ямар өмчгүй үлдээн энэ дутуу байдлыг нь улам л гүнзгийрүүлсэн байдаг.

Ла Фоллетт эмэгтэйчүүдийн эдийн засгийн тэгш байдал, үнэндээ аливаа анги эсвэл хүмүүсийн бүлгийн тэгш байдал бүх хүнтэй ижил тэгш хандах үед л зөвхөн ирэх болно гэдгийг сахин хамгааллаа. Асуудал бэрхшээл нь эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн хяналтаас гаргах явдал биш харин хувь хүний эрхийг давуу эрхтэй, хүчирхэг элитүүд зөрчиж буй бүх явдлыг

26 *The Freeman*

27 *libertarian feminism*

28 *labour legislation*

29 *illegitimacy*

алга болгох явдал байв. Цаашилбал эдийн засгийн эрх чөлөөгүй бол улстөрийн болон нийгмийн эрх чөлөө зүгээр л хоосон зүйл байх болно гэж шаргуу ятгаж байсан. Эдийн засгийн эрх чөлөө улстөрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн санал өгөх эрхээс илүү чухал ажээ. Бүх бүлэгт зориулсан жинхэнэ чөлөөлөлт нь төрийг устгах явдлыг дам илэрхийлдэг гэв.

1930-аад онд Ла Фоллетт Лев Троцкий^[30] (1879–1940 он)-г Зөвлөлтийн дарангуйлагч Иосеф Сталин (1878–1953 он)-ээс урвасан гэмт хэргийг цагаатгуулах гэж ажиллаж байжээ. Тэрбээр хожим нь *Чөлөөт Хүн* [анг. *The Freeman*] сэтгүүлийг либертари, анти-стэйтист утга зохиолын сэтгүүл *Шинэ Чөлөөт Хүн* [анг. *The New Freeman*] болгож дахин амилуулсан бөгөөд амьдралынхаа сүүлчээр *Нэйшинл Ревю* [анг. *National Review*] сэтгүүлийн анхны редактор захирал болсон.

[84] Ф. А. Хаек (1899–1992 он): Англи–Австрийн эдийн засагч, улстөрийн ухааны эрдэмтэн. **Гол үзэл санаа:** Бизнесийн мөчлөгийн онол; төлөвлөлтийн тухай шүүмжлэл; хүмүүний мэдлэгийн хязгаар; рационализмын алдаа; өөрөө-тогтдог дэг журам. **Гол бүтээл:** *Боолчлогдох зам* [анг. *The Road to Serfdom*]^[31] (1944 он); *Эрх Чөлөөний Үндсэн Хууль* [анг. *The Constitution of Liberty*] (1960 он); *Хууль, Хууль Тогтоох Явц, Эрх Чөлөө* [анг. *Law, Legislation and Liberty*] (1973 он)^[32].

Хаек хамгийн оюун цэцэн, ухааны хувьд бүтээлч, либерал сэтгэгчдийн нэг байсан билээ. Янз бүрийн сонирхолтой шинжлэх ухаанч гэр бүлд төрсөн тэрбээр эдийн засгийн ухаан, философ, улстөрийн ухаан, психологи, үзэл санааны түүхийн талаар тасралтгүй бичиж байв. Түүний авсан Нобелын Шагнал энэхүү

30 Leon Trotsky

31 Монгол хэлээр орчуулан гаргасан.

32 2024 оны төгсгөлөөр Монгол хэлээр хэвлүүлнэ.

хязгаарыг нь харуулдаг бөгөөд түүнийг бизнес мөчлөг, хүмүүний нийгмийн өөрөө-тогтдог дэг журмыг тайлбарласан ажлынх нь төлөө шагнасан.

Хаек 1944 оны дайны цаг үед социал буюу нийгмийн ардчилал хэрхэн тоталитаризм болж хялбархан хувирдгийг харуулсан, социалист төлөвлөлтийг шүүмжилсэн бүтээл *Боолчлогдох Зам* [анг. *The Road to Serfdom*]-аа бичсэн нь түүнд алдар хүнд авчирлаа. Удалгүй тэрбээр сэхээтнүүдийн бүхэн бүтэнд үед нөлөөлсөн, Маргарет Тэтчер (1925–2013 он), Роналд Рейгэн (1911–2004 он), Берлиний Хана нурсны дараа гарч ирсэн Зүүн Европын Удирдагчдын бодлогод чиг баримжаа болж замчилсан^[33], либерал үзэл санааны форум буюу хэлэлцүүлгийн талбар болох Мон Пелерин Нийгэмлэг^[34]ээ байгуулжээ.

Дэлхийн I Дайны дараа албандаа Хаекийг **Лүдвиг фон Мизэс** эдийн засагчаар ажилд авсан байдаг бөгөөд 1927 онд энэ хоёр огцом өсөлт-хямралын мөчлөгийг судлах хүрээлэн байгуулав. Тэд эдгээр мөчлөг төв банк зэлийн хүүгийн хэмжээг хэт бага болгосноос гарсан гэж дүгнэжээ – хэт ихээр зээл авах, хөрөнгө оруулах, зардал явдлыг энэ нь дэмждэг байна. Гэвч мөн зээлийн бага хүү хадгалж хураах явдал буюу хадгаламжийг үл дэмждэг тул, санхүүжүүлэх сан ширгэж дундарч, хөрөнгө оруулалт зогсоход хүмүүс ажлаасаа халагддаг гэжээ. Хаек хожим нь үүнээс хамгийн сайн сэргийлэх арга зам бол *валютын өрсөлдөөн* гэж санал болгосон байдаг– ингэвэл хүмүүст хялбархан илүү сайн баталгаажсан валют^[35] руу шилжих боломж олгох болно.

1930-аад онд Хаек Британид очиж, мэргэжлийн хувьд алдар нэртэй болсон бөгөөд энэ нь зарим талаараа Жон Мэйнэрд Кэйнс (1883–1946 он)-тэй маргалдаж байснаас болсон байж болох юм.

33 *informed*

34 *Mont Pelerin Society*,

35 *sound currency-бас fiat money гэж үүнээс ондоо, алтны-баталгааг үгүй хийсний дараа одоо бүх улсад хэрэглэж буй баталгаажуу мөнгө бий. Мөн hard currency гэж ойлголт байдаг.*

Кейнс эдийн засгийг огцом тэлэхийн тулд төр засгийн зарцуулалт гаргахыг өмгөөлж хамгаалдаг байв; Хаек энэ нь зөвхөн инфляц, хохирол, өр л бүтээх болно батлан өгүүлж байлаа.

Гэвч Кэйнсийн үзэл санаа тэр цагт ялж, Хаек илүүтэй нийгмийн болон улстөрийн философи руу эргэсэн байдаг. Түүний гүн мэдлэг нь өөрөө үүсэл гарлыг нь **Адам Фергүсон, Адам Смит**, бусад хүн хүртэл мөшгөж шинжилсэн, өөрөө-тогтдог дэг журм^[36]ын концепц байсан. Хүмүүний нийгэм болон амьтны сүрэг илэрхий зүй тогтолтой^[37] байдгийг ажиглажээ. Гэлээ гээд хэн ч зөгийн сүрэг эсвэл хүмүүний хэл яриа эсвэл зах зээлийн үйл ажиллагааг төлөвлөөгүй. Эдгээр нь жам ёсоороо, өөрөө-өрнөх байдлаар гарч ирсэн бөгөөд эдгээр нь хэрэгтэй ашигтай байсан учраас л хувьсан хөгжиж, хадгалагдаж үлдсэн ажээ. Өөрөө-тогтдог дэг журам үйл хийхдээ тодорхой байнга давтагддаг арга замыг дагах үед, жишээлбэл хэлний дүрэм, эсвэл зах зээл ёс журам зэрэг ёс журмыг дагаж мөрдөхөд үүсэж гардаг. Голдуу бид ёс журмыг томьёолж буулгах боломжгүй, мөн тэдгээрийг дагаж мөрддөг гэдгээ ч таньж мэдээгүй байдаг ажээ. Гэвч эдгээр байнга давтагдамхай зүйл^[38] хувьсаж хөгжсөн цэцэн ухаанд агуулагдаж байдаг – энэ бол бидэнд хөгжиж цэцэглэх боломж олгодог мэдээлэл эсвэл мэдлэг юм.

Хувь ёс журмууд болон ерөнхий үр дагаврын хоорондох харилцан хамаарал нийлмэл байдаг: бид нэгэнт иймэрхүү дэг журам хэрхэн ажилладгийг үл мэдэмхий байдаг тул бид түүнийг хялбархан гэгч нь сайжруулах боломжтой гэж итгэдэг нь өөрөө тэнэг хэрэг гэж Хаек анхааруулжээ. Жишээлбэл эдийн засгийн төлөвлөлт бол хамгийн сайн үр дагаврыг олохын тулд зүгээр л өгөгдөл цуглуулж боловсруулах явдал биш байдаг. Төлөвлөгч ийм шийдэлд хэрэгтэй мэдээлэлд бүр ойртож ч очиж чаддаггүй – учир нь мэдээлэл сарниж тархсан, хэсэгчилсэн байдалтай,

36 *Spontaneous orders*

37 *regularities.*

38 *regularities*

хурдан өөрчлөгддөг, дамжуулах боломжгүй зүйл ажээ. Юу үйлдвэрлэхийг мэдэхийг тулд төлөвлөгч хүн хүмүүс юу хүсэж, юуг үнэлж цэгнэдэг болохыг мэдэх хэрэгтэй болно – гэвч үүнийг хэмжиж эсвэл дамжуулж мэдээлэх боломжгүй. Үнэндээ төвлөрсөн төлөвлөлтийн олон арван жилийн туршид тохиолддог гачлантай бүтэлгүйтэл бол энэ ажил хэрхэн угаасаа боломжгүй болохыг баг нот баталгаа юм. Гэлээ гээд өөрөө-тогтдог зах зээлийн дэг журам энэхүү сарниж тархсан, хэсэгчилсэн бүх мэдээллийг бүх төвшинд, цаг мөч бүрд боловсруулдаг. Бидэнд зарим нэг дундын зорилгоо таньж мэдэх хэрэг байхгүй: зах зээл өөр өөр зорилготой, ондоо ондоогоор үнэлж цэгнэдэг худалдагч болон худалдан авагч адилаар хүмүүсийг хооронд нь эвлэрүүлэх болно. (Үнэн хэрэгтээ хүмүүс юуг үнэлдэг талаараа илүү их хоорондоо зөрүүтэй байх нь тэднийг арилжаа наймаагаар дамжуулан хамтран ажиллах явдлыг илүү хялбар болгодог ажээ.) Зах зээлийн тогтолцоо тиймээс аливаа бусад төлөвлөдөг дэг журмаас илүү том болж өргөжин, илүү нийлмэл болох боломжтой.

Бидэнэхүү зах зээлийн тогтолцоог урьдаст төлөвлөж гаргаагүй гэж Хаек хэлдэг: харин илүүтэй бид энэ тогтолцоотой тааралдаж [ашигтайг нь таньж мэдсэн] байна. Хүмүүс бараагаараа биет солилцоо хийх, бараа бүтээгдэхүүнээ солилцох үедээ тэд энэ нь арилжаа худалдаагаар дамжуулан хамтын ажиллагааны дэлхийг хамарсан тогтолцоо болж өснө гэж мэдэж байсангүй. Гэвч тэр биетээр бараагаа солилцох болон солилцоо^[39] хийх үед нь үнэ үүсэж гарч эхэлсэн бөгөөд үнэ энэхүү тогтолцоог ажиллахад хэрэгтэй бүх мэдээллийг агуулдаг ажээ. Бид яагаад хүмүүс ямар нэг зүйлийг үнэлж цэгнэдгийг эсвэл үүнийг юунд хэрэглэхийг эсвэл хүмүүс яагаад үүнээс илүү их авахыг ойлгох хэрэгцээ байхгүй: өсөж буй үнэ үүнийг бүгдийг нь хэлээд өгнө. Тэр үед ашгийн талаархи ирээдүйн төлөв тэр бүтээгдэхүүнийг хангах явдал руу хүмүүсийн эрч хүчийг татаж, нөөц баялгийг тэдний хамгийн үнэлж цэгнэдэг хэрэглээ тийш илүү зардалтай

хэрэггүй нэгнээс нь холдуулж замчилдаг чиглүүлдэг – ингэхдээ өөр өөр хүмүүсийн олон янз алсын бодлыг нилээд автоматжсан байдлаар хооронд эвлүүлж тааруулна.

Энэхүү автоматтогтолцооны өөр нэг шинж бол байнга явагддаг сайжрах үйл явц юм. Бусад нэгнээс ирэх өрсөлдөөнтэй нүүр тулсан нийлүүлэгч байнга л өөрийн бараа бүтээгдэхүүнээ ондоо өөр болгохыг оролддог. Байнгын шинэчлэлт болон хэрэглэгчийн шилж сонгох үйл явцаар дамжин бараа бүтээгдэхүүн улам сайн, улам хямд болдог. Зах зээл болон өрсөлдөөн хэзээ ч “төгс” байгаагүй боловч эдгээр нь ондоошиж өөр болох, олж нээх, сайжруулах *хувьсаж өөрчлөгдөмхий үйл явц* байсаар ирсэн.

Хаек эрх чөлөөг өөрөө-тогтдог дэг журмын ажиллагаанд амин чухал гэж ойлгодог байв. Төлөвлөгчид зарим нэг урьдаас ойлгож харж буй үр дагавартаа хүрэхийн тулд биднийг тодорхой арга замаар үйл хийлгэх гэж албадахаар оролдохдоо бидний ёс журмаар-замчлагддаг үйл хөдлөлийг эвдэж, ёс журмын цэцэн ухааныг гээгдүүлж, нийт дэг журмаа эрсдэлд оруулдаг. Мөн өөрөө-тогтдог нийгмийн болон эдийн засгийн дэг журамд хувьсаж хөгжих, томорч өргөжих, бат суурьтай болж бэхжихэд нь шинэчлэл шинэ санаа, шинэ үзэл санаа (**Жон Стюарт Миллийн** ажигласан шигээр) хэрэгтэй ажээ. Чөлөөт хүмүүс бүтээлч, шинэчлэл хиймтгий хүмүүс байдаг; тэдний эрх чөлөөг бид хязгаарлавал бидэнд л хувьсаж хөгжимхий үйл явцыг тэтгэх гэжээж түлш бага л болох болно.

Хаекийн хувьд эрх чөлөө гэдэг нь албадлагыг бууруулна гэсэн үг байжээ. Нийгэм тушаалаар биш харин ёс журам дээр цогцолж бий болдог бөгөөд бид төрдөө хязгаарлагдмал албадлагын эрх мэдэл хүмүүс ёс журмыг зөрчихөөс сэргийлэх гэж зөвхөн олгодог – энэ бол төр хүмүүсийг тодорхой арга замаар үйл хийлгэх хүчлэх эрх мэдэл биш. Иймэрхүү эрх мэдлийг буруугаар ашиглахаас сэргийлэхийн тулд бидэнд төр засгийг ёс журмаар мөн л хязгаарлаж хорих хэрэгтэй. Хаек үүнийг *хууль ёс*^[40] гэж

40 *rule of law-Тайлбарлах*

нэрлэсэн байдаг: хууль урьдаас мэдэгддэг, тодорхой, бүх хүнд хэрэглэмтгий, бас буцаан үл хэрэглэдэг, (үүнийг эрт цагт **Жосеф Приестлий** гаргаж тавьсан шигээр) бидэнд аль болох их *хувийн оронзай* үлдээдэг байх ёстой ажээ.

Хаек *шударга ёс* гэдгийг нийгмийн дэг журам ажиллах боломж олгодог ёс журам гэж ойлгож байлаа. Бид шударга ёсны ёс журм^[41]ыг зохион гаргах боломжгүй: бид алдах онох үйл^[42]ээрээ эдгээрийг олж нээх л ёстой ажээ. Хүмүүсийн “социал буюу нийгмийн шударга ёс” гэж нэрлэдэг зүйл үүнээс нилээд өөр зүйл байдаг – энэ нь ёс журмын бүрдэл биш харин урьдаас таамаглаж бодсон нийгмийн социал үр дагавар ажээ. Тийм үр дүнд хүрнэ гэдэг нь хүмүүстэй өөр өөр харьцана хандана гэсэн; нэгэнт л бид ийм зүйл хийж эхэлбэл бид хаана очиж зогсох нь ерөөсөө мэдэгдэхгүй, боол болох замдаа орлоо гэсэн үг юм. Гэвч ‘социал буюу нийгмийн шударга ёс’ ямар ч тохиолдолд хий хоосон зэрэглээ байдаг. Учир нь хэрхэн ийм дахин түгээлтийг явуулах ёстой талаар санал нэгдсэн зүйл хаана ч байдаггүй. Хаек ‘нийгмийн шударга ёс’ хоорондоо өрсөлдөж буй ашиг сонирхлын бүлгүүд төрийн дэмжлэг олох гэсэн лоббигоор уусаж алга болох болно гэж батлан өгүүлж байв.

Хаекийн хувьд нийгмийн талаархи социалист алсын хараа алдаа байсан байдаг. Либерал төр засаг нийгмийн дэг журам ажиллахад хэрэгтэй нөхцөлийг зөвхөн бүрдүүлнэ. Хууль бол шударга ёсны ёс журмыг *олж нээх* гэсэн бидний оролдлого ажээ; төр засаг нийт нийгмийн үйл ажиллагааг хууль тогтоомжоор зохицуулж чадна гэж бодох ёсгүй^[43]. Басхүү төр засаг ардчилсан олонхи тэдэнд зөв үүргээсээ давах эрх өгсөн гэж ч бодох ёсгүй. Үүнээс илүү харин төр засгийг онцгой эрх ашгийг эрхлүүлэх боломжгүйгээр, хүмүүстэй ижил тэгш харьцахыг нь бататгадаг, мөн чөлөөт хүмүүсийн авьяасыг суллан тавьдаг үндсэн хуулиар

41 *rules of justice*

42 *trial and error*

43 *they could legislate the running of an entire society*

үнэндээ хязгаарлах ёстой ажээ.

[85] Карл Поппер (1902–1994 он): Англи-Австрийн философич. **Гол үзэл санаа:** Хисторицизм бол авторитарианизмын үндэс; худал шинжлэх ухаан, үл тэвчихүй; тэвчихүйн ач холбогдол. **Гол бүтээл:** *Хисторицизмын Ядуурал* [анг. *The Poverty of Historicism*] (1936 он); *Нээлттэй Нийгэм ба түүний Дайсан* [анг. *The Open Society and Its Enemies*] (1945 он).

Попперулстөрийн философид маш чухал хувь нэмэр оруулсан, шинжлэх ухааны гарамгай философич байжээ. Залуудаа Вена хотын марксист явсан (тэнд тэрбээр **Ф. А. Хаекийн** найз байлаа) тэрбээр удалгүй Марксистч догматизм болон хүч хэрэглэх явдлыг үгүйсгэж түүнийг орхисон байна. Хэдэн жилийн хугацаанд идеалистч социалист хэвээр үлдсэн боловч эгалитарианизмийг эрх чөлөөний улстөрийн гол үнэт зүйлтэй үл нийцэх зүйл гэж үгүйсгэсэн. Хэдийгээр тэрбээр нийгмийн асуудлыг шийдвэрлэх төрийн үүрэг нөлөөний төлөө үргэлжлүүлэн маргаж мэтгэлцээр байсан ч түүний анти-авторитарианизмын үзэл санаа, “нээлттэй нийгэм” дэх индивидуализм, оюун ухаан, хүлцэхүй, эв найр, эрх чөлөөг хамгаалдаг явдал нь түүний либерал бат суурьтай итгэл үнэмшлийг нь үүсгэж тогтоожээ.

Поппер фашизм, национализм, коллектизм буюу хамтач ёс, төвлөрсөн төлөвлөлтийн гол шүүмжлэлүүдийг бичсэн. Үүний ихэнхи нь түүний шинжлэх ухааны философид нь үндэслэсэн байдаг. Тэрбээр мэддэг гэж бодогддог бүх “мэдлэг” үнэндээ хожим нь шинэ баримт нотолгоо худал гэдгийг нь үгүйсгэх боломжтой зөвхөн *ОНОЛ* байдаг гэдгийг баримталдаг байв. Тийм учраас дарангуйлагчдын “тодорхой үнэн”-ийг мэддэг гэсэн мэдэгдэл хий хоосон зүйл ажээ: хэрэгтэй ашигтай үзэл санаа зөвхөн *авторитарич биш* “нээлттэй” нийгэмд л цэцэглэж хөгждөг. Энэ явдал хүлцэхүйг маш чухал зүйл болгодог. Гэвч парадокс

байдлаар (мөн дотооддоо зөрчилтэй) дараахь зүйл болдог:

Хязгааргүйгээр хүлцэх нь хүлцэхүй алга болгоход хүргэнэ. Хэрэв бид хязгааргүй хүлцэхүйг бүр үл хүлцэгч тэр хүмүүст хэрэглэвэл хэрэв бид хүлцэхүйтэй нийгмийг үл хүлцэгчийг хүч давамгай дайралтаас хамгаалахад бэлэн биш бол тэр үед хүлцэгч нь устгагдаж, хүлцэхүй нь тэдэнтэй хамт алга болно.

Поппер нийгмийн ухааны алдаатай арга, хувь хүмүүст гэхээсээ илүү хүмүүсийн бүлэгт анхаарал хандуулан, гэрчилгээжсэн дарангуй удирдагчийг хувь хүмүүсийг өөрсдийн улстөрийн үзэл санаанд захируулдаг болгодог гэж батлан өгүүлж байлаа. Тэд мөн үйл явдлыг хувь хүмүүс биш харин түүхэн “хууль” л тодорхойлдог гэж санал болгосон байдаг— энэ нь тэдгээрийг ойлгодог гэж мэдэгдсэн (Марксистууд мэт) хүмүүст хуурамч эрх дарх дахиад л өгдөг ажээ. Гэвч нийгэм нийлмэл байдаг, ямар ч түүхэн хууль гэж оршдоггүй, мөн тэдний хэт бардам байдлын зорьсон зорилгын зориогүй үр дүн нь үргэлж аймшигтай байдаг.

Попперын хувьд улстөрийн асуудал нь дараахь зүйл байсан: ‘Бид муу эсвэл ур чадваргүй удирдагч хэт их хохиролтой зүйл хийчих явдлаас сэргийлэхийн тулд улстөрийн институтүүдээ хэрхэн зохион байгуулах боломжтой вэ?’ Түүний хариулт нь муу удирдагчийг эв найртайгаар сонгуулиар зайлуулдаг тогтолцоо байсан. Энэ байдал бол хязгаарлагдмал ардчиллыг зөвтгөдөг зүйл юм: энэ тогтолцооны яг таг нарийн хэлбэр тийм ч чухал биш ажээ.

[86] Айн Рэнд (1905–1982 он): Орос-Америкийн роман туурвигч, моралистч. **Гол үзэл санаа:** Үнэнийг объектив сэтгэлгээгээр олдог; амьдралд тулгуурласан ёс зүй; ёсзүйд тулгуурласан улстөрийн зарчим; бүтээлч байдал, хөгжил дэвшилд эрх чөлөө шаардлагатай байдаг. **Гол бүтээл:** Эх

Сурвалж [анг. The Fountainhead] (1943 он); Атлантын мөр тэнийв [анг. Atlas Shrugged] (1957 он).

Айн Рэнд нь **Изабел Патерсон, Рөүз Вилдер Лэйн** нарын хамтаар орчин үеийн Америк Либертанианизмийн тэргүүлэгч үндэслэгчдийн нэг байсан – гэвч тэрбээр “либертарич” гэдэг шошгоос татгалзаж, өөрийгөө “радикал индивидуалистч”, “капитализмын төлөөхь радикал үзэлтэн” гэж нэрлэсэн байдаг. Энэ гурваас Рэндийг өнөөдөр архитекторч Ховард Роарк радикал алсын харааг нь эсэргүүцдэг захиргаадалтын ажилтнуудтай тэмцдэг *Эх Сурвалж [анг. The Fountainhead] (1943 он)*^[44] болон ажил хэрэгч хүмүүс шунаг засаг төрийн боомилгогч хяналтыг эсэргүүцэж өөрсдийн бизнесээ хаацгаан, өөрсдийнхөө өөрийн гэсэн нийгмийг байгуулж буй тухай гардаг *Атлантын Мөр Тэнийв [анг. Atlas Shrugged] (1957 он)*^[45] маш нөлөөтэй романуудаар хамгийн ихээр дурсдаг билээ. Эдгээр романы алдар хүнд нь жил бүр хэдэн мянган хүмүүс (ялангуяа залуус) -ийг индивидуалист үзэл санааны ертөнц рүү татан оруулж байна. 1990-ээд онд Конгрессын номын Сангийн судалгаагаар *Атлантын Нуруу Тэнийв* номыг Библийн дараа орох хамгийн нөлөөтэй ном гэж нэрлэсэн байдаг.

Санкт Петербургийн Орос-Еврей эмзүйчийн охин Рэнд^[46]ийг 12 настай байхад Орост Хувьсгал гарчээ. Түүний “хотын хөрөнгөтөн” гэр бүл дайн тэмцлээс зугтаан гарсан ч Большевикууд тэдний гэр бүлийн бизнесийг нь булаан авав. Шаргуу хөдөлмөр хүмүүсийг үүнийг хүртэх эрхгүй бусад

44 Монгол хэлээр орчуулан гаргасан

45 Монгол хэлээр орчуулан гаргасан

46 *Жинхэнэ нэр нь Алиса Зиновьевна Розембаум. Гэр бүлээсээ ганцаараа гадаадад гарч чадсан бөгөөд ээж, аав Ленинградын бүслэлтийн үеэр өөд болж, холбоо тасарсан нэг охин дүү нь 1950-аад оны сүүлчээр түүнийг алдартай болсныг, амьд байгаагад гадаадын сэтгүүлээс санамсаргүй олж харж байсан гэдэг.*

хүмүүсийн ашиг тусын төлөө мөлжиж ашиглах явдлын шударга бус байдал хожим нь Рэндийн бүтээлийн дийлэнхийн нь гол сэдэв байх болно. Энэ Хувьсгалын дараа Рэнд түүх, философиор Петроградын Улсын Их Сургуульд суралцаж, дараагаар нь Кино Урлагийн Улсын Дээд Сургуульд жүжгийн зохиолчоор суралцсан байдаг. Тэрбээр АНУ-ын киноны салбарт суралцах виза авчээ. Холивүүдэд байхдаа Америк жүжигчин Фрэнк О Коннортой танилцаж гэрлэсэн бөгөөд 1931 онд Америкийн иргэн болов.

Анхны жүжгээ нийтэд үзүүлсэн Нью Йоркод байхдаа Рэнд нь **Изабел Патерсон**той найз болж, **Лүдвиг фон Мизэст**тэй танилцсан байна. Тэрбээр *Бид Амьд Хүмүүс* [анг. *We the Living*] (1936 он)^[47] гэсэн романаа бичиж эхлэв. Түүндээ Зөвлөлт Орост төр нь хэрхэн хувь хүмүүсийг дарлаж дарангуйлж буйг дүрсэлж харуулсан байдаг. Мөн тоталитар ирээдүйн баргар байдлыг буулгасан *Сүлд* [анг. *Anthem*] (1938 он)-ээ бичиж эхэлжээ. Тун удалгүй *Эх Сурвалж* [анг. *The Fountainhead*] (1943 он) бүтээл нь амнаас ам дамжсаар амжилтад хүрч, Гари Күүпер гол дүрд нь тоглосон уран сайхны кино хүртэл хийжээ; энэ явдал дэмжигчдийн бүлгийг өөртөө татав – тэр дэмжигчдийн дунд ирээдүйн АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн захирал Алан Грийнспэн (1926 он–) байжээ. Тэрбээр түүнтэй уулзаж үзэл санааных талаар “Хамтрал”^[48] гэсэн ёжтой нэртэй бүлэгт хэлэлцэж байсан. *Атлантын Нуруу Тэнийв* [анг. *Atlas Shrugged*] (1957 он) нь таагүй шүүмж авсан ч гэсэн хамгийн их борлуулалттай ном болж, индивидуализм, лэзе-фээр капитализм, өөрийгөө-илэрхийлэх явдл^[49]ын тухай гол хэлэх санаануудаараа сая сая хүмүүсийг өөртөө татжээ.

Рэндийн романууд, уран зохиолын бүтээл биш *Шинэ Сэхээтнүүдэд Зориулав* [анг. *For the New Intellectual*] (1961 он), *Өөрийгөө Бодох Явдлын Сайн Тал* [анг. *The Virtue of Selfishness*]

47 Монгол хэлээр орчуулан гаргасан

48 'The Collective'

49 self-determination

(1964 он)^[50] гэсэн номууд нь өөртөө түүний философийн тогтолцоо, *рационал байдлаар өөрийн-тусыг бодох явдалд* үндэслэдэг ёсзүйн кодынх нь хамтаар *Объективизмыг* агуулдаг. Өөрийн философийн ухааны баатрууд болох Аристотл (НТӨ 384–322 он), **Тома Аквиний** адилаар Рэнд өөрийгөө-илэрхийлсэн үнэн^[51] гэх зүйлээс өөрийнхөө тогтолцоог үүсгэж гаргажээ. Тэрбээр бодит байдал бол объектив, хүмүүний ухааны гаднахь зүйл юм: ухамсар^[52] бол бид оршиж байгаа зүйлийг юмсыг хэрхэн ухаарч ойлгож байгаа явдал юм; оюун ухаан^[53] бол бид түүнийг хэрхэн ухаж ойлгож буй явдал гэдэгт бат итгэлтэй байлаа. Тиймээс оюун ухаан хүмүүний оршин байхад амин чухал бөгөөд энэ нь бидний хүмүүн бодгаль болохыг тодорхойлдог зүйл юм: бид оюун ухааныг үл тоох үед бид хүмүүнлэг чанар^[54] аасаа урвадаг ажээ.

Рационал хувь хүмүүсийн хамгийн дээд ёс суртахуунт зорилго *өөрийгөө-идэвхжүүлэх явдал*^[55] байдаг. Хүмүүс өөрийн аз жаргалдаа, агшин зуурын таашаалд биш харин рационал, эв найртай, урт хугацаанд өөрсдийн амьдрал, үнэ цэнээ сайжруулахаар тэмүүлэх ёстой ажээ. Рэнд шашин, коллективизм, алтруизм зэрэг рационал бус үндэслэл гэж үздэг зүйл дээр бүтэж цогцолсон ёс суртахууны код^[56]ыг буруушаадаг байв. Эв найр болон хөгжил дэвшил өөрийгөө золиослох явдлаас гаргадаггүй ч харин өөрийн рационал байдлаар өөрийн-тусыг-бодох явдал^[57] даа хүрэхээр хүсэж тэмүүлэх, өөрийн эрхийг бататгах, бусдын үүнтэй адилхан эрхийг хүндлэх явдлаас гардаг ажээ. Өөрөөр хэлбэл: “Чин үнэндээ миний философи

50 *Монгол хэлээр орчуулсан гаргасан.*

51 *self-evident truths*

52 *consciousness-ухамсарт байдал*

53 *reason*

54 *humanity*

55 *self-actualisation*

56 *moral codes*

57 *rational selfinterest*

бол өөрийн аз жаргалаа амьдралынхаа ёс суртахуунт зорилго болгосон, бүтээлч амжилт нь түүний зөв үйл ажиллагаа нь байдаг, оюун ухаан нь цор ганц зөвхөн түүний үнэмлэхүй зүйл байдаг, баатарлаг бодгаль болох хүний тухай концепц юм’.

Рационал хүмүүн төрөлтөн өөрийн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг – үйлдлийнхээ үр дагаврыг хариуцдаг, үүнтэй адилаар тэдгээрийн үр шимийг нь ч хүртэх эрхтэй ажээ. Юу ч тэднээс хүчээр хуульзүйн дагуу авах боломжгүй. Учир нь хүч оюун ухааны антитезис буюу эсрэг зүйл^[58] байдаг, хүч эрх рүү нь халддаг билээ. Гэвч рационал байдлаар өөрийн-тусыг боддог хувь хүмүүсийн дунд, *Атлантын Мөр Тэнийвд* байдаг шиг салж одон өөрийн хүмүүсийн хүрээллийг байгуулдаг хүмүүс байвал энд ямар ч зөрчил, үнэндээ ямар ч өөрийгөө-золиослох явдал байдаггүй. Тэд тэдний нэг бүр нь бусад өөрийн-тусыг боддог хувь хүмүүсийн ур чадвараас ашиг тус харилцан гэрээ болон солилцоогоор дамжуулан хүртэх боломжтой байдаг гэдгийг мэддэг. Рэндийн баатрууд уран зохиолд ч бодит амьдрал дээр ч өвөрмөц шинждээ бат итгэсэн, алтруизмээс биш харин рационал байдлаар өөрийн-тусыг бодох явдлаараа дамжуулан технологи зохион бүтээсэн, урлаг уран зохиол бүтээсэн, үзэл санаагаа урагшлуулж хөгжүүлсэн, бизнесээ босгосон хүмүүс байдаг билээ.

Рэнд бидний хүмүүнлэг чанарыг тодорхойлдог шинж чанар болох оюун ухаан^[59] эгоизмыг дам илэрхийлдэг, мөн эгоизм нь өөрөө эргээд капитализмыг дам хэлдэг гэж хэмээн батлан өгүүлж байжээ. Тэрбээр лэзе-фээр капитализмыг хувь хүмүүсийн амьдран суух эрх, чөлөөт байдал буюу эрх чөлөө, өмчтэй уялддаг эдийн засгийн цор ганц тогтолцоо гэж ойлгож байсан бөгөөд үүнээс үүдээд биднийг хамгаалах хамгийн магадлалтай цор ганц тогтолцоо, мөн аливаа нэг ёс суртахуунт зарчим^[60]тай

58 *antithesis of reason*

59 *reason*

60 *any moral standing*

цор ганц тогтолцоо гэж ойлгож байсан.

Бидний зам ёсны эрхийг улам цааш нь хамгаалах, хүчирхийллийг хориглохын тулд Рэнд хязгаарлагдмал эрх мэдэлтэй үндсэн хуулийн төр засгийг өмгөөлж хамгаалан, либертанианизмийг анархистч ерөнхий хандлагынх нь төлөө буруутгаж байв. Энэ явдал **Муррэй Ротбард** зэрэг эрх чөлөөний-төлөөх идэвхтнүүдтэй, мөн объективистуудынхээ дунд ч үзэл санааны ноцтой зөрчил үүсгэсэн. Гэвч өнөөдөр Рэндийн оптимистч буюу өөдрөг идеал болох хүмүүс сүргээ дагалгүйгээр баян тансаг, бүрэн дүүрэн, бие даасан амьдралаа хөөдөг тэр идеал нь эрх чөлөөний төлөөх бүх төрлийн хөдөлгөөнд асар олон хүнийг татсаар байна. Хэн нэгэн хэлсэнчлэн ‘Айн Рэндээс л бүх зүйл эхэлдэг’ билээ.

[87] Исаяя Берлин (1909–1997 он): Латви–Британийн философич. **Гол үзэл санаа:** Ёс суртахууны эсвэл улстөрийн ямар ч цор ганц үнэн гэж байдаггүй; позитив-шинжтэй болон негатив-шинжтэй эрх чөлөө. **Гол бүтээл:** *Эрх Чөлөөний Хоёр Концепц [анг. Two Concepts of Liberty] (1958 он); Эрх Чөлөөний Тухай Дөрвөн Эссэ [анг. Four Essays on Liberty] (1969 он).*

Оросын хувьсгалын дараа Берлиний гэр бүл Британи руу зугтаж тэндээ тэрбээр хожим нь Оксфордын тэтгэлэг олж авчээ. Рига дахь хүүхэд байсан үед нь коммунистуудын үзүүлсэн аймшиг амьдралынх туршид харгис дарангуйллыг жигшихэд хүргэсэн бөгөөд тэрбээр олон ургалч үзэл болон хүлцэхүйн тэргүүний хамгаалагч болжээ.

Ямар ч ганц загвар эсвэл үзэл бодол эсвэл идеологи хүмүүний үзэл санаа, үнэт зүйл, түүхийн асар их олон янз байдал болон динамизмийг бүхэлд нь өөртөө агуулж чадахгүй. Үйлдлийг шүүн цэгнэх боломжтой ёс суртахууны үнэн зарчим, тогтчихсон стандарт гэсэн ямар ч зүйл байдаггүй: амьдрал өөр өөр, голдуу

хоорондоо зөрчилдсөн, жишээлбэл эрх чөлөө болон тэгш байдал зэрэг үнэт зүйлийн хоорондохь байнгын буулт хийх явдал байдаг. Түүхийг Марксистуудын боддогчлон шинжлэх ухааны хуулиар эсвэл эзэн биегүй хүчээр тодорхойлдоггүй: хүмүүний амьдрал болон хүмүүний түүх олон янз байдалтай, урьдаас таамаглах боломжгүй зүйл байдаг ажээ.

Эрх Чөлөөний Хоёр Концепц [анг. *Two Concepts of Liberty*] (1958 он)-доо Берлин *позитив-шинжтэй* болон *негатив-шинжтэй* эрх чөлөөг хооронд нь ялгав. **Жон Локк** болон **Жон Стюарт Миллийн** бүтээлд жишээ болгож дурдаж асан негатив-шинжтэй эрх чөлөө^[61] хүмүүсийн хязгаарлалтгүйгээр үйл хийх эрхийг харуулдаг. Харин позитив-шинжтэй эрх чөлөө^[62] хүмүүс өөрсдийн хувь тавилангаа хэлбэржүүлж, мөн өөрийгөө идэвхжүүлж чадахгүй бол хүмүүс жинхэнээсээ эрх чөлөөгүй байх боломжтой гэдгийг батлан харуулдаг байна. Берлин энэ хоёр концепцийг хоёулаа гавьяатай харж байсан бөгөөд бид амьдралаа бүрэн дүүрэн болгохын тулд бусдад туслах гэсэн жам ёсны хүсэлтэй байх үедээ сонгодог либерализмийн тулгын чулуу болсон негатив-шинжтэй эрх чөлөөг нөхөх биш харин ганхуулж бөхөөхөд ашиглаж ирсэн идеологид позитив-шинжтэй эрх чөлөөний үзлийг ашиглах бий гэж эмээж байжээ. Тэрбээр энэхүү сэдвээ улам цааш нь *Эрх Чөлөөний Дөрвөн Эссэ* [анг. *Four Essays On Liberty*] (1969 он)-дээ судалсан.

[88] Роналд Көүз (1910–2013 он): Англи хүн, Нобелийн Шагналт эдийн засагч, хуульзүйн онолч. **Гол үзэл санаа:** Хэлцлийн үнэ цэнэ; өмчийн эрх, зах зээлийн үр дүн. **Гол бүтээл:** *Пүүсийн Байр Байдал* [анг. *The Nature of the Firm*]

61 *negative liberty*-хөндлөнгөөс үл заасан-шинжтэй эрх чөлөө. Өргөн утгаараа энэ нь бусдын хөндлөнгөөс оролцох, албадлага, эсвэл хязгаарлалтгүй эрх чөлөө ажээ. Үүнд сэтгэн бодох гм эрх чөлөө ордог.

62 *Positive liberty* -хөндлөнгөөс заасан-шинжтэй эрх чөлөө.

(1937 он); *Нийгмийн Зардлын Асуудал* [анг. *The Problem of Social Cost*] (1960 он).

Теоремыг өөрийнх нь нэрээр нэрлэсэн хэдхэн эдийн засагчдын нэг болох Көүз Лондонгийн эдийн засгийн Сургуульд өнгөрүүлсэн хугацаандаа хуульч гэхээсээ илүүтэй эдийн засагч болно гэдэгтээ бүрэн итгэлтэй болов. Гэлээ гээд бүтээлдээ хэрхэн хууль болон институтууд зах зээлийн үр дагаварт нөлөөлдөг тухай анхаарал хандуулж байв. Тэрбээр *Хууль болон Эдийн Засгийн Ухааны Сэтгүүл* [анг. *Journal of Law and Economics*]-ийн эрхлэгч болж, хоёр гол нийтлэлийнхээ гүнзгий мэдлэгийн төлөө Нобелийн Шагнал хүртжээ.

Пүүсийн Байр Байдал [анг. *Nature of the Firm*] (1937 он) бүтээлдээ хэрхэн пүүсийн хэмжээ болон бүтэц хэлцлийн өртөг зардлаас хамаардгийг харуулсан – үүнд нь хэрэглэгч болон нийлүүлэгч олох судалгааны зардал, хэлцэл хийх зардал⁶³, гэрээгээ албадан хэрэгжүүлэх зардал⁶⁴ зэрэг зардал орно. Технологи эдгээр зардлыг маш ихээр өөрчлөх боломжтой байдаг нь зах зээлийн бүрэн шинэ бүтцэд (өнөөдрийн вэбэд-суурилсан “хуваалцах эдийн засаг⁶⁵”-ийн өсөлт харуулж байгаачлан) хүргэх болно гэсэн байдаг.

Нийгмийн Зардлын Асуудал [анг. *The Problem of Social Cost*] (1960 он)-дээ Көүз “төгс өрсөлдөөнт” зах зээл дээр зах зээлийн бүтэлгүйтэл гэж байх боломжгүй гэсэн өөрийн теоремоо гаргаж тавив. Хэлцлийн зардлыг нэмэгдүүлж (хуульзүйн маргааны зардал зэрэг) өмчийн эрхийг сайтар тодорхойлж гаргаагүй байхад зах зээл бүтэлгүйтдэг ажээ. Бүр тэгээд талууд хамгийн хямдхан харилцан үр өгөөжтэй шийдэл эрж хайх болно: жишээлбэл чимээ шуугиантай цех өртөг ихтэй хуулийн маргаанаар маргалдах

63 *bargaining costs*

64 *costs of enforcing contracts*

65 *sharing economy*-Энэ бол хувь хүмүүс дундаа эд зүйл болон үйлчилгээгээ хуваалцах эдийн засгийн тогтолцоо юм.

гэхээсээ илүүтэй хөршүүддээ нөхөн төлбөр өгөх мөнгө төлөх магадлалтай байх болно. Тиймээс зах зээлийн бүтэлгүйтлийн шийдэл заавал дүрэм журам байх албагүй ч хэлцлийн зардлыг бууруулдаг, зах зээлийн шийдэл үүсэж гарах боломж олгодог өмчийн эрхийг ойлгомжтой болгох явдал л байдаг. Энэхүү дүгнэлт байгаль орчны асуудал бэрхшээлийн талаархи, ойн аж ахуйгаас авахуулаад усны менежментийг дамжаад, өргөн нэвтрүүлгийн долгионы спектрийг хуваарьлах^[66] хүртэлхи бодлогын мэтгэлцээн маргаанд асар их нөлөөлсөн бөгөөд төрийн хамгийн бага интервенцтэйгээр ‘нийтийн сан’-гийн нөөц баялгийг удирдан зарцуулах тухай **Элинор Остром**ын бүтээлд ч санаа өгчээ.

[89] Милтон Фрийдмэн (1912–2006 он): Америк хүн, эдийн засагч. **Гол үзэл санаа:** Мөнгөний тоо хэмжээний онол; лицензжүүлэх явдал зөвхөн үйлдвэрлэгчдэд л тустай; сургууль сурах ваучер буюу эрхийн бичиг; амьдралын хэвмаягийг зохицуулахын эсрэг гаргалгаа нотолгоо; эдийн засгийн интервенцийн зориогүй үр дагавар. **Гол бүтээл:** *Капитализм ба Эрх Чөлөө [анг. Capitalism and Freedom] (1962 он); Сонгох Эрх Чөлөө [анг. Free to Choose] (1980 он).*

Фрийдмэн мэргэжлийг лицензжүүлэх болон инфляцийн бодлогын талаархи бүтээл нь өөрийг нь төр засгийн дүрэм журам, зохицуулалт болон эдийн засгийн менежмент урвуу муу нөлөөтэй байдаг гэдэгт итгүүлсэн, Нобелийн Шагнал хүртсэн эдийн засагч байлаа.

Гэвч мэргэжлийн амьдралынх нь ихэнхид иймэрхүү либерал үзэл бодол цөөнхийн үзэл бодол байсан: 1930-аад оноос 1980-аад он хүртэл дэлхийн эдийн засагт төр засгийн төлөвлөлт болон хяналтад итгэх явдал давамгайлж, ноёлж байв. Гэвч Фрийдмэн

66 *allocation of broadcast spectrum*

либерал үзэл санааны маш чадварлаг, бусдыг ятгамгай түгээгч байлаа⁶⁷. Эхнэр Рөүзийн хамтаар бичсэн, *Капитализм ба Эрх Чөлөө* [анг. *Capitalism and Freedom*] (1962 он)⁶⁸ гэсэн бүтээл болон *Сонгох Эрх Чөлөө* [анг. *Free to Choose*] (1980 он)⁶⁹ ТВ-ийн цуврал нэвтрүүлэг болон номоор нь дамжуулан сая сая хүмүүс чөлөөт зах зээл, нээлттэй худалдаа, эрх чөлөө, капитализмын талаар суралцаж мэдсэн. Централист буюу төвөөс-удирдах явдлыг таашаадаг хуучны сэтгэлгээ эцэст нь асар олон бүтэлгүйтлээсээ болж итгэлгүй зүйл болоход эдгээр үзэл санаа л тэдгээрийг орлох болов – энэ үзэл санаа дэлхийн иргэд болсон тэрбум тэрбум хүний өдөр тутмын амьдралын нэг хэсэг болжээ. ‘Хэдхэн хүнд л иргэншлийн явах чиглэлийг бодитоор өөрчлөх хангалттай өвөрмөц үзэл санаатай байсан билээ’ гэж АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн Дарга асан Алан Грийнспэн дүгнэсэн байдаг. ‘Милтон бол тэр хэдхэн хүний нэг байсан юм’.

Фрийдмэн Нью Йоркийн Брүүклинд Унгарын цагаач Еврей гэр бүлд төрсөн. Түүний эцэг нь олдсон ажлаа л хийдэг байсан бол ээж нь Нью Йоркийн хөлслөх байр буюу бүгчим өрөө⁷⁰нд хувцас оёдог байлаа. (Фрийдмэн хожим нь Сонгох Эрх Чөлөөнийхөө гэсэн телевизийн үзэгчдэд хэрхэн иймэрхүү ажлын байр хамгийн ядуу хүнд өөрийгөө-сайжруулах⁷¹ад нэг амин чухал шат нь болж байсныг тайлбарласан байдаг.) Гэр бүл нь гэртээ англиар ярих санал гаргацгааж, Милтон ч сургуульдаа гарамгай амжилт гарган Ратгерс болон Чикагод их сургуулийн орон тоонд тэнцээд тэндээ **Франк Найтын** дор суралцжээ.

Засгийн газрын янз бүрийн албан тушаалд томилогдож

67 *particularly able and persuasive communicator*

68 *Монгол хэлээр орчуулж гаргасан.*

69 *Монгол хэлээр энэ нэвтрүүлгийг бас ижил нэртэй номыг нь Хувь Заяагаа Сонгох нь гэсэн нэрээр орчуулж гаргасан.*

70 *sweatshop-тайлбарлах*

71 *self-improvement*

байсныхаа дараагаар Фрийдмэн өөрийнхөө найз Жорж Стиглер (1911–1991 он)-тэйгээ нэгдлээ – Найз нь хожим Миннесотагийн Их Сургууль байхдаа Нобелийн Шагналтан болох болно. Тэд *Дээвэр үү эсвэл Тааз уу?* [анг. *Roofs or Ceilings?*] (1946 он) гэсэн бүтээлд хамтран ажиллав. Энэ бол рент буюу түрээсийн хяналтаас эрс татгалзах тухай бүтээл бөгөөд түүндээ тэд энэ нь газрын эздийг өөрийнхөө өмчлөлийн өмчөө сахин хамгаалж, завсарлаж сайжруулах, түрээслүүлэх хүсэл зориггүй болгож, орон сууцны хангамж болон чанарыг бууруулах болно гэж батлан өгүүлсэн. Үүнтэй ойролцоо цаг үед Фрийдмэн *Мэргэжлийн Бие Даасан Ажил Эрхлэлтээс Ирэх Ашиг* [анг. *Income from Independent Professional Practice*] (1945 он) гэсэн бүтээлээ хэвлүүлэн (эмч, хуульч, нягтлан бодогч зэрэг) мэргэжлийг зохицуулах явдл^[72] аас гарах гол ашиг тусыг хүртэгч^[73] нь тэр ажлыг эрхлэгчид өөрсдөө байдаг. Харин дүрэм журмаар хамгаалахыг зорьдог тэр олон нийт ашиг тусыг нь хүртдэггүй болохыг харуулжээ. Дүрэм журам болон зохицуулалт өрсөлдөөнийг хязгаарладаг учраас хэрэглэгчид эцэст нь муу үйлчилгээний төлөө илүү их үнэ төлөхөд хүрдэг. Фрийдмэний энэ болон тэр асуудлын талаархи судалгаа нь түүнийг үнэндээ зөвхөн онолоор зогсохгүй капитализм бусад хувилбаруудаасаа илүүтэй эдийн засгийн (илүү их эрх чөлөө, ардчилал) асар их үр өгөөжийг бий болгодог гэж бат итгэхэд хүргэсэн.

Чикагод Фрийдмэн инфляцийн эсрэг тэмцэлд орлоо. Энэ үзэгдэл ялангуяа дайны дараахь он жилүүлдэд том зовлон бэрхшээл болоод байсан юм. Тэрбээр төр засаг инфляцийг удирдаж чадна, ажил эрхлэлтийг татварлах явдал болон зарцуулалтын бодлогоор дамжуулан нэмэгдүүлж чадна, эдийн засгийн өсөлтийг “нарийн тохируулж” чадна гэсэн Кейнсийн ортодокс үзл^[74]ийг хүчтэй шүүмжилж байв. Фрийдмэн инфляцийг хянахын тулд төр засаг эргэлтэд оруулж буй *МӨНГӨНИЙ*

72 *regulation of professions*

73 *chief beneficiaries*

74 *Keynesian orthodoxy*

тоо хэмжээг хязгаарлах ёстой гэж батлан өгүүлж байсан: үүнээс өөр ямар ч багаж хэрэгсэл ажиллахгүй. Гэвч иймэрхүү мөнгөний бодлого маш бүдүүлэг арга хэрэгсэл тул төр засаг зүгээр л найдвартай бүтэц бүрдүүлж, аливаа зүйлд бичил менежмент хийх гэсэн ямарваа нэг санаанаас татгалзах ёстой ажээ.

Капитализм ба Эрх Чөлөө нь Фрийдмэнийг шинжлэх ухааны эдийн засагч^[75] аас олон нийтийн алдартай сэхээтэн^[76] болгов. Энэ номдоо тэр цагийн үеийн олон нийтийн дараахь гол том асуудал бэрхшээлд анхаарал хандуулжээ: эдийн засгийн бодлого, арилжаа худалдаа, боловсрол, ялгаварлан гадуурхалт, монополь байдал, ядуурал үүнд нь багтана. **Жон Стюарт Милл** болон **Ф. А. Хаекийн** үзэл санаанд тулгуурлаж тэрбээр төр засгийн интервенц либерал бус, үр ашиггүй зүйл гэж батлан өгүүлж байлаа. Түүндээ хөгжил дэвшлийг тэтгэж дэмжих хувь хүмүүсийн нэр төр, олон янз байдал болон олон төрөлтэй байх явдлын үүрэг нөлөөг илэрхийлэн харуулж, эрх мэдлийг төвлөрүүлэх нь эрх чөлөө болон хөгжил цэцэглэлтийн асар том аюул занал болохыг анхааруулав. Түүнд дурдсан бодлогын жор нь тэр цаг үедээ байж боломгүй радикал буюу хурц ширүүн гэж харагдахаар байсан – тэгш буюу нэгэн жигд татвар нэвтрүүлэх, Понзи-хэвмаягтай үндэсний тэтгэврийн тогтолцоо^[77] г хувийн хувь хүний хадгаламжийн дансаар солих, шуудангийн салбарыг хувьчлах, цэрэгт албадан татахыг зогсоох, хар тамхийг эрүүгийн гэмт хэрэг биш болгох зэрэг зүйл үүнд багтжээ. Гэлээ гээд гучин жилийн дотор *Сонгох Эрх Чөлөөнд* дурдсан эдгээр үзэл санаа дэлхийн олон хэсэгт хэрэгжиж эхлээд байна.

Фрийдмэний радикал боловч нотолгоонд-суурилсан үзэл санаа, түүний ойлгомжтой, анхаарал татам тайлбар, мэтгэлцээний үеэрхи баясгалантай төрх нь түүнийг ТВ-ээр байнга гаргадаг, хэвлэл мэдээллийн дуртай хүн болгожээ. 1966-

75 *academic economist*

76 *public intellectual.*

77 *Ponzi-style national pension systems*

гаас 1984 он хүртэл *Нью Вийкийн* тогтмол нийтлэл нь түүнийг Америкийн хамгийн алдартай, бодлого тайлбарлагч болгов: тэрбээр яагаад хамгийн бага цалин залуу хар арьстнуудад туслах гэхээсээ илүүтэй тэднийг хохироодог болохыг нь тэдгээртээ тайлбарлаж хэвшжээ; хэрхэн өнөөгийн бодлого инфляц, үүний хамтаар хямралыг үүсгэх бол (давамгайлж буй эдийн засагчид боломжгүй зүйл гэж бодож байсан); хэрхэн том бизнесүүд чөлөөт зах зээлийн талаар ярьдаг ч төр засгийн таатай үйлдлээр хөгжиж цэцэглэсэн тухай; маш олон өөр зүйлийн тухай өгүүлж байжээ.

Улстөрчид, төр засгууд түүний зөвлөгөөг эрэлхийлж байв: тэрбээр Никсон засаг захиргаан^[78]д валют солилцооны тогтвортой ханш хэрэглэж асан хорин таван жилийг дуусгавар болгож, АНУ-ын долларыг хөвөгч валют болгоход нь тусалжээ – гээд түүний инфляцад ямар нөлөөгүй, эдийн засгийг л зөвхөн хохироох болно гэж урьдаас таамагласан, цалин болон үнийн хяналтыг Никсон нэвтрүүлэхэд тэрбээр огцорлоо.

Чикаго [их сургуулиас]-гоос халагдсаныхаа дараагаар Фрийдмэн Калифорни руу нүүсэн бөгөөд тэнд нь нэгэн ажил хэрэгч кино бүтээгч хүн түүнийг өөрийн нийгэм, эдийн засаг, улстөрийн үзэл санаагаа дэлгэцээр өөрөө тайлбарлах, хэдэн сая долларын цуврал баримтаг кино хийх санал тавив. Хагас цагийн сегмент бүрд Фрийдмэн түүний үзэл санаагаа Америкаас Ойрхи Дорнод хүртэлхи дэлхий даяархи байршил харуулсан газрын зургийн өмнө зүгээр л ямар ч үзүүлэх дүрс үгүйгээр жирийн хөнгөн өрнөлтэйгээр ойлгомжтой тайлбарлах болно. *Сонгох Эрх Чөлөө* гэсэн энэхүү цуврал бүтээл агшин зуур алдартай бүтээл болж, дэлхий даяар дэлгэцээр гарлаа. Ном нь ч ижил нэртэйгээр саяас илүү хувь зарагдсан байдаг. Эдгээр бүтээл Фрийдмэний либерал үзэл санааг асар олон үзэгчдэд, үүн дотроо өөрийн улс орондоо хуучны сэтгэлгээ нуран унахад улс орноо удирдах улстөрчдөд хүргэж аваачсан юм. ‘Энэтхэг болон

Хятадад хүмүүс үүнийг таньж мэдээгүй байж болох ч’ гэж эхлээд Нобелийн Шагналт эдийн засагч **Гари Беккер** ‘тэдний нөхцөл байдал сайжирсан явдалд талархах учиртай тэр хүн нь Милтон Фрийдмэн байсан юм’ гэж тайлбарлаж байв.

[90] Жэймс М. Бачэнэн (1919–2013 он): Америк хүн, эдийн засагч

[91] Гордон Таллокк (1922–2014 он): Америк хүн, улстөрийн эдийн засагч, хуульзүйн онолч. **Гол үзэл санаа:** Олон Нийтийн Сонголтын Сургууль; сонгогч, улстөрч, албан тушаалтнуудын шунаг ашиг сонирхол; төр засгийн бүтэлгүйтэл зах зээлийн бүтэлгүйтлээс илүү муу байх боломжтой. **Гол бүтээл:** *Санал Нэгдэх Явдлын Тооцоолол [анг. The Calculus of Consent] (1962 он); Өгөх Саналын Сэдэл [анг. The Vote Motive] (Таллокк, 1976 он).*

Бачэнэн болон Таллокк нар эдийн засгийн ухааны Олон нийтийн Сонголтын Сургуул^[79]ийг үүсгэж хөгжүүлэн, дэмжсэн билээ. Түүндээ хэрхэн өөрийн-тусыг бодогч сонгогчид, улстөрчид, албан тушаалтнууд төр засгийн шийдвэр-гаргах явцын байр байдал болон үр ашигт нөлөөлдөг болохыг харуулсан байдаг. Бачэнэн нь Нобелийн Шагнал энэхүү сэдвээр хийсэн бүтээлээрээ авсан.

Бачэнэн олон нутгийнхаа Теннессийн коллежээ дайны цагийн цэргийн алба хаахаасаа өмнө төгсжээ. Тэрбээр Чикагогийн их сургуульд суралцсан бөгөөд тэнд алдартай эдийн засагч **Фрэнк Найт** түүнийг ‘зах зээлийн эдийн засгийн атаархмаар өмгөөлөгч хамгаалагч’ болгож хувиргасан байдаг. Таллок дайны цагийн цэргийн албаа хаасны дараагаар хуулийн зэрэгтэй болж, Гадаад харилцааны албанд элсэн орж Ойрхи Дорнодод янз бүрийн газарт ажиллаж байжээ. Дараагаар нь Виржиниагийн Политехникийн Хүрээлэнд багшилсан бөгөөд хожим нь Бачэнэн

79 *Public Choice school of economics*

түүнтэй тэнд нэгджээ. Авьяас чадвараа эдийн засгийн ухаан болон олон нийтийн захиргааны асуудал нэгтгэснээр энэ хоёр Олон Нийтийн Судалгаанд Зориулсан Төвөө байгуулав (энэ төв хожим нь Жорж Мэйсон Их Сургууль рүү шилжжээ). Мөн тэр хоёр шинэ санаа агуулсан *Санал Нэгдэх Явдлын Тооцоолол* [анг. *The Calculus of Consent*] (1962 он) бүтээлд хамтран ажиллаж, бас *Олон Нийтийн Сонголт* сэтгүүлээ байгуулж гаргасан байдаг.

Олон Нийтийн Сонголтын онол зах зээлийн бүтэлгүйтэл нийтлэг байдаг, төр засгийн интервенц түүнийг залруулахад эсвэл засахад хэрэгтэй гэж итгэдэг байсан, давамгайлж буй “халамжийн эдийн засагчид^[80]”-ын төсөөллийг сорилтод оруулжээ. Гэвч тэр эдийн засагчид олон нийтийн бодлогыг рационал байдлаар, үр дүнтэйгээр гаргасан батлан өгүүлцгээж байв. Харин Бачэнэн болон Таллокк нар олон нийтийн шийдвэр-гаргах явцын рационал байдал болон үр ашигтай байдал алхам тутамдаа өөрийн-тусыг бодох явдал болон улстөрийн институтцийн өөрийнх нь тэр байр байдлаас болж ганхаж суларч байдаг гэж төсөөлж бодож байжээ.

Жишээлбэл сонгуулийн үр дагавар үр дүн объектив байдлаар “зөв” биш боловч (**Кондорсе** харуулсанчлан) энэ нь тухайн сонгуулийг явуулах ёс журмаас хамаардаг. Тиймээс *жирийн олонхийн засаглал*^[81] шийдвэр гаргах явдлыг хялбар болгосон боловч дөнгөж 50% + 1 гэсэн олонхи цөөнхөө мөлжиж ашиглах боломж олгодог байна. *Шалгуур-хангасан олонхийн засаглал*^[82] (нэрлэж хэлбэл гурваны-хоёрын эсвэл бүр санал нэгтэй байх явдал^[83]) шийдвэр гаргах явцыг хэцүү болгох ч гэлээ цөөнхөө хамгаалах болно.

Ямар ч тохиолдолд сонгууль “олон нийтийн ашиг сонирхол”-ын шалгуур биш харин *өрсөлдөж буй* ашиг сонирхлуудын

80 *welfare economists*

81 *simple majority rule*

82 *qualified majority rule*

83 *unanimity*

уралдаан байдаг. Хүчтэй, дундын тодорхой зорилго буюу үр дагаврын төлөөх ашиг сонирхол бүхий тусгай ашиг сонирхлын бүлэг нь сонгуульд ашиг сонирхол нь сарнисан, дунд зэрэг байдаг ерөнхий олон нийтээс илүү ихээр давамгайлж ноёлдог ажээ. Нэгэнт улстөрчид тэднийг сонгуулахад хүргэх эвсэл байгуулахын тулд дэмжлэгийг нь авахаар санал тавьцгаадаг тул тэдгээр бүлэг л улстөрийн хэлэлцэх асуудлыг тодорхойлж урагшлуулдаг. Энэ байдлыг *рент эрэлхийлэх* буюу *хонжоо хайх явдл*^[84] аар тэтгэдэг бөгөөд компани болон бүлэг хүмүүс өөрсдийгөө хамгаалах эсвэл өөрсдөдөө ашиг гаргах гэж ямар нэг хуулийн төлөө кампанит ажил явуулдаг гэж Таллокк хэлж байжээ. Үнэндээ лоббидох явдалд бага зэрэг хөрөнгө оруулах нь эргээд тусгай ашиг сонирхлын бүлгийн хувьд асар их санхүүгийн ашигтай байх боломжтой.

Улстөрчид хууль тогтоох явцаар өөрсдийн арга хэмжээгээ батлуулахын тулд *харилцан-наймаалцах явдл*^[85]ыг мөн ашигладаг: гэвч энэхүү ‘чи миний арга хэмжээг дэмжвэл би чинийхийг дэмжих болно’ гэсэн стратеги хүн бүрийн жинхэнээсээ хүсэж байснаас илүү их тогтоол шийдвэр гаргах явдлаар бидний хүсэл дуусах болно гэсэн үг юм. Эцэст нь хуулийг албадан хэрэгжүүлдэг захиргаадалтын ажилтнууд мөн л энэ үйл явцад өөрийн сэдлээ нялзааж хэрэглэдэг байна – жишээлбэл өөрийн эзэнт гүрнээ бүтээхийн тулд дүрэм журмыг маш ихээр нарийн хэцүү болгодог ажээ (эсвэл бүр авилгал авах бололцоогоо нэмэгдүүлдэг).

Энэхүү улстөрийн үйл явцаас үүсэж гардаг бодлого шийдвэрлэхийг оролдож буй бэрхшээлээсээ ч илүү хор хохиролтой байж болно гэж Бачэнэн болон Таллокк нар

84 *rent seeking*-үнэ цэнэ бүтээхгүйгээр ашиг олох гэсэн утгатай хэллэг.

85 *logrolling*-хууль тогтоох байгууллагын гишүүд өөрийн ашиг сонирхлоо урагшуулахын тулд нөгөө гишүүдтэйгээ тэдний саналыг дэмжээд өөрийнхөө саналаа хариуд нь бас дэмжүүлэхээр тохиролцдог байдлыг хэлдэг.

дүгнэсэн. *Зах зээлийн бүтэлгүйтэл* мэдээжээр байх ч бас *төр засгийн бүтэлгүйтэл* тэнд байдаг гэдгийг бид санаж байх ёстой ажээ.

[92] Муррэй Ротбард (1926–1995 он): Америк хүн, эдийн засагч, улстөрийн онолч. **Гол үзэл санаа:** Анархи-капитализм; валют чөлөөтэй хэвлэн гаргах. **Гол бүтээл:** *Хүн, Эдийн Засаг, Төр* [анг. *Man, Economy and State*] (1962 он); *Шинэ Эрх Чөлөөний Төлөө* [анг. *For a New Liberty*] (1973 он).

Ротбард *анархи-капитализмын* тэргүүний хошуулагч бас архитекторч байлаа. Тэрбээр төрийн албадлагын монополь эрхийг хувь хүний эрх чөлөө болон олон нийтийн сайн сайхн^[86]ы хамгийн аюултай аюул занал гэж үздэг байсан. Төр бол ‘зүйтогтолжсон, өргөн хүрээг хамарсан тонуулын байгууллага’ юм, харин олон нийтийн сайн сайхан^[87]д үйлчилдэг гэдэг хуулийг хууль тогтоогчид болох “дээрэмчдийн бүлэг”-ийн ашиг тусыг төлөө бүтээсэн ажээ. ‘Татварлах явдал бол үнэндээ зүгээр л хулгай’ гэж тэрбээр эхлээд ‘гээд энэ нь ямар ч мэдэгдэж буй алдартай хулгайчийн мөрөөдөх ч, найдах ч хэрэггүй тийм том, тийм өргөн хэмжээтэй хулгай л байдаг’ гэж бичиж байв.

Ротбард “корпорацын-шинжтэй төрийн монополь тогтолцоо”^[88]-гоор нийлүүлж олгодог бүх зүйлийг хувийн байгууллагууд илүү сайнаар нийлүүлэх боломжтой гэдэгт итгэдэг байжээ. Түүний анархи-капиталистч загвар^[89]т хүмүүсийг хамгаалах санал тавьдаг, цагдаа болон шүүхийн үйлчилгээ^[90]тэй өрсөлдөх хувийн хамгаалалтын байгууллага

86 *public welfare*

87 *public good*

88 *‘monopoly system of the corporate state’*

89 *anarcho-capitalist model*

90 *, policing and judicial services*

үүсэж гарна гэдгийг урьдаас харсан байдаг. Энэ явдал шүүх болон хүч хэрэглэх явдал дахь төрийн монополь эрхийг төгсгөх болно. Төрийн албадлагын эрх мэдэл эрх мэдэлтэнд, засаг захиргаанд тусгай эрх дарх олгодог нь **Иммануэл Кантын** тогтоож гаргасан, ижилхэн хандаж харьцах ёс суртахууны зарчмыг зөрчиж байгаа учраас ёс суртахуунгүй гэж Ротбард бодож байжээ. Жишээлбэл хар тамхи хэрэглэгчийг (тэдний өөрийгөө-мэдэх эрхэд халдаж) баривчилдаг цагдаагийн офицерыг хүн хулгайлсан гэж яллах ёстой гэж байв.

Ротбард эрхийн тухай эдгээр индивидуалистч үзэл санаа, мөн төрийг үгүйсгэдэг өөрийн анархист үгүйсгэлээ **Лүдвиг фон Мизэсийн** лэзе-фээр эдийн засгийн бодлоготой нэгтгэсэн. Тэрбээр төрийн мөнгө хэвлэх монополь эрхийг хөөсрөлт, огцом өсөлт, гарцаагүй хямралыг бүтээдэг зээлийн хэт их тэлэлтийг дэмждэг, ялангуяа маш сүйрэл дагууламтгай хууран мэхлэлт гэж (Мизэс болон **Ф. А. Хаекийн** тайлбарласанчлан) ойлгодог байлаа. Тэрбээр үр дүнд нь “хуульжсан хууран мэхлэлт”, үр дүнгүй зардал гарлага гэж үл тоомсорлодог төв банк, хэсэгчилсэн хадгаламжийн банкны үйл ажиллагаа^[91], мөн үл баталгаажсан мөнг^[92]ийг эсэргүүцэж байв. Үүний оронд тэрбээр 100 хувийн хадгаламжийн банкны үйлчилгээ^[93], сайн дурын алтан стандарт, эсвэл хоорондоо өрсөлддөг хувийн валют^[94]ыг өмгөөлж хамгаалдаг байсан. Түүний хувьд “Хүчирхийллийн зөв үүрэг бол хувь хүн болон өмчийг хүчирхийллээс хамгаалах явдал байдаг, мөн иймэрхүү хамгаалалтаас давсан аливаа хүчирхийлэл хэрэглэх явдал өөрөө түрэмгийлэл, шударга бус, гэмт хэрэг юм гэдгийг либертанианизмд баримталдаг” ажээ.

91 *fractional reserve banking* - банкны нөөцийн зөвхөн хэдэн хувийг л бэлэн байлгах, бэлнээр гаргах шаардлагатай байдаг банкны тогтолцоо.

92 *fiat money*

93 *reserve banking*

94 *private currencies*

АРАВДУГААР БҮЛЭГ: ӨНӨӨ ЦАГИЙН ЛИБЕРАЛ СЭТГЭГЧИД

Либерализмийн галыг Дэлхийн II Дайны дараагаар ассан хэвээр нь байлгахын тулд либералчууд шаргуу ажиллаж, үүнийгээ цаашид олон арван жил үргэлжлүүлцгээлээ. Коллективизмын хөнөөл дагуулсан үр дүн илэрхий болох тэр цаг үед либералууд социализмын дутагдалтай талын талаархи болон өөрсдийн хандлагын рационал байдлын талаархи бүрэн хэмжээтэй бүтээл зохиол^[1] хөгжүүлж гаргаж чадсан байдаг. Тэд мөн эдийн засгийн болон улстөрийн либерал бодлогыг дахин амилуулах бодлогын зэвсгийг асар ихээр зохиомжлон гаргацгаав: энэ бол нэгэн жигд татвар^[2], бие даасан төв банк, хувийн тэтгэврийн даатгал^[3], хувийн арбитрын үйлчилгээ, мэргэжлийг зохицуулалтгүй болгох^[4], төрийн үйлдвэрийг хувьчлах, хөрөнгө өмчлөгч ардчилал^[5], өөр олон зүйл үүнд багтаж байлаа.

Берлиний Хана 1989 онд нурахад Өрнөдийн олон нийт коммунизмын дэглэм дор амьдрал хэрхэн аймшигтай байсныг өөрсдөө харах боломжтой болсон. Эцэст нь либерал дэг журам оршин тогтноход аюултай чухам тэр гол аюул заналыг үгүй хийв. Гэвч үүнийг өөр хохирол учруулдаг аюул заналаар, ө.х.

1 *complete narrative*

2 *flat taxes*

3 *individual pension plans*

4 *deregulation of professions*

5 *capital owning democracy-Энэ бол монополь байдал үүсэж, давамгайлахаас илүүтэй бүтээлч өмчийг хүн амдаа ерөнхийд нь зөв шударгаар төрийн институтууд хуваарилдаг гэх нийгмийн тогтолцоо ажээ. Түүнд бүх хувь хүн зах зээлд зөв шударгаар, ижил бололцоотой оролдох явдлыг бататгахыг зорьдог гэнэ.*

холбиромтгой зохицуулалт^[6], популизм, данхар төр засаг, өсөж өндийж буй улстөрийн анги^[7]ар сольчихжээ. Орчин цагийн үеийн либералуудын хувьд шийдэх асуудал бага болсонгүй ээ.

[93] Гари Беккер (1930–2014 он): Америк хүн, эдийн засагч. **Гол үзэл санаа:** Эдийн засгийн ухааныг социологийн асуудалд хэрэглэх. **Гол бүтээл:** *Хүмүүн Хөрөнгө [анг. Human Capital] (1964 он); Ялгаварлах Явдлын Эдийн Засаг [анг. The Economics of Discrimination] (1971 он).*

Милтон Фрийдмэний шавь, өөрөөрөө эдийн засгийн ухааны Чикагогийн Сургуулийн тэргүүлэх гэрэл нь болсон Беккер Нобелийн Шагнал ‘микро-эдийн засгийн шинжилгээний хүрээг хүмүүний зан үйл болон харилцах үйлдлийн өргөн хүрээнд өргөжүүлж хэрэглэсэн’-ийхээ төлөө авчээ. Тэрбээр эдийн засгийн зарчмыг үүн дотроо зардал, өгөөж, үнэ, хөрөнгө оруулалт зэргийг уламжлал ёсоор зөн совин, соёл эсвэл сэтгэл хөдлөлийн хэрэг явдал гэж үздэг байсан хүмүүний амьдралын олон янз байдалд хэрэглэсэн. Түүнд бас боловсрол, гэмт хэрэг, цагаачлал, хар тамхи, эрхтэн шилжүүлэн суулгах, арьстны өнгөөр ялгаварлан гадуурхах явдал ордог.

Энэхүү шинжилгээ олон нийтийн бодлогод чухал үр нөлөөтэй байсан. Жишээлбэл Беккер цөөнхийн эсрэг ялгавар гадуурхах явдал илүү их өрсөлдөөнт зах зээлд бага байх болно гэдгийг харуулжээ. Пүүсүүдийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэхээр зохиомжилсон хууль эсрэг нөлөөтэй байв: зөвхөн-цөөнхийн пүүс зардлаа бууруулж, үр ашгаа нэмэгдүүлэн, цөөнхийн хүн амыг улам л ихээр ажилд авч өрсөлдөх боломжтой байсан.

Гэмт хэргийн талаар Беккер гэмт хэрэг үйлдэл байдал үргэлж оюуны зарим нэг гажиг согогийн үр дагавар байдаггүй

6 *creeping regulation*

7 *political class*

ч гэмт хэрэгтнүүд гэмт хэргээс гарах ашгийг баригдах магадлал, шийтгэл хүлээх, ял шийтгэл^[8]тэй нь харьцуулж өгөөжийн талаар рационал байдлаар үнэлж цэгнэдэг гэж батлан өгүүлэв. Илүү өндөр шийтгэл болон сайн албан хэрэгжүүлэх явдал асар ихээр хянаж ажиглах^[9] гэсэн либерал бус бодлогоос илүү их үр дүнтэй ажээ.

Беккер *хүмүүн капитал буюу хөрөнгө*^[10]ний талаар томоохон дэвшил гаргав. Боловсрол зөвхөн соёлын зүйл байгаад зогсохгүй бас хэн нэгний бүтээлч байдлыг огцом нэмэгдүүлэх зориулалттай, хувь хүний хөрөнгө оруулалт гэдгийг харуулав. Тиймээс боловсролын эрэлтийг зөвхөн соёлын утгаар биш бас эдийн засгийн утгаар шинжлэх боломжтой ажээ. Хүмүүний капитал буюу хөрөнгөний бусад хөрөнгө оруулалтад дадлагажилт бэлтгэл, ажлын туршлага, бүр эрүүл амьдралын-хэвмаяг^[11] ч ордог.

Беккер өөрийнхөө судалгааны хандлага буюу арга барил^[12]ыг ардчилалд, ялангуяа шунаг ашиг сонирхолтой бүлэг хүн^[13] бусдыг ашиглаж мөлжих явдалд хэрэглэсэн. Рент-эрэлхийлэгч^[14]ийн өгөөж нэмэгдэхэд бусад хүмүүсийн алдагдал зэрэг дэвших үйлдлээр л өсдөг гэж тэрбээр батлан өгүүлж байлаа. Аажимдаа тэсвэрлэхийн аргагүй болтол хавчигдахад алдагдалд орсон тэд эргэж ширүүнээр тэмцэх болно – энэ бол төр засгийг болон түүний зохицуулах, давуу тал олгох чадлыг хязгаарлах ёстой тухай өөр нэг гаргалгаа нотолгоо ажээ.

8 *chances of apprehension, conviction and punishment*

9 *greater surveillance*

10 *human capital*

11 *coordinated*

12 *approach*

13 *vested interest groups*

14 *rent seekers-үнэ цэнэ бүтээхгүйгээр ашиг ологч этгээд буюу хонжоо хайгч этгээд гэсэн утгатай хэллэг*

[94] Израэл Кирцнер (1930 он–): Америкийн эдийн засагч. **Гол үзэл санаа:** Ажил хэрэгч байдлын ач холбогдол; эдийн засгийн онол дахь динамик байдлын ач холбогдол. **Гол бүтээл:** *Өрсөлдөөн ба Ажил Хэрэгч Байдал* [анг. *Competition and Entrepreneurship*] (1973 он); *Нээлт, Капитализм, Хуваарилалтын Шударга Ёс* [анг. *Discovery, Capitalism and Distributive Justice*] (1989 он).

Еврей эрдэмтэн, раббины^[15] хүү Кирцнер Лондонд төржээ. Гэр бүл нь эхлээд Кэйп Таун, дараагаар нь Нью Йорк рүү нүүж, тэнд тэрбээр **Лүдвиг фон Мизэс**ээс суралцав. Тэрбээр эдийн засгийн түүх, зах зээлийн ёсзүйн талаар бичдэг байсан ч либерал сэтгэлгээнд оруулсан түүний гол хувь нэмэр бол эдийн засгийн үйл явц дахь ажил хэрэгч байдлын үүрэг нөлөө болон ач холбогдлын талаархи түүний бүтээлүүд юм.

Өрсөлдөөн ба Ажил Хэрэгч Байдал [анг. *Competition and Entrepreneurship*] (1973 он) гэсэн бүтээлдээ Кирцнер төгс өрсөлдөөний нео-классик, шинэ сонгодог загварыг төөрөгдөлд оруулахуйц статик зүйл гэж шүүмжилсэн. Эдийн засгийн ухаан бол хүмүүс бусдынхаа өөрчлөгдөж буй үйлдлийн хариу болгож үйлдлээ тохируулах, төлөвлөгөөгөө залруулдаг динамик буюу хөдөлгөөнт үйл явц юм гэж тэрбээр тайлбарлав. “Тэнцвэрт байдал”^[16]-д анхаарал төвлөрүүлдэг, харин хэрхэн зах зээл энэ тэнцвэрт байдалд хүрдгийг судалдаггүй эдийн засгийн уламжлалт онол хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагааг харилцан тохируулга хийлцдэг энэхүү байнгын үйл явцаар дамжуулан жинхэнээсээ зохицуулж байдгийг тайлбарладаггүй ажээ.

Энэхүү үйл явцын гол үндсэн хэсэг бол хүмүүс (заавал мэргэжлийн ажил хэрэгч хүмүүс биш бас жирийн хүмүүс) зах зээл дээрхи зай завсар, үл нийцэл байгааг олж хараад, дараагаар

15 *rabbi*

16 *'equilibrium'*

тэдгээрийг дүүргэх, залруулах гэж үйл хийдэг ажил хэрэгч байдал юм. Энэ байдал эргээд эдийн засгийн тохируулга болон зохицуулалт^[17] нь өөр хувь хүмүүсийн тухайн газрын зах зээлийн нөхцөлийн талаархи мэдлэгээс ихээр хамаардаг – энэ байдал нь хүн бүр “төгс мэдээлэл”-тэй байдаг уламжлалт төсөөллөөс ялгаатай гэдгийг санал болгожээ. Мөн энэ нь бидэнд бид заавал энэхүү ажил хэрэгч сэтгэл зүрх хөгжиж дэвжих зөв нөхцөлийг бүтээх ёстой болохыг сануулдаг.

Нээлт, Капитализм, Түгээлтийн Шударга Ёс [анг. *Discovery, Capitalism and Distributive Justice*] (1989 он) гэсэн бүтээлдээ Кирцнер “социал буюу нийгмийн шударга ёс”-ны тухай эдийн засгийн шүүмжийг өгч эдгээр үзэл дээрээ тулгуурлан бүтээжээ. Ажил хэрэгч хүмүүс байнга л шинэ баялаг бий болгож байдаг гэж тайлбарлаж байв. Дахин хуваарилахад бэлэн байгаа нөөц баялаг үргэлж өөрчлөгдөж байхад дахин хуваарилах замаар тэгш байдлыг удаан хугацаанд хэвээр нь байлгах боломжгүй. Ямар ч тохиолдолд ихэнхи хүмүүс ямар нэг шинэ зүйл бүтээсэн хүн шинэчлэлээсээ ашиг тусыг нь хүртэх бүрэн эрхтэй гэдэгт санал нийлдэг.

[95] Жүлиан Л. Саймон (1932–1998 он): Америк хүн, бизнесийн профессор. **Гол үзэл санаа:** Зах зээл хэрхэн ховор байдлыг ялдаг вэ; хүн ам тустай нөөц баялаг болох нь. **Гол бүтээл:** *Цор Ганц Нөөц Баялаг* [анг. *The Ultimate Resource*] (1981 он); *Нөөц Баялаг Дүүрэн Дэлхий* [анг. *The Resourceful Earth*] (1984 он).

Саймон дэлхийн нөөц баялаг хэт их хүн ам, хэт их олборлолтоос болж дуусаж буй тухай уламжлалт үзэл санааны гол шүүмжлэгч байв. Бодит байдал дээр нөөц баялаг хямд болсоор буй гэж батлан өгүүлсэн. Нэмэгдэж буй эд баялаг, илүү сайн технологи шинэ нөөц баялаг ашиглах боломж олгосон;

17 coordination

хуучны нөөц баялгийг дахин хэрэглэх хэрэглээнд ашиглах боломжтой; бид байнга л ховор нөөц баялгийн шинэ хувилбарыг хөгжүүлж гаргаж ирж байжээ.

Үнэт металын урт хугацааны үнэ энэхүү гол санааг дэлгэж харуулдаг гэж Саймон батлан өгүүлдэг байсан. Учир нь тэдгээрийн үнэ тогтвортой эсвэл унаж байжээ. Тэрбээр Америкийн биологич Поол Р. Эхрлич (1932 он–)-тэй алдартай бооцоогоо тавив. Энэ биологич уламжлалт үзэл бодлын тэргүүлэх өмгөөлөгч хамгаалагчдын нэг бөгөөд Эхрличийн сонгож авсан таван металын ямар ч багс арван жилийн дараа хямдхан байх болно гэж түүнтэй энэ мөрийг тавьжээ. Тэгээд ийм зүйл болов: арван жилийн дараа Эхрлич хариу хүлээлгүйгээр Саймон руу өөрийнх нь авах бооцоог нь, тооцоо дүүрэн хуудсын хамт илгээсэн байдаг.

Саймон нь Томас Малтус (1766–1834 он)-ын олонд алдаршсан, өсөж буй хүн ам эдийн засгийн хүндрэл учруулах болно гэсэн үзэл санааг үгүйсгэлээ. *Цор Ганц Нөөц Баялаг* [анг. *The Ultimate Resource*] (1981 он) болон бусад бүтээлдээ тайлбарласанчлан өсөж буй хүн ам нөөц баялгийг хоосруулж дундруулахгүй харин үнэндээ хүмүүс шинийг сэтгэдэг учраас энэ нь ховор хомс байдлын бэрхшээлийг шийдэх шийдэл болдог. Хүмүүний институт гэвч хүмүүний оюун ухаан адилаар амин чухал бөгөөд бодит бэрхшээл хэт олон хүндээ бус харин эрх чөлөөнд хэт олон хязгаарлалт тавьсан явдал л байдаг ажээ.

Зах зээлийг найдвартай өмгөөлж хамгаалагч Саймон авиакомпаниуд аялагчдад хэт олон захиалгатай байгаа нислэгээсээ татгалзвал тэднийг санамсаргүй сонголтоор “хөөж” гаргахын оронд бэлэн мөнгөний урамшуулал олгох ёстой гэж санал болгосон – энэ үзэл санааг аажимдаа [тээврийн] зохицуулагч нар хүлээн зөвшөөрч, одоо агаарын тээврийн бизнест байнга ашигладаг үйлдэл болжээ.

[96] Элинор Остром (1933–2012 он): Америк хүн,

улстөрийн эрдэмтэн. **Гол үзэл санаа:** Олон нийтийн сайн сайхны менежмент дэх өөрөө-тогтдог дэг журам^[18]. **Гол бүтээл:** *Жирийн Олныг Засаглах нь* [анг. *Governing the Commons*] (1990 он).

Нобелын Шагналт хүртсэн, олон нийтийн нөөц баялгийг хамгийн сайнаар удирдаж залах тухай Остромын бүтээлийн санаа нь түүний ирээдүйн нөхөр Винсент Остром өмнөд Калифорнид усны нөөц баялгийн менежментийн талаархи судалгаагаар хийхэд тусалснаар гарчээ. Уламжлалт эдийн засгийн ухаанд нийтийн нөөц баялаг, үүн дотроо загас, газрын-тосны талбай, бэлчээр нутаг, ой эсвэл усан хангамж зэргийг хэрэв төрийн зохицуулалтаар л үүнээс сэргийлэхгүй бол л хэт ихээр ашиглах хэрэглэх болно гэж үздэг. Остромын судалгаа, үүн дотроо Африк болон Непалын судалгаагаар энэ явдал худлаа гэдгийг харууллаа. Үнэндээ хэрэглэгчид голдуу урт хугацаанд экотогтолцоогоо удирдаж залах өөрийн гэсэн арга замтай байцгаадаг – энэ шийдэл бол олон нийтийн бодлогын интервенцээр хялбархан үгүй хийчих шийдэл юм.

Остром нийгэм *иргэний сайн дурын эвслээрээ* дамжуулан экотогтолцоог хамгаалах олон янз байдалтай арга замыг үүсгэж хөгжүүлдэг гэдгийг харуулжээ. Эдгээр арга зам нь харилцаа холбоо, итгэлцэл, хэрэглэгчдийн хоорондох хамтын ажиллагаанд үндэслэдэг бөгөөд түүнийг үр дүнтэй хянаж шалгах, шийтгэл оногдуулах^[19], маргаан шийдвэрлэх явдлаар дэмждэг. Тухайн орон газрын нөхцөл байдал маш чухал байдаг учраас шийдвэрийг үндэстний төвшинд биш тухайн газарт нь гаргавал хамгийн сайн байдаг ажээ. Цагдаагийн үйлчилгээ үүний жишээ юм. Хотууд голдуу л орон нутгийн цомхон цагдаагийн хүчтэй байдаг нь хэрэгцээгүй, үр дүнгүй гэж итгэн тэдгээрийг нь илүү том анги нэгж рүү нэгтгэж нийлүүлдэг. Гэвч Остром энэ хоёрын

18 *public goods management*

19 *sanctions*

аль нь ч мөнгө хэмнэж бас гэмт хэрэг бууруулахгүй, үнэндээ үүнээс нилээд ондоо үр дүнтэй байдаг гэдгийг харуулсан.

Орон нутгийн, “хагас-төвлөрсөн” менежмент холион бантан^[20] мэт харагдаж байж болох ч энэ нь ажилладаг гэж Остром дүгнэсэн байдаг. Орон нутгийн нөхцөл болон түүнд оролцдог хүмүүсийн хоёулынх нь олон янз байдал төр засгийн дээд төвшинд нүдэнд харагдахгүй байж ч болох юм. Хагас-төвлөрсөн менежмент^[21] шийдвэрийг илүү хурдан, юмс үзэгдэлтэй нь илүү ойроос гаргах боломж олгодог гэнэ. Бид тиймээс төрд хэт их итгэл өөрсдийнхөө амьдралыг залуулж удирдуулах гэж өгөхдөө тун болгоомжтой байх ёстой ажээ.

[97] Волтер Виллиамс (1936 он–): Африк-Америкийн эдийн засагч, улстөрийн онолч. **Гол үзэл санаа:** Нийгэм, улстөр, эдийн засгийн либертанианизм; лэзе-фээр тогтолцоо дэлхийн хамгийн ёс суртахуунтай, үр бүтээлтэй тогтолцоо болох нь; арьсны өнгийн тухай хуулийн сөрөг нөлөөтэй байр байдал. **Гол бүтээл:** *Харуудын Эсрэг Зогсдог Төр* [анг. *The State Against Blacks*] (1982 он).

Ном нийтлэл арвин ихээр гаргаж Виллиамс либертари нийгэм, улстөр, эдийн засгийн үзэл санааны тэргүүлэх өмгөөлөгч хамгаалагч болжээ. Тэрбээр өөрийгөө мэдэх^[22] сонгодог либерал зарчим зэрэг олон асуудалд хатуу тууштай чиг шугам баримталж ирсэн. Өмчлөлийн амин чухал хэсэг бол өөрийн өмчилдөг зүйлээ зарах, эсвэл бусдад өгөх боломжтой байх явдал юм: тиймээс өөрийн эд эрхтэнээ зарахын эсрэг хууль байх ёсгүй гэж Виллиамс хэлдэг. Тэрбээр үүнтэй адилаар эдийн засгийн бодлогын талаар шулуухан хэлдэг бөгөөд төв банкны өөрийн улсын валютыг мэдэх монополь эрх үнэндээ хууран

20 *hodgepodge*

21 *Poly-centric management*

22 *self-ownership*

мэхлэх лиценз ажээ.

Виллиамс чөлөөт зах зээл, лэзе-фээр нь хүмүүн төрөлхтөний одоохондоо бодож гаргасан хамгийн ёс суртахуунтай, үр дүнтэй тогтолцоо гэж батлан өгүүлдэг. Капитализмын өмнө хүмүүсийн цөөнхи нь булаан авах, дээрэмдэх, бусдыг боолчлох зэргээр эд баялаг олж авдаг байсан гэж тайлбарлаж байв. Үүнээс ялгаатай нь капитализм хүн бүрд бусдад үйлчлэх замаар эд баялагтай болох боломж олгосон ажээ.

Харуудын Эсрэг Зогсдог Төр [анг. *The State Against Blacks*] (1982) гэсэн бүтээлдээ харуулсан, Виллиамсийн судалгаанаас цөөнхийн ажил эрхлэлтийг огцом нэмэх гэсэн төр засгийн интервенц (цалингийн доод хэмжээ, арьсны өнгөөр ялгаварлах боломж олгох үйлдэл^[23]) үүнийхээ эсрэг нөлөөтэй байсныг дэлгэж харуулав. Жишээлбэл хүмүүсийг ажилд авах явдлын зардлыг нэмэгдүүлж цалингийн доод хэмжээ нь угаасаа муу боловсролтой, ур чадвартай багатай байх хандлагатай цөөнхийг ажил олгогчид ажил авахаасаа улам л татгалздаг болгосон байдаг. Иймэрхүү хууль үл тэвчих, ялгаварлан гадуурхах^[24] аас илүү муухай зүйл гэж тэрбээр дүгнэжээ – энэ шүүмжлэлийн зохиогч нь өөрөө хар арьстан байсан нь түүнийг улам бүр л илүү хүчтэй болгосон.

[98] Роберт Нозикк (1938–2002 он): Америк философич.
Гол үзэл санаа: Минималистч төр^[25]; хүмүүсийн жам ёсны ёс суртахууны эрх хуульзүйн институтүүдээс бүр урьдын зүйл болох нь; дахин хуваарилах явдалд ямар ч рационал тооцоо байдаггүй; хувааж өгөхөд бэлэн эд баялгийн тогтвортой нөөц гэж байдаггүй. **Гол бүтээл:** *Анархи, Төр, Утопи* [анг. *Anarchy, State and Utopia*] (1974 он).

23 *affirmative action*

24 *bigotry and discrimination*

25 *minarchist state*

Мэргэжлийн амьдралынхаа ихэнхийг Харвардад өнгөрүүлсэн Нозиккийг *Анархи, Төр, Утопи* [анг. *Anarchy, State and Utopia*] (1974 он) бүтээлээр нь хамгийн сайн мэддэг. Энэхүү номын цомхон төрийг хамгаалсан, буулт үл хийгч хамгаалалт шинжлэх ухааны хүрээллийнхн^[26]ийг цочирдуулжээ. Төрийг хувь хүний амьдран суух буюу амьд явах эрх, өмч, гэрээний эрхийг хамгаалахаар л зөв хязгаарлах ёстой гэж батлан өгүүлж байв. Төр өөрийн эрх мэдлээ эд баялаг эсвэл орлогыг дахин хуваарилах, хүмүүсийг ёс суртахуунтай үйл хийлгэхээр албадах, эсвэл хүмүүсийг өөрсдийгөө гэмтээхээс нь сэргийлэхэд ашиглахгүй байж болно. Хувь гишүүдийнхээ ашиг тусыг хамгийн их болгох ёс суртахууны төлөвөөс өөр ямар зохицуулалт гэж байдаггүй.

Хувь хүмүүсийн эрх болон ёс суртахуун хүмүүс хэрхэн бусадтайгаа харьцах боломжтой болохыг хязгаарладаг. Эдгээр нь санал нэгдэх боломжтой аливаа “нийгмийн гэрээ”-нээс ч өмнө оршиж байв. Бид тэдгээрийг бидний сэдэл ямар ч байсан гэсэн ёс суртахуунтайгаар зөрчих боломжгүй. Жишээлбэл бид урагшлуулж хөгжүүлэх өөрийн гэсэн сайн сайхантай тийм нийгмийн байгууламж^[27] байдаггүй учраас зарим хүмүүсийг өөрсдийнхөө өмчийг (жиш. татвар төлөх байдлаар) “нийт нийгмийн сайн сайхан”-ыг дэмжихийн тулд золиосол гэж хүчилж чадахгүй: энд зөвхөн хүмүүсийн хүрээллийг бүрдүүлдэг, нэг бүр нь өөр өөр ашиг сонирхолтой хувь хүмүүс л байдаг. **Иммануэл Кант** хувь хүмүүс *арга хэрэгсэл* биш харин *зорилго* юм гэж шаргуу ятгаж байсанчлан: бид нэг хүнийг бусад хүмүүсийн ашиг тусын төлөө буруугаар ашиглах боломжгүй ажээ. ‘[Я]мар ч ёс суртахууны тэнцвэржүүлэх үйл бидний дунд байх ёсгүй’ гэж Нозикк дүгнэжээ. ‘Нийт нийгмийн аугаа сайн сайханд хүргэх гэж бусад хүн бидний амьдралыг солигт гаргах явдалд ёс суртахуун гэж байдаггүй. Бидний зарим нэг нь бусдынхаа төлөө өөрийгөө золиослох ямар ч үндэслэл байхгүй’.

26 *academic establishment*

27 *social entity*

Нозикк нь **Жон Локкийн** адилаар жам ёсны эрхийн үзэл санаанаас эхэлсэн өөр дүгнэлтэд хүрчээ. Жишээлбэл тэрбээр эрхийг салшгүй зүйл гэж үзсэнгүй: хүмүүс жишээлбэл сайн дураараа боолчлогдох гэж гэрээнд сайн дураараа санал нэгдэх боломжтой ажээ. Тэрбээр Локк нийгмийн гэрээний ямар нэг төрөл иргэний институтц үүсэж гарахад хэрэгцээ шаардлагатай байсан гэж үзэж төсөөлөхдөө алдсан гэж бодож байсан: **Адам Фергүсон** болон **Адам Смит** цохон заасанчлан хүмүүний нийгмийн психологи харилцан ашигтай зохицуулалт өөрөө-бүрэлдэх байдлаар үүсэж гарах боломжтой, бас ийм байдлаар үүсэж гардаг зүйл ажээ.

Муррэй Ротбард зэрэг анархи-капиталистууд хүч байхгүй үед үүсэж гарч ирэх зүйл нэг бүр нь хүмүүстэй тэдний эрхийг хамгаалах гэж батлан хамгаалах, шүүхийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулдаг хувийн төрөл бүрийн байгууллага л байх болно гэж бодож байсан. Гэвч Нозикк энэхүү өөрөө-бүрэлдэх үйл явцаар цор ганц үүсэж гарах тэр зүйл бол эдгээр үйлчилгээгээр хангадаг нэг л байгууллага, мөн чанартаа төр л гарах болно гэж батлан өгүүлж байжээ. Гэвч хэрэв хувь хүмүүсийн үндсэн эрхийг хүндэлдэг хэвээр байхын тулд уг төрийн эрх мэдлийг хязгаарлах ёстой. Төр зөвхөн хувь хүмүүсийн эрхийг бататгах, тэднийг албадлага, хулгай, хууран мэхлэлтээс хамгаалах, тэр сайн дурын гэрээг албан хэрэгжүүлэх гэж л оршдог ажээ – түүнд өөр ямар ч үүрэг байхгүй. Нозикк гэвч энэхүү цомхон төр хэн нэгний эрхэд халдахгүйгээр хүрэх боломжтой харилцан ашиг тусыг хамгийн их болгосоор л байх болно гэж шаргуу ятгаж байв. Хэн ч иймэрхүү зохицол нийцлийг гээж орхиод өөрийнхөөрөө өөр нэг зохицуулалт хийн үүнээс сайн зүйл хийж чадахгүй.

Анархи, Төр, Утопи бол Жон Роолсын нийгмийн гэрээний хандлагыг “хамгийн бололцоотой муутай хүмүүсийн хамгийн их ашиг тус”-ыг тэтгэхэд ашигласан *Шударга ёсны Онол* [анг. *A Theory of Justice*]-ын жинлүүрийн эсрэг тал юм. Энэхүү бодлого нийгмийн бүтэн байдлыг сахин хамгаалахад хэрэгтэй гэж Роолс хэлж байв. Нозикк харин үүнийг нь энэ нь Роолсын

зүгээр л ёс суртахууны төсөөлөл гэж үгүйсгэсэн: хэний ч эрхийг зөрчихгүй түүнд халдахгүй байсаар байх хүртэл сайн хүмүүс өөрийнхөө тэр давуу талыг “Вилт Чамберлайн”-ы жишээнд үзүүлдэг шигээр хүссэнээрээ хэрэглэх эрхтэй ажээ. Бид ямар нэг “шударга” хуваарилалтаас эхлэлээ гэж төсөөлөхийг санал болгосон байдаг; гэвч Вилт Чамберлайн гэдэг сагсан бөмбөгийн од байв, түүний тоглолтыг үзэх гэж мөнгө төлөхөд бэлэн мянга мянган хүн байжээ. Тэрбээр тэр орой зөндөө мөнгөтэй болж харин тэр хүмүүс арай бага мөнгөтэй болов. Тэр од болон энэ хүмүүс одоо санхүүгийн хувьд тэгш бус байдалтай байна – гэвч энэхүү өөрчлөлт цэвэр сайн дурын үндсэн дээр гарчээ. Хэрэв бид шударга хуваарилалтаас эхэлбэл (энэ жишээн дэх шигээр) хэн ч шударга бусаар үйл хийхгүй, харин үр дүнд нь гарч буй хуваарилалт тэр үед тэгш бус бас шударга байх мөн ёстой гэж дүгнэсэн байдаг. Аливаа нэг тодорхой хуваарилалт (санхүүгийн тэгш байдал зэрэг)-ыг бий болгох, сахин хамгаалахын тулд төр хүмүүсийн эрхийг бусад хүмүүсийн ашиг тусын төлөө зарим нэгнээс нь авч хүчээр зөрчихөөр зөвхөн зогсдоггүй; төр энэхүү шударга бус үйлээ өдөр бүр давтан хийсээр л байх болно.

Эд баялаг бол энэ байдлаар хуваалцах гэж *зүгээр л оршиж байдаг* тийм нэг зүйл биш юм гэж Нозикк шаргуу ятгаж байлаа: эд баялаг бол хүмүүс хүчин чармайлт, чадвар, ажил хэрэгч байдал, авьяасаараа *бүтээдэг* тийм үйл ажээ. Чухал эм олж нээсэн эрүүл мэндийн эмчилгээний судлаач жишээлбэл үүнийхээ төлөө өөрийнхөө хүссэн төлбөрийг авах бүхий л эрхтэй. Учир нь энэ үйл явцаараа тэрбээр хэнийг ч гэмтэж хохироогоогүй, ашиг тустай бололцоог л зөвхөн тэрбээр нэмжээ.

Нозикк өөр нэг жишээндээ өөрийнх нь итгэж буйгаар төр хэр зэрэг цомхон байх ёстойг харуулсан байдаг. Нэг хүн шаргуу ажиллаж, *мөнгө олж байхад* нөгөө нэг нь наран дор залхуурч хэвтсээр сохор зоос ч үгүй байж гэнэ. Яагаад бид эхний хүнээс нь (татвараар дамжуулан) мөнгө авч хоёрдох нь (түүнийг албадан хөдөлмөрлүүлж) зүгээр суухыг болиулахын оронд өгдгийг илүү шударга гэж бид нар бодох ёстой гэж? Энд ямар ч ялгаа алга

гэж Нозикк дүгнэсэн байдаг: татварлах үйлдэл бол боолчлолын хэлбэр, энэ бол бидний эрхийг зөрчиж буй үйлдэл ажээ.

[99] Хернандо де Сото Полар (1941 он –): Перүгийн эдийн засагч. **Гол үзэл санаа:** Хөгжил дэвшил дэх өмчийн эрх болон институцийн ач холбогдол. **Гол бүтээл:** *Өөр Зам: Гуравдагч Ертөнцийн Үл Харагдах Хувьсгал* [анг. *The Other Path: The Invisible Revolution in the Third World*] (1986 он); *Хөрөнгийн Нууц* [анг. *The Mystery of Capital*] (2000 он).^[28]

Перүгийн дипломатын хүү Сото болон түүний гэр бүл 1948 оны цэргийн эргэлтийн дараагаар Европ руу дүрвэжээ. Тэрбээр Перүд гучин жилийн дараа буцан ирж, Эрх Чөлөө болон Ардчиллын төлөөх Хүрээлэнгээ байгуулсан. Энэ хүрээлэн нь Перүгийн эдийн засагт мэдэгдэхүйц нөлөөтэй тинк танк буюу судалгааны байгууллага байжээ. Гаргасан бодлогуудад нь захиргаалтын хэлхээг үгүй хийх^[29], өмчийн эрхийг үүсгэж тогтоох явдал багтаж байв. Энэ нь Перүгийн хамгийн ядуу хүмүүсийн заримд нь албан бус эсвэл “хар” эдийн засагт түгжигдэн байхаасаа илүүтэй хуульзүйн дагуу бизнес эхлүүлэх, өмч өмчлөх боломж олгожээ.

Хэт их зохицуулалт болон дүрэм журам, өмчийн эрх байхгүй байгаа нь хүмүүс хуульзүйн дагуухь бизнес бий болгох явдлыг хэцүү болгож, тэд үүний оронд албан бусаар бизнесээ бүтээжээ гэж батлан өгүүлсэн. Гэвч ийм бизнесийг өргөжүүлж тэлэх боломжгүй. Өргөжүүлж тэлбэл (голдуу л авилгажсан) засаг захиргааны анхаарал татах болно; бизнес эсвэл бүр газар эсвэл орон байрныхаа хуульзүйн дагуухь эрх дарх байхгүй ядуу хүмүүст аж ахуйдаа хөрөнгө оруулахын тулд зээл авахдаа барьцаалах ямар ч зүйл байдаггүй. Тэдний хөрөнгө де Сотогийн

28 Монгол хэлээр орчуулан гаргасан.

29 cuts in red tape

хэлэхээр үхмэл хөрөнгө ажээ – энэ бол бодитой байгаа ч ашиглах боломжгүй. Учир нь энэ нь хуулиас гадуурхь хөрөнгө юм. Төр засагтайгаа хамтран ажиллаж де Сото бизнес эхлэхэд шаарддаг цаасны ажлыг мэдэгдэхүйцээр бууруулж, бага хэмжээтэй фермер болон ажил хэрэгч хүмүүст өмчийн эрхийг хамааруулах ажлыг гардан зохион явуулжээ. (Үр дүнд нь хөгжил цэцэглэлт хамгийн ядуу Перүчүүдийн дунд гарч, даалууны нөлөө тус улсын Гэрэлтэх Зам партизаны хөдөлгөөний дэмжлэгийг үгүй хийсэн бөгөөд энэ нь де Сотогийн албан байранд тэсрэх бөмбөг тавихад хүргэж байв.)

Де Сото мөн хөгжингүй улс орны хүмүүс өмчийн эрх, хуульзүйн тогтолцоо, хүнээс үл хамаардаг шүүх, мэдээлэл олж авах боломж^[30] зэрэг институтийг баталгаатай байдаг зүйл гэж боддог гэж батлан өгүүлж байсан. Үр дүнд нь тэд эдгээр зүйл байдаггүй хүмүүсийн хүнд нөхцөлийг ойлгож чаддаггүй. Жишээлбэл хуульзүйн тогтолцоо өмчлөлийн талаархи бичиг баримт гаргах, хадгалахад амин чухал хэрэгтэй байдаг бол нээлттэй мэдээлэл арилжаа худалдаанд хүмүүс үнэ шалгаж мэдэх, зээлд хамрагдах боломжтой байдлаа мэдэх, өмчлөгчийн нэрийг мэдэх^[31] гэх мэт олон зүйлийг боломжтой болгож амин чухал байдаг. Олон ядуу улс оронд эдгээр ашиг тус баячуудад очдог боловч орчин үеийн зах зээлийн эдийн засаг энэ бүгдийг бүх нийтээрээ таашаан эдэлж буй эсэхээс хамаардаг ажээ.

[100] Дийдр МакКлоский (1942 он–): Америк хүн, эдийн засагч, түүхч. **Гол үзэл санаа:** Эдийн засгийн өсөлт дэх либерал үнэт зүйлийн үүрэг нөлөө. **Гол бүтээл:** *Жижиг Хөрөнгөтний Сайн Тал* [анг. *The Bourgeois Virtues*] (2006 он); *Жижиг Хөрөнгөтний Нэр Төр* [анг. *Bourgeois Dignity*] (2010 он); *Жижиг Хөрөнгөтний Тэгш Байдал* [анг. *Bourgeois Equality*] (2016 он).

30 *impartial justice and access to information*

31 *check prices, credit worthiness, ownership titles*

Крикет тоглодог, хуучны Марксист Дийдр МакКлоский эрэгтэй хүн болж төрсөн ч (Доналд МакКлоский) 53 насандаа эмэгтэй болжээ. Түүний эхэн үеийн ном зохиолд нь мөнгөний онолын тухай, мөн эдийн засгийн ухаанд уран илтгэл ашиглах талаархи бүтээл ордог. Гэвч түүний үзүүлсэн гол нөлөө Британийн эдийн засгийн түүхийн судалгааны үр дүнгээс нь хожим гарчээ. Энэ судалгаандаа сүүлийн хоёр зууны туршид гарсан эдийн засгийн асар том их өсөлтийг хөрөнгө эсвэл институтцээр биш харин либерал үзэл санаа, ялангуяа “хөрөнгөтний үнэт зүйл” тархаж түгсэн явдлаар сайн тайлбарлах боломжтой гэж дүгнэсэн байдаг.

МакКлоский сүүлийн үеийн эдийн засгийн өсөлтийн асар их цар хүрээг тод томруунаар харуулсан. 1800 онд дундаж хүмүүн төрөлтөн ойролцоогоор өдөрт \$3 дунджаар олж байв. Өнөөдөр энэ нь \$33 болжээ (энэ бол хамгийн ядуу улсуудын олон тоотой хүн амын тоогоор дундажлагдаж буурсан тоо юм). Энэ үеэр хүн ам 1800 оноос хойш долоо дахин өссөн – харин \$33 болсон явдал хүмүүн төрөлтөн тэр үед байснаасаа дал дахин их эд баялаг бүтээдэг болжээ гэсэн үг юм. Бас энэ нь зүгээр л дан материаллаг байдлаар баяжих явдал биш билээ: эд баялаг өсөж, амьдрал уртсаж, бичиг үсэгт тайлагдах явдал нэмэгдсэнээр оюун ухаан болон соёлын хувьд баяжиж цэцэглэх явдал мөн гарчээ.

Энэхүү *аугаа баяжих явдал*^[32] ойролцоогоор 1860 оны үест эхэлсэн. Энэ явдлыг арвандөрөвдүгээр зууны Хар үхлээс хойших Британийн эдийн засгийн тогтвортой өсөлтөөр, мөн хожим нь арваннаймдугаар зуунд эхэлсэн Аж Үйлдвэрлэлийн Хувьсгалаар ч, Британийн институтцүүдээр болон хууль ёсоор ч тайлбарлах аргагүй. Зөвхөн үзэл санаа л юмсыг ийм хурдан хугацаанд өөрчлөх чадвартай гэж тэрбээр шаргуу ятгаж байв. Жирийн хүмүүст анх удаа эрх чөлөө, нэр төртэй байх, хөгжил цэцэглэх боломж олгосон “Хөрөнгөтний либерализм” тархан түгснээс

аугаа баяжих явдал үндэслэж гарав. Энэ хүртэлхи зуу зуун жилд арилжаа худалдааг утгагүй муу зүйл гэж бодож байжээ. Гэвч **Жон Локк** болон **Адам Смит** зэрэг зохиогч нар эрх чөлөө, арилжаа худалдаа, эд баялаг болон хөрөнгө хуримтлагдах явдал, жирийн иргэдэд өгсөн нэр төр болон өөрийгөө үнэлэх явдлын сайн талыг хамгаалж байсан. Гэнэтхэн л бүтээлч байдал болон ажил хэрэгч байдлыг арагш нь юу ч хойш чангааж чадахаа больжээ.

[101] Дэвид Д. Фрийдмэн (1945 он–): Америк хүн, анархи-капиталист эдийн засагч, хуульзүйн онолч. **Гол үзэл санаа:** Анархи-капитализм; хувийн хууль; хуультай санал нэгдэх явдалд төрийн хэрэгцээ байхгүй; либертанианизмийн зохистой ашиг тус. **Гол бүтээл:** *Эрх Чөлөөний Механизм* [анг. *The Machinery of Freedom*] (1973 он).

Дэвид Фрийдмэн бол Нобелийн Шагналт эдийн засагч Милтон Фрийдмэн, түүний эхнэр Рөүзийн хүү билээ. Өөрийнх нь хүү Патри Фрийдмэн (1976 он–) бол *далайн чөлөөт хөвөгч нутаг үүсгэх*^[33] талаархи бүтээлээрээ алдаршсан, өөр нэг либертари онолч юм.

Фрийдмэн үнийн онол болон эдийн засгийн бусад сэдэвт хувь нэмэр оруулсан боловч түүнийг ялангуяа зах зээлийн анархистч хуульзүйн онолоор нь сайн мэддэг. Тэрбээр төр бол хэрэгцээ шаардлагагүй муу зүйл, төрийн бүх үйлчилгээг өрсөлдөөнт хувийн эдийн засаг, үүн дотроо хууль өөрөө үүнд ороод илүү сайн хангах нийлүүлэх боломжтой гэдгийг сахин хамгаалдаг ажээ: ‘Хууль бүтээх нь машин, хүнс үйлдвэрлэхээс дутуугүй хялбар ажил тул хэрэв төр засаг машин эсвэл хүнс үйлдвэрлэхдээ чадваргүй юм бол яагаад та нар дараагаар нь дотор нь машин болон хүнс үйлдвэрлэхээр болж байгаа тэр хуульзүйн тогтолцоог

33 *seasteading-энэ бол аливаа засгийн газрын өмчилдөг нутаг дэвсгэрийн гадна, олон-улсын далайнд оршдог, далайн чөлөөт хөвөгч байнгын нутаг бүтээх тухай концепц юм.*

төр засаг бий болгохдоо сайн байх болно гэж бодож байгаа юм бэ? Үүнийгээ дэмжиж тэрбээр ихэнхи хууль аль хэдийнээ *хувийн хууль*^[34] болсон, үүний дээр гэмт хэргийн ихэнхи нь төрийн эсрэг (гэрээний хууль болон нийтийн хуул^[35]инд байдаг шиг) биш харин хувь хүмүүсийн эсрэг гарсан (бас түүнд нь тэднийг мөрдөн мөшгөдөг) болсон гэж батлан өгүүлдэг. *Эрх Чөлөөний Механизм* [анг. *The Machinery of Freedom*] (1973 он)-доо энэхүү сэдвээ шинжилж судалжээ.

Энэхүү хандлага хуульзүйн кодыг анархи-капиталистч хүмүүсийн хүрээлэл буюу нийгэмлэгийг бүтээх талуудын санал нэгдэх явдлаар тогтооно гэж төсөөлдөг **Муррэй Ротбард** зэрэг бусад тэргүүлэх анархи-капиталистч нарынхаас ялгардаг. Мөн тэрбээр Ротбардаас зах зээлийн капитализмын төлөөх *консеквенсиалистч* гаргалгаа нотолгоо^[36]гоороо ялгардаг. Ротбард анархи-капитализмыг хувь хүмүүсийн халдашгүй жам ёсны эрх^[37]ийн үндсэн дээр зөвтгөдөг байсан бол Фрийдмэн төр засгийн үйлдлийн зардал болон ашиг тусыг шинжлээд төргүй байсан бол энэ нь илүү ашигтай байх байсан гэж үздэг болжээ. Ротбард либертанианизмыг “хувьсгалч” хөдөлгөөн гэж үздэг бол Фрийдмэн үүний оронд төр засгийн үйл ажиллагааг улам нэмэн хувьчлах^[38]ыг таашааж, хуулийн хувьчлал^[39]ыг өөрийг нь төгсгөхийг дэмждэг байна.

34 *private law*

35 *contract law and the common law*

36 *consequentialist argument*

37 *inviolable natural rights*

38 *privatisation of government activities*

39 *privatisation of law*

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ДҮГНЭЛТ

Либерал мэтгэлцээн

Либерализм бол идеологи буюу үзэл баримтлал биш харин үргэлжилж буй мэтгэлцээн юм. Түүний зорилго хувь хүний эрх чөлөөг хамаг сайнаар хэрхэн хамгийн их болгох явдлыг олж нээх явдал ажээ. Либералууд хүмүүн төрөлтөн төгс биш, төгс болох ч боломжгүй гэдгийг мэддэг; бидний ертөнцийг цэвэр зарчмаар тайлбарлах боломжгүй, бас жирийн томъёогоор залж чиглүүлэх ч боломжгүй. Үйл явдал бол голдуу рационал биш, үр ашигтай байхаас хол байдаг, хүмүүн төрөлтний үйлдлийн үргэлж зориогүй урьдаас таамаглах аргагүй үр дагавар юм. Бидний хамгийн сайн бодлого бол хүмүүний бодит байдлыг хүлээн зөвшөөрөх, үүнийг үр ашигтай чиглэл рүү залах явдал ажээ.

Либерализм мөн л хүмүүн төрөлтөн олон янз байдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд өөр өөрийн зорилгодоо хүрэхээр тэмүүлэх орон зай, бололцоог нь хамгийн их болгохыг л эрэлхийлдэг. Либерализм ийм олон янз ертөнцийн иргэд хэрхэн хамтдаа эв найртай хамтран ажиллах боломжтой вэ гэдгийг лавлаж судалдаг. Үүний эхлэл цэг бол хэрэв үйл явцынхаа үеэр бусдыг хохироогоогүй бол энэ нь хүмүүс хүн бүрийн бодож сэтгэх, ярьж хэлэх, ажиллах, өөрийн зорилгодоо хүрэхээр тэмүүлэх эрх чөлөө юм; либералчууд бие даасан шүүхийн тогтолцоо энэхүү дэг журмыг сахин хамгаалахад ач холбогдолтой болохыг илэрхийлдэг. Тэд хүмүүсийн өөрийн зорилгодоо өөрийн арга замаараа бүр энэ нь өөрийгөө-гэмтээх байсан ч гэсэн ямар нэг зүйл хийхийнхээ өмнө зарим нэг засаг захиргаанаас зөвшөөрөл авахгүйгээр хүрэхээр тэмүүлэх эрх чөлөөг дэмждэг. Тэд хувийн оронзайг улстөрийн засаг захиргаа эрх дархтан интервенц хийх буюу хөндлөнгөөс оролцох эрхгүй, ерөөсөө иргэддээ ийм зүйл хийх эрхгүй тийм орчин гэж ойлгохыг хүсдэг. Тэд эдгээр эрх

чөлөөг хумихыг хүссэн хүн бүр *маш хүчтэй* үндэслэл нотолгоо гаргаж харуулах ёстой гэж батлан өгүүлцгээдэг.

Өнөөдрийн либералууд өөдрөг үзэлтнүүд билээ. Тэд эдийн засгийн чөлөөт дэг журамд итгэлтэй байдаг. Тэд энэ дэг журам дэлхий даяар түгэн тархах нь хүмүүст, ялангуяа ядуус хүмүүст илүү сайн боловсролтой болох, илүү удаан наслах, өвчин зовлонгүй байх, илүү их бололцоотой болох боломж өгөх болно гэдгийг сахин хамгаалдаг. Технологи болон даян дэлхийн зах зээл улам л олон хүмүүст хөдөлмөрийнхөө үр шимийг алс холын өөр бусад хүмүүст зарж борлуулах боломж олгодог нь төрөлжилт болон үр ашгийг улам их болгодог ажээ. Бусадтай хийх арилжаа худалдаагаар өөрсдийн нөхцөлөө сайжруулах хүмүүсийн хүсэл хүчтэй хэвээр л байна.

Энэ чинь либерал ертөнц мөн үү?

Гэлээ гээд хэцүү төвөгтэй, тодорхой бус, тайван бус, олон янз байдалтай энэ цаг үед олон хүн төр засгаас хамгаалалт, эдийн засгийн аюулгүй байдал хараачилсаар л байдаг болжээ. Үүний хариуд тэдгээр төр засаг томорч, мөн улстөрчдийн болон албан тушаалтны эрх мэдэл, бусдыг өмгөөлж хаацайлах явдал нэмэгдэж байна. Либерал хүн бүр үүний аюулыг мэддэг.

Либералчууд эрх мэдэлд байгаа хүмүүсийг хуульзүйн дагуухь өөрсдийнх нь эрх дархын хязгаарлалтыг өөрсдөө хүлээн зөвшөөрдөг болгож хараахан амжаагүй л байсаар байна. Гэлээ гээд эдийн засаг, улстөр, нийгмийн эрх чөлөөний дэмжлэг дэлхий даяар түгэн тархсаар байгаа нь аялал жуулчлал, боловсрол, харилцаа холбоо сайжирснаас ихээхэн болжээ – мөн чөлөөт хүмүүсийн бүтээлч суут ухааныг ухаж ойлгосон гарамгай либерал сэтгэгчдийн үе үеийнхэн гаргасан эдгээр эрх чөлөөг дэмждэг гаргалгаа нотолгооноос бас энэ бүгд хамаарч ирсэн билээ.

ЛИБЕРАЛ ЭШЛЭЛ

- [1] Хүмүүсийг удирдахын тулд ард нь алх.

Лаоз

- [2] Чамайг улстөр сонирхдоггүй гэдэг нь зүгээр л улстөр чамайг сонирхохгүй гэсэн үг биш шүү.

Перикл

- [3] Эрх чөлөө бол түүнийг хамгаалах эр зоригтой зөвхөн тэр л хүмүүсийн баттай өмч билээ.

Перикл

- [4] Нэг номтой хүнээс болгоомжил.

Тома Аквин

- [5] Чөлөөт хүн бол сэцэн ухаан нь хийж чадах тэдгээр зүйлийг хийхийг хүссэн зүйлээ хүч чадлаараа хийхдээ хоригддоггүй хүн юм.

Томас Хоббес

- [6] Жам ёсны эрх^[1] ... бол өөрийн хүч чадлаа өөрөө өөрийнхөөрөө, өөрийн байр байдлаа хадгалж үлдэхийн тулд хэрэглэх гэж хүн бүрд байдаг эрх чөлөө юм; дурдаж хэлбэл өөрийнх амьдрал билээ.

Томас Хоббес

- [7] Ямар нэг зүйл мэддэг аливаа хүн бүх хүн жам ёсны эрх чөлөөтэй төрдөг гэдгийг эсэргүүцэхээр тэнэг байх боломжгүй.

Жон Милтон

- [8] Төр засгийг байгуулдаг, түүнд захирагдахаар зөвшөөрдөг хүмүүсийн цор ганц зорилго бол шударга ёс болон

1 *The right of nature*

хамгаалалт олж авах явдал юм; энэ хоёрыг хоёулыг нь өгч чадахгүй бол энэ нь тэр хүмүүст өөрсдийн аюулгүй байдлынхаа төлөө тэд хамгийн сайн байх гэж бодсоноороо үйл хийх эрх өгдөг.

Алжернон Сидний

- [9] Хүмүүс байр байдлаараа бүгд эрх чөлөөтэй, ижил тэгш, бие даасан байдаг тул хэн ч тэднийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өмчийг нь булаан авч, бусдын улстөрийн эрх мэдэлд захируулах боломжгүй бөгөөд өөрийн зөвшөөрсөн саналаараа тав тухтай, аюулгүй эв найртай амьжиргааныхаа төлөө, өөрийн өмчөө баталгаатай эдлэн таашаах гэж нийгэмд нэгдэж, нийлдэг.

Жон Локк

- [10] [Y]нэмлэхүй эрх мэдэл хүмүүний цусыг цэвэрлэж, хүмүүний байр байдлын дорой талыг залруулдаг гэж боддог тэр хүн үнэндээ үүний эсрэг зүйлийг батлан өгүүлсэн энэ эсвэл өөр бусад цаг үеийн түүхийг унших хэрэгтэй.

Жон Локк

- [11] [X]үн бүрд өөрт нь өмч гэж бий. Энэ өмчид нь өөрөөс нь өөр хэнд ч ямар ч эрхгүй байдаг. Түүний биеийн хөдөлмөр бол түүний өмч гэж бид хэлж болно ... Нийт нийгэм рүү нэгдэж орох, өөрсдийгөө төр засгийн удирдлагад оруулах гэсэн хүмүүсийн аугаа, гол зорилго тиймээс өмчөө хадгалж үлдэх явдал байдаг.

Жон Локк

- [12] Халаг гэж! Эрх мэдэл өдөр бүр л амжилттайгаар эрх чөлөөг няцалж байгаа нь илэрхий байна; тэдгээрийн дундах тэнцвэр бараг л алдагдчихжээ. Харгис дарангуйлал бараг бүх дэлхийг хучиж, хүмүүн төрөлтний үндэс салбар бүрт цохилт өгч буй нь дэлхийг нядлагын газар болгочихжээ; энэ нь нэг бол өөрийгөө устгах хүртлээ эсвэл устгахаар өөр юу үлдэхгүй болтол нь мэдээж цаашид үргэлжлүүлэн устгасаар л байх болно.

Томас Гордон

- [13] Би хүнд жам ёсны зүйл байдаг найрсаг чанар, сайхан сэтгэл ч тэр, бас оюун ухаан болон өөрийгөө-хориглох байдлаараа үйлдэж чадах жинхэнэ сайн үйл ч тэр хоёулаа нийгмийн үндэс биш гэдгийг дэлгэж харуулснаараа өөрөөрөө бахархдаг; гэвч энэ дэлхийд бидний муу зүйл гэж нэрлэдэг зүйл, ёс суртахуун мөн жам ёс бол биднийг нийгэмшихүйц бодгаль болгодог, ямар ч эргэлзээгүйгээр бат суурьтай үндэслэл, амьдрал, бүх арилжаа, ажил эрхлэлтийг дэмждэг аугаа том зарчим юм: эндээс л бид заавал бүх урлаг болон шинжлэх ухааны жинхэнэ гарал үүслийг харах ёстой байдаг бөгөөд муу зүйл дуусах цаг мөчид нийгэм хэрэв бүхэлдээ тарж бутардаггүй юм аа гэхэд заавал муудсан байх ёстой.

Бернард Мандевилл

- [14] Байгалийн төлөвд ... бүх хүн ижил тэгш төрсөн ч тэд энэхүү ижил тэгш байдалтайгаар үргэлжлэн [амьдрах] боломжгүй. Нийгэм тэднийг үүнийгээ алдахад хүргэдэг бөгөөд тэд зөвхөн хуулийн хамгаалалтаар л үүнийгээ сэргээн авдаг.

Монтескю

- [15] [Б]айнгын сургамж туршлага бидэнд эрх мэдэлтэй хүн бүр түүнийг буруугаар ашиглах хандлагатай байдгийг харуулдаг; тэрбээр хязгаарлалт хориг олж харах хүртлээ л цааш явдаг.

Монтескю

- [16] Засаглах урлаг бол үндэстнийхээ гуравны-хоёрыг үлдсэн гуравны нэгнийхээ ашиг тусын төлөө төлж чадах бүх зүйлээ төлдөг болгох явдал ажээ.

Волтаир

- [17] Үзэл бодлын эрх чөлөө^[2] байхгүй бол цэцэн ухаан мэт ийм

2 *freedom of thought-энэ нь freedom of speech, freedom expression*

зүйл байхгүй; үг хэлэх эрх чөлөө байхгүй бол олон нийтийн эрх чөлөө зэрэг ийм зүйл байхгүй.

Бенжамин Франклин

- [18] Үг хэлэх эрх чөлөө^[3] бол чөлөөт төр засгийн үндсэн тулгуур юм; энэхүү тулгуурыг авчихвал чөлөөт нийгмийн үндсэн хууль задарч үгүй болон, түүний нуранги дээр харгис дарангуйлал цогцлох болно.

Бенжамин Франклин

- [19] Аливаа төрлийн эрх чөлөө гэнэтхэн л алга болох нь ховор ... Гэвч хэрэв хэвлэлийн эрх чөлөө^[4] алдагдвал энэ нь тэр даруйдаа л устдаг.

Дэвид Юм

- [20] Тиймээс л хаад, сайдууд хувь хүмүүсийн эдийн засгийг харж ханддаг гэж дүрсгэх нь, тэдний зардлыг хязгаарладаг нь хамгийн дээд увайгүй зан, бардамнал байх болно ... Тэд өөрсдөө ямар ч ялгалгүйгээр нийгмийнхээ үрэлгэн этгээдүүд^[5] байдаг. Тэдэнд өөрсдийн зардлаа өөрөө харах боломж олгож, харин тэднийг хувь хүмүүст өөрсдийнх нь зардлыг итгэж үлдээх нь аюулгүй байж болох юм.

Адам Смит

- [21] Төрийг хамгийн дорд бүдүүлэг байдлаас нь эд баялгийн хамгийн дээд зэрэг хүргэхэд зүгээр л эв найр, бага хялбар татвар, шүүхийн хүлцэхүйц захиргааны явдлаас өөр юу ч хэрэггүй; үлдсэн бүх зүйлийг нь юмс үзэгдлийн жам ёсны явц бий болгоно.

Адам Смит

- [22] Өөрийн ашиг сонирхолдоо хүрэхээр тэмүүлэхдээ [хувь хүн бүр] жинхэнээсээ үүнийг тэтгэх гэж зорихоосоо илүү их үр

гэдгээс өөр.

3 *Freedom of speech*

4 *liberty of the press*

5 *pendthrifts*

дүнтэйгээр нийгмийг байнга дэмжиж байдаг.

Адам Смит

- [23] Хувь хүн бүрийн өөрийн нөхцөлөө сайжруулах гэсэн жам ёсны хүчин чармайлт ... маш хүчирхэг бөгөөд энэ нь ямар ч тусламжгүйгээр дангаараа нийгмийг эд баялагтай, хөгжиж цэцэглэсэн болгох чадалтайгаар барахгүй хүмүүний тэнэг хууль хэт олонтоо үйл ажиллагаанд нь тээг болдог зуу зуун хатуу ширүүн саад тотгорыг давах боломж олгодог.

Адам Смит

- [24] Шударга төрийн үйлдэл буюу функц хүмүүст хамгийн бага хориглолт тавих, хамгийн их эрх чөлөөг нь батлан хамгаалах явдал бөгөөд энэ нь хэзээ ч хүнийг эд зүйл гэж үздэггүй.

Иммануэл Кант

- [25] Эрх мэдэл таашаан эдлэх нь гарцаагүй оюун ухааныг самууруулж, эрх чөлөөг нь бохирдуулдаг.

Иммануэл Кант

- [26] Нэг албадлага хэрэглэвэл үргэлж дараагийнх нь гарцаагүй хэрэглэх болдог.

Андерс Чидениус

- [27] Өөрийн эрх чөлөөгөө аюулгүй байлгахыг хүсэж буй тэр хүн бүр өөрийн дайснаа дарлал хэлмэгдүүлэлтээс заавал хамгаалж өмгөөлөх ёстой; хэрэв тэрбээр энэхүү үүргээ зөрчвөл ийм зүйл өөрт нь ирэх үүдийг үүсгэж тогтоож буй нь тэр юм.

Томас Пэйн

- [28] Шийтгэл шударга байхын тулд энэ нь хүнийг гэмт хэрэг үйлдэхийг нь болиулж ятгахад л хангалттай байхуйц хатуу чанга шаталсан хэмжээ^[6]нээс бүрдэх ёстой.

Чезар Беккэриа

[29] Би Бурханы ширээний өмнө хүмүүний оюун ухааныг дарлах харгис дарангуйллын аливаа хэлбэрт мөнхөд дайсагнахаа андгайлж байна.

Томас Жефферсон

[30] Төр засгийг эсэргүүцэх сэтгэл зүрх тодорхой тохиолдолд маш үнэ цэнэтэй байдаг тул би үүнийг үргэлж амьд хэвээр байлгахыг хүсэж байна. Түүнийг голдуу л буруу ашиглах гээд байдаг ч гэсэн энэ нь түүнийг хэзээ ч ашигладаггүй байхаас хамаагүй дээр зүйл юм.

Томас Жефферсон

[31] Цензүр буюу утга санааны шүүлтүүрээс гардаг муу зүйл бол түүний үр дүнг хэмжих боломжгүй, мөн энэ нь хаана дуусахыг нь хэлэх боломжгүй байдаг явдал юм.

Жереми Бентам

[32] Буруу засаглалаа нуух халхлах халхавч болгож ихэвчлэн ашигладаг хэд хэдэн бүрхэг нэршлийн дундаас энэхүү хий хоосон зэрэглээ шиг уур амьсгалд “дэг журам” гэдэг үгнээс илүү нүдэнд тусах нь үгүй.

Жереми Бентам

[33] Бүх эрхмэдлийг, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрхмэдлийг нэг байгууллагад, нэг эсвэл хэдхэн, эсвэл олон гэхдээ өв залгамжилсан, өөрийгөө-томилсон, эсвэл сонгогдсон хүнд бөөгнөрүүлэхийг зүгээр л харгис дарангуйллын маш илэрхий тодорхойлолт гэж шударгаар зарлан мэдэгдэж болно.

Жэймс Мадисон

[34] [Б]үх эрх мэдлийг анхнаас хүмүүс эзэмшиж байсан, үүнээс улбаалаад тэднээс л энэ нь үүсэж гардаг. Төр засгийг хүмүүсийн сайн сайхны тулд институтцжүүлж, тэдний төлөө ажиллуулах ёстой; хүмүүсийн энэ сайн сайхан нь амьд явах, эрх чөлөө, өмчтэй болох эрхээ таашаан эдлэхээс бүрдэх бөгөөд ерөнхийдөө аз жаргал болон

аюулгүй байдалдаа хүрэхээр тэмүүлж, тэдгээрээ олж авах эрх билээ.

Жэймс Мадисон

- [35] Хямрал бол харгис дарангуйлагчийн дайны уухай юм.

Жэймс Мадисон

- [36] Аугаа их эрх мэдэл голдуу сайн нэрээ баллаж завхруулдаг; энэ нь гарцаагүй муу зүйлийг илүү их хорлонтой үйлдэнэ ... Төр засгийн эрх мэдлийг нэмсэн хувь хэмжээгээр түүний өөрийнх нь шинж чанар болон хүмүүсийн шинж чанар хоёулаа мууддаг.

Каролины Жон Тэйлор

- [37] Төр засаг өөрийн гараа хөлөө бэхжүүлэх, мөн өөрийн институтээ мөнхийн зүйл болгохдоо боловсролыг ашиглахаас ч сийхгүй.

Виллиам Годвин

- [38] Төр засгийн дүрэм журам бүгд ямар нэг байдлаар албадлага бөгөөд тэдгээр нь ийм биш байсан ч гэсэн хүмүүст өөрсдийг нь гаднаас сургах, чиглүүлэх, тэдэнд туслахыг хүлээх тийм зуршил суулгадаг.

Вилхелм фон Хамболдт

- [39] Бидний хэрэг явдлыг шийдвэрлэх гэж төр засаг оролдох бүрд бид үүнийгээ өөрсдөө шийдсэн бол гарахаас зардал илүү их болж, үр дүн нь улам бүр мууддаг.

Бенжамин Констант

- [40] Хүмүүсийг завхарсан бүтэлгүй этгээд гэж хэлэх хэрнээ тэд бүгдийн тодорхой хэсэгт нь улам л их эрх өгөх гэдэг нь хачин санаа юм ... үүний эсрэгээр тэд [төр]-энд бага эрх мэдэл өгөх ёстой.

Бенжамин Констант

- [41] Хүмүүст өөрийн ур чадвар, эсвэл авьяасаа гуравдагч талын эрхэд халдахааргүй байхад нь чөлөөтэй ашиглахыг нь хориглох тэр үедээ тэр хүний ур чадварт байдаг өмчид

нь халдаж буй болно.

Жан Батист Сэй

- [42] Гэвч сургамж туршлагаас төр ч, бас банк ч энэ эрх мэдлээ буруугаар ашиглахгүйгээр цаасан мөнгө хэвлэх хязгааргүй эрх мэдэлтэй хэзээ ч [sic]^[7] байгаагүй болох нь харагддаг; тиймээс бүх төр засаг цаасан мөнгө хэвлэхдээ зарим нэг шалгуур болон хяналт дор үүнийгээ хийх ёстой; тухайн цаасан мөнгө хэвлэгчийг цаасан мөнгөнийхөө оронд нэг бол алтан зоос эсвэл цутгамал алтаар төлөх үүрэг хүлээдэг болгох шиг маш зөв [хяналтын] зорилго гэж байхгүй.

Дэвид Ричардо

- [43] Өөрийн оюун санааны эрх болон хүч чадлаа атаархмаар хайрлаж хамгаалдаг, ямар ч хүнийг өөрийн эзэн гэж дууддаггүй, идэвхигүй эсвэл өв залгамжилж авсан бат итгэлээр өөрийгөө хязгаарладаггүй, энэ нь хаанаас гарч буйгаас үл хамаарч өөртөө гэрэл гэгээ нээдэг хүнийг л эрх чөлөөт хүн гэж би хэлнэ.

Виллиам Эллери Чаннинг

- [44] Хүмүүний иргэний байна уу эсвэл сүм хийдийн байна уу аливаа эрх мэдлийг сохроор дагаж мөрдөх, нийцээгүй байдлаар захирагдах тухай сургаал бол дарангуйллын сургаал бөгөөд Бүгд Найрамдахчууд болон Христосын Шашинтны дунд байх газар түүнд байх ёсгүй.

Анжелина Гримке

- [45] Хууль үнэн зорилгоогоо гажиж холдсон байж болохын хэрээр, хуулиар өмчийг хамгаалахын оронд түүнд халддаг болох тэр үед хүн бүр хууль гаргахад оролцохыг хүсэж, нэг бол тонуулаас өөрийгөө хамгаалах гэж эсвэл түүнийг тонуул хийхэд ашиглахыг хүсдэг. Улстөрийн асуудал үргэлж хорлонтой, давамгайлсан, бүхнийг-шингээгч байх

7 [sic]-үүнийг ингэж үгийн эсвэл хэсэг үгсийн ард бичсэнээр энэ бол яг зохиогчийн бичснийг хэвээр бичив гэсэн санааг үзүүлдэг.

болно. Хууль тогтоох явц руу оролцох гэсэн тэмцэл тулаан, мөн хууль тогтоох явц дотор ч тэмцэл тулаан гарах болно.

Фредерик Бастиа

- [46] Амьдрал, эрх чөлөөт байдал, өмч хүмүүс хууль гаргасан учраас оршдоггүй. Үүний эсрэгээр амьдрал, эрх чөлөө, өмч түүнээс өмнө байсан учраас хүмүүс юуны түрүүнд хууль гаргахад хүрсэн.

Фредерик Бастиа

- [47] Одоо хуульжсан тонуулыг хязгааргүй олон арга замаар хийх боломжтой болжээ. Тиймээс бидэнд түүнийг зохион байгуулах хязгааргүй олон төлөвлөгөө бас байна. Үүнд: тарифын хамгаалалт, ашиг тус, татаас, тэтгэмж, шатлан нэмэгдэх татвар, олон нийтийн сургууль, баталгаатай ажил, баталгаатай ашиг, хамгийн бага цалин, тусламж авах эрх, үнэгүй зээл, гм зүйл орно...

Фредерик Бастиа

- [48] Хүч бол [зовлонг арилгах] эм биш.

Жон Брайт

- [49] Ардчилал хувь хүмүүсийн оронзайг тэлж, харин социализм түүнийг хязгаарладаг. Ардчилал хүн бүрд байж болох бүх үнэ цэнийг олгодог; социализм хүн бүрийг төлөөний хүн, зөвхөн тоо болгодог. Ардчилал болон социализмд ямар ч ижилхэн зүйл байхгүй ч нэг л хэрэглэдэг үг л бий: тэгш байдал. Гэвч ялгааг нь анзаарцгаагаарай: ардчилал эрх чөлөөний тэгш байдлыг эрж хайдаг байхад социализм хязгаарлалт, боолчлолын тэгш байдлыг эрж хайдаг билээ.

Алекс де Токкевилл

- [50] Америкийн Бүгд Найрамдах Улс улстөрчид нь хүмүүсийг өөрсдийнх нь мөнгөөр авилгалдах боломжтой гэдгийг таньж мэдэх хүртэл оршсоор байх болно.

Алекс де Токкевилл

- [51] Нэг л хүмүүн төрөлтний эрх чөлөөг боолчилбол дэлхий

даяар эрх чөлөө аюулд орох болно.

Виллиам Ллойд Гаррисон

- [52] Хэрэв бүх хүн төрөлхтөн нэг хүнээс бусад нь нэг ижил санаатай байвал энэ хүн эрх мэдэлтэй байсан бол бүх хүмүүн төрөлхтөнийг дуугүй болгох үндэслэл түүнд байдаггүйтэй адилаар хүмүүн төрөлхтөнд тэр нэг хүнийг чимээгүй болгох үндэслэл бас байхгүй.

Жон Стюарт Милл

- [53] Нэрэндээ таарсан цор ганц эрх чөлөө бол бид бусдын зүйлийг тэднээс булаан авах эсвэл түүнээ олж авах гэсэн хүчин чармайлтыг саатуулж хорихгүй байвал өөрийн арга замаараа өөрийн сайн сайхан руугаа хүрэхээр тэмүүлэх тэр эрх чөлөө юм.

Жон Стюарт Милл

- [54] Олонхи нь цөөнхиө захирдаг гэсэн зарчим бол үнэн хэрэгтээ бүх төр засгийг зүгээр л хоёр төрлийн хүмүүсийн хоорондохь хэн нь захирагч, хэн нь харин тэдний боол байх тухай өрсөлдөөний талбар болгодог...

Лисандер Спүүнер

- [55] Муу бодол гэмт хэрэг биш.

Лисандер Спүүнер

- [56] [Т]өр засаг гэж хэлж болох зүйлд энэ нь бүхэлдээ сайн дурын дэмжлэгээс нэгэнтээ хамаарахаа больсон бол түүнд саруул ухаанаар итгэж, эсвэл түүнийг үзэл санааны хувьд үнэнч зөв зорилготой байна гэж бодох боломжгүй.

Лисандер Спүүнер

- [57] Хэрэв зөвхөн бүх хүмүүн төрөлхтөн, эрчүүд, эмэгтэйчүүд ижил тэгш эрх чөлөөтэй байвал би жинхэнээсээ эрх чөлөөтэй байна. Миний эрх чөлөөг үгүйсгэдэггүй, эсвэл хязгаарладаггүй бусад хүмүүсийн эрх чөлөө бол үүний эсрэгээр миний эрх чөлөөний гарцаагүй урьдач нөхцөл, баталгаажуулалт нь болдог.

Михайл Бакунин ^[8]

- [58] Хэн ч нутаг нэгтнийг чинь дарж дарлах боломжгүй болгохыг хүсэж байна уу? Тэгвэл хэнд ч ийм эрх мэдэл байх ёсгүй гэдгийг баталгаатай зүйл болго.

Михайл Бакунин

- [59] Аливаа гаднын хүслээр, энэ нь хүмүүн эсвэл бурхан, хамт олон эсвэл хувь хүмүүс байна уу гаднаас нь тулгасан учраас биш харин тэдгээрийг ийм байдаг гэдгийг нь хүлээн зөвшөөрсөн учраас жам ёсны хуулийг дагаж мөрдөх явдлаас л хүний эрх чөлөө бүрддэг.

Михайл Бакунин

- [60] Хэрэв мянган хүн татвараа энэ жил төлөөгүй бол энэ нь хүчирхийлэл бас цуст арга хэмжээ биш харин төлсөн бол Төрд хүчирхийлэл үйлдэх, гэмгүй цус урсгах үйл хийх боломж олгох байсан тийм зүйл юм. Үнэндээ энэ явдал бол хэрэв иймэрхүү зүйл болох боломжтой бол эв найртай хувьсгалын тодорхойлолт юм.

Хенри Дэвид Төрүэ

- [61] Төр хувь хүмүүсийг дээд, бие даасан эрх мэдэл, мөн өөрийнх нь бүх эрх мэдэл түүнээс үүсэж гардаг, бас энэ байдлаар түүнтэй харьцана гэдгийг хүлээн зөвшөөрөх хүртэл жинхэнээсээ эрх чөлөөтэй, гэгээрсэн Төр болохгүй.

Хенри Дэвид Төрүэ

- [62] Үг хэлэх эрх чөлөөг хориглох нь давхар муу зүйл юм. Ингэх нь түүнийг сонсогч, мөн түүнийг яригчийн эрхэд халддаг.

Фредерик Дуглас

- [63] Бусад ангийнх нь эрх чөлөөг аюулгүйгээр үнэмлэхүй байдлаар итгэл хүлээлгэн өгөхөөр тийм шударга, гэгээрсэн,

8 *Mikhail Alexandrovich Bakunin (1814 – 1876 он) - Оросын Хувьсгалч анархист байжээ. Тэрбээр анархизмын нөлөөтэй төлөөлөгч, хувьсгалч социалист, нийгмийн анархист, хамтач ёсны анархист уламжлалын гол зүтгэл байсан.*

хүмүүнлэг нутаг нэгтнийхээ ямар ч ангийг би мэдэхгүй.

Фредерик Дуглас

- [64] Дайн монополь байдлын үр дагавар байдгийн адилаар эв найр эрх чөлөөний жам ёсны үр дагавар байдаг.

Густав де Молинали

- [65] Хүний эрх чөлөөт байдал бол гаднаас түрэмгийлдэг зүйл биш. Учир нь түүнээс ингэж хийхийг албаддаг хүмүүс хүнийг үүнээс нь ашиг тус хүртэх болно гэсэн итгэл үнэмшилтэй байдаг.

Херберт Спенсер

- [66] Эрх чөлөө гэдгийг хүн бүр өөрийн үүрэг гэж итгэдэг тэр зүйлээ хийхдээ засаг захиргаа, олонхи, уламжлал, бодол санааны нөлөөллөөс хамгаалагдсан байх гэж би ойлгодог.

Лорд Актон

- [67] Улс орон жинхэнээсээ эрх чөлөөтэй эсэхийг шүүдэг хамгийн ойлгомжтой шалгуур бол цөөнхи нь таашаан эдэлдэг аюулгүй байдлын цар хүрээ юм.

Лорд Актон

- [68] [Х]үсээгүй хүмүүсээс хүчээр авсан бүх татвар эсвэл хүүгийн хэмжээ ёс суртахуунгүй, хүмүүсийг дарлаж буй зүйл юм.

Оберон Херберт

- [69] Төр засаг хүн бүрийн тэгш эрхийг бусдаас хамгаалж эрх чөлөөг бататгахад шаардлагатай байхаас илүүгээр дарлаж дарамталдаг байх ёсгүй бөгөөд төр засгийн хориглолт хязгаарлалт энэхүү шугамаас давсан тэр мөчид төр засаг үйлчлэх зорилготой хүмүүсээ хамгаалах яг тэр зорилгоосоо няцах аюулд ордог.

Хенри Жорж

- [70] Эрх мэдэлд өөрөө үүнийгээ нэмэх, хамрах хүрээгээ томруулах, түүнд зориулж гаргасан хязгаарын цаана нь гарахыг үргэлж хүсэж байдаг тийм ерөнхий хандлага

байсаар ирсэн; иймэрхүү дадал зуршлыг эсэргүүцэх зан төлөв өндийж бүрдээгүй газарт, мөн хувь хүмүүсийг өөрийн эрхэндээ харам байлгаж сургаагүй газарт хувь хүний өвөрмөц чанар аажимдаа алга болж, засгийн газар эсвэл Төр бүх-зүйлийг мэдэгч^[9] болдог.

Бенжамин Таккер

[71] [X]үнсний бүтээгдэхүүний монополист байгууллага амин дэмийнхээ оронд голдуу л хор өгдөгтэй яг адилаар батлан хамгаалахын монополь эрхээ Төр нутаг орноо хамгаалахынхаа оронд халдан түрэмгийлэхэд хэрэглэдэг; нэг халамжлагч нь хордуулах гэж [бусдаас] төлбөр авдгийн адилаар нөгөө нэг халамжлагч нь [тэднийг] боолчлох гэж [хүмүүсээс] төлбөр авна; эцэст нь Төр бүх хүмүүст тэд хүссэн ч эс хүссэн ч өөрийнхөө бүтээгдэхүүнийг худалдан авдаг болгосон цор ганц давуу эрхийг эдлэх учраас өөрийн өөдгүй зангаараа бүх нутаг-нэгтэн монополистуудаа давж гарна.

Бенжамин Таккер

[72] Үг ярианы тухай ямар ч хууль бүү гарга, үг хэлэх явдал эрх чөлөөтэй үлдэнэ; үг хэлэх нь чөлөөтэй байх тухай цаасан дээр тунхаглан зарласан даруйд та нар ‘эрх чөлөө гэдэг нь гутаан доромжлох явдал биш, бас эрх чөлөөт байдлын лиценз биш’^[10] гэдгийг баталсан зуун зуун хуульчтай болох бөгөөд тэд ийм эрх чөлөө оршдоггүй гэдгийг тодорхойлох болно.

Волтаирин де Клеире

[73] Төр ... гарал үүслээрээ ч, мөн үндсэн зорилгоороо ч анти-социал зүйл байдаг. Энэ нь жам ёсны эрхийн үзэл санаанд тулгуурладаггүй ч хувь хүмүүс Төр түүнд түр зуур батлан олгосон байж болох тэр эрхүүдээс өөр эрхтэй байдаггүй гэсэн үзэл бодолд тулгуурладаг.

9 *all-in-all*

10 *freedom does not mean abuse, nor liberty license*;

Алберт Жэй Нокк

- [74] Төр засгийн үүрэг бол хувь хүмүүсийг өөрийнх нь тэнэг байдлаас хамгаалах явдал юм гэдэг зарчмыг нэгэнт хүлээн зөвшөөрсөн бол улам ихээр дарлах дарангуйлахын эсрэг хөгжүүлэх ямар ч ул суурьтай эсэргүүцэл гэж цаашид байхгүй болно.

Лүдвиг фон Мизэс

- [75] Социализмын аваргууд өөрсдийгөө прогрессивчүүд буюу дэвшилтэд үзэлтнүүд гэж дууддаг боловч тэд өдөр тутамдаа хатуу чанд дэгд захирагдах шинжтэй, өөрчлөгдөж сайжрах явдлын аливаа төрлийг эсэргүүцдэг шинж чанартай тогтолцоог санал болгодог. Тэд мөн өөрсдийгөө либералчууд гэж дуудаг ч тэд эрх чөлөөг устгах зорилготой байдаг. Тэд өөрсдийгөө ардчилагчид гэдэг боловч тэд дарангуйллын төлөө тачааддаг. Тэд өөрсдийгөө хувьсгалчид гэж нэрлэдэг боловч тэд төр засгийг бүхнийг чадагч болгохыг хүсдэг. Тэд Диваажингийн Цэцэрлэгийг амладаг ч гэлээ тэд ертөнцийг асар том шуудангийн газар болгож хувиргах төлөвлөгөө гаргадаг. Хүн бүр нэгээс бусад нь албан газарт захирагддаг албат л болно.

Лүдвиг фон Мизэс

- [76] Татвараар дэмждэг, албадлагын боловсролын тогтолцоо бол тоталитари төрийн бүрэн гүйцэт загвар юм.

Изабел Патерсон

- [77] Ямар ч төр, ямар ч засгийн газар оршдоггүй. Үнэндээ оршиж буй зүйл нь олон хүнийг захирах эрх мэдэлтэй хүн, эсвэл хэдхэн хүн билээ.

Рөүз Вилдер Лэйн

- [78] Ямар ч хүмүүн төрөлтөн, эрэгтэй, эмэгтэй, хүүхдийг өөр нэгний эрх мэдэлд аюулгүй гэж итгэл хүлээлгэн өгч болохгүй ч байж болох юм; хүмүүн төрөлтөнд мөн үнэмлэхүй эрх мэдлийг итгэж аюулгүйгээр өгч бас боломжгүй ч байж болно.

Сузанне Ла Фоллетт

- [79] Хэрэв туршлага сургамж бүх зүйлийг зааж сургадаг сан бол тэр зүйл нь хүмүүсийн хүрээлэл буюу нийгэм хийхээр барьж авсан зүйлээ муу л хийдэг гэх зүйл байх болно. Энэ байдал ийм ажил хэрэгт гардаг авилгалд [хүмүүс] хүчтэй татагддагаас, магадгүй бүр цаашилбал түүнд оролцдог хүмүүсийн хувьд хувийн ашиг сонирхол байхгүй байгаагаас хэсэгчилж болдог биз ээ.

Сузанне Ла Фоллетт

- [80] Эдийн засгийн ухааны зугаатай ажил бол хүмүүст тэд өөрсдөө бодож төлөвлөж чадна гэж буй зүйлийн талаар хэрхэн бага зүйл мэдэж буйг нь [тэдэнд] дэлгэж харуулах явдал юм.

Ф. А. Хаек

- [81] Эрх чөлөөт байдлыг дэмждэг гаргалгаа нотолгоо бол хүмүүний оюун ухаан хэрэглэж чадах хамгийн хүчирхэг багаж хэрэгслийн нэг болох зохион байгуулалтын эсрэг гаргалгаа нотолгоо биш харин бүх онцгой, эрх дархтай, монополист байгууллагын эсрэг, мөн бусдыг илүү сайн хийхээс нь хорьж саатуулдаг албадлага хэрэглэхийн эсрэг гаргалгаа нотолгоо юм.

Ф. А. Хаек

- [82] Дэлхий дээрхи хамгийн бага цөөнхи бол хувь хүн юм. Хувь хүний эрхийг үгүйсгэдэг хүмүүс цөөнхийн хамгаалагч гэж өөрсдийгөө хэлэх чадахгүй. Хувь хүмүүсийн эрх бол олон нийтийн өгөх саналаар [шийдэгддэг] зүйл биш; олонхид цөөнхийн эрхийг булаан авахаар санал өгөх эрх байхгүй; эрхнүүдийн улстөрийн функц бол цөөнхийг олонхийн дарлал дарамтаас хамгаалах явдал юм.

Айн Рэнд

- [83] Би амь насаараа, түүнийгээ хайрладаг хайраараа би хэзээ ч бусад хүмүүсийн төлөө амьдрахгүй, бас бусад хүнийг миний төлөө амьдрана уу гэж хэзээ ч шаардахгүй гэдгээ

андгайлья.

Айн Рэнд

- [84] Эрх чөлөөг өөрийн хувь тавилангийнхаа төлөө энэ бол [ямар нэг юманд зориулагдан] сонгогдох эрх чөлөө биш харин сонгох эрх чөлөө юм гэж итгэж үнэлж цэгнэдэг хүмүүс бол хүмүүн төрөлтнийг хүмүүн болгодог зүйлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Исайя Берлин

- [85] Өнөө үед төр засаг үр ашигтай байдлынхаа сөрөг хязгаарын үе шатандаа ихээр ойртож очин маш том хэмжээтэй болсон явдал бол түүнд аливаа нэмэлт функц өгөх нь сайн гэхээсээ илүүтэй илүү хортой үр дагавартай байх болно гэж үзэх чухал шалтгаан байж болох юм...

Роналд Кеүз

- [86] Эрх чөлөөнөөс дээр гэж ... тэгш байдлыг чухалчилдаг нийгэм тэгш байдал ч үгүй, эрх чөлөө ч үгүй болж дуусна.

Милтон Фрийдмэн

- [87] Эрх чөлөөг хадгалж үлдэх явдал бол төр засгийн хязгаарлагдмал, төвлөрөөгүй эрх мэдлийг хамгаалах шалтгаан юм. Гэвч мөн конструктив шалтгаан^[11] үүнд бий. Иргэншилд гарсан уран барилга эсвэл уран зураг, шинжлэх ухаан эсвэл утга зохиол, аж үйлдвэр эсвэл хөдөө аж ахуйн аугаа дэвшил хэзээ ч төвлөрсөн төр засгаас гарч байгаагүй.

Милтон Фрийдмэн

- [88] Нэг дор хуримтлагдсан эрх мэдлийг түүнийг бүтээсэн хүмүүсийн сайн зорилгод хор учруулахгүйгээр ашиглах боломжгүй.

Милтон Фрийдмэн

- [89] Би хар тамхийг хуульзүйн дагуухь зүйл болгохыг дэмждэг.

11 *constructive reason-бүтээлч шалтгаан*

Миний үнэ цэнийн тогтолцооны дагуу хэрэв хүмүүс өөрсдийгөө хороохыг хүсвэл тэд ингэх бүрэн эрхтэй. Хар тамхинаас гарч буй хор хөнөөлийн ихэнх нь тэдгээр зүйл хуульзүйн дагуух зүйл биш учраас учир байгаа юм.

Милтон Фрийдмэн

- [90] Төр засгийн түр зуурын хөтөлбөрөөс илүү мөнхийн зүйл гэж байдаггүй.

Милтон Фрийдмэн

- [91] Улстөрчид болон захиргаадалтын ажилтнууд үлдсэн биднээсээ өөрцгүй хүмүүс. Тэд бусад бүх хүний адилаар л өөрсдийнхөө ашгийг хамгийн их байлгах болно.

Жэймс М. Бачэнэн

- [92] Төрийг хамгаалагчдын үйлдсэн хамгийн аугаа утгагүй дүгнэлт^[12] ... нийгмийн хэрэгцээт байдлаас Төрийн хэрэгцээт байдал руу үсрэх орох тухай байдаг.

Муррэй Ротбард

- [93] Дэлхийн зовлон бэрхшээл хэт олон хүн биш харин улстөр болон эдийн засгийн эрх чөлөө дутаж буй явдал юм.

Жулиан Саймон

- [94] Нэг төв бүтэц албадлага хэрэглэх монополь эрхтэй байсаар байвал бидэнд өөрийгөө-захирдаг нийгэм гэхээсээ илүүтэй төр л байх болно.

Элинор Остром

- [95] Гэвч надад социал буюу нийгмийн шударга ёсны тухай өөрийн тодорхойлолтоо санал болгох боломж олгоно уу: Би өөрийн хөдөлмөрлөж олсон зүйлээ өөртөө авах болно. Та нар санал нэг байна уу? Тэгвэл миний хөдөлмөрлөж олсон зүйлийн хэр их хэсэг нь танд оногддог вэ? Яагаад танд оногдох бол юм оо?

Волтер Виллиамс

12 *non sequitur*

- [96] Ардчилал болон эрх чөлөө ижил зүйл биш. Ардчилал сүрэг хүмүүсийн засаглал байхад харин эрх чөлөө бол хувь хүмүүний бие даасан байдал юм.

Волтер Виллиамс

- [97] Капитализмаас өмнө хүмүүс асар их баялгаа нутаг нэгтнээсээ булаан авч, тэднийг дээрэмдэж, тэднээ боолчилж хуримтлуулдаг байлаа. Капитализм хүмүүст нутаг нэгтэндээ үйлчилж баян болох боломж өгсөн.

Волтер Виллиамс

- [98] Хөдөлмөрөөс авах орлогын татвар бол албадлагын хөдөлмөртэй адилхан зүйл юм. Хэн нэгний хөдөлмөрийн үр шимийн хураан авах нь түүнээс цаг хугацааг нь булаан авахтай, түүнийг өөр янз бүрийн үйл ажиллагаа хийлгэх гэж түүнд тушаахтай адилхан зүйл.

Роберт Нозикк

- [99] Бас Шинэчлэлийн Эриний үеэр хүмүүсийн үргэлж ярьдагчлан ядуус нь улам ядуурсангүй. Үүний эсрэгээр ядуус нь орчин цагийн капитализмын гол ашиг тус хүртэгч нь болсон. Энэ бол шинэчлэлээс гардаг ашиг юуны түрүүнд хөрөнгөтөн баячууд руу голчлон явдаг гэсэн логик үнэнээр халхлагдсан түүхийн маргашгүй нотолгоо баримт юм.

Дийдр МакКлоский

- [100] Бизнесийн хүмүүс ялангуяа эрсдэл гаргаж, давуу талаа ашигласан байдлаар бага үнээр юм худалдан авч, их үнээр зардгийг хэрэв бүх л арилжаа наймаа муу зүйл биш бол, хэрэв та нар дэлгүүр хэсэхдээ бодолтой байгаа учраас муу хүн болчихдоггүй бол, бүх аливаа хээнцэр хэрэгцээгээ багасгаж хумихгүй бол, атаархлын гэм нүгэлд дөрлүүлж ёсзүйтэй амьдрахыг хүсэхгүй бол үүнийг муу зүйл үзэж болохгүй гэдэг.

Дийдр МакКлоский

- [101] Өмч бол аливаа нийгмийн эдийн засгийн гол институтц

бөгөөд хувийн өмч чөлөөт нийгмийн үндсэн институтуц
байдаг.

Дэвид Д. Фрийдмэн

ЭЗХЯХ-гийн тухай

Энэ хүрээлэн бол хязгаарлагдмал санхүүжилттэй, судалгаа болон боловсролын буяны байгууллага (No. CC 235 351) юм. Түүний алсын зорилго чөлөөт нийгмийн суурь институтүүдийн талаарх ухаарац мэдлэгийг эдийн засаг болон нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үзүүлэх зах зээлийн үүрэг нөлөөг шинжлэх, түгээн дэлгэрүүлэх замаар сайжруулах явдал юм.

ЭЗХЯХ хэтийн зорилгодоо дараахь арга замаар хүрнэ:

- хэвлэн нийтлэх сайн чанартай хөтөлбөр
- бага хурал, семинар, лекц, бусад үйл ажиллагаа
- дунд сургууль, коллежийн оюутнуудад хүрч ажиллах
- хэвлэл мэдээллийн танилцуулга бэлдэх, нэвтрүүлэг ярилцлаганд орох

1955 онд Эрхэм Энтони Фишер үүсгэн байгуулсан ЭЗХЯХ бол улстөрийн байгууллага биш харин боловсролын буяны байгууллага юм. Энэ байгууллага аливаа улстөрийн нам эсвэл бүлгээс ангид байдаг бөгөөд ямар нэг сонгууль эсвэл олон нийтийн санал асуулгын үеэр эсвэл хэзээ хаана ч аливаа улстөрийн нам эсвэл түүний нэр дэвшигчийг дэмжихэд нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулдаггүй. ЭЗХЯХ ном хэвлэлийнхээ борлуулалт, бага хурлын хураамж, сайн дурын хандиваар санхүүждэг.

Гол цуврал ном товхимолоосоо гадна ЭЗХЯХ мөн улирал тутмын Economic Affairs гэсэн сэтгүүл (jointly with the University of Buckingham), хэвлүүлдэг.

ЭЗХЯХ-гийн ажилд олон-улсын нэр хүндтэй Эрдэмтдийн Зөвлөх Зөвлөл [анг. Academic Advisory Council], мөн олонд алдартай Хүндэт Гишүүд [Honorary Fellows]-ийн бүлэг туслалцаа үзүүлдэг. Бусад эрдэмтдийн хамтаар энэ улс ЭЗХЯХ-гийн ирээдүйд гарах ном товхимолыг хянуулах, тэдний тайлбар санамжийг зохиогчид нь нэргүйгээр дамжуулж өгдөг. ЭЗХЯХ-гийн бүх ном зохиол тиймээс шинжлэх ухааны тэргүүлэх сэтгүүл гаргахад ашигладаг бие даасан,

хатуу чанга хянаж шалгах үйл явцыг давж гардаг.

ЭЗХЯХ-гийн ном товхимолыг өргөн хэмжээгээр дунд сургууль, их сургуулиудад хичээлд ашигладаг. Эдгээр бүтээлийг дэлхий даяар борлуулдаг бөгөөд ихэвчлэн л орчуулж, дахин-хэвлэн түгээдэг.

ЭЗХЯХ 1974 оноос хойш дэлхийн 70 улсад ижил төстэй 100 институтийн дэлхий-дэхний сүлжээг бүтээлцсэн билээ. Тэдгээр нь бүгд бие даасан байгууллага ч гэлээ ЭЗХЯХ-гийн хэтийн зорилготой зорилго дүйдэг.

ЭЗХЯХ-гийн ном товхимолд илэрхийлсэн үзэл санаа бол (корпорацын үзэлгүй) уг Хүрээлэн, түүний Удирдлагын Итгэмжлэгдсэн Баг, Эрдэмтдийн Зөвлөх Зөвлөлийн гишүүд эсвэл ахлах ажилтнуудынх биш харин зохиогчдынх нь үзэл санаа юм.

Тухайн Хүрээлэнгийн Эрдэмтдийн Зөвлөх Зөвлөл, Хүндэт Гишүүд, Итгэмжлэгдсэн Баг, Ажилтны багийн гишүүдийг арын хуудсанд жагсаан бичлээ.

ЭЗХЯХ Профессор Роналд Көүз агснаас бидний хэвлэлийн хөтөлбөр болон бусад ажлыг санхүүжүүлсэн өгөөмөр дэмжлэгт гүнээ талархаж байна.



The Institute of Economic Affairs
2 Lord North Street, Westminster,
London SW1P 3LB
Tel: 020 7799 8900 Fax: 020 7799 2137
Email: iea@iea.org.uk Internet: iea.org.uk

Director General & Ralph Harris Fellow Mark Littlewood

Editorial Director Dr Richard Wellings

Managing Trustees

Chairman: Neil Record
Kevin Bell
Robert Boyd
Linda Edwards
Robin Edwards
Sir Michael Hintze

Professor Patrick Minford
Bruno Prior
Professor Martin Ricketts
Linda Whetstone

Academic Advisory Council

Chairman: Professor Martin Ricketts
Graham Bannock
Dr Roger Bate
Professor Alberto Benegas-Lynch, Jr
Professor Christian Bjørnskov
Professor Donald J Boudreaux
Professor John Burton
Professor Forrest Capie
Professor Steven N S Cheung
Professor Tim Congdon
Professor Christopher Coyne
Professor N F R Crafts
Professor David de Meza
Professor Kevin Dowd
Professor David Greenaway
Dr Ingrid A Gregg
Dr Samuel Gregg
Walter E Grinder
Professor Steve H Hanke
Professor Keith Hartley

Professor Peter M Jackson
Dr Jerry Jordan
Dr Lynne Kiesling
Professor Daniel B Klein
Dr Mark Koyama
Professor Chandran Kukathas
Dr Tim Leunig
Dr Andrew Lilico
Professor Stephen C Littlechild
Professor Theodore Roosevelt Malloch
Dr Eileen Marshall
Professor Antonio Martino
Dr John Meadowcroft
Dr Anja Merz
Professor Julian Morris
Professor Alan Morrison
Professor D R Myddelton
Paul Ormerod
Professor David Parker

Professor Victoria Curzon Price
Professor Colin Robinson
Professor Pascal Salin
Dr Razeen Sally
Professor Pedro Schwartz
Professor J R Shackleton
Jane S Shaw
Professor W Stanley Siebert
Dr Elaine Sternberg
Professor James Tooley

Professor Nicola Tynan
Professor Roland Vaubel
Dr Cento Veljanovski
Professor Lawrence H White
Professor Walter E Williams
Professor Geoffrey E Wood

Honorary Fellows

Professor Michael Beenstock
Sir Samuel Brittan
Professor Richard A Epstein
Professor David Laidler

Professor Deirdre McCloskey
Professor Chiaki Nishiyama
Professor Vernon L Smith
Professor Basil S Yamey

ЭЗХЯХ-гээс саяхан хэвлүүлсэн бусад ном товхимол:

Federal Britain: The Case for Decentralisation

Philip Booth

Readings in Political Economy 3; ISBN 978-0-255-36713-4; £10.00

Forever Contemporary: The Economics of Ronald Coase

Edited by Cento Veljanovski

Readings in Political Economy 4; ISBN 978-0-255-36710-3; £15.00

Power Cut? How the EU Is Pulling the Plug on Electricity Markets

Carlo Stagnaro

Hobart Paperback 180; ISBN 978-0-255-36716-5; £10.00

Policy Stability and Economic Growth – Lessons from the Great Recession

John B. Taylor

Readings in Political Economy 5; ISBN 978-0-255-36719-6; £7.50

Breaking Up Is Hard To Do: Britain and Europe's Dysfunctional Relationship

Edited by Patrick Minford and J. R. Shackleton

Hobart Paperback 181; ISBN 978-0-255-36722-6; £15.00

In Focus: The Case for Privatising the BBC

Edited by Philip Booth

Hobart Paperback 182; ISBN 978-0-255-36725-7; £12.50

Islamic Foundations of a Free Society

Edited by Nouh El Harmouzi and Linda Whetstone

Hobart Paperback 183; ISBN 978-0-255-36728-8; £12.50

The Economics of International Development: Foreign Aid versus Freedom for the World's Poor

William Easterly

Readings in Political Economy 6; ISBN 978-0-255-36731-8; £7.50

Taxation, Government Spending and Economic Growth

Edited by Philip Booth

Hobart Paperback 184; ISBN 978-0-255-36734-9; £15.00

Universal Healthcare without the NHS: Towards a Patient-Centred Health

System

Kristian Niemietz

Hobart Paperback 185; ISBN 978-0-255-36737-0; £10.00

Sea Change: How Markets and Property Rights Could Transform the Fishing

Industry

Edited by Richard Wellings

Readings in Political Economy 7; ISBN 978-0-255-36740-0; £10.00

Working to Rule: The Damaging Economics of UK Employment Regulation

J. R. Shackleton

Hobart Paperback 186; ISBN 978-0-255-36743-1; £15.00

Education, War and Peace: The Surprising Success of Private Schools in War-Torn Countries

James Tooley and David Longfield

ISBN 978-0-255-36746-2; £10.00

Killjoys: A Critique of Paternalism

Christopher Snowden

ISBN 978-0-255-36749-3; £12.50

Financial Stability without Central Banks

George Selgin, Kevin Dowd and Mathieu Bédard

ISBN 978-0-255-36752-3; £10.00

Against the Grain: Insights from an Economic Contrarian

Paul Ormerod

ISBN 978-0-255-36755-4; £15.00

Ayn Rand: An Introduction

Eamonn Butler

ISBN 978-0-255-36764-6; £12.50

Capitalism: An Introduction

Eamonn Butler

ISBN 978-0-255-36758-5; £12.50

Opting Out: Conscience and Cooperation in a Pluralistic Society

David S. Oderberg

ISBN 978-0-255-36761-5; £12.50

Getting the Measure of Money: A Critical Assessment of UK Monetary Indicators

Anthony J. Evans

ISBN 978-0-255-36767-7; £12.50

Socialism: The Failed Idea That Never Dies

Kristian Niemietz

ISBN 978-0-255-36770-7; £17.50

Top Dogs and Fat Cats: The Debate on High Pay

Edited by J. R. Shackleton

ISBN 978-0-255-36773-8; £15.00

School Choice around the World: ... and the Lessons We Can Learn

Edited by Pauline Dixon and Steve Humble

ISBN 978-0-255-36779-0; £15.00

ЭЗХЯХ-гийн бусад ном товхимол

ЭЗХЯХ-гийн бүтээл болон бусад ном хэвлэлийн талаархи мэдээллийг www.iea.org.uk гэсэн сайтаас үзэх боломжтой. Аливаа ном товхимол захиалахыг хүсвэл мэдээллийг нь дороос үзнэ үү.

Хувь хэрэглэгчид

Хувь хэрэглэгчид захиалгаа ЭЗХЯХ-д өгөхдөө дор хаягаар хандах хэрэгтэй:

Clare Rusbridge

IEA

2 Lord North Street

freepost lon10168

London sw1p 3yz

Tel: 020 7799 8907. Fax: 020 7799 2137

Email: crusbridge@iea.org.uk

Арилжааны хэрэглэгчид

Арилжааны номын бүх захиалгыг өгөхдөө ЭЗХЯХ-гийн дистрибьютерүүд рүү дараахь хаягаар хандах хэрэгтэй:

NBN International (IEA Orders)

Orders Dept.

NBN International

10 Thornbury Road

Plymouth PL6 7PP

Tel: 01752 202301, Fax: 01752 202333

Email: orders@nbninternational.com

ЭЗХЯХ-гийн товхимолын захиалга

ЭЗХЯХ-гээс мөн тогтмол хэвлэлийн захиалга авдаг. Жилийн нэг удаагийн төлбөр (одоогоор £42.00, НХУ) төлж тус Хүрээлэнгээс хэвлүүлсэн монограф бүрийг захиалагч хүлээн авах болно. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг холбоо барих мэдээлэлд дурдсан хүнтэй холбоо барина уу:


Clare Rusbridge
Subscriptions
IEA
2 Lord North Street
freepost lon10168
London sw1p 3yz
Tel: 020 7799 8907. Fax: 020 7799 2137
Email: crusbridge@iea.org.uk

ОРЧУУЛСАН БҮТЭЭЛҮҮД:

(Зарим бүтээлээ www.libraryforfreereople.mn гэсэн онлайн номын-сандаа байрлуулав)



ЛҮ Худалдаанд гарсан




Худалдаанд гарсан



Худалдаанд гарсан




Номын-сан, он-лайнаар нийтэд түгээв.




Номын-сан, он-лайнаар нийтэд түгээв.




Номын-сан, он-лайнаар нийтэд түгээв.



Номын-сан, он-лайнаар нийтэд түгээв.



Номын-сан, он-лайнаар нийтэд түгээв.



Номын-сан, он-лайнаар нийтэд түгээв.

ОРЧУУЛСАН БҮТЭЭЛҮҮД:

(Зарим бүтээлээ www.libraryforfreereople.mn гэсэн онлайн номын-сандаа байрлуулав)




Номын-сан, онлайнгаар нийтэд түгээв.




Номын-сан, онлайнгаар нийтэд түгээв.



Худалдаанд гарсан



Орчуулж дууссан.2024 он 2-р хагас



Орчуулж буй.



Номын-сан, онлайнгаар нийтэд түгээв.



Худалдаанд гарсан.



Номын-сан, онлайнгаар нийтэд түгээв.




Орчуулж буй.

ОРЧУУЛСАН БҮТЭЭЛҮҮД:


(Зарим бүтээлээ www.libraryforfreereople.mn гэсэн онлайн номын-сандаа байрлуулав)



Орчуулж буй.



Номын-сан, онлайнаар нийтэд түгээв.




Орчуулахаар төлөвлөж буй.



ГАЙТАЙ МӨНГӨ
ФРЕДЕРИК БАСТИА

Орчуулж буй.
Дууссан



Номын-сан, онлайнаар нийтэд түгээв.



Institute of
Economic Affairs

СЭТГЭЛГЭЭНИЙ СУРГУУЛЬ – 101 Аугаа Либерал Сэтгэгч хэмээх энэ номд хувь хүний эрх чөлөөний төлөө зогсдог зарим нэг гарамгай сэтгэгчийн амьдрал, үзэл санааг эрт цагаас өнөө үе хүртэл дэлгэж үзүүлжээ.

Шагнал хүртсэн байсан **Иймонн Батлер** либерал санаа бодлын гол зүйлсийг тоймлон гаргаж, зуун зуун дамжиж эдгээрийг хэлбэржүүлсэн тэднийг цаг хугацааны дарааллаар өгүүлсэн болно.

Тэрбээр тэд улсын нийтлэг зорилгыг ялгаж харуулахын зэрэгцээгээр тэдний үзэл бодлын ялгааг жишээлбэл бидний өдөр тутмын амьдралд оролцох төр засгийн оролцооны тухай бодлыг нь тодруулж үзүүлсэн.

Улстөр, засаг төр, нийгмийн институт, капитализм, эрх, эрх чөлөө, ёс суртахуунт байдлыг сонирхдог аливаа хүний хувьд **СЭТГЭЛГЭЭНИЙ СУРГУУЛЬ – 101 Аугаа Либерал Сэтгэгч** хэмээх ном радикал буюу хурц ширүүн үзэл санааны бүрдэл, тэдгээрийн ард буй сэтгэгчдийн тухай ойлгомжтой, товч таниулга бичиг нь байх болно.

